

Дараахь нэр дурдсан хүмүүс энэхүү “Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт” гарын авлагыг бэлтгэхэд туслалцаа үзүүлсэн болно.

Ерөнхий эрхлэгч

Philipp Fluri /Швейцарь/ ба Anders B.Johnsson /Швед/

Зохиогч ба эрхлэгч

Hans Born /Голланд/

Туслалцаа үзүүлсэн:

Alexey Arbatov (ОХУ), Jean-Christophe Burkel (Франц), Eva Busza (АНУ), Marina Caparini (Канад), Umit Cizre (Турк), David Darchiashvili (Georgia), Jonah Isawa Elaigwu (Нигери), Hans-Peter Furrer (Швейцарь), Denise Garcia (Бразил), Suzana Gavrilesку (Румын), Wilhelm Germann (Герман), Owen Greene (Англи), Miroslav Hadzic (Серб, Монтенегро), Karl Haltiner (Швейцарь), Heiner Hanggi (Швейцарь), David Hobbs (Англи), Jan Hоекема (Голланд), Rogier Huizenga (Голланд), Andrzej Karkoszka (Польш), Peter G. Kelly (АНУ), Simon Lunn (Англи), Tom McDonald (Англи), Dorijan Marsic (Словени), Gian Giacomo Migone (Итали), Michael F. Noone (АНУ), Aleksandr Pikaуев (ОХУ), Christine Pintat (Франц), Andreas Prufert (Герман), Christopher Sabatini (АНУ), Liliane Serban (Румын), Ravinder Pal Singh (Энэтхэг), Anders C. Sjaastad (Норвеги), Bauke Snoer (Голланд), Svitlana Svetova (Украин), Jan Trapans (Латви), Matias Tuler (Аргентин), Marlene Urscheler (Швейцарь), Pentti Vaananen (Финлянд), Biljana Vankovska (Македони), Marie Vlachova (Чех), Casper W. Vroom (Голланд), Tamas Wachsler (Унгар), Donna Winslow (Канад), Herbert Wulf (Герман).

Эрхлэгчийн алба

Willem van Eekelen (Голланд), Andreas Gross (Швейцарь), Miroslav Filipovic (Серб, Монтенегро), Stepan Sulakshin (ОХУ), Dimitro Tabachnik (Украин), Ahmad Husni Hanadzlah (Малайз), Adeseye Ogunlewe (Нигери) and Elissavet Paradimitriou (Грек) Beth Mugo (Кени) and Ricardo Vasquez (Аргентин).

Хэлний эрхлэгч

Oliver Wates /Англи/

Эх хувилбар


Англи, Женев. 2003 он

Оршил

Аюулгүй байдал гэдэг бол ард иргэдийн амгалан тайван байдлыг хангах зайлшгүй чухал хүчин зүйлийн нэг юм. Иймд ард иргэдийн үзэл бодол нь Үндэсний аюулгүй байдлын бодлогод тусгалаа олж байдаг. Тэгэхээр аюулгүй байдлын бодлого нь төр засгаас анхаарал тавьж буй, аюулгүй байдлыг нь хангах ёстой эрхэм нандин зүйлс, мөн баримтлах зарчмыг агуулсан байдаг.

Энэ утгаараа ардчилсан сонгуулиар сонгогдсон ард иргэдийн төлөөлөгчид болох парламентын гишүүд нь Засгийн газар, Аюулаас хамгаалах салбартай нягт хамтын ажиллагаатай байх зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр эдгээр байгууллагууд нь эцэстээ нэг зорилгод хүрэхийн тулд ажиллаж байгаа ч үүрэг хариуцлага нь тус бүрдээ ялгаатай байдаг. Парламент нь хууль эрх зүйн хэмжүүр үзүүлэлтүүдийг тодорхойлж, төсөв батлах, аюулаас хамгаалах салбарын ажлыг хянах үүрэгтэй. Парламент нь өргөн хэмжээний мэдээлэл авах боломжтой байж, шаардагдах мэргэжлийн мэдлэгтэй, Засгийн газар парламентад ажлаа тайлагнадаг зарчмыг бий болгосноор өөрийн үүрэгт ажлыг бүрэн хэмжээгээр биелүүлж чадна. Харин энэ нь нөгөө талаас итгэлцэл, харилцан ойлголцол дээр үндэслэгдсэн нийгмийн тогтолцоог шаардана.

Чили дэх зэвсэгт хүчин, нийгмийн салбаруудын хоорондын харьцаа сүүлийн жилүүдэд сайжирсан билээ. Өнөөдрийн байдлаар Олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар Чилид харилцан бие биеэ хүндэтгэсэн, хамтын ажиллагааны уур амьсгал бүрдсэн гэж үзэж байгаа бөгөөд ирээдүйд ийм байдал нь хадгалагдсаар байх болно гэж найдаж байна. Уг бяцхан гарын авлага нь Аюулаас хамгаалах салбарын голлох төлөөлөгчид нь хүн нэг бүр, иргэн бүрийн эрмэлзэх нийтлэг нэг зүйл болох аюулгүй байдлын төлөө хамтын хүчээ зориулахад тусална гэдэгт би итгэлтэй байна.



Сенатор Sergio Paez Verdugo
Парламент Хоорондын Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч

Өмнөх үг

Эрт дээр үеэс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдал нь оршин тогтнох чадвар бүхий улсыг байгуулахад зайлшгүй шаардлагатай байсаар ирсэн. Өнөө үед аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудын тогтолцоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байна. Шинэ хэлбэрийн зэвсэгт мөргөлдөөн, улс хоорондын харилцаа нягтарч байгаагаас үүдэн аюулгүй байдлын ухагдахуунд шинэ сэтгэлгээ, шинэлэг үйл ажиллагаа шаардлагатай байна. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдал, түүний үр дагавар энэ хэрэгцээг улам тод томруунаар харууллаа.

Шинээр гарч буй дээрх шаардлагад нийцэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангах, хариуцлагыг өндөржүүлэх нөхцлөөр хангахын тулд парламентын хяналт үр өгөөжтэй байх хэрэгтэй. Парламентын хяналт байхгүй бол аюулаас хамгаалахын албад нь өөрсдийн үйл ажиллагааны зорилгыг буруу ашиглан улс доторх улс мэт болж, байгаа хязгаарлагдмал нөөцөд хүнд хэмжүүрүүд тогтоох, улс төр, эдийн засгийн нөлөөллөө ихэсгэх зэрэг аюул тулгарч болох юм. Энэ нь ардчиллын явцыг удаашруулж, мөргөлдөөн гарах нөхцлийг ихэсгэх магадлалтай. Нийгмийн шилжилтийн үе шатанд, дайнд нэрвэгдсэн, хямралд өртсөн орнууд нь иймэрхүү бодит эрсдэлтэй байдаг байхад ардчилсан нийгэмд цэрэг, иргэний харилцааг зохицуулах, өөрчлөгдөж буй аюулгүй байдлын орчинд энэхүү харилцааг өөрчлөх, зохицуулах асуудал гарч ирдэг.

Аюулаас хамгаалах салбар бүтэц нь байнга өөрчлөгдөж байдаг зүй тогтолтой нь парламентын зүгээс тавих хяналтыг маш төвөгтэй болгодог. Ихэнхдээ нарийн мэдлэг шаардах асуудал, аюулаас хамгаалах байгууллагын иж бүрэн зохион байгуулалт, зохистой хэмжээ, нууцлалын тухай хуулийн заалт, практик хэрэгжилт гээд парламентын гишүүдэд үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулахад маш төвөгтэй асуудлууд гарч ирдэг. Парламентын гишүүд нь бие даан судалгаа явуулж, мэргэжлийн мэдлэг туршлагаа дээшлүүлснээр энэ ажлыг гүйцэтгэх чадвартай болно.


Дээрх шалтгааны улмаас Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт Хүчинд Ардчилсан Хяналт тавих төв нь

аюулаас хамгаалах салбарт тавих хяналтад парламент өөрийн хувь нэмрээ оруулахад тус дэм болох зорилгоор практик амьдралд хэрэгжиж буй жишээ, механизмыг товч тусгасан бөгөөд хүн бүрийн хүртээл болгох практик хэрэгцээг хангах зорилгоор товхимол гаргахаар тохиролцсон билээ. Уг номыг зохиох явцад номын агуулгын илэрхийллийг парламентын гишүүдийг оролцуулсан редакциар хянуулахын зэрэгцээ шинжээчдээр дүгнэлт хийлгүүлсэн юм.

Уг номыг бичихдээ орон бүрт ижил үйлчилдэг парламентын хяналтын цорын ганц загвар байдаггүй гэдгийг анхаарч үзсэн. Ямарваа нэг улс оронд үр өгөөжтэй хэрэгжиж байсан ажлын практик өөр газар хэрэгжих ямар ч боломжгүй байж болох юм. Үүнээс гадна парламентууд нь эрх мэдлийн хувьд харилцан адилгүй байдаг. Ийнхүү бодит амьдрал дээр парламентын хяналт харилцан адилгүй байдаг учир уг гарын авлагад орсон саналууд дэндүү идеалист хэлбэртэй мэт санагдаж болох юм. Нөгөө талаас аюулаас хамгаалах асуудлын мөн чанар маш төвөгтэй олон талтай байдгаас энэ ганц номын агуулгаар бүхий л асуудлыг хязгаарлах боломжгүй юм. Тиймээс энэ гарын авлагыг аюулаас хамгаалах салбарт парламентын зүгээс тавих хяналтыг хэрхэн сайжруулах тухай нийтлэг, ерөнхий танилцуулга хэмээн ойлгож болох ба уншигчдад уг сэдвээр цаашид судалгаа хийх урам зориг хайрлана гэдэгт найдаж байна. Эцэст нь хэлэхэд энэ ном нь ард иргэдэд үйлчлэх зорилго бүхий аюулгүй байдлын бодлого нь үнэхээр тэдний үзэл санааг шингээсэн бодлогын бичиг баримт байхад хувь нэмрээ оруулна гэдэгт бид найдаж байгаа чин хүслээ илэрхийлж байна.



Anders B. Johnsson
Парламентуудын Холбооны
Ерөнхий нарийн бичгийн дарга



Элчин Сайд Dr. Theodor H. Winkler
Женев дэх Зэвсэгт хүчинд
Ардчилсан Хяналт тавих төвийн
захирал

Энэ гарын авлагаас та юу мэдэж болох вэ?

Уг гарын авлага нь найман хэсэгтэй, хэсэг тус бүр нь хэд хэдэн бүлэгтэй бөгөөд хоёр янзаар уншиж болно. Гарын авлагыг бүхэлд нь уншиж дуусгаснаар аюулаас хамгаалах асуудал, парламентын хяналтын талаар ерөнхий ойлголттой болно. Хэдий тийм боловч уншигч сонирхсон сэдвийнхээ дагуу бүлэг, хэсгийг сонгон уншиж болно. Гарын авлагад хавсаргасан индекс, тухайн уншиж буй бүлэгт холбогдох болон өөр сонирхсон сэдвийн тухай уг гарын авлагын ямар бүлгээс мэдэж болох талаар хийсэн эшлэл нь хэсэгчлэн унших нөхцлийг хангаж өгнө.

Гарын авлагад тухайн сэдвийг тодотгох зорилгоор тусгайлсан тодруулгуудыг оруулж өгсөн. Энэ тодруулгуудад аливаа улс оронд хэрэгжиж буй хууль тогтоомж, парламентын үйл ажиллагаанаас авсан жишээнүүдийг оруулсан болно. Ихэнх бүлгийн эцэст “Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?” гэсэн хэсгийг оруулсан. Энд танд хэрэгтэй зөвлөгөөг багтаасан. Харин эдгээр зөвлөгөөг улс орон бүр өөр өөрийн нөхцөл байдалд тохируулан ойлгох нь чухал юм.

Эхний хоёр хэсэгт парламентаас аюулаас хамгаалах салбарт тавих хяналтын цар хүрээг онолын болон судалгааны хувьд тодорхойлсон. I хэсэг нь Аюулгүй Байдал гэсэн ухагдахууныг тайлбарлахад чиглэгдсэн бөгөөд парламент болон улсын бусад байгууллагуудын үүрэг хариуцлагын тоймыг харуулсан болно. I хэсэгт дараахь асуудлуудыг тайлбарласан болно. Үүнд:

- ❑ Аюулаас хамгаалах салбарт сүүлийн үед гарсан өөрчлөлтүүд юу вэ?
- ❑ Шинээр гарч ирсэн аюул заналхийлэл, түүнээс үүдэн гарч буй шаардлагад нийцэх үйл ажиллагааг хэрхэн явуулах вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт ямар учраас парламентын хяналт шаардлагатай вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт сайн засаглалын ямар зарчмуудыг эрхэмлэх ёстой вэ?
- ❑ Парламент, Засгийн газар, Шүүх байгууллагуудын үүрэг юу вэ?

II хэсэгт үндэсний аюулгүй байдлын бодлогын үе шатууд, үндэсний аюулгүй байдлын бодлогод харгалзан үзэх ёстой олон зохицуулалтуудыг тайлбарласан. Энэ хэсгийн сүүлийн хоёр бүлэгт иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, аюулаас хамгаалах асуудалтай холбогдон гарч ирэх хүйсийн ялгааны асуудлыг авч үзсэн. Голлох асуултууд:

- ❑ Үндэсний аюулгүй байдлын бодлоготой холбогдон гарах шийдвэрт парламент ямар үүрэгтэй байх вэ?
- ❑ Олон улсын хууль тогтоомжууд нь үндэсний аюулгүй байдлын бодлогод ямар хязгаарлалтыг бий болгодог вэ?, эсвэл сайжруулах ямар нөхцлийг бүрдүүлдэг вэ?
- ❑ Иргэний нийгмийн тогтолцоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл аюулаас хамгаалах салбарт хэрхэн нөлөөлдөг вэ?, парламент энэ хоёр хэрэгслийг хэрхэн ашиглаж болох вэ?
- ❑ Аюулаас хамгаалах асуудлын талаар олон нийттэй хэрхэн харьцах вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг юу вэ?

III хэсэгт аюулаас хамгаалах салбарын байгууллагуудын албан үүргийг тайлбарласан. Үүнд Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллага, тагнуулын алба, улсын цэрэгжсэн бусад байгууллагууд, аюулаас хамгаалах хувийн хэвшлийн байгууллагууд орно.

- ❑ Аюулаас хамгаалах салбарын нэгж бүрийн ажлын үүрэг юунд оршдог вэ?
- ❑ Дотоод болон улс төрийн хяналтын ямар механизмыг бий болгох шаардлагатай вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт парламент хэрхэн үр өгөөжтэй хяналт тавьж чадах вэ?

IV хэсэгт аюулаас хамгаалах салбарт тавих хяналтад парламентын зүгээс хэрэглэж болох арга барил, хэрэгслийг тайлбарлаж, дараахь асуултуудад хариулт өгсөн. Үүнд:

- ❑ Аюулаас хамгаалах салбарт тавих хяналтыг тогтворжуулахын тулд парламент ямар хэрэглүүрүүдийг хэрэглэж болох вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарын тухай парламентын гишүүдийн мэдлэгийг хэрхэн сайжруулж болох вэ?
- ❑ Аюулаас хамгаалах асуудлаар парламентаас лавлагаа, сонсгол явуулах нь ямар ач холбогдолтой вэ?
- ❑ Батлан хамгаалах хороо хэрхэн үр өгөөжтэй ажиллах вэ?
- ❑ Агент ямар үүрэгтэй байх вэ?
- ❑ Батлан хамгаалах асуудал хариуцсан агентийн үйл ажиллагаа хэрхэн явагддаг вэ?

- ❑ Парламентын гишүүд яагаад аюулгүй байдлын албанд айлчлал хийх хэрэгтэй вэ?

Ү хэсэгт онцгой байдал, дотоодын аюулгүй байдалд аюул учрах, терроризм, кибер гэмт хэрэг зэрэг асуудлуудыг авч үзнэ. Үүнээс гадна олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсоноор гарах үр дагаврын тухай хэлэлцэнэ. Энэхүү үйл ажиллагаа нь аюулгүй байдал бүрмөсөн алдагдсан буюу бүрэн бус хангагдсан бүс нутагт явагддаг. Тиймээс Ү хэсэгт дараахь асуултуудад хариулт өгсөн. Үүнд:

- ❑ Онцгой байдал, дотоодын аюулгүй байдал, хүний эрхийг дээдлэх гэсэн асуудлуудыг хэрхэн тэнцвэртэйгээр шийдэх вэ?
- ❑ Онцгой байдал зарласнаар ямар зорилгод хүрч, ямар хязгаарлалт бий болох вэ?
- ❑ 9 дүгээр сарын 11-нээс хойш ямар өөрчлөлтүүд гарсан бэ? Терроризм, хууль ёсны дагуу хийж буй ардчилсан хэв журамд захирагдсан эсэргүүцэл хоёр ямар ялгаатай вэ?
- ❑ Зэвсэгт хүчнийг хилийн чанадад, олон улсын энхийн төлөө үйл ажиллагаанд оролцуулахаар илгээхэд парламентын оролцоо, ач холбогдол нь юу вэ?

ҮI, ҮII, ҮIII хэсгүүдэд аюулгүй байдлын салбартай холбогдол бүхий нөөцийн гурван салбарт судалгаа хийсэн. ҮI хэсэгт батлан хамгаалах төсөв, үүнд парламентын болон улсын аудитын хяналт тавих байгууллагуудыг авч үзсэн.

- ❑ Улсын төсөв ямар учраас аюулаас хамгаалах салбарын гол үзүүлэлт байдаг вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт ил тод байдал, ажлын үүрэг хариуцлагыг хэрхэн бий болгох вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт хяналт тавих зохистой нөхцөл юу вэ?
- ❑ Аюулаас хамгаалах салбарт аудитын хяналт хэрхэн тавих вэ? Ямар учраас бие даасан аудитын байгууллага чухал байдаг вэ?, тэр нь үйл ажиллагаагаа хэрхэн явуулдаг вэ?

ҮII хэсэгт аюулаас хамгаалах салбарын боловсон хүчний тухай өгүүлсэн бөгөөд цэргийн албан хаагчдыг дайчлах, томилох, бэлтгэх, албанаас чөлөөлөх, тэтгэврийн журам, цэрэг татлага, дүйцүүлэх алба зэрэг асуудлыг зохицуулахад парламентад тусламж өгөхийг зорьсон.

- ❑ Аюулаас хамгаалах салбарт ардчиллын хэр хэмжээ, эрхэм зүйлсийг хэрхэн тусгаж өгөх вэ?

- ❑ Цэргийн албан хаагч нь цэргийн холбоо, эвсэл байгуулж болох уу?
 - ❑ Цэрэг татлага, цэргийн дүйцүүлэх алба улс орнуудад хэрхэн зохицуулагдсан байдаг вэ?
 - ❑ Энэ салбар мэргэжлийн ямар ёс суртахуунтай вэ?
 - ❑ Албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхдээ мөрдөх журам байдаг уу? Олон улсад мөрддөг стандарт бий юү?
 - ❑ Парламентын гишүүд энэ салбар дах боловсон хүчний удирдлагын ямар асуудлуудыг анхаарч үзэх ёстой вэ?
- Эцсийн VIII хэсэгт аюулаас хамгаалах салбарын материалын нөөц, нэн ялангуяа зэвсэг худалдан авах (хэнээс юу худалдан авах), худалдаалах, тээвэрлэх асуудлуудыг багтаасан.
- ❑ Хууль ёсны ямар хязгаарлалтууд байдаг вэ?
 - ❑ Зэвсэг худалдан авах тухай иж бүрэн шийдвэр гаргах үйл явц ямар байх вэ?
 - ❑ Ямар нөхцөлд нууцлах ёстой вэ?
 - ❑ Парламент энэ асуудалд хэрхэн үнэлэлт гаргах вэ?

Тодруулга

Тодруулга №1	Өнөө үед аюулгүй байдалд учирч болох заналхийлэл (дангаараа буюу хоорондоо уялдсан хэлбэрээр ...)	22
Тодруулга №2	Аюулгүй байдлын асуудлаарх тохиролцоонууд	23
Тодруулга №3	Аюулаас хамгаалахад улсын үндсэн гол салбаруудын гүйцэтгэж болох магадлалтай үүргүүд	30
Тодруулга №4	Сайн засаглал нь аюулаас хамгаалах салбарт парламентын хяналт тавихад эрхэмлэх зүйл	33
Тодруулга №5	Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар асуухуй	35
Тодруулга №6	Шууд ардчиллын хэлбэр, олон улсын хэлэлцээр, бусад ач холбогдол бүхий томоохон гэрээнд гарны үсэг зурах нь: Швейцарь улсын жишээ	45
Тодруулга №7	Латин Америкийн орнуудад бүрэлдэн бий болж буй иргэний нийгмийн тогтолцоо	49
Тодруулга №8	Шинэ маягийн дайн: Хэвлэлийн эрх чөлөөнд цөвүүн цаг тулгарлаа	51
Тодруулга №9	2001 оны 9 дүгээр сарын 11-нээс хойшхи хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	53
Тодруулга №10	Парламентын Вэб хуудас	54
Тодруулга №11	Парламент ба мэдээллийн хэрэгсэл	56
Тодруулга №12	Энх тайвны үйл ажиллагаа дахь хүйсийн ялгаа	60
Тодруулга №13	Энхийг сахиулах үйл ажиллагаа, үйл явцыг хүйсийн ялгааны талаас авч үзвэл	61
Тодруулга №14	Зэвсэгт хүчин дэх эмэгтэй боловсон хүчин: НАТО-гийн орнуудын жишээ	63
Тодруулга №15	Хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх зорилгоор аюулгүй байдлын бодлогод эмэгтэйчүүдийг оролцуулах нь	64
Тодруулга №16	Аюулаас хамгаалах салбарт эмэгтэйчүүдийг оролцуулах болсноор гарч ирэх шинэ хэмжүүр, шаардлагууд	64

Тодруулга №17	Зэвсэгт хүчин байдаггүй улсууд . . .	69
Тодруулга №18	Батлан хамгаалах салбарын шинэчлэл ямар зорилготой вэ? . . .	70
Тодруулга №19	Өмнөд Африкт Зэвсэгт хүчнийг иргэний хуулийн хэрэгжилтэнд ашигласан тухай	73
Тодруулга №20	Улсын бусад цэрэгжсэн байгууллагуудын тухай сонгон авсан орнуудын жишээ	77
Тодруулга №21	Цагдаагийн байгууллагын ардчилсан үйл ажиллагааны гол хэлбэрүүд . .	79
Тодруулга №22	Аюултай байдал бий болох нөхцөл	80
Тодруулга №23	Эритрэа дахь цагдаагийн үйл ажиллагаа: хөгжиж буй орны жишээ	81
Тодруулга №24	Парламентаас тагнуулын албанд зориулан батлах тусгай төсөв: Аргентины жишээ	85
Тодруулга №25	Парламентын хороод нууцлал бүхий баримт бичигтэй харьцах практик үйл ажиллагаанаас	87
Тодруулга №26	Аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн компаниуд ба эдгээрээс ардчилалд учирч болзошгүй аюулууд	93
Тодруулга №27	Аюулаас хамгаалах салбарт ардчилсан хяналтыг тогтооход парламентаас хэрэгжүүлж болох арга замууд	100
Тодруулга №28	Парламентаас аюулаас хамгаалах салбарт тавих хяналтанд зориулсан сонгодог төлөвлөгөө	103
Тодруулга №29	Аюулгүй байдлын асуудлаарх парламентын ур чадварыг дээшлүүлэхэд зориулсан практик арга барил, механизм	104
Тодруулга №30	Дээд албан тушаалтанд хяналт тавих парламентын бүтэц, дэг журмын нийтлэг шинжүүд	107
Тодруулга №31	Сонгодог асуулт тавихад зориулсан зөвлөгөө	109
Тодруулга №32	Парламентын лавлагааны хороодын үндсэн шинж чанарууд	111
Тодруулга №33	Сомали дахь Канадын цэргийн хүчний үйл ажиллагааны лавлагааны хороо: аюулгүй байдлын асуудлаарх	

	парламентын тайланд олон нийтээс үзүүлсэн нөлөө	113
Тодруулга №34	Батлан хамгаалах буюу аюулгүй байдлын асуудлаарх парламентын хорооны үндсэн үүргүүд	117
Тодруулга №35	Норвегийн парламент /Стортинг/-ын гадаад харилцаа болон батлан хамгаалах хорооны хамтарсан хуралдаан	118
Тодруулга №36	Засгийн газрын болон олон нийтийн байгууллагын эсрэг хувь хүмүүсийн гаргасан гомдол, саналыг хүлээж авдаг иргэдийн төлөөлөгч /омбудсмен/	120
Тодруулга №37	Сонгон авсан орнууд дахь батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчийн хяналт	121
Тодруулга №38	Германы Парламентын Зэвсэгт хүчний тусгай эрхт төлөөлөгч	123
Тодруулга №39	Аргентины жишээ	126
Тодруулга №40	Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн албан бус протокол нь аюулгүй байдлын албанд хийх айлчлалын боломжийг өргөтгөдөг	127
Тодруулга №41	Улсын онц аюултай байдал: Зорилго ба зарчим	133
Тодруулга №42	Ардчилал ба аюулгүй байдлыг бэхжүүлэх	138
Тодруулга №43	Ноцтой үр дагавартай мушгин гуйвуулах явдал	139
Тодруулга №44	9 дүгээр сарын 11-ний үйл явдалд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс өгсөн хариу	142
Тодруулга №45	Терроризмын эсрэг тэмцэл	145
Тодруулга №46	Хувь хүний мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан гаргасан хувь хүнийг хамгаалах конвенци	155
Тодруулга №47	Энхийг тогтоох, энхийг сахиулах, энхийг хэрэгжүүлэх, энхийг байгуулах тухай НҮБ-ын тайлбарууд	158
Тодруулга №48	НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааг алхам алхмаар хийх ажиллагаа	162
Тодруулга №49	Энхийн төлөөх үйл ажиллагаанд оролцох дүрэм журам	163

Тодруулга №50	Энхийг сахиулах НҮБ-ын сургалт	165
Тодруулга №51	Төсөв: ардчилсан засаглалын гол хэрэгсэл	169
Тодруулга №52	Яагаад парламент төсвийн асуудалд идэвхтэй байр суурь эзэлдэг вэ?	171
Тодруулга №53	Дэлхийн зарим орны ДНБ дахь батлан хамгаалахын төсвийн зарцуулалт /хувиар/	171
Тодруулга №54	Төлөвлөх ба хөтөлбөр, төсөв боловсруулах систем /ГХТБС/	174
Тодруулга №55	Батлан хамгаалахын төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг: Испаний батлан хамгаалахын 2002 оны төсөв	177
Тодруулга №56	Аюулгүй байдлын төсөв боловсруулахад ил тод байх гол бэрхшээлүүд	178
Тодруулга №57	Аюулгүй байдлын төсөв дахь ангиллын гурван төвшин	180
Тодруулга №58	Аюулгүй байдлын төсөвт үр ашигтай хяналт тавихад гарч болзошгүй асуудлууд	181
Тодруулга №59	Зүүн Өмнөд Европын зарим орнуудын батлан хамгаалахын төсвийн тухай /2001 оны байдлаар/	183
Тодруулга №60	Ерөнхий Аудит	186
Тодруулга №61	Аюулаас хамгаалах салбарт тавьж буй парламентын хяналт дахь Их Британий Үндэсний хяналт шалгалтын газрын үүрэг	187
Тодруулга №62	Грузиний парламент ба төсвийн хяналт	189
Тодруулга №63	Зэвсэгт хүчний мэргэжлийн штабын гишүүдэд зориулсан байгууллага, холбооны гишүүн байх эрхийн тухай Европын Зөвлөлийн зөвлөмж	196
Тодруулга №64	Германы Зэвсэгт хүчний удирдлага ба иргэний боловсрол: дотоодын удирдлагын зарчим	200
Тодруулга №65	Хууль сахиулах албаны ажилтнуудад зориулсан зохицуулах хууль	201
Тодруулга №66	Аюулаас хамгаалах албаны цэрэг-улс төрийн үзэл баримтлалын тухай Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын зохицуулах хууль /1994/: гол зарчмууд	203

Тодруулга №67	Боловсон хүчний удирдлага: парламентын гишүүдийн анхаарал тавих чиглэлүүд	208
Тодруулга №68	Дэлхийн өнцөг булан бүрийн цэргийн алба	212
Тодруулга №69	Цэрэг татлагын дарамт	214
Тодруулга №70	НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998 оны 77 дугаар тогтоол: цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах тухай	216
Тодруулга №71	Дүйцүүлэх алба: Швейцарь улс	218
Тодруулга №72	Парламентын гишүүд яагаад зэвсэг ханган нийлүүлэх асуудалд санаа тавих ёстой вэ?	223
Тодруулга №73	Зэвсэг ханган нийлүүлэлтийн бодлого сул буюу нууцлалын өндөр зэрэглэл бүхий зэвсэг ханган нийлүүлэлтийн асуудал дараахь зүйлд хүргэж болзошгүй	224
Тодруулга №74	Батлан хамгаалах ханган нийлүүлэлтийн тухай Голландын бодлого: парламентын хяналтын хэмжээ	225
Тодруулга №75	Зэвсгийн шилжүүлэг: тодорхойлолт	228
Тодруулга №76	Зэвсгийн шилжүүлгийн тухай бүс нутгийн хэлэлцээр	230
Тодруулга №77	Зэвсгийн зөвшөөрлийг боловсронгуй болгох: парламент юу хийж чадах вэ?	232
Тодруулга №78	Илүүдэл зэвсгийн худалдаа: Зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох явдлын эсрэг зэвсгийн худалдаа	234
Тодруулга №79	Жижиг буу зэвсгийн худалдааны тухай тооцоо	235
Тодруулга №80	Жижиг буу зэвсэг, галт зэвсгийн хууль бус худалдааны эсрэг НҮБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр	235
Тодруулга №81	Зэвсгийн экспортын хяналтанд парламентын үүрэг оролцоо: Европын орнууд дахь ил тод байдал, хариуцлага	237

Бүх эрхийг хуулиар хамгаална. Энэхүү номын ямар нэг хэсгийг Парламент хоорондын холбоо буюу Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан хяналт тавих төвийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлан олшруулж дахин хэвлэж үл болно.

Энэхүү бүтээлийг ашиг хонжоо олохоос бусад замаар худалдах, түрээслэх, ашиглуулах замаар эргэлтэнд оруулж болно. Худалдаанд гарснаас бусад тохиолдолд зохиогчийн эрхгүйгээр буюу дараахь хэвлэн нийтлэгчийн эрхгүйгээр эргэлтэнд оруулж үл болно.

ISBN 92-9142-142-1 /IPU/
ISBN 86-83543-10-2 /CCMR-DCAF/

**Аюулаас хамгаалах салбарт тавих
парламентын хяналт:
Дэг журам, механизм, практик**

Хэвлэн нийтэлсэн:

Парламент Хоорондын Холбоо
Женев дэх Зэвсэгт Хүчинд Ардчилсан Хяналт тавих төв

Ерөнхий эрхлэгчид:

Philipp Fluri /Швейцарь/
Anders B. Johnsson /Швед/

Зохиогч ба эрхлэгч:

Hans Born /Голланд/

Гүйцэтгэн нийтлүүлсэн:

Белград дахь Цэрэг, иргэний харилцааны төв

Хэвлэсэн:

Гораграф, Белград

Женев, Белград. 2003 он

Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт

I ХЭСЭГ

**Аюулгүй байдлын бодлого
боловсруулалт, оролцох
төлөөллүүд:**

Парламентад тулгарч буй асуудлууд

1 дүгээр бүлэг

Дэлхий дахинд гарч буй өөрчлөлтүүдээс үүдэн аюулгүй байдлын орчин өөрчлөгдөх нь

Сүүлийн арван жилд дэлхий нийтийн аюулгүй байдалд үлэмж хэмжээний өөрчлөлт гарсан билээ. Урьд өмнө нүүрлэн байсан аюулууд үгүй болж шинэ хэлбэрийн сэтгэл түгшээсэн зүйлүүд гарч ирлээ. Үүнтэй уялдаад аюулгүй байдал, улс төрийн хямрал, энх тайвнаар зэрэгцэн орших зэрэг ухагдахууныг шинээр тодорхойлоход хүрсэн юм.

Ардчилсан нийгэм дэх энх тайван, аюулгүй байдлын тухай ойлголтууд

Ямарваа нэг шалтгаанаар гарч буй хямрал бүхэн нь энх тайван аюулгүй байдалд заналхийлж байх ёстой биш юм. Аливаа нийгэмд хэлэлцэгдэж байгаа асуудлууд бие биенийгээ буруушаасан, өөр хоорондоо зөрчилдсөн олон янзын үзэл баримтлалууд байж болно. Ардчилсан нийгмийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг нь ард иргэд өөрсдийн сонгосон төлөөллөөр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэхэд оршино. Харин төлөөлж буй хүмүүс нь үүсэн гарч ирж буй асуудлуудыг хэлэлцүүлэх, эдгээрийг олон нийтийн хэлэлцүүлгээр шүүн хянуулах үүрэг хүлээдэг. Ардчилсан нийгмийн энэхүү үйл явц нь хямралыг намдаах, мөн нийгмийн хэмжээнд олонхийн дэмжлэг хүлээж болохуйц шийдвэр гаргах боломжийг эрэн хайхад дөхөмтэй болгоно. Үйл ажиллагаа нь зөв явагдах ардчилсан зохион байгуулалт байхгүй тохиолдолд аливаа асуудалд тавих хяналт алдагдаж, эцэст нь хүч хэрэглэсэн тэмцэлд хүрэх нь элбэг байдаг. Иймээс ардчилсан нийгэмд хямралыг зохицуулах механизмыг бий болговол, энэ нь энх тайван, аюулгүй байдал бий болох нөхцөл байдалтай шууд хамааралтай байна.

Энэхүү хамаарал нь бас өөр нэг шалтгааны улмаас бий болдог. Аюулгүй байдал бол эцсийн зорилго биш, энэ нь ард

иргэдийн тайван амьдралыг цогцлуулж өгөх арга зам гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Парламентын үйл ажиллагаанд тулгуурласан ардчилсан нийгэм энэ санааг амьдралд хэрэгжүүлэхэд хамгийн дөхөмтэй хэлбэр юм.

“Улс орон, бус нутгийн үндэсний тусгаар тогтнол нь цорын ганц эрхэм зүйл болох хүний халдашгүй дархан байдлыг бий болгон, үүндээ тулгуурлан, уялдуулан бий болгосноор биелэлээ олно” Vaclav Havel.

Үндэсний аюулгүй байдал, үүний үндсэн зорилго болох улс орныг хамгаалах үйлс нь хувь хүн, хамтын бүлэглэлийг тэргүүн зэрэгт тавьсан хүний аюулгүй байдлаар тодорхойлогдоно. Аюулгүй байдалд учирч болох аюул заналхийлэлд цохилт өгөх бодлогын хүрээг дараахь байдлаар өргөжүүлсэн:

- ✓ **Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа:** хямрал намжаах хүн төвтэй бодлого, энх тайвны төлөө үйл ажиллагаа зэрэг хямралаас урьдчилан сэргийлэх санаачилга,
- ✓ **Оролцоо:** Бусад арга зам мухардсан онцгой тохиолдолд ард иргэдийг илүү их эрсдэлд өртөхөөс сэргийлэх зорилгоор дотоодын хямралд оролцох,
- ✓ **Хариу цохилт:** Иргэний дайн ба зэвсэгт мөргөлдөөний үеэр, эсвэл түүний дараа дайнд нэрвэгдсэн энгийн номхон ард иргэдийг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулах. Үүнд гэр оронгүй болсон хүмүүст зориулсан хуаран барих, дүрвэгсдийг орогнох газраар хангах, түр орогнуулах зэрэг ажил багтана.

Цэргийн аюулгүй байдлын ухагдахуунаас нэгдмэл аюулгүй байдлын ухагдахуунд шилжих нь

Хүний аюулгүй байдалд анхаарсан шинэ бодлогод шилжсэнээр энэ нь зөвхөн цэргийн талаас анхаарч боловсруулсан аюулгүй байдлын үзэл баримтлалыг өөрчлөх шаардлагатай болно. Аюулгүй байдлын асуудал нь цэргийн бус хүчин зүйлийг тусгасан нэгдмэл, иж бүрэн байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх нь улам л ихэссээр байгаа билээ (Тодруулга №1-ийг үзнэ үү).

Тодруулга №1

Өнөө үед аюулгүй байдалд учирч болох заналхийлэл (дангаараа буюу хоорондоо уялдсан хэлбэрээр . . .)

- ▷ Дотоод дахь улс төрийн тогтворгүй байдал, төрийн эргэлт, алан хядлага, хүний эрхийг хөсөрдүүлэх гэх мэт улс **төрийн аюул заналхийлэл**;
- ▷ Ядуурал, баян хоосны ялгаа ихэсч буй улсууд, дотоодын санхүүгийн хүчин чадлын доройтол, эдийн засгийн хувьд хүчирхэг буюу тогтворгүй хөрш зэргэлдээ улс орны хэт нөлөөлөлд автах, хуурамч бараа үйлдвэрлэх зэрэг **эдийн засгийн аюул заналхийлэл**;
- ▷ Цөмийн аюул, дэлхийн нийтээр учирч буй экологийн өөрчлөлтүүд, газар эзэмшилт болон усны хэмжээ багасах, хоол хүнс тэжээл бусад зүйлийн хомсдол гэх мэт **байгаль орчин, хүнээс үүдэлтэй аюул**;
- ▷ Үндэсний олонхийн болон цөөнхийн хоорондын маргаантай асуудлууд, хүн амын хэт өсөлт, зохион байгуулалттай гэмт хэрэг, хил дамжуулсан хар тамхины наймаа, хууль бус наймаа, хяналтаас гадуур их хэмжээгээр дүрвэх, цагаачлах, өвчин дэлгэрэх гэх мэт **нийгмийн хүрээг хамарсан аюул заналхийлэл** нүүрлэж болох юм.

Аюулгүй байдлын үзэл баримтлалыг өргөн утгаар авч үзсэнээр аюулгүй байдалд учирч буй аюул заналхийлэл, үүнд хэрхэн хариу өгч болохыг бүрэн гүйцэд ойлгоход дөхөмтэй болох давуу талтай юм. Нөгөө талаар аюулгүй байдлыг хангах үйлчилгээ үзүүлэх байгууллагууд нь иргэд, улс орноо хамгаалах зорилгоор хүч хэрэглэх болон хүч хэрэглэх тушаал өгөх хууль ёсны эрхтэй болсноор нийгэм дэх цэргийн бус салбарууд хэт хүчирхэгжих сөрөг талтай юм. Үүнээс гадна аюулгүйн салбар нь энэхүү шинээр гарч ирж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хүрэлцэхүйц туршлага мэдлэггүй байж болох талтай.

Улс орон бүрийн бие даасан аюулгүй байдлын үзэл баримтлалаас улс орнуудын аюулгүй байдлын хамтын ажиллагааны үзэл баримтлалд шилжих нь

Үндэсний аюулгүй байдлыг зөвхөн ганц улс өөрийн хүчин чармайлтаар хангаж чадахгүй, олон улс аюулгүй байдлын талаар хамтран ажилласнаар энэхүү зорилгодоо хүрч чадна

гэсэн санаа нь дээр үеэс улбаатай юм. XIX зуунд гэхэд л хүчний тэнцвэртэй байдал гэдэг ухагдахуун их дэлгэрч байлаа. XX зуунд Үндэстнүүдийн Лиг, үүний залгамжлагч болох Нэгдсэн Үндэстний Байгууллага зэрэг аюулаас хамгаалах салбарт хамтран ажиллах байгууллагууд олноор төрөн гарсан. Үүний зэрэгцээ батлан хамгаалах салбарт хамтран ажиллах НАТО байгуулагдсан.

Хүйтэн дайны сүүлчээс эхлэн дотоодын хямралууд гарах нь элбэгшсэн. Сүүлийн үед алан хядлага болох терроризмын тухай мэдээллүүд сонины тэргүүн нүүрийг чимэх боллоо. Мөн даяаршлын нөлөөгөөр улс орнуудын хоорондын харилцаа эрчимжсэн нь аюулаас хамгаалах салбарыг мөн л тойрсонгүй. Өнөө үед аливаа нэг улс оронд учирч буй заналхийлэл нь тухайн улсын хөрш орнуудад нөлөөлж үүгээрээ бүс нутгийн, тэрчлэн дэлхийн энх амгалан байдлыг тогтворгүйжүүлэх аюултай юм. Энэхүү шинээр үүсэн гарч ирж буй бодит байдал, үүний зэрэгцээ аюулгүй байдлын тухай ухагдахууныг өргөн утгаар ойлгох болсноор олон улсын аюулгүйн салбарт хамтран ажиллаж байгаа байгууллагуудад шинэ эрч хүч өгсөн юм

Тодруулга №2

Аюулгүй байдлын асуудлаарх тохиролцоонууд

▷ Батлан хамгаалах хамтын үйл ажиллагаа

Батлан хамгаалах хамтын үйл ажиллагаа нь хэлэлцээрийн гишүүн аль нэг орон нь гадны халдлагад өртсөн тохиолдолд бие биедээ харилцан туслалцах талаар тохиролцсон хоёр орон хоорондын хэлэлцээр хэмээн тодорхойлогдсон байдаг.

▷ Хамтын аюулгүй байдал

Энэ үйл ажиллагаа нь эвсэлд нэгдсэн улсууд өөр хоорондоо хүч хэрэглэхээс татгалзаж эвслийн аль нэг улсад халдан довтолсон тохиолдолд тусламж үзүүлэхээр тохиролцсон байдаг. Олон улсын хамтын нийгэмлэгүүдийн хувьд энэ тохиролцоо нь энх амгалан байдлыг алдагдуулах зөрчил гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах нэг арга хэлбэр юм. Хамтын аюулгүй байдлын ухагдахуун нь эвслийн гишүүн орнуудын өөр хоорондын халдлагын эсрэг чиглэсэн байдгаараа хамтын батлан хамгааллын ухагдахуунаас ялгагддаг. НҮБ бол хамтын аюулгүй байдлын ухагдахууны практикт хэрэгжиж буй нэг тод жишээ юм. НҮБ-ын Дүрмийн 41, 42 дугаар зүйлд зааснаар эвслийн гишүүд нь энх

тайван байдал алдагдуулагчийн эсрэг цэргийн бус эсвэл цэргийн хүч хэрэглэх аргаар шахалт үзүүлэхийг зөвшөөрсөн байдаг.

Эх сурвалж: *Simma, Bruno: НҮБ-ын дүрэм, 1995*

▷ **Аюулгүй байдлын хамтын ажиллагаа**

Аюулгүй байдлын хамтын ажиллагааны систем нь хамтын аюулгүй байдлын ухагдахууныг нэгдмэл аюулгүй байдлын ухагдахуунтай уялдуулж өгдөг. Аюулгүй байдлын хамтын ажиллагаа нь үүрэг даалгаврын хувьд олон талтай бөгөөд айлган цочоохоос илүү хурцадмал байдлыг намжаах, гишүүдийн хувьд хязгаарлалтгүй, үйл ажиллагааг хязгаарлахаасаа илүү өргөжүүлэх, олон улсын хоорондын үйл ажиллагааг илүүтэй эрхэмлэх, аливаа асуудлыг дайны аргаар шийдэхгүй байхыг эрмэлзэх, тусгаар улсууд нь аюулгүй байдлын тогтолцооны голлох гишүүд байхыг хүлээн зөвшөөрсөн, харин өөр шатны төлөөлөгчид чухал үүрэг гүйцэтгэж болохыг үгүйсгэхгүй, мөн аюулгүй байдлыг хангах албан ёсны байгууллага бий болгохыг шаардахгүй боловч, ийм байгууллага байж болно гэдгийг үгүйсгэхгүй, олон улсын тавцанд харилцан бие биеэ ойлголцох дадал бий болгохыг юунаас илүү эрхэмлэхэд чиглэсэн аюулгүй байдлын тухай үзэл баримтлал юм.

Эх сурвалж: *Evans Gareth: Энх тайвны төлөө хамтран ажиллахуй, 1993.*

Хамтын батлан хамгаалах ажиллагааны тохиролцоо нь хамтын ажиллагааны хамгийн түгээмэл хэлбэр юм. Үүний хажуугаар аюулаас хамгаалах салбарын хамтын ажиллагааны хэлбэрүүд нь хоёр буюу хоёроос дээш орны хоорондын тохиролцоон дээр үндэслэгддэг боловч албан ёсны буюу гүйцэтгэх цэргийн байгууллагагүй байсаар байна.

Аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах зорилго бүхий байгууллагууд ялангуяа хамтын батлан хамгаалах үйл ажиллагаа явуулах зорилго бүхий байгууллагад элсэх шийдвэр гаргаснаар улс орны аюулгүй байдлын нөхцөл байдалд маш их өөрчлөлт ордог. Үнэндээ иймэрхүү хамтын ажиллагаа нь гадны аюул заналхийллийн эсрэг хамтын хүч бий болгож байгаагаар улс орны үндэсний аюулгүй байдлыг дээшлүүлнэ. Гишүүн болсноор тухайн зорилго, шаардлагад нийцсэн бодлого явуулах ёстой нь мэдээж бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах салбарын бодлогыг тодорхойлоход хязгаарлагдмал хүрээ бий болно. Түүнчлэн парламентын зүгээс тавих хяналтын нэг хэлбэр болох шийдвэр гаргах үйл явцын тодорхой нэг хэсэг нь үндэсний асуудлаас халин гарч олон улсын асуудал болж хувирдаг.

2 дугаар бүлэг

Парламентаас тавих хяналтын ач холбогдол

Төрийн гүйцэтгэх байгууллагууд нь шаардлагатай мэдээллээр хангагдсан, үүний зэрэгцээ гүйцэтгэх чадвар өндөр, түргэн байдгаас үндэсний аюулгүй байдлын бодлого нь эдгээр байгууллагуудын үндсэн үүрэг байх ёстой гэсэн үзэл санаа нийтлэг байдаг. Парламент нь үйл ажиллагаандаа цаг их зарцуулдаг, хэрэгцээт мэдээлэл, мөн мэргэжлийн мэдлэг туршлагатай боловсон хүчингүй байдгаас аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хариуцсан байгууллага байх нь зохимжгүй гэж үзэх тал бий. Парламент нь улс төрийн бусад бодлогод хяналт тавьдаг гүйцэтгэгч байгууллагуудыг хянах үүрэгтэй. Парламентаас аюулаас хамгаалах салбарт хяналт тавих шаардлагатай гэдгийг харуулсан дөрвөн шалтгаан байдаг.

Хараа хяналтгүй дэг журам тогтохоос урьдчилан сэргийлэх нь ардчиллын тулгын чулуу

Францын ерөнхий сайд агсан Georges Clemenceau “*Дайн бол зөвхөн цэргийн хүчинд даатган орхиж болохооргүй чухал асуудал юм*” гэж хэлсэн байдаг. Хэдийгээр энэ нь хошин, явган яриа төдий боловч, цаад утгаараа ардчилсан нийгэм дэх төрийн дээд эрхийг иргэдийн төлөөлөгчид гартаа барьж байх ёстой бөгөөд парламентын хяналтаас гадуур улсын ямар ч салбар байх ёсгүй юм гэдгийг сануулж байгаа билээ. Улсын аюулаас хамгаалах салбар, тэр тусмаа зэвсэгт хүчин парламентын хяналтад байхгүй бол энэ нь ардчилсан нийгэм төгс бүрдээгүй байгааг, эсвэл ардчилал бүтээн байгуулах шатандаа байгаа гэж үзэж болох талтай.

Америкийн нэрт эрдэмтэн Robert A.Dahl хэлснээр “*улс төрийн хүрээнд байнга тулгарч байдаг хамгийн ноцтой асуудал бол хараа хяналтгүй дэг журам үүсэн бий болохоос сэргийлэхэд оршдог*”. Аюулаас хамгаалах салбар нь аливаа төр засгийн үндсэн үүрэг аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагаатай нягт уялдаатай байдаг учраас гүйцэтгэх

байгууллагын эрх мэдлийг тэнцвэржүүлэх хяналтын системийг бий болгох нь чухал. Аюулаас хамгаалах салбарт парламентын хяналтыг тогтоож өгснөөр улсын төвшинд хүчний хуваарилалтыг бий болгож, гүйцэтгэгч байгууллагууд болон ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлаж өгдөг.

Төлөөлөх эрхгүйгээр татвар татах эрх байдаггүй

Орчин үед гүйцэтгэх байгууллагуудыг хянах хамгийн үр дүнтэй хэлбэр нь эдгээрийн төсвийг хянах ажиллагаа байдаг. Баруун Европт ардчилал анх хөгжиж ирсэн тэр цагаас хойш парламентууд нь улс төрийн асуудалд “Төлөөлөх эрхгүйгээр татвар татах эрх эдэлдэггүй” гэсэн лоозонг мөрдлөг болгодог. Аюулаас хамгаалах салбарын байгууллагууд нь улсын төсвийн томоохон хэсгийг зарцуулдаг учир парламентын зүгээс энэхүү санхүүгийн эх сурвалж зөв зохистой, эдийн засгийн хувьд үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэхийг хянах зайлшгүй шаардлагатай.

Аюулаас хамгаалах асуудалд хууль ёсны хэм хэмжээг бий болгох нь

Практик амьдралд аюулаас хамгаалах салбартай холбогдол бүхий хууль тогтоомжийг боловсруулагчид нь хэрэгжүүлэх шатны байгууллагууд байдаг. Гэсэн хэдий ч парламентын гишүүд нь дээрх хуулийн төслүүдийг хянан боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд парламентын гишүүд нь хуулинд өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй байдгаараа шинэ хуулийн заалтууд нь аюулаас хамгаалах салбарт гарч буй шинэ үзэл бодлыг тусгаж чаддаг. Мөн хууль гэдэг нь зүгээр нэг товхимол бичиг биш, амьдралд бүрэн хэрэгжих ёстой юмаа гэдгийг парламент нь үйл ажиллагаараа харуулдаг.

Ард түмэнтэй холбох гүүр

Гүйцэтгэгч байгууллагууд аюулаас хамгаалах салбарын талаар ард түмний дунд байгаа үзэл бодлын талаар зохих мэдээллийг авч чаддаггүй байж болох талтай. Парламентын гишүүд нь нийт ард түмэнтэй холбоотой байж тэдний үзэл бодлыг ойлгож, баттай мэдээлэл авах бололцоотой. Үүгээрээ парламентын гишүүд нь иргэдийн санал хүсэлтийг

парламентад байнга уламжилж, аюулгүй байдлын тухай хууль дүрэм, бодлогод тусгагдаж байгаа эсэхийг хянаж байх бололцоотой юм.

Парламентаас аюулаас хамгаалах салбарт тавих хяналтад гарч ирж буй шинэ шаардлагууд

Аюулаас хамгаалах салбартай холбогдол бүхий гурван чухал асуудал нь парламентын зүгээс тавих хяналтад гарч буй шинэ хүчин зүйлүүдийг харуулж байна.

Нууцлалын тухай хууль нь аюулаас хамгаалах салбарт ил тод байдал бий болоход саадтай байж болох юм. Ялангуяа ардчилал дөнгөж хөгжиж буй орнууд болон дотоодын хямрал байнга болж байдаг орнуудад нууцлалын тухай хууль гаргаснаар аюулаас хамгаалах салбарт парламентаас тавих хяналтыг хязгаарлах буюу үгүйсгэх аюултай байж болох юм. Энэ нь мэдээллийн эрх чөлөөг хуульчлан баталгаажуулаагүйгээс болдог.

Аюулаас хамгаалах салбар нь зэвсэг худалдан авах, зэвсэгт хяналт тавих, зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн бэлэн байдалд хяналт тавих зэрэг маш төвөгтэй асуудалтай салбар билээ. Парламентын гишүүд хангалттай мэргэжлийн мэдлэг туршлага байдаггүйгээс аюулгүй байдлын салбарын асуудалд үр өгөөжтэй шийдвэр гаргах нь ховор байдаг. Цаг хугацааны хувьд хавчигдмал байдгаас дээрх асуудлыг хөөцөлдөх зав, боломж муу, нөгөө талаас дотоодын болон гадаадын эх сурвалжаас мэдээлэл авах боломж бага байдаг.

Олон улсын хэмжээний хамтын үйл ажиллагаанд парламентыг татан оролцуулаагүйгээс улс орны ардчилсан ёс зүй, ил тод байдалд сөргөөр нөлөөлж болох талтай. Иймээс парламент олон улсын тавцанд шийдэгдэх асуудалд байр сууриа илэрхийлж, шийдвэр гаргахад оролцох нь чухал юм.

3 дугаар бүлэг

Парламентын болон улсын бусад байгууллагуудын үүрэг, хариуцлага

Хамтын хариуцлага

Засгийн газар, парламент нь аюулаас хамгаалах салбарт тус тусын үүрэг хариуцлагатай байдаг боловч аюулаас хамгаалах салбарын саадгүй үйл ажиллагаанд хамтын хариуцлага хүлээнэ. Энэхүү хамтын хариуцлага нь улс төрчид, цэргийн эрх мэдэлтнүүдийн хувьд мөн адил хэмжээгээр үйлчилнэ. Тэдгээрийг эсрэг тэсрэг зорилго бүхий өрсөлдөгчид гэж ойлгож хэрхэвч болохгүй бөгөөд харин ч үр өгөөжтэй, иж бүрэн, хүн төвтэй аюулаас хамгаалах бодлого явуулахад хамтдаа хүчин зүтгэх үүрэгтэй субъектүүд гэж үздэг. Тиймээс ардчилсан хяналтаар улс төрийн лидерүүд болон дээд албан тушаалын офицеруудын хооронд харилцан итгэлцэл, ил тод байдал, нөхөрсөг харилцаан дээр тулгуурласан харилцан ойлголцлыг бий болгох нь чухал. Ийнхүү байнга санал сэтгэгдлээ солилцсоноор улс төрчид, цэргийн эрх мэдэлтнүүд хамтран ажиллаж, тогтвортой байдлыг бий болгож чадах давуу талтай.

Гүйцэтгэх үүргийн хуваарилалт

Төрийн гурван салбар болох хууль тогтоох, хууль хэрэгжүүлэх, хууль хянах байгууллагууд нь үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтэд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Тодруулга №3 дахь гурван байгууллага тус бүрийн гүйцэтгэх үүргийг төрийн гүйцэтгэх байгууллагын – төрийн тэргүүн, засгийн газар, жанжин штабын - ажлын хүрээнд тодорхойлов. Энэ хүснэгт нь улс төрийн тогтолцоог ерөнхий тоймчлон харуулахыг зорьсон учир улс орон бүр улс төрийн тогтолцооны хувьд ялгаатай байж болохыг үгүйсгээгүй юм.

Парламент, шүүх хяналтын байгууллага, гүйцэтгэгч байгууллагуудын хажуугаар иргэний нийгмийн тогтолцоо

аюулгүй байдлын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн намуудын гүйцэтгэхээр зэхэж буй үйл ажиллагааг олон түмэнд мэдээлснээр өөрийн хувь нэмрээ оруулдаг (6 дугаар бүлгийг харна уу).

Эцэст тэмдэглэхэд үндэсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтэд Омбудсмен (16 дугаар бүлгийг харна уу), болон Ерөнхий Аудит (24 дүгээр бүлгийг харна уу) гэсэн хоёр байгууллага маш чухал үүрэгтэй байдаг.

Улс төрийн тайлагнал

Үндэсний аюулгүй байдлын алба нь төрийн гол гурван салбарын байгууллагуудад ажлаа тайлагнах ёстой байдаг:

- ✓ **Хууль гүйцэтгэх байгууллагууд** нь засгийн газрын дээд, дунд шатны гүйцэтгэх байгууллагуудын төвшинд шууд хяналт тавьж, аюулгүй байдлын албаны төсөв, ерөнхий чиг үүрэг, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл зэргийг баталдаг.
- ✓ **Хууль тогтоох байгууллага** нь аюулаас хамгаалах албаны эрх мэдлийг хуулийн дагуу тогтоон өгч, төсвийн зохистой харьцааг тодорхойлох замаар парламент хяналт тавьдаг. Иймэрхүү хяналтад парламентын дэргэд омбудсмен, комисс томилж иргэдийн зүгээс ирсэн гомдлын дагуу судалгаа явуулах ажил бас хамрагдана.
- ✓ **Хууль хяналтын байгууллага** нь аюулаас хамгаалах салбарт хяналт тавихын зэрэгцээ шаардлагатай бол төрийн албаны хүмүүсийн буруутай үйл ажиллагааг иргэний болон эрүүгийн хуулийн дагуу шүүн таслана.

Тодруулга 3

Аюулаас хамгаалахад улсын үндсэн гол салбаруудын гүйцэтгэж болох магадлалтай үүргүүд

	Парламент	Хууль хяналтын байгууллага		Хэрэгжүүлэн гүйцэтгэгч	
			Төрийн тэргүүн	Сайд нарын танхим	Бүх Цэргийн Жанжин
Дээд удирдлага	Зарим оронд парламент мэтгэлцэн хэлэлцээд цэргийн дээд удирдлагыг томилдог	Үндсэн хуулийн цэц ерөнхийлөгч ба сайд нарын танхимыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд үндсэн хуулийн дагуу тохирох эсэхэд үнэлгээ өгдөг	Зарим оронд төрийн тэргүүн зөвхөн ёс төдий үүрэгтэй байдаг бол дайны үед Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэх зэрэг бодит эрх мэдэлтэй байдаг	Дайны үед төрийн удирдлага Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн үүрэгтэй байдаг	Зарим оронд Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн орон тоо зөвхөн дайны үед байдаг бол бусад оронд энэ албан тушаал байнгын байна
Аюулгүй байдлын бодлого	Батлан хамгаалах зарчмын талаар мэтгэлцэх ба баталдаг, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг		Аюулгүй байдлын бодлогтой холбогдсон хууль тогтоомжид гарын үсэг зурна.	Аюулгүй байдлын бодлогыг санал болгон хэрэгжүүлнэ	Аюулгүй байдлын бодлогын хувьд төр засагт зөвлөнө, төлөвлөн, зохих туслалцаа үзүүлэн хэрэгжүүлнэ
Төсөв	Төсөв батална			Төсөв санал болгоно	Төр засагт зөвлөнө
Батлан хамгаалах хууль тогтоомж	Хууль тогтоомж батална	Үндсэн хуулийн цэц хууль тогтоомжийг үндсэн хуулинд нийцүүлнэ	Хууль тогтоомжийн тунхаглан хүчин төгөлдөр болохыг батлан гарын үсэг зурна	Хууль тогтоомжийг санал болгох ба тогтоол шийдвэрийг батална	Төр засагт зөвлөх ба хуулийг хэрэгжүүлнэ

Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт

Бие бүрэлдэхүүн	Зарим оронд парламент үндсэн гол албан тушаалуудын томилолтыг батлах эрх мэдэлтэй байдаг	Тэдгээрийн биеэ авч явах байдал хуулинд зохицож байгаа эсэхийг шийднэ.	Гол цэргийн удирдлагыг томилоно; Боловсон хүчний төлөвлөгөөг батлана.	Гол цэргийн удирлагыг томилоно.	Боловсон хүчний төлөвлөгөөнд зөвлөлтөгөө өгнө; боловсон хүчний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ; бага тушаалын цэргийн дарга нарыг томилно.
Хангамж	Гол чухал зэр зэвсгийн хангамжийн төлөвлөгөөг хянаж батална	Авилгал, хахууль болон залилан мэхлэлийн шүүхийн хуулинд гаргасан зөрчлийг шүүнэ		Зэр зэвсгийн хангамжийг санал болгоно	Зэр зэвсгийн хангамжийг санал болгон хэрэгжүүлнэ
Гадагш цэрэг илгээх / Гадны цэргийг байрлуулах	Урьдчилсан баталгаа, дараагийн шатны баталгаа эсвэл ямар нэгэн баталгаа шаардлагагүй	Тэдгээрийн биеэ авч явах байдал хуулинд нийцэж буй эсэхийг шүүнэ	-	Олон улсын оролцоог хэлэлцэн, оролцох байдлын журмыг шийднэ	Үйл ажиллагааг захирч явуулах
Олон улсын гэрээ хэлэлцээр, гэрээ хэлэлцээрт бүлэглэлд элсэх	Батлах		Олон улсын гэрээ хэлэлцээрийг байгуулна	Үндэстэн хоорондын гэрээ хэлэлцээрийн хариуцлагыг хүлээнэ	Төр засагт зөвлөлтөгөө өгнө

Дээр дурдаж байсанчлан төрийн хүчний гурван салбарын үүрэг оролцоо орон бүрт харилцан адилгүй байж болох юм. Гэсэн хэдий ч аюулаас хамгаалах салбарт улс төрийн эрх мэдлийг буруугаар ашиглахаас хамгаалах зорилгоор хүчний харьцааг тэнцвэржүүлэх, хянах улс төрийн эрх мэдлийн тогтолцоо байх нь зайлшгүй чухал юм. Ихэнх оронд засгийн газар нь аюулаас хамгаалах салбарт голлох үүрэг

оролцоотой байдгийг харгалзан парламентад хяналт тавих эрх мэдэл, бололцоогоор хангаж өгөх нь зохистой. Энэ бүхэн нь 1 дүгээр бүлэгт дурдсан аюулаас хамгаалах салбарт гарч ирж буй шинэ шаардлагын улмаас олон нийтийн байгууллагууд өөрсдийн үүргийг шинээр тодорхойлохтой холбогдон улам илүү ач холбогдолтой болно.

Парламентаас хяналт тавих ардчиллын зарчим

Аюулаас хамгаалах, батлан хамгаалах асуудлууд нь үндэсний дотоод бодлогын асуудалд хамаарагдана гэж үздэгийн улмаас парламентаас тавих, ардчилсан хяналтын талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт байдаггүй. Харин бүс нутгийн хувьд тохиролцоонууд байдаг, Жишээлбэл Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн үйл ажиллагааны дүрэм (тодруулга №66-аас харна уу). Мөн ардчилсан нийгмийн цэрэг, иргэний харилцааг зохицуулсан тодорхой зарчмууд байдаг. Үүнд:

- ✓ Аливаа нийгэмд хүч хэрэглэх хууль ёсны эрх бүхий цорын ганц төлөөлөгч нь төр байна. Аюулаас хамгаалах албад нь хууль ёсны эрх бүхий, ардчилсан зарчмаар сонгогдсон байгууллагуудад тайлагнах үүрэгтэй байна;
- ✓ Парламент нь бие даасан байх ба гүйцэтгэгч байгууллага нь аюулаас хамгаалах болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт шалгалтын ажлын талаар парламентад тайлагнана;
- ✓ Зөвхөн парламент л батлан хамгаалах, аюулаас хамгаалах салбарын төсвийг батлах, үүнд хяналт тавих эрхийг үндсэн хуулийн дагуу эдэлнэ;
- ✓ Парламент нь онцгой байдал, дайны цагийн байдал зарлах, хүчингүй болгоход гол үүрэг гүйцэтгэнэ;
- ✓ Сайн удирдлагын зарчим болон хуулийн заалтууд засгийн газрын бүх салбарт хамааралтай байдаг тул аюулаас хамгаалах салбарт ч мөн хамаарна;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын ажилчид нь үндэсний болон олон улсын хууль дүрэм зөрчсөн бол хуулийн өмнө өөрийн биеэр хариуцлага хүлээнэ;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын байгууллагууд нь улс төрийн хувьд төвийг сахисан бодлого баримтлана.

Тодруулга № 4

Сайн засаглал нь аюулаас хамгаалах салбарт парламентын хяналт тавихад эрхэмлэх зүйл

Сайн засаглал нь урьдчилан харж болох, нээлттэй, гүйцэд боловсруулсан улс төрийн бодлого байх бөгөөд олон нийтийн ашиг сонирхлыг дэмжихийн төлөө, хуулийн дагуу ил тод үйл ажиллагаа явуулдаг, олон нийтийн асуудалд иргэдийн оролцоог идэвхжүүлэхэд чиглэсэн удирдлагын тогтолцоо байна. Үүний эсрэгээр муу засаглал гэдэг нь хэн нэгний ашиг сонирхлыг илэрхийлсэн улс төрийн бодлоготой, хууль эрх зүйн тогтолцоо нь эрх тэгш бус буюу шийдвэр гүйцэтгэх чадваргүй, төрийн гүйцэтгэх байгууллагууд эрх мэдлээ буруугаар ашигладаг, олон нийтийн амьдралд иргэдийн оролцох бололцоог хангасан иргэний нийгэм төлөвшөөгүй, хээл хахуульд хэт автсан зэрэг шинж чанараар тодорхойлогддог.

Эх сурвалж: Дэлхийн Банк, 1994, Засаглал: Дэлхийн Банкны Туршлагаас, Вашингтон.

Аюулаас хамгаалах салбарт тавих ардчилсан хяналт нь сайн удирдлагад эрхэмлэх нэг гол зарчим юм.

*Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт
тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт*

II ХЭСЭГ

Үндэсний аюулгүй байдлын бодлогод тавих хяналт

4 дүгээр бүлэг

Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулах нь

Тусгагдах зүйлс

Үндэсний аюулгүй байдлын бодлого нь засгийн газрын аюулгүй байдалд хандах хандлага, аюулгүй байдлыг хэрхэн хангах арга барилыг тодорхойлдог. Үндэсний аюулгүй байдлын бодлогод төр, нийгмийн гадаад, дотоод аюулгүй байдлыг хөндсөн аюулгүй байдлын голлох асуудлууд багтдаг. Энэ нь аюулгүй байдлын талаар тодорхойлсон арга барил дээр үндэслэгдсэн байх бөгөөд цэргийн бодлогын чиглэл болж, тухайн улс гишүүнчлэлд нь багтдаг олон улс, бүс нутгийн эвслийн зохицуулалтын хүрээнд боловсруулагдсан байна. Иймээс үндэсний аюулгүй байдлын бодлого нь зөвхөн үндэсний аюулгүй байдалд үүсч бий болох хэрэгцээ, шаардлага дээр бус, гадны олон төрлийн хүчин зүйл, шахалт, хүлээх ёстой үүрэг хариуцлагыг харгалзан үзсэн байх ёстой юм. Ямар ч болов үндсэн хуульд заагдсан зарчим, дээдлэн эрхэмлэх эрхэм зүйлсийг хатуу чанд мөрдлөг болгодог.

Тодруулга №5

Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар асуухуй

Үндэсний аюулгүй байдлын бодлого хэлэлцэх, батлах, үүнээс гадна онцгой нөхцөл байдалд түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хэлэлцэхдээ, ард түмний төлөөлөгчид нь доорх асуудлуудыг нэг бүрчлэн буюу хэсэгчлэн хэлэлцэж үзсэн байх шаардлагатай. Үүнд:

- ✓ Ямар аюул заналхийллийн үед нийгмийг хамгаалах ёстой вэ? Юуг, хэнийг нэн түрүүн хамгаалах ёстой вэ? Түүнчлэн, аюулгүй байдлын ямар хэлбэр шаардлагатай вэ?
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого нь зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм гэх мэт шинээр үүсэн гарч буй эрсдэлүүдийг хянан үзэх ёстой гэж үндэсний аюулгүй байдлын бодлогод тусгагдсан байх шаардлагатай юу?
- ✓ Аюулгүй байдлын хэр хэмжээ ямар байх шаардлагатай вэ?

- ✓ Үндэсний аюулгүй байдлыг хэрхэн хангах нь илүү өгөөжтэй вэ? Аливаа нэг эвсэлд нэгдсэнээр үү? Эсвэл төвийг сахисан байр суурь баримталснаар уу?
- ✓ Үндэсний аюулаас хамгаалах хүчин ямар төрлийн үйл ажиллагаа явуулах ёстой вэ? Зөвхөн батлан хамгаалах ажиллагаа юу? Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөх эсэх?
- ✓ Аюулгүй байдлын хэрэгцээт төвшинг хангахын тулд ямар хэрэгсэл, ямар салбарыг татан оролцуулах шаардлагатай вэ? Ямар хугацаагаар, ямар болзлоор?
- ✓ Аюулгүй байдлын бодлогыг ямар давтамжтай хянаж байх шаардлагатай вэ?
- ✓ Санхүүгийн болон эдийн засгийн хувьд асуудлыг хэрхэн шийдэх, татвар төлөгчид хэдий хэмжээний татварыг төлөх ёстой вэ?
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлснээр гадаад харилцаа болон бүс нутгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөх вэ?
- ✓ Үй олноор хөнөөх зэвсгийн талаар баримтлах үндэсний стратегийн одоогийн байр суурь, ирээдүйн хандлага ямар байх вэ?

Ихэнх улсын агентлагууд, албан газрууд Үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулалтад улс төрийн бодлогын тухай бусад бичиг баримтуудыг хэрэглэх шаардлагатай болно. Ийм учраас аливаа улс нь үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахдаа иж бүрэн нэгдмэл болгож, холбогдох бүхий л газрууд, үзэл баримтлалуудад тусгагдсан байхаар хийсэн байх шаардлагатай. Энэ арга нь засгийн газар аюулгүй байдлын ухагдахуунтай холбогдох бүхий л зүйлийг иж бүрнээр, нэгдсэн нэг цөм болгон авч үзэх боломжоор хангана. Терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг шинээр гарч ирж буй эрсдэлүүдтэй тэмцэхэд Зэвсэгт хүчин, сангийн яам, цагдаагийн байгууллага, хилийн цэрэг, тагнуулын гэсэн олон газрыг хамруулах шаардлагатай болж байна.

Парламентын оролцооны ач холбогдол

Парламент нь иргэдийн эрх ашиг, хүсэл сонирхлыг төлөөлөх байгууллагын хувьд Үндэсний Аюулгүй байдлын бодлого, төлөвлөлтөд парламентын оролцоог шаардахын зэрэгцээ парламентаар батлуулах шаардлагатай байдаг. Үүнд:

- ✓ Үндэсний Аюулгүй байдлын бодлого нь иргэдийн амь нас, амгалан тайван байдал, тэдний эрхэмлэх зүйлст

- нөлөөтэй байж болох учраас зөвхөн Засгийн газар буюу Зэвсэгт хүчний асуудал биш байдаг.
- ✓ Үндэсний Аюулгүй байдлын бодлого нь Зэвсэгт хүчин болон түүний ажилтан албан хаагчдын ирээдүй хойчид чухал үр дагавартай байна.
 - ✓ Үндэсний Аюулгүй байдлын бодлого нь санхүүгийн үр дагавартай байдаг бөгөөд энэ нь татвар төлөгчдийн мөнгөнөөс санхүүждэг.
 - ✓ Санхүүгийн зардлаас гадна аюулаас хамгаалах арга хэмжээ нь иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж, ардчилалд ямарваа нэг хэлбэрийн нөлөөлөл учруулж болох юм.

Үндэсний аюулгүй байдлын бодлогын боловсруулалтын төвшин дэх парламентын гүйцэтгэх үүрэг

Үндэсний аюулгүй байдлын бодлогын тухай асуудал нь парламентын хувьд нэг удаагийн бус, боловсруулалт, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, шалгах гэсэн дөрвөн үе шатыг дамжсан үйл явц юм. Парламент нь хэдийгээр төсөл боловсруулах, бодлого хэрэгжүүлэх гээд Засгийн газар болон хэрэгжүүлэгч байгууллагуудын ажилд оролцох эрхгүй ч энэ үйл явц аль болох ил тод, хамтын оролцооны хэлбэрээр явагдаж, энэ үйл ажиллагаанд нөлөөлж болох бүхий л байгууллагуудын тэнцвэрт байдлыг хангасан хэлбэрээр явагдах ёстой.

Аль ч шатанд байсан парламентын гишүүд нь иргэдийн эрх ашиг, хүсэл сонирхлыг хэрэгжүүлэгч байгууллагуудад илэрхийлж болохуйц механизм, нөхцлөөр хангагдсан байх шаардалагатай. Жишээлбэл амаар болон бичгээр асуудал дэвшүүлэх, хүсэлт гаргах, хороодод сонсгол хийх, “Цагаан ном”, яам болон холбогдох газруудад илтгэл тавих зэрэг хамаарагдана. (Аюулаас хамгаалах салбарт хэрэглэгдэх парламентын механизмуудын тухай 14 дүгээр бүлгийг үзнэ үү).

Боловсруулалт

Парламентын аль ч тогтолцоонд Аюулгүй Байдлын шинэ бодлого боловсруулалтад парламентын гүйцэтгэх үүрэг хязгаарлагдмал байдаг. Харин энэ үүрэг нь холбогдох

газрууд, Засгийн газрын агентлагуудад ногдоно. Парламент болон парламентын гишүүд нь одоо хэрэгжиж байгаа бодлого иргэдийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, үүнийг шаардлагатай үед дахин шалгуулах шаардлага тавих, санал гаргах эрхийг эдэлнэ.

Харин парламент нь өөрөө зөвшөөрөөгүй мөн татгалзаагүй байгаа бичиг баримтыг ард иргэдэд толилуулснаар үүргээ хязгаарлаж болохгүй. Парламентын хороод нь бичиг баримтын боловсруулалтын анхны шатанд зөвлөлдөж, бодлого зохицуулалтын бичиг баримт, бэлтгэгдэж байгаа хуулийн бичиг баримтад улс төрийн олон хүчний үзэл бодлыг тусгаж өгнө. Ингэснээр иргэдийн үзэл бодлыг бичиг баримт боловсруулалтын анхан шатнаас эхлэн тусгаж өгөх төдийгүй, уг бичиг баримт парламентаар батлагдах болоход эерэг уур амьсгал бий болгож, хэлэлцүүлгийг нааштай болгох ач холбогдолтой. Үндэсний язгуур эрх ашиг нь парламентын эрх барих нам болон сөрөг хүчнийхний эрх мэдлийн харьцаанаас давж гарсан асуудал бөгөөд харин Үндэсний Аюулгүй байдлын бодлогын бичиг баримтыг уншиж сонсоход саад хийх ёсгүй юм. Энэ утгаараа парламент уншиж танилцуулсан бичиг баримтад өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй байна.

Шийдвэр гаргах

Шийдвэр гаргах явцад парламент нь маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Нэн ялангуяа Үндэсний аюулгүй байдлын бодлого нь парламентын хэлэлцүүлэгт орсон тохиолдолд энэ нь парламентын өмч болдог бөгөөд парламент шууд хариуцлага хүлээнэ. Иймд тус бичиг баримттай нарийн танилцах, татгалзах хангалттай цаг хугацаа олгоно.

Парламент нь засгийн газраас оруулсан шинэ бодлого, хууль тогтоомжид зөвшөөрөх, эсвэл татгалзсан шийдвэр гаргах, өөрчлөх санал гаргаж болно. Дахин хэлэхэд энэ үе шатанд уг бичиг баримт хангалттай биш байгаа тохиолдолд өөрчлөлт оруулах, зэрэг нөлөөлөл үзүүлэх боломжтой байх шаардлагатай. Парламентын хэлэлцүүлэг, шийдвэр гаргах үед харгалзан үзэх ёстой гол асуудлыг энэ бүлгийн эхэнд дурдсан билээ.

Энэ үе шатанд парламентын зүгээс зохистой төсөв батлах замаар нөлөө үзүүлж болно (нарийн мэдээллийг санхүүгийн

эх сурвалжийн тухай ҮІ хэсгээс үзнэ үү). Парламентын хороод тусгай хэлэлцүүлэг хийж, аюулаас хамгаалах салбарын нэгж бүр дээр гарах зарцуулалт болон аюулгүй байдлын бодлогын нийт зарцуулалтад санал хураах замаар дээрх нөлөөллийг ихэсгэж болох юм. Батлан хамгаалах төлөвлөгөөнд шалгалт явуулах цаг хугацааг тодорхойлсон, төсвийн хэрэгцээтэй нарийн уялдаа холбоотой байх шаардлагатай. Парламент нь олон нийтийн дэмжлэгийг дээшлүүлэх, хэрэгжих бодлогын хууль ёсны байдлыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас парламентад болж байгаа аюулаас хамгаалах асуудлын тухай хэлэлцүүлгийн явцыг ил тод байлгах нь маш чухал бөгөөд мэдээллийн хэрэгсэл парламентын хэлэлцүүлэг, сонсголд байлцах эрхтэй байх ёстой.

Хэрэгжүүлэлт

Аюулаас хамгаалах асуудлын талаар парламентад ногдох үүрэг хариуцлага нь бодлогын бичиг баримтыг баталснаар дуусахгүй, хяналт, аудит хийх зэрэг үүрэгт ажлууд бас ногдоно. Хэрэгжүүлэлтийн үе шатанд парламент нь Засгийн газрын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд бүхий л арга хэлбэрээр (14 дүгээр бүлгийг үзнэ үү), мөн бусад байгууллагын тусламжтайгаар дүн шинжилгээ хийнэ (24 дүгээр бүлгийг үзнэ үү). Парламентын зүгээс зохистой төсөв батлах замаар нөлөө үзүүлж болно. Аудитын үйл ажиллагаа явуулахын тулд парламент нь аудитын байгууллагуудын мэргэжлийн болон техникийн хүчин чадлыг хянан үзэх шаардлагатай.

Парламент нь түүний зөвшөөрөл шаардагдах, засгийн газрын үйл ажиллагаанд өөрчлөлт гарсан тохиолдолд оролцож болно. Жишээлбэл Зэвсэгт хүчний ангиудыг гадаад оронд илгээх (22 дугаар бүлгийг үзнэ үү) эсвэл онцгой байдал зарлах (18 дугаар бүлгийг үзнэ үү) г. м. Үүний зэрэгцээ засгийн газар ноцтой алдаа гаргавал парламентын оролцоо шаардагдана. Энэ тохиолдолд парламент асуудал дэвшүүлж, зайлшгүй тохиолдолд онцгой хүсэлт гаргана.

Үнэлэлт, суралцсан зүйлс

Ардчилсан орчинд Засгийн газар мөрдөж буй бодлогодоо ач холбогдлын талаар үнэлэлт, дүгнэлт хийж гарсан чанарын

болон тоон үзүүлэлтийг парламентад илтгэх хариуцлага хүлээнэ. Парламентад илтгэхдээ энэ үнэлэлт нь зохицуулан баталсан төсөв тоон болон дансны үзүүлэлтийн хувьд хэрхэн хэрэгжиж байгаад тавих аудитийн хяналт зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр ийм үнэлэлт нь өнгөрсөн тоо баримтуудыг агуулдаг боловч одоо хэрэгжиж байгаа бодлогод батлан тодорхойлох, шинэ бодлого боловсруулах асуудал шийдэхэд эдгээр тоо баримтыг харгалзан үзнэ. Иргэний нийгэм үргэлж өөрчлөгдөж байдаг ба иргэний нийгмийн төрийн бус байгууллага нь өөрийн байгууллагын үйл ажиллагаанд байнга үнэлэлт, дүгнэлт хийдэг. Жишээлбэл энхийн төлөө үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, батлан хамгаалах яамны үнэ өртөг ихтэй, үлэмж хэмжээний зэвсгийн хөтөлбөр, боловсон хүчний тогтолцоонд (ялангуяа цэрэг татлагад) үнэлгээ өгөх зэрэг хамрагдана. Парламент үүнээс гадна зөвлөгч нарыг тусгай аудит хийлгэхээр хуралдуулж болно.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Аюулаас хамгаалах бодлого

- ▷ Аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаанд баримтлах номлол, үзэл баримтлал, батлан хамгаалах төлөвлөгөө, төсвийн хэрэгцээ зэрэг нь уялдаа холбоотой байхад анхаарах;
- ▷ Бусад орнуудад ижил төстэй нөхцөлд ямар бодлого баримталж байсныг харьцуулсны дараа аюулгүйн салбарт шинээр гарч ирж буй хөгжлийн улмаас аюулаас хамгаалах бодлогыг шинэчлэх, эсвэл үүний ач холбогдлын талаар асуудал дэвшүүлэх, Аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, боловсруулалтад оролцох байгууллагуудын тухай I хэсгийг үзнэ үү.
- ▷ Парламент нь аюулгүй байдлын бодлогын боловсруулалт, шийдвэрлэлт, хэрэгжүүлэлт, дүгнэлт гаргах гэсэн энэ дөрвөн үе шатанд парламентын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон хууль гаргах.

Холбогдох асуултууд

- ▷ Үндэсний аюулгүй байдлын бодлогыг тодорхойлох, шинээр тодорхойлоход “Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар асуухуй” тодруулга №5 дахь асуултууд шийдэгдсэн байна.

5 дугаар бүлэг

Үндэсний аюулгүй байдлын бодлого, олон улсын зохицуулалт

Олон улсын зарчим

Олон улсын гэрээ хэлэлцээр нь үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулалтад хязгаарлалт тавих тохиолдол байдаг ч зарим тохиолдолд харин сайжруулах тал ч байдаг. Дэлхийн ихэнх улс орнууд НҮБ-ын гишүүн байдаг учраас НҮБ-ын дүрмийн 2.3, 2.4 дүгээр зүйлд заалтад захирагддаг. Үүнд:

“Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүх гишүүн олон улсын харилцаандаа аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эсвэл улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх буюу хүч хэрэглэх, түүнчлэн Нэгдсэн Үндэстний зорилгуудад харшлах ямарваа бусад үйлдлийг цээрлэнэ”.

Үүний зэрэгцээ олон улсын жишгээр даган мөрддөг зарчмууд байдаг ба эдгээр нь нийт үйл ажиллагааны хүрээг тодорхойлдог. Улс орнуудын хамтын ажиллагаа, найрсаг харилцааны тухай олон улсын хууль дүрэмд тусгахад мөрдөх зарчмуудын тухай Ерөнхий ассемблейн 2625 дугаар тайлбар нь НҮБ-ын дүрмийн маш оновчтой тайлбар хэмээн олон нийтээр хүлээн зөвшөөрдөг. Эдгээр зарчмыг НҮБ-ын гишүүн орон бүр мөрдөнө. Дээрх дүрэмд доор дурдсан найман зүйлийн зарчмыг тэгш эрхтэйгээр мөрдөхөөр тодорхойлсон байна. Үүнд:

- 1-р зарчим:** Заналхийлэх болон хүч хэрэглэхээс татгалзах.
- 2-р зарчим:** Олон улсын маргааныг энх тайвны замаар зохицуулах.
- 3-р зарчим:** Аливаа улс орны хил хязгаарын халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх.
- 4-р зарчим:** Ард түмэнд өөрөө шийдэх эрх олгох, олон улсад зөвшөөрөгдөн батлагдсан хил хязгаар

бүхий өөрийн нутаг дэвсгэрт энх тайвнаар аж төрөх эрх.

5-р зарчим: Улс орон ижил тэгш харьцаатай байж, аливаа улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх.

6-р зарчим: Хүний эрхийг дээдлэх.

7-р зарчим: Улс хоорондын хамтын ажиллагааг эрхэмлэх.

8-р зарчим: Олон улсын хууль зүйн дагуу хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх.

Аюулгүй байдал, батлан хамгаалах талаар улс хоорондын хэлэлцээр

Аюулгүй байдлын асуудлаар хийгдсэн улс хоорондын гэрээ нэлээд байдаг. Иймэрхүү гэрээ хэлэлцээрийн голлох ангиллуудыг доор жагсаав. (Доорх жагсаалт тухайн ангилалд багтах хэлэлцээрүүдээс жишээ болгон оруулсан учир бүрэн биш болно).

Дэлхий нийтийн аюулгүй байдлын тухай хэлэлцээрүүд:
НҮБ-ын дүрэм

Олон улсын, мөн олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах олон улсын хүний эрхийн хуулиуд, гэрээ хэлэлцээрүүд: 1949 оны Женевийн конвенциуд, түүний дараа 1977 онд гарсан нэмэлт протоколууд.

Төрөл бүрийн зэвсэг худалдан авах, улс төрийн тогтолцооны тухай олон улсын хэлэлцээрүүд:
стратегийн Зэвсэг хорогдуулах гэрээ

Аюулаас хамгаалах салбарын бүс нутгийн байгууллагууд байгуулах тухай олон улсын хэлэлцээрүүд: Америкийн Улсуудын Байгууллагын тунхаглал, Европын Холбооны улсуудын хэлэлцээр, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE), Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны бага хурал (CSCE), Африкийн Холбооны Улсуудын Үндсэн Хуулийн Баримт Бичиг.

Цэргийн хамтын ажиллагаа, батлан хамгаалахад харилцан туслалцах тухай бүс нутгийн тохиролцоонууд:

Цэргийн хамтын ажиллагаа, батлан хамгаалахад харилцан туслалцах тухай бүс нутгийн тохиролцоонууд: НАТО-гийн хэлэлцээр, энх тайвны тухай Нөхөрлөлийн Гэрээ, Баруун Европын Холбооны Хэлэлцээр, Харилцан туслалцах тухай Америкийн улсуудын хэлэлцээр.

Улс орнууд олон улсын аюулгүй байдлын тухай гэрээнд гарын үсэг зурах гол нөхцөл шалтгаан нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, хоёр улсын хоорондын болон олон улс хоорондын хамтын ажиллагааг сайжруулах талаар олон улсын харилцааны төлөв байдлын зарчмыг тодорхойлоход оршдог. Төрийн гүйцэтгэх байгууллага өөрийн нэгж болох гадаад хэргийн ямаар дамжуулан гэрээ хэлэлцээрийн явцыг удирддаг.

Найрсаг байдал, хамтын ажиллагаа, цэргийн талаар харилцан туслалцах тухай хоёр орны хоорондын гэрээ хэлэлцээрүүд

Улсын аюулгүй байдлын бодлогыг бий болгоход хоёр улсын хоорондын тохиролцоо чухал ач холбогдолтой байдаг. Зөвхөн хоёр тал оролцож байгаа онцлогтойгоор дээрх маягийн хэлэлцээрүүдийн заалтаар тухайн орнуудын хэрэгцээ, нөхцөл байдал, онцгой эрхэмлэх зүйлсийг харгалзан тохиролцоонд хүрч болдог. ЗХУ, АНУ-ын хооронд хийгдэж байсан Стратегийн зэвсэг хорогдуулах тухай Хэлэлцээр нь үүний нэг жишээ юм.

Дээрх хэлбэрийн хэлэлцээр нь зөвхөн хамтын найрсаг харилцаа, халдан довтолхгүй байх асуудлыг зохицуулахад ашиглагдах (1997 онд Орос, Армени хоёр улсын хооронд хийгдсэн найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээ үүний нэг жишээ юм) төдийгүй харийн нутагт цэрэг, зэвсэг байрлуулах зөвшөөрөл олгох зэрэг практик амьдралд шаардлага бүхий цэргийн хамтын ажиллагааны асуудлыг шийдэхэд хэрэглэж болно. 1990-ээд онд Орос улс хуучин ЗХУ-д багтаж байсан хэд хэдэн улс оронтой цэргийн хамтын ажиллагааны тухай хоёр орон хоорондын гэрээ хийсэн.

Энэхүү хэлэлцээрээр шаардлагатай үед цэргийн бодит тусламж авах асуудлыг шийдвэрлэж болно. 1994 онд байгуулагдсан Ардчилсан Хамтын Нөхөрлөлийн тунхаглал

нь АНУ, Казахстаны хооронд 1992 онд хийгдсэн гэрээний үргэлжлэл байсан гэж үзэж болох юм. Энэ гэрээ нь хоёр орны хоорондын цэргийн харилцааг хөгжүүлэх үүд хаалгыг нээж өгсөн.

Ямар ч болов хоёр орон хоорондын хэлэлцээр нь аюулгүй байдлын гадаад бодлогын ерөнхий хүрээг тодорхойлох, бусад оронтой найрсаг харилцааг бэхжүүлэх, урган гарч ирж буй бодит асуудлуудыг шийдэх арга байдаг гэж хэлж болно. Ийм хэлбэрийн гэрээ хэлэлцээрүүд нь урьд элбэг байсан олон улс хоорондын гэрээ хэлэлцээрээс парламентын гүйцэтгэх үүрэг шийдвэрийн шинж чанартай байдаг ба тухайн хэлэлцээрийн үг хэллэгийг өөрчлөх санал оруулах зэрэг эрхийг парламент эдэлдгээрээ ялгаатай байдаг. Ийнхүү хэлэлцээрийн үг хэллэг өөрчлөгдсөн тохиолдолд гүйцэтгэх байгууллага нь хэлэлцээрийг үргэлжлүүлэх үүрэг хүлээнэ.

Парламентын болон олон нийтийн оролцооны ач холбогдол

Олон улсын гэрээ, хэлэлцээр хийж, хүчин төгөлдөр болгоход парламент болон олон нийт оролцох уламжлал байдаггүй улсуудад эдгээрийг татан оролцуулахыг дэмжих хэрэгтэй юм. Ингэснээр тухайн шийдэгдэх асуудал нь олон нийтийн дэмжлэг хүлээх боломж өснө гэсэн үг юм. Ардчилсан тогтолцооны мөрддөг зарчмын дагуу гүйцэтгэгч байгууллага парламентад мэдэгдэлгүйгээр нууц гэрээ, хоёр орны хоорондын хэлэлцээр байгуулж болохгүй. Аливаа нэг орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэр, тухайн орны олон улсын статусыг хөндсөн гэрээ хэлэлцээр нь ихэнхдээ заавал парламентаар хэлэлцэгдэж батлагдсан байх шаардлагатай байдаг.

Харин Швейцарь зэрэг зарим улсад томоохон гэрээ хэлэлцээрүүдийг олон нийтийн санал хураалтаар шийдэх ёстой байдаг. Энэ тохиолдолд тухайн улсын гадаад бодлогын асуудалд орж буй өөрчлөлтөд иргэний нийгмийн оролцоо бий болох баталгаа болж байгаа юм. Швейцарь улс аливаа гэрээ хэлэлцээр хийхээсээ өмнө заавал олон нийтийн санал асуулга явуулдаг (Тодруулга №6-г үзнэ үү).

Тодруулга №6

Шууд ардчиллын хэлбэр, олон улсын хэлэлцээр, бусад ач холбогдол бүхий томоохон гэрээнд гарын үсэг зурах нь: Швейцарь улсын жишээ

Швейцарь улсад олон улсын гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурахад Холбооны Парламент, Холбооны зөвлөл (засгийн газар), нийт ард түмэн оролцдог байна. Ач холбогдол бүхий гэрээ хэлэлцээр нь зөвхөн парламентад хэлэлцэгдээд зогсохгүй, нийт ард түмнээр хэлэлцэгдэх ёстой байдаг. Нийгмийн гишүүд нь тохиролцох гэж буй хэлэлцээрийн асуудал дээр өөрсдийн саналыг олон нийтийн санал асуулгын хэлбэрээр өгнө. Үүний зэрэгцээ ард түмэн Холбооны зөвлөлд хэлэлцээр эхлэх, дуусгах эрхийг өгч болдог байна. Олон нийтийн санал асуулга нь Холбооны зөвлөл, аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллага, эсвэл Улс хоорондын эвсэлд нэгдэхийг зорьсон тохиолдолд шаардлагатай болдог байна (Холбооны үндсэн хуулийн 140 б заалт).

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Хэлэлцээрээр батлах асуудлыг хэлэлцэх

- ▷ Парламент буюу парламентын холбогдох хороод:
 - улс төрийн янз бүрийн хүчнээс сонгогдсон парламентын гишүүдийг хэлэлцээрийн багт багтааснаар хэлэлцээрийн явцын талаар байнга мэдээлэлтэй байх;
 - хэлэлцэгдэж байгаа асуудлын талаар иргэний ардчилсан нийгмийн холбогдох байгууллагуудаас, энэ дундаа судалгааны болон хуулийн зөвлөгөө өгөх байгууллагуудаас зөвлөгөө авах;
 - засгийн газрын албан ёсны хуралд өөрийн саналыг илэрхийлснээрээ ард түмний үзэл бодол, хүсэл эрмэлзлэлийг хүлээн авч байгаагаа харуулах.

Нөлөөллийн шинжилгээ

- ▷ Аливаа нэг хэлэлцээрээс болж улс төр, нийгэм, эдийн засгийн амьдрал, байгаль орчин болон бусад салбарт гарч болох нөлөөллийн талаар (үүнд дунд болон урт хугацааны нөлөөллийг авч үзэх) хийсэн нарийвчилсан шинжилгээг парламентад танилцуулж хэлэлцүүлэх асуудлыг шийдвэрлэх.

Гарын үсэг зурах

- ▷ Хэлэлцээрт гарын үсэг зурах талаар парламентад хүсэлт гаргасан байх шаардлагатай;
- ▷ Хэлэлцээрт гарын үсэг зурахдаа хэлэлцээрийн заалт нь дотоодын хууль дүрэмд нийцэж байгаа эсэхийг шалгах, шаардлагатай бөгөөд боломжтой бол олон улсын тохиролцооны заалтуудад тайлбар хийх орон зай үлдээх, түдгэлзэж болох арга замуудыг хайх.

Түдгэлзэх буюу тайлбар хийх боломж бүхий заалтууд

- ▷ Танай орны хувьд тохиролцсон, түдгэлзэх буюу тайлбар хийх боломж бүхий заалтууд хүчинтэй хэвээрээ эсэх талаар тогтмол шалгаж байх.

6 дугаар бүлэг

Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүрэг роль

Аюулаас хамгаалах салбар нь томорсоор, бүтэц зохион байгуулалтын хувьд ээдрээтэй болсоор байгаа билээ. Энэ нь аюулаас хамгаалах салбарыг хянах ажлыг үр өгөөжтэй болгоход зайлшгүй шаардагдах мэргэшсэн боловсон хүчин, мөн зохистой эх сурвалжгүй байдаг парламентын гишүүдэд бэрхшээлтэй болж байгаа юм. Парламент хэдийгээр эрх барих дээд байгууллага ч гэсэн ч түүний ажил үүргийг гүйцэтгэх олон тооны байгууллагууд шинээр гарч ирж байгаа юм. Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл аль аль нь парламентаас аюулаас хамгаалах салбарт тавьж буй хяналтад парламентын тодорхойлсон ажлын хүрээний дагуу өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах боломжтой юм.

Иргэний нийгэм

Иргэний нийгэм гэдэгт нэг талаас улсын байгууллагууд, нөгөө талаас хувь хүмүүсийн эрх ашгийг төлөөлсөн бүлэглэлүүдийг нэгтгэсэн бие даасан байгууллагууд үүсэн бий болох боломжийг нэгтгэн ойлгодог. Үүнд нийгмийн янз бүрийн эрх ашгийг хамгаалсан, төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд, сайн дурын байгууллагууд, нийгмийн хөдөлгөөнүүд хамрагдана. Иргэний нийгмийн тогтолцоо нь яагаад аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагаанд өөрийн гэсэн үүрэгтэй байх ёстой, энэхүү үүрэгт чухам юу хамаарагдах, мөн иргэний нийгэм нь парламентаас тавьж буй хяналтад хэрхэн туслах вэ зэрэг асуудлыг доорх хэсгүүдэд тайлбарласан болно.

Иргэний нийгэм ба ардчилал

Иргэний нийгэм бол ардчиллын үйл явцад маш чухал ач холбогдолтой байдаг бөгөөд ардчиллын гол илэрхийлэл болж өгдөг. Иймээс ардчиллыг бэхжүүлэх үйл явцад иргэний нийгмийн үүрэг ихэссээр байгаа юм. Иргэний нийгэм нь аливаа улс оронд олон янзын үзэл сонирхол, шаардлага байдгийн илэрхийлэл бөгөөд улсын төсөв батлах, улсын

бодлого боловсруулахад энэ байдлыг анхаарч үзэх, тусгах ёстойг эрх баригч улс төрийн лидерүүдэд сануулж байдгаараа онцлогтой. Ингэснээрээ иргэний нийгмийн тогтолцоо нь ардчиллын тулгуур үзүүлэлтийн нэг болно. Иргэний нийгэм бүрэлдэн тогтсоноор улсын эрх мэдлийг тэнцвэржүүлсэн сөрөг хүчин бий болж байна гэсэн үг бөгөөд захиргаадалтыг буруушаасан, олон ургальч үзлийг бий болгосноор төр засаг цөөн хэдэн хүн буюу хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан хэрэгсэл болохоос урьдчилан сэргийлж байдаг.

Иргэний нийгэм, аюулаас хамгаалах салбар

Эрдэм шинжилгээний байгууллагууд, хүний эрхийн төлөө болон бусад зорилгыг үйл ажиллагаандаа агуулсан төрийн бус байгууллага зэрэг иргэний нийгмийн тогтолцоонд үүсэн гарч ирдэг бүлэглэлүүд нь аюулаас хамгаалах асуудалтай холбогдох шийдвэр гаргахад өөрийн нөлөөллийг бий болгох гэсэн эрмэлзэлтэй байж болох юм.

Засгийн газар ч гэсэн улс орны аюулгүй байдал, зэвсэгт хүчин, бодлого хэрэгжүүлэлт, тагнуулын байгууллагын талаар олон нийтээр хэлэлцэгдэж байгаа асуудалд ТББ-ыг татан оролцуулахыг дэмжиж болно. Иймэрхүү хэлэлцүүлэг нь засгийн газрын үйл ажиллагааг ил тод болгож өгөх сайн талтай.

Төрийн бус байгууллагуудын болон аюулаас хамгаалах салбарын талаар судалгаа явуулдаг байгууллагуудын онцгой үүрэг

Төрийн бус байгууллагууд (ТББ) ихэнхдээ тодорхой нэг чиглэлээр нийгмийн ашиг сонирхол, үзэл бодлыг илэрхийлэх зорилго бүхий ашгийн төлөө бус хувийн байгууллагууд байдаг. Судалгааны байгууллагууд нь төр засгаас тусдаа бие даасан ТББ хэлбэрээр эсвэл, засгийн газраас санхүүждэг, түүнээс хамааралтай байгууллага байдаг.

ТББ болон судалгааны институтууд нь дараахь байдлаар аюулаас хамгаалах салбарт парламентын хяналтыг сайжруулахад хувь нэмрээ оруулж болно. Үүнд:

- ✓ Аюулаас хамгаалах салбар, цэргийн асуудлууд, батлан хамгаалах салбарын талаарх мэдээлэл, бие даан хийсэн судалгааг парламентад өргөн барих буюу мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх;
- ✓ Аюулаас хамгаалах салбарт мөрдөгдөх хууль тогтоомж, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх ажлыг дэмжин хянах;
- ✓ Нийгэмд бүхэлд нь хамаатай аюулгүй байдлын асуудлуудыг улс төрийн хэлэлцэх асуудлын нэг болгох;
- ✓ Сургалт, семинар явуулснаар парламентын гишүүдийн чадварыг дээшлүүлэх;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын бодлого, батлан хамгаалах төсөв, төсвийн бүрдэлт, эх сурвалжийг бий болгох тал дээр засгийн газрын баримталж байгаа бодлогын талаар мэргэжлийн хүмүүсийн өөр санал бодлыг харуулах, олон нийтийн хэлэлцүүлэг хийх, бодлогын талаар боломжийн сонголтуудыг бий болгох;
- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийг хэлэлцэх;
- ✓ Олон нийтийн боловсролыг сайжруулах, олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудалд ард түмний алтернатив хэлэлцүүлэг явуулах.

Латин Америкийн орнууд дахь иргэний нийгмийн оролцоо нь ТББ болон судалгааны төвүүд парламентаас аюулаас хамгаалах салбарт тавих хяналтад хэрхэн нөлөөлж болохыг харуулж байна. (Тодруулга №7-г үзнэ үү).

Тодруулга №7

Латин Америкийн орнуудад бүрэлдэн бий болж буй иргэний нийгмийн тогтолцоо:

Иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг хариуцлага, ач холбогдлыг харуулсан бодит жишээ.

1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр Латин Америкийн олон оронд засгийн газар нь шинээр сонгогдож, зэвсэгт хүчний тогтолцоог шинэчлэх хүчин чармайлт тавьж эхэлснээр иргэд, төр засгийн хоорондын харилцан ойлголцлыг сайжруулах зорилго бүхий олон тооны нийгмийн бүлэглэлүүд гарч ирэх үндсийг тавьж өгсөн. Энэ хүчин чармайлтын дүнд зэвсэгт хүчний тусгаарлагдмал байдал алга болж, иргэний нийгэм, ардчилсан сонгуулиар сонгогдсон албан тушаалтнууд, цэргийн өндөр эрх мэдэлтнүүдийн хооронд мэргэжлийн төвшинд санал солилцох үйл явцын эхлэл болсон. Энэ үеэс хойш дээр дурдсан нийгмийн бүлэглэлүүд нь

иргэдийн санал сэтгэгдлийг илэрхийлэх чухал эх сурвалж болж, батлан хамгаалах болон аюулаас хамгаалах салбарт техникийн тусламж үзүүлэх, цэргийн бодлого, төсөвт хяналт тавихад томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Үүний нэг жишээ бол „SER 2000 онд“ бүлэг юм. 1990 оны төрийн эргэлт хийх гэсэн оролдлогын дараа байгуулагдсан „SER 2000 онд“ бүлэг нь иргэний нийгмийн төлөөлөгчид, улс төрийн нам, Зэвсэгт хүчний хооронд харилцан ойлголцол бий болгох зорилгоор үйл ажиллагаагаа эхэлсэн. Энэ нь алсдаа батлан хамгаалах бодлогын үйл ажиллагааны хүрээг тодорхойлох энх тайвны тухай хууль тогтоомжийн боловсруулалтад иргэдийн оролцоог бий болгох үндэс суурь тавигдаж байгаа юм.

Үүний адилаар Доминиканий БНУ-д иргэний нийгмийн төлөөлөгчид, батлан хамгаалахын мэргэжилтнүүд хамтран FLASCO бүлэглэлийг байгуулан, цагдаагийн байгууллагыг шинэчлэх хууль боловсруулахад Зэвсэгт хүчинтэй хамтран ажилласан байна. Мөн энэ талаар Засгийн газар, Конгресст өөрсдийн саналыг илэрхийлэх боломжтой байдаг байна.

Латин Америкийн олон оронд Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хянах хүчин чадлыг дээшлүүлэх талаар Конгрессийн батлан хамгаалах, аюулаас хамгаалах хороод нь нийгмийн бүлэглэлүүдтэй нягт хамтын ажиллагаатай байдаг ажээ. Перу улсын Улс төрийн судалгаа, стратегийн институт нь конгрессийн болон батлан хамгаалах комиссын гишүүдэд цэргийн төсөв, цэргийн удирдлагын талаар сургалт явуулдаг байна.

Гватемалийн FLASCO бүлэглэл нь Тагнуулын алба, цэргийн хүчний шинэчлэлийг хамруулсан хэд хэдэн хууль тогтоомжийг батлахад судалгааны тал дээр тусалсан байдаг.

Иргэдийн мэргэжлийн мэдлэг дутмаг байдал

Батлан хамгаалах, аюулаас хамгаалах салбарын талаарх мэдлэг Латин Америкийн ард иргэдийн дунд дутмаг байгаа хэвээрээ байна. Энэ байдал нь Зэвсэгт хүчинд засгийн газар, парламентаас тавьж буй хяналтыг сайжруулахад саад болж байгаа юм. Иргэний тогтолцооны байгууллагууд нь дээрх байдлыг арилгахад иргэдийн төлөөлөл болон улсын байгууллагуудад сургалт явуулах замаар тусалж байна.

Сүлжээ

SER 2000 онд“ бүлэг нийгмийн ноцтой асуудалд онолын судалгаа шинжилгээ хийх байгууллагууд, аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр байгуулагдсан ТББ-ын сүлжээг бий болгосон. RESDAL (www.ser2000.org.ar) хэмээх энэ сүлжээ аюулаас хамгаалах,

батлан хамгаалах салбартай холбогдолтой хууль тогтоомж, материалын мэдээллийн санг байгуулж, иргэдэд тус байгууллагыг сонирхох, судалгаа хийх боломжоор хангах программыг бий болгосон байна.

Эх сурвалж: Chris Sabatini, Ардчиллын Төлөө Үндэсний Сан, Вашингтон 2002 он.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хараат бус байснаар олон нийт болон олон нийтийн улс төрийн төлөөлөл нь найдвартай мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргахад боломжтой болно. Хараат бус байдал нь төрийн хүчний гурван салбарын үйл ажиллагааг хянахад тусалж, олон нийтээр хэлэлцүүлсэн асуудал утга, чанарын хувьд сайжрах болно. Нөгөө талаар төр засаг, бизнесийн харилцаа, эрдэм шинжилгээний салбар, иргэний нийгмийн байгуулалд нөлөөтэй байх юм. Ийм учраас чөлөөт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь ардчиллын гол түлхүүр болдог. Тодруулга №8-д улс орныхоо засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилсэн сэтгүүлчдэд учирч болох бэрхшээлүүдийг дурдсан байна. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангана гэдэг нь хэвлэлийн эрх чөлөөний гол утга агуулга болдог.

Тодруулга №8

Шинэ маягийн дайн: Хэвлэлийн эрх чөлөөнд цөвүүн цаг тулгарлаа

„Дэлхийн хүн амын гуравны нэг гаруй хувь нь хэвлэлийн эрх чөлөө хориотой орнуудад амьдарч байна. Дайны талбарт ажил үүргээ гүйцэтгэж байхад нь сэтгүүлч гэдгийг нь мэдэлгүйгээр егүүтгэсэн тохиолдлоос гадна тал засах, хувьдаа завших, нуун дарагдуулах, шударга бус үйл ажиллагаа гэх мэт ноцтой асуудлын талаар судалгаа хийж, нийтлэл хэвлүүлж, олонд хүргэснийхээ улмаас санаатай аллагад өртсөн сэтгүүлчид байна. Үндэсний болон хувийн үзэл бодол, шашин шүтлэг гэх мэт эрх ашгаас үүдэн гарч байгаа шинэ маягийн дайн нь сэтгүүлчдийн ажиллагааг хүндрүүлж байгаа юм. Тэгэхдээ сэтгүүлчид гэмтэх, алуулах явдал нь санамсаргүй бус үйлдэл байх нь цөөнгүй байна. Зарим тохиолдолд хууль ёсны засгийн газрын байнгын армийн төлөөлөгчид нь өөрсдийн үйл ажиллагааг гэрчлэх хүнийг санаатайгаар хороох үйлдэл байсаар байна.

Эх сурвалж: 2002 оны жилийн тайлан, Хил Хязгааргүй Сурвалжлагчид байгууллага.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл засгийн газрын байгууллагуудаас хараат байдаг оронд мэдээллийн хэрэгслийг эрх мэдэл бүхий хүмүүсийн үзэл бодлыг сурталчлахад ашиглахад маш хялбар байдаг. Ийм тохиолдолд мэдээллийн хэрэгслийг аюулаас хамгаалах салбарыг хянах ардчилсан хяналт, ил тод байдлыг сайжруулахад хэрэглэж чадахгүй нь тодорхой.

Интернэтийн сүлжээ бий болсноор олон нийт албаны мэдээлэл авах боломжоор илүүтэй хангагдаж байгаа билээ. Сүүлийн арван жилд ил тод байдал, олон нийтийн өмнө тайлагнах, албаны мэдээлэл авах боломжийг дээшлүүлэх зэрэг асуудалд ахиц гарч байгаа нь харагдаж байна. Энэ хандлага нь иргэдийг мэдээллээр хангах, олон нийтийн хэлэлцүүлгийн чанарыг сайжруулах, түүгээр дамжуулан сайн засаглал бий болгоход хувь нэмрээ оруулж байгаа тул цаашид дэмжих шаардлагатай. Гэвч интернэтийг хэт туйлширсан (extremist) бүлэглэлүүд өөрийн явцуу үзэл бодлыг дэлгэрүүлэхэд ашиглах явдал газар авсаар байна. Сүүлийн үед интернэтээс гадна зарим нэг FM радио нь хэт туйлширсан бүлэглэлүүдийн дуу хоолой болж энэ нь нийгмийн янз бүрийн бүлэглэлийн хооронд өс хонзон бий болгох хор уршигтай юм.

Аюулгүй байдлын асуудлын талаар мэдээлэл цуглуулах, түгээх

Ардчилал, сайн засаглалын зүгээс авч үзвэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн эрх ашгийг хөндсөн, аюулаас хамгаалах салбарын холбогдол бүхий мэдээлэл цуглуулах түгээх эрхтэй байж, ингэхдээ үнэн зөв, товч тодорхой мэдээллийг шударгаар хүргэх хариуцлага хүлээнэ.

Ингэснээрээ мэдээллийн хэрэгсэл нь улс төрийн үйл явдлын тухай мэдээлэл авах, мэдлэгтэй байх эрх бүхий иргэдэд өөрийн явуулж буй бодлого, гаргасан шийдвэрийг тайлбарлах боломжийг засгийн газарт олгож байгаа билээ. Жишээлэхэд мэдээллийн хэрэгсэл нь аюулаас хамгаалах салбарт хэн ямар албан тушаал хашиж байгааг, хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын бодлого, гадаад улс орноос цэргээ татах, цэргийн үзэл суртал, эдгээр нь ямар гэрээ, хэлэлцээр, бусад албан ёсны бичиг баримт дээр үндэслэгдсэн болохыг, голлох үүрэг гүйцэтгэгчийн тухай, аюулаас хамгаалах

салбарт тулгарч байгаа шинэ шаардлагууд, холбогдох хэлэлцүүлгийн талаар мэдээлснээр олон нийт хууль ёсны эрхээ эдлэхэд өөрийн хувь нэмрээ оруулдаг.

Хэвлэл, мэдээллийн тухай хууль ба аюулаас хамгаалах асуудлууд

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомж аль ч оронд байдаг. Энэ зарчмыг НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан байдаг. Үүнд:

„Хүн бүр үзэл бодол, үүнийгээ илэрхийлэх эрх чөлөөтэй байна. Үүнд хөндлөнгийн оролцоогүйгээр өөрийн гэсэн үзэл бодолтой байх, аливаа мэдээлэл, үзэл санааг ямар нэг мэдээллийн хэрэгслээр улс орны хил хязгаарыг үл харгалзан дамжуулан авах эрхтэй“.

Дээр дурдсан эрх чөлөөг хэрхэн хангах талаар олон улсын гэрээ хэлэлцээр байхгүй боловч энэхүү зарчим нь аюулаас хамгаалах салбарт гарч болзошгүй хязгаарлалтуудыг үл харгалзан ямар ч тохиолдолд хүчинтэй байх юм.

Тодруулга №9

2001 оны 9 дүгээр сарын 11-нээс хойшхи хэвлэл, мэдээллийн эрх чөлөө

Хэвлэлийн эрх чөлөөний Олон улсын өдрийг жил болгон 5 дугаар сарын 3-нд тэмдэглэдэг. 2002 оны Олон улсын өдөр 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын улмаас үндэсний болон олон улсын аюулгүй байдлыг сэргээн тогтворжуулах зорилгоор авсан арга хэмжээ хэвлэлийн эрх чөлөөнд хэрхэн нөлөөлж байгаад анхаарлаа хандуулсан юм.

Хэвлэлийн эрх чөлөөг жинхэнэ утгаар нь эдлэх, террорист халдлагын улмаас үүсэн гарсан аюулгүй байдлын хэрэгцээг хангах асуудал зөрчилдөх нь ойлгомжтой боловч террорист үйл ажиллагааны эсрэг чиглэгдсэн ямар ч компани ажлын үндсэн зорилго нь бидний эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэх ёстой“ хэмээн ЮНЕСКО-гийн ерөнхий захирал Коийчиро Матсуура хэлсэн байна.

Эх сурвалж: Дэлхийн Парламент, № 6, 2002 оны 5 дугаар сар, ПХХ.

Парламент нь аюулгүй байдлын асуудлаар олон нийттэй харилцаатай байх нь

Сайн засаглалын зарчмын дагуу парламентын төвшинд хэлэлцэгдэж буй голлох асуудлуудын талаар олон нийт мэдээлэлтэй байснаар ардчилсан хяналт үр өгөөжтэй байна.

Аюулгүй байдлын асуудлаар олон нийттэй харилцаа тогтоосноор үр өгөөжөө өгөх эсэх нь Засгийн газар, Парламентаас олон нийтэд хүргүүлж байгаа мэдээлэл хэр зэрэг үнэн, бодит байна гэдгээс шалтгаална. Парламент нь төр засгаас явуулж байгаа бодлогын одоогийн байдал, парламентаас гаргаж байгаа шийдвэрийн үр дүн ойлгомжтой байх, мэдээллийн төвшин чанарын шаардлага хангасан байхад онцгой анхаарах ёстой.

Олон нийтэд хүргэх бичиг баримтыг боловсруулах нь

Олон нийтийг мэдээллээр хангах үр өгөөжтэй нэг арга хэлбэр бол засгийн газартай хамтран буюу эсвэл дангаараа олон нийтэд хүргэх аюулаас хамгаалах асуудлын талаарх бичиг баримтыг вэб хуудсын хэлбэрээр нийтлэх явдал мөн.

Тодруулга №10

Парламентын Вэб хуудас

2002 оны 5 дугаар сарын байдлаар 180 оронд 244 парламентын танхим байсан (64 парламент нь 2 танхимтай). Парламент хоорондын холбоо (ПХХ) мэдээлснээр 128 оронд нийт 165 парламентын вэб хуудас байна. (Зарим орны парламентын танхимууд тус тусдаа вэб хуудастай). 2000 оны 5 дугаар сард ПХХ-оос эрхлэн гаргасан „Парламентын вэб хуудасны зохион байгуулалт, агуулгын зааварчилгаа“-г ПХХ-ны вэб хуудас (<http://www.ipu.org>)-наас татан авч болно.

Аюулаас хамгаалах салбарын олон нийтэд хүргэж болох мэдээллүүдийг жишээ болгон авлаа. Эдгээр нь олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр хийгдсэн байвал зохимжтой:

- ✓ Үндэсний аюулгүй байдлын бодлого зэрэг стратегийн ач холбогдол бүхий бичиг баримтууд;

- ✓ Батлан хамгаалах төсөв (нууц төсвийг хамруулалгүйгээр);
- ✓ Парламентаар хэлэлцэгдсэн аюулаас хамгаалах салбартай холбогдол бүхий голлох хэлэлцүүлгүүд, шийдвэрүүд, өргөдөл, хууль тогтоомжуудийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацсан хэлбэрүүд;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын асуудлаарх парламентын болон парламентын хорооны хэлэлцүүлгийг (хаалттай хуралдаанаас бусдыг) дамжуулан үзүүлэх, ингэхдээ хаалттай хуралдаанаар хэлэлцэх асуудал, болох цаг хугацааг мэдээлэх;
- ✓ Аюулаас хамгаалах асуудлаар парламентын зүгээс гаргасан лавлагаа;
- ✓ Аюулгүй байдлыг хангах үйлчилгээ хэрхэн явагдаж буй талаар гаргасан парламентын жилийн илтгэл, тайлан;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын талаар иргэдийн төлөөлөгчид, ерөнхий аудитын тавьсан тайлан, ингэхдээ зарим нэг онцгой үйл ажиллагааны тухай илтгэлийг оруулахгүй байж болох ба дээрх илтгэлийг сонгогдсон хороодод өгөхийг шаардах, иргэдийн төлөөлөгчид, ерөнхий аудитын парламентад тавьсан тайлангийн дагуу засгийн газраас авсан арга хэмжээний жагсаалт;
- ✓ Олон улсын болон хоёр улс хоорондын гэрээний талаарх мэдээлэл;
- ✓ Аюулаас хамгаалах асуудлын талаар (төсөв, олон улсын байгууллагын гишүүн болох, цэрэг татлага г.м.) парламентын гишүүн, фракц тус бүр хэрхэн санал өгсөн талаарх мэдээлэл;
- ✓ Мэдээллийн эрх чөлөөний талаарх хууль тогтоомж.

Парламентын ажилд олон нийтийн оролцоог бий болгох нь

Нэг талыг барьсан мэдээллийн үр өгөөж муу байдаг. Тиймээс парламент нь олон нийтэд аюулаас хамгаалах асуудлаар санал солилцох боломжийг бий болгох шаардлагатай. Хоёр урсгалын харилцаа холбоо нь дараахь шалтгааны улмаас үр дүнгээ өгдөг байна. Үүнд:

- ✓ Олон нийтийн оролцоо, байнгын хяналтыг бий болгоно;
- ✓ Парламентын найдвартай үйл ажиллагаанд итгэх итгэл төрүүлнэ;

- ✓ Удирдлагын буруутай үйл ажиллагааг хянах боломжтой болно. (жишээ нь парламент дахь иргэдийн төлөөлөгчид /омбудсман/-ийн тусламжтайгаар);
- ✓ Энэ нь хууль тогтоомж, төр засгийн бодлогыг хууль ёсны, олон нийтийн дэмжлэг авахад дөхөмтэй болгож ардчиллыг тогтворжуулна.

Хоёр урсгалын харилцааг парламентаас мэдээллээр хангах, шинээр гарч буй үйлчилгээг хянах, телевизийн нээлттэй ярилцлага, засаг захиргааны нэгжийн оршин суугчдад зориулан бэлтгэсэн мэдээллийг парламентын судалгааны албанаас гаргах зэрэг хэлбэрээр бий болгож болно.

Тодруулга №11

Парламент ба мэдээллийн хэрэгсэл

11. Ассемблей нь үндэсний парламентуудыг дараахь зорилго бүхий үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэхийг уриалдаг. Үүнд:

1. Парламентын болон парламент хоорондын үйл ажиллагааг улам нээлттэй болгох, ингэхдээ энэ асуудлыг харилцааны бодлогын асуудал гэдэг талаас бус ардчиллын үйл ажиллагаанд шууд нөлөөлөл бүхий улс төрийн тэргүүн зэргийн арга хэмжээ гэдэг утгаар авч үзэх;
2. Харилцааны уламжлалт арга хэлбэр болон шинэ тутам гарч ирж буй технологиудыг, нэн ялангуяа:
 - а) Хэвлэл мэдээллийн алба, энэ дундаа парламентын сурвалжлагчдын ажиллах орчныг бүрдүүлэх;
 - б) Хэлэлцүүлгийн тухай мэдээллийг түргэн шуурхай цацах, үйл явцын тайланг үг үсэг нэг бүрчлэн нийтлэх;
 - в) Олон нийттэй болон сэтгүүлчидтэй шууд харилцах сүлжээний үйлчилгээ бий болгох,
 - г) Парламентын баримт бичигтэй танилцах боломжоор бүрэн хангах, ингэснээр хэлэлцүүлэх хуулийн тухай санал асуулт болохоос өмнө олон нийтийн хэлэлцүүлэг явуулах.
3. Харилцаа, холбооны мэргэжилтнүүдийн зөвлөгөөг ашиглах;
4. Хууль зүйн утга агуулга бүхий бичиг баримтыг энэ асуудалд мэргэшээгүй уншигчдад ойлгомжтой болгох;
5. Улс төрийн хэлэлцүүлгийн төвд байх алхам хийх, жишээлбэл шийдвэр гаргах үйл явцыг хурдасгах боломжтой бол үйл ажиллагааг явуулах;
6. Мэдээлэл, харилцааны хүрээнд хууль болон онцгой асуудлуудыг холбогдох мэргэжлийн хүмүүс, сэтгүүлчдэд танилцуулах ажлыг хөхүүлэн дэмжих;

7. Сэтгүүлчдэд зориулсан хуулийн заалтуудыг батлах, парламентын үйл ажиллагааны явцыг танилцуулах, парламент болон олон улсын байгууллагуудын хоорондын харилцааны талаарх ойлголтыг сайжруулах зорилгоор парламентын үйл ажиллагааны тухай сургалт явуулах. Үүнд хөдөө орон нутгийн сонин сэтгүүлийн сурвалжлагчдад гол анхаарлаа хандуулах;
8. Иргэдийг парламентын гишүүд, парламентын мэдээллийн албатай харьцах боломж олгохын тулд интернэтэд сүлжээ бий болгох;
9. Европын олон орон, АНУ, Канадад байдаг парламентын ажлыг дэмжих зорилго бүхий хараат бус телевизийн суваг байгуулах ажлыг төлөвлөх;
10. Хараат бус үйл ажиллагааны хүрээнд өндөр чанар бүхий мэдээлэл хүргэх чармайлт гаргаж буй мэдээллийн хэрэгслийг, зах зээлийн зүгээс эрсдэлд орсон тохиолдолд санхүүгийн болон бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх.

Эх сурвалж: Европын Зөвлөлийн парламентын ассемблейн 1142 тоот тушаал.

Олон нийтийн оролцоо нь ардчиллыг удаан хугацаагаар тогтвортой байлгахад чухал үүрэгтэй байдаг. Олон нийтийн оролцооны төвшин орон бүрт харилцан адилгүй байдаг. Зарим парламентын хороодын хуралдаанд олон нийт оролцох эрхтэй. Энэ нь ТББ болон хууль батлах үйл явцыг сонирхсон хувь хүмүүст маш чухал ач холбогдолтой юм. Ийнхүү оролцсоноор батлах эрхгүй боловч хороодын хуралдаанд байлцсанаар ихийг мэдэж авах эрхэм чухал зүйл байдаг.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Албан бус байгууллагуудын саналыг аюулгүй байдлын бодлогод харгалзан үзэх

- ▷ аюулгүй байдал болон аюулаас хамгаалах асуудлын талаар иргэний нийгмийн төлөөлөгчдийн саналыг харгалзан ашигтай байдлаар тусгаж авч болох механизмыг парламентад бий болгох;
- ▷ аюулгүй байдал, аюулаас хамгаалах асуудал хариуцсан парламентын хороодын ажлыг хөнгөвчлөх зорилгоор зохих үйл ажиллагаа явуулах чадвар бүхий байгууллага, ТББ, хэвлэл мэдээллийн газруудыг дэмжих хууль тогтоомж батлах ажлыг дэмжих.

Олон нийтийн мэдээллийн төвшин

- ▷ Парламент нь аюулгүй байдал, аюулаас хамгаалах асуудлаар гаргасан шийдвэрт зохицсон олон нийтийн бодлого баримтлах.

Аюулгүй байдал ба хэвлэл, мэдээллийн эрх чөлөө

- ▷ Аюулаас хамгаалах асуудлаар хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлагдан, амьдралд хэрэгжиж байгаа эсэхэд анхаарах, ямар нэг хязгаарлалт байгаа тохиолдолд олон улсын хүний эрхийн зарчмыг хөндөөгүй байгааг анхаарах;
- ▷ Мэдээллийн эрх чөлөөний талаар зохих хууль тогтоомжийг бий болгох.

7 дугаар бүлэг

Аюулгүй байдлын бодлогын хүрээнд хүйсийн асуудлыг авч үзэх нь

Хүйсийн эрх тэгш байдал нь харьцангуй сүүлийн үеэс олон нийтийн анхаарлыг татах болсон. Хэдий ийм боловч хүйсийн асуудал нь аюулгүй байдлын асуудлын чухал хэмжүүрүүдийн нэг болоод байна. Учир нь зэвсэгт мөргөлдөөний хохирогчид, дүрвэгсэд, нийгмээс гадуурхагдсан хүмүүсийн дийлэнх хэсэг нь эмэгтэйчүүд, хүүхэд байдагтай холбоотой төдийгүй дэлхийн хүн амын тал хэсгийг эзэлж байгаа эмэгтэйчүүд маань эрэгтэй хүмүүстэй ижил эрх, үүрэгтэй байж, аюулгүй байдлын асуудлыг шийдэхэд өөрийн хувь нэмрээ оруулах ёстой гэдгээс үүдэн гарч байгаа юм. Эмэгтэйчүүдийн авъяас, аливаа зүйлийг тусгаж авах чадвар зэргийг харгалзан үзвэл эдүгээ шинээр гарч ирж буй аюулгүй байдлыг хангах шинэ шаардлага болох хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Ингэх нь хүний аюулгүй байдлын ухагдахуунтай нийцэж, илүү холч хараатай бодлого байх юм. Тиймээс аюулгүй байдлыг хангах бодлогод хүйсийн тэгш эрхт байдлыг харгалзан үзэхдээ энэ асуудлыг хоёр талаас авч үзэх нь чухал юм. Нэгдүгээрт, аюулаас хамгаалах бодлого хүйсийн тэгш байдлыг бий болгоход саад учруулж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэх ёстой. Асуудлыг шийдэх боломжийн шийдвэрүүдийг танилцуулж, эмэгтэйчүүдийн эрх, үүрэг болон эрх ашгийг хүндэтгэсэн тогтолцоог бий болгох шаардлагатай. Хоёрдугаарт, шийдвэр гаргах бүх төвшин, аюулаас хамгаалах асуудал хөндөгдсөн бүхий л салбарт эмэгтэйчүүдийн оролцоог бий болгох нэн түрүүн шийдвэрлэх асуудлын нэг юм.

Эмэгтэйчүүд ба мөргөлдөөнийг зохицуулах нь

Мөргөлдөөнийг зохицуулах, энхийг сахиулах, энх тайвныг бий болгох үйл ажиллагаа нь зөвхөн тухайн дайн, тухайн зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа (дийлэнх нь эрэгтэй)

хүмүүсийн хэрэг биш гэдэг нь тодорхой. Хэлэлцээр хийгчдийн тоонд эмэгтэй хүн байх нь ховор байсаар ирсэн бөгөөд хэдийгээр зэвсэгт мөргөлдөөн, дайны үеэр уламжлалт үүргээ солин эрэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ажлыг хийж байсан ч хэлэлцээрт оролцох нь цөөн байгаа хэвээрээ л байна. Харин эмэгтэйчүүд холч хараа, аливаа зүйлийг тусгаж авах зэрэг чухал чадвартай байдаг нь улам тодорхой болсоор байгаа билээ. Практик амьдрал дээр эмэгтэйчүүд шийдвэр гаргах үйл явц, мөргөлдөөнийг зохицуулах, энх тайвныг дэмжих үйл ажиллагаанд шууд оролцох нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн талаарх уламжлалт сэтгэлгээг өөрчлөх шаардлагыг бий болгодог.

Тодруулга №12

Энх тайвны үйл ажиллагаа дахь хүйсийн ялгаа

“Эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага болон үүргийг үгүйсгэсэн энхийг сахиулах үйл ажиллагаа нь байгалийн хуулийг зөрчиж байгаатай адил бөгөөд ийм ч учраас хэрэгжилт нь тогтвортой биш байдаг” “Мөргөлдөөн гарсны дараах өөрчлөлтийн үйл явцад эмэгтэйчүүдийн эрх мэдлийг сэргээх нь нийгмийн болоод эдийн засгийн сэргээн босголтонд маш чухал ач холбогдолтой юм. Эмэгтэйчүүд эрчүүдийн адил дайнаас хохирол амссан, мөн дайнд оролцогчид байдаг боловч, амссан туршлагын хувьд ялгаатай байдаг. Дайны үед эмэгтэйчүүд уламжлалт бус шинэ үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд энэ нь урьд өмнө хүлээж үүрч байсан хариуцлагыг өндөрсгөдөг. Энэ өөрчлөлтийн хажуугаар эмэгтэйчүүд мөргөлдөөний дараахь энх тайвныг бий болгох үйл ажиллагаанд бараг оролцдоггүй, энэ нь мөргөлдөөний улмаас үүсч бий болсон нийгэмд төдийгүй олон улсын энх тайвны байгууллагуудын шугамаар явагдаж буй энхийг бий болгох стратеги боловсруулалт, хэрэгжилтэнд мөн л адил байдаг.

Эх сурвалж: Хүний аюулгүй байдлын асуудал дахь хүйсийн ялгаа: Эмэгтэйчүүдийг шахан зайлуулах бодлогоос тэдгээрийг энхийг сахиулах үйл ажиллагаанд татан оролцуулах нь, 2001 он, Норвегийн Олон улсын асуудал судлалын хүрээлэн.

Тодруулга №13-т НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2000 оны 1325 дугаар шийдвэрийг хэсэгчлэн харуулсан байна. Үүнд эмэгтэйчүүд зэвсэгт мөргөлдөөний зөвхөн хохирогч байдаг (үүнд хүч хэрэглэх, хүчиндэх зэрэг үйлдлүүд орно) гэсэн үзлээс ангижирч, мөргөлдөөнийг зохицуулах, энх тайван байдал бий болгох, энхийг сахиулах үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн нэг адил эрх тэгш эрхтэй оролцогч байна гэдэг үзэлд шилжихийг онцлон тэмдэглэсэн байна. Энэхүү

үзэл бодлын өөрчлөлт бий болгоход дайны дараа болон дайны өмнө эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн гүйцэтгэж байсан үүргийг анхааран үзэх ёстой. Үүнээс хүйсийн эрх тэгш байдал, хүйсийн ялгааны асуудал нь улс төрийн бодлого боловсруулалтын эхэн үед хамрагдах асуудал гэдэг нь харагдана.

Тодруулга №13

Энхийг сахиулах үйл ажиллагаа, үйл явцыг хүйсийн ялгааны талаас авч үзвэл

Аюулгүйн Зөвлөл (. . .)

7. гишүүн орнууд нь хүйсийн асуудлаарх сургалт явуулах хүчин чармайлтыг санхүү, техник, бэлтгэн нийлүүлэх хэлбэрээр явуулах сайн дурын тусалцаа үзүүлэх ажлыг эрчимжүүлэх;

8. энх тайвны хэлэлцээр хийж буй талуудад хэлэлцээрийн үеэр, хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ хүйсийн асуудлыг анхаарч үзэх нэн ялангуяа дараахь асуудлыг хамруулахыг уриалж байна. Үүнд:

- a) Дахин суурьшуулах, сэргээн босголтын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд, охидуудын онцгой хэрэгцээг харгалзан үзэх;
- b) Орон нутаг дахь эмэгтэйчүүдийн энхийн төлөөх үйл ажиллагаа, мөргөлдөөнийг зохицуулах хувь нэмэр оруулах үйл явцыг дэмжих, энх тайвны хэлэлцээрийн хэрэгжүүлэлтийн бүх шатанд эмэгтэйчүүдийг оролцуулах арга хэмжээ авах;
- c) Эмэгтэйчүүд, охидын эрхийг хүндлэх, хамгаалах арга хэмжээ авах, үүнд үндсэн хуулиар заагдсан эрх, сонгуулийн тогтолцоо, шүүх цагдаагийн байгууллагатай холбоотой эрхүүд орно.

15. Аюулгүйн Зөвлөлийн үйл ажиллагаа орон нутгийн болон олон улсын эмэгтэйчүүдийн байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр эмэгтэйчүүдийн эрх, хүйсийн асуудлыг анхааран үзэх ёстой гэсэн хүсэл бодлоо илэрхийлж байна.

2000 оны 10 дугаар сарын 31-нд баталсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2000 оны 1325 тоот тушаалын хэсгээс

1325 тоот тушаалын дагуу НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга “Эмэгтэйчүүд, Энх тайван, Аюулгүй байдал” гэсэн нэртэй илтгэл гаргасан (2002 оны 10 дугаар сар). Энэ илтгэл зэвсэгт мөргөлдөөн эмэгтэйчүүд, охидуудад хэрхэн нөлөөлөх, олон улсын эрх зүйн хүрээ, энх тайвны үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо, энхийг сахиулах үйл ажиллагаа, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, сэргээн босголт, зэвсэг хураах, цэрэг татах, дахин нэгтгэх

зэрэг сэдвүүдийг авч үзсэн байдаг. Эдгээр нөхцлүүдийн зарим хэсгийг энэ бүлэгт толилуулах болно.

Парламент дахь батлан хамгаалах хороодын эмэгтэй гишүүд

ПХХ-оос сүүлийн 25 жилд эмэгтэйчүүдийн улс төрд оролцож буй байдлын талаар явуулсан судалгаагаар парламентын батлан хамгаалах хороодод эмэгтэй гишүүд байхгүй байх буюу харьцангуй цөөн тооны төлөөлөлтэй байх нь элбэг байна. Дээрх хороодын дарга, орлогч дарга, илтгэгч зэрэг албан тушаалд эмэгтэй хүн байх нь ховор гэдгийг дурдах нь илүүц биз ээ. 1997 онд ПХХ-оос явуулсан (эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн улс төрийн оролцоо: ардчилал төлөвшсөөр байна) судалгаагаар парламентын хороодод ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн талаар мэдээлэл өгсөн нийт 97 парламентын 3 хувьд нь эмэгтэй хүн батлан хамгаалах хороог даргалж байна гэсэн дүн гарсан. Ерөнхийд нь авч үзвэл нийт парламентын хороодын дарга нарын 18.6 % нь эмэгтэйчүүд байна. Энэ байдлыг хоёр шалтгаанаар тайлбарлаж болох юм. Нэгдүгээрт, дэлхий нийтээр авч үзвэл парламент дахь эмэгтэй гишүүдийн тоо цөөн байдаг (2002 оны 5 дугаар сарын байдлаар 14.3 %). Хоёрдугаарт, дэлхий нийтээр дайн, энх тайван, аюулаас хамгаалах асуудлууд нь эмэгтэй хүний хэрэг биш гэж бат итгэсэн байдаг оршдог. Дайн дажин нь нийт хүн амыг хамарч, ихэнхдээ эрэгтэйчүүдээс илүүгээр эмэгтэйчүүд хохирол амсдаг болохоор энэ маш ээдрээтэй асуудал болж байгаа билээ.

Зэвсэгт хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо

Эмэгтэйчүүд зэвсэгт хүчний захиргаа, арын алба, хангалтын салбарт ажиллах нь ихэнх оронд түгээмэл байдаг уламжлалтай. Ийнхүү арын албаны тушаалд эмэгтэйчүүд байх нь зөвхөн энхийн цагт бус, дайны үед, ялангуяа зэвсэгт мөргөлдөөний үед маш их ач холбогдолтой байдаг. Харин цэргийн анги, нэгтгэл, үйл ажиллагаанд эмэгтэйчүүд сүүлийн үеэс оролцож эхлэх болсон юм. Цэргийн анги нэгтгэлүүд дэх эмэгтэйчүүдийн талаар олон улсын харьцуулсан судалгаа, тоо баримт цөөн байдаг. Тодруулга №14-т НАТО-ийн гишүүн орнуудын цэргийн анги, нэгтгэл дэх эмэгтэйчүүдийн тоог харуулсан байна.

Тодруулга №14

Зэвсэгт хүчин дэх эмэгтэй боловсон хүчин: НАТО-гийн орнуудын жишээ

Улс	Тоо	Зэвсэгт хүчинд эзлэх хувь
Бельги	3 202	7,6 %
Канад	6 558	11,4 %
БН Чех улс	1 991	3,7 %
Дани	863	5,0 %
Франц	27 516	8,5 %
Герман	5 263	2,8 %
Грек	6 155	3,8 %
Унгар	3 017	9,6 %
Итали	438	0,1 %
Люксембург	47	0,6 %
Голланд	4 170	8,0 %
Норвеги	1 152	3,2 %
Польш	277	0,1 %
Португал	2 875	6,6 %
Испани	6 462	5,8 %
Турк	917	0,1 %
Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс	16 623	8,1 %
АНУ	198 452	14,0 %

Эх сурвалж: 2001 оны НАТО-гийн зуны тайлан

Ерөнхийдөө эмэгтэйчүүдийг цэрэгт татах, мэргэжлийн цэргийн албанд оруулах нь улс төрийн удирдагчдын шийдвэр байх буюу аюулаас хамгаалах салбарын хөгжлийн үр дүн байж болох юм. Энэ хандлага нь харилцан уялдаагүй хоёр шалтгааны улмаас гарч ирсэн байж болох юм. Үүнд:

- ✓ Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор нийт хүн амыг цэрэг татлагад хамруулах шаардлагатай байх;
- ✓ Бусад салбарын үйл ажиллагааны адилаар зэвсэгт хүчний шинэчлэл нь нийгмийн өөрчлөлтөд нөлөөлж ингэснээр хүйсийн тэгш эрхийг бий болгох асуудал улам бүр ноцтой болж байна.

Тодруулга №15

Хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх зорилгоор аюулгүй байдлын бодлогод эмэгтэйчүүдийг оролцуулах нь

Засгийн газрын аюулгүй байдлын бодлогод хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх үүднээс үнэлэлт өгөх шаардлагатай. Бээжинд болсон НҮБ-аас зохион байгуулсан Дэлхийн Эмэгтэйчүүдийн 4 дүгээр зөвлөлгөөн дээр НҮБ нь хүйсийн эрх тэгш байдлыг бий болгох гол стратеги нь хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх гэж заасан байдаг. Хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх гэдгийг НҮБ дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Аливаа төлөвлөж байгаа үйл ажиллагаанд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн оролцоог үнэлэх үйл явц байх ба үүнд хууль тогтоомж, улс төрийн бодлого төлөвлөлт, хөтөлбөр хамрагдана гэжээ. Ингэснээр улс төр, эдийн засаг нийгмийн аль ч салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, хэв загварт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн сонирхол, туршлагыг харгалзан нэгтгэн тусгаж, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд нэгэн ижил ашигтай байхаар үйлдэнэ. Үүний туйлын зорилго нь хүйсийн тэгш эрхийг хангахад оршино”.

Эх сурвалж: UN ECOSOC Хэлэлцэж тогтсон дүгнэлт

Зэвсэгт хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцоо ихэссэнээр уламжлалт батлан хамгаалах ухагдахуунаас хүний аюулгүй байдлын шинэ ойлголтонд шилжихэд дөхөмтэй болох магадлалтай. Судалгаа, мэдээллийн технологи, тагнуулын үйл ажиллагаа нь уламжлалт биеийн хүч шаардагдах цэргийн үйл ажиллагааны хажуугаар, эсвэл эдгээрийн анхаарлын төвд байх салбарууд болсон байна. Энэ шинээр гарч ирж байгаа хандлага нь эмэгтэйчүүдэд, ялангуяа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд сурч боловсрох тэгш эрхтэй орнуудад шинэ боломжийг бий болгож байгаа билээ.

Тодруулга №16

Аюулаас хамгаалах салбарт эмэгтэйчүүдийг оролцуулах болсноор гарч ирэх шинэ хэмжүүр, шаардлагууд

Эмэгтэйчүүдийг аюулаас хамгаалах салбарт оролцуулах болсноор, нэн ялангуяа цэргийн анги нэгтгэл, цагдаагийн байгууллагад эмэгтэйчүүдийн сургалт (ялангуяа биеийн тамирын бэлтгэл сургуулилт), сахилга батын шаардлага эрэгтэйчүүдтэй адил байх ёстой юу гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна.

Хүйсийн харьцааны асуудлыг зохицуулах шаардлага тулгарч байгаа нь урьд нь цэргийн байгууллага, улсын цэрэгжсэн байгууллагууд, цагдаагийн байгууллагуудад ийм харьцааг авч үзэх шаардлага байдаггүй байлаа. Аливаа нэг анги нэгтгэл болон өөр анги нэгтгэлийн гэрлэсэн болон гэрлээгүй хосуудын онцгой эрх ашгийг харгалзан үзэх, мөн эцэг эх, эхчүүдийн асуудлыг анхааран үзэх шаардлагатай болж байгаа юм.

Үүнээс гадна хувцаслалт, гоо сайхан, бас дур сонирхол төрүүлэх маягаар хувцасласан байж болох асуудлыг дахин авч үзэх хэрэгтэй болж байгаа юм. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дүрэмт хувцас адилхан байх ёстой юу? Ямар ч тохиолдолд эрэгтэй шийдэлтэй хувцас өмсөх ёстой юу? гэх мэт.

Энэхүү бодит байдлаас урган гарч буй асуудлууд нь шинэ сэтгэлгээг шаардаж байгаа юм. Үндэсний хууль тогтоомж, цэрэг болон цэрэгжсэн бэлтгэл бүхий улсын байгууллагууд, цагдаагийн газруудын дүрэм журам нь энэ шинээр урган гарч буй байдалд нийцсэн байх ёстой.

Энхийг сахиулах үйл ажиллагаа ба батлан хамгаалах яамны үйл ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоо

2002 оны НАТО-ийн зуны судалгаагаар дэлхийн II дайнаас хойш энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон эмэгтэйчүүдийн тоо хязгаарлагдмал хэвээрээ байгаа нь харагдаж байгаа юм. Канад, Унгар, Франц, Голланд, Португал зэрэг цөөн орнуудын хувьд энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийн 5-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. НҮБ-ын туршлагаас авч үзвэл эмэгтэйчүүд оролцсоноор явагдаж буй тухайн үйл ажиллагаанд эерэг хандлагатай үзүүлэлтүүд өссөөр байгаа юм. Үүнд хүйсийн ялгаа, хүч хэрэглэсэн асуудлуудыг илүүтэй анхаарч үздэг байна.

Эмэгтэй хүн батлан хамгаалахын сайд, наанадаж орлогч сайдаар сонгогдох нь маш ховор байдаг байна. 2002 оны ПХХ-оос явуулсан судалгаагаар батлан хамгаалах, аюулаас хамгаалах асуудлыг хариуцсан эмэгтэй сайд 1.3 %, дээрх асуудлыг хариуцсан орлогч сайд, төрийн нарийн бичгийн дарга нарын нийт 3.9 % нь эмэгтэйчүүд байсан байна.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Мэдээ баримт

- ▷ Цэргийн анги нэгтгэл, бусад цэрэгжсэн улсын байгууллагууд, цагдаагийн газрууд, тагнуулын байгууллагуудын ажилчдын дунд эмэгтэй ажилчдын эзлэх хувийг харуулсан мэдээ баримт шаардах. Үүнээс гадна өндөр албан тушаалтан, шийдвэр гаргах эрх мэдэлтнүүд болон таны өөрийн орноос НҮБ, НАТО, бусад олон улсын байгууллагуудад сууж буй төлөөлөгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг харуулсан мэдээлэл шаардах.

Хүйсийн асуудал, мөргөлдөөнийг зохицуулах, сэргээн босголт

- ▷ Хэлэлцээр хийж буй багт хүйсийн тэнцвэртэй байдал бий болгохыг чармайх;
- ▷ Энх тайвны хэлэлцээрт зэвсэгт мөргөлдөөнөөр эмэгтэйчүүдэд учрах хор нөлөө, энхийг сахиулах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оруулж буй хувь нэмэр, тэдний хэрэгцээ шаардлага, эрхэмлэх зүйлсийг тусган оруулах;
- ▷ Мөргөлдөөний үеэр эмэгтэйчүүдийн хуримтлуулсан мэдлэг, туршлага, чадварыг сэргээн босголтын үйл ажиллагаанд үр өгөөжтэйгээр ашиглах боломжийг бүрдүүлэх.

Хүйсийн асуудал болон энхийг сахиулах ажиллагаа

- ▷ Энхийг сахиулах ажиллагаа болон мөргөлдөөний дараахь сэргээн босголтын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг татан оролцуулахыг зөвлөх;
- ▷ Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцогчид болон бусад олон улсын байгууллагын ажилчдыг улс орны хүмүүсийн харьцааны соёл, уламжлал ёс заншлийн ялгаа, үүнээс гадна хүйсийн асуудлаар сургалтанд хамруулах;
- ▷ Эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөн, энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцогч болон олон улсын байгууллагын ажилтанд оноосон ял шийтгэлд хяналт тавих.

Засгийн газар

- ▷ Батлан хамгаалах яаманд ажиллаж буй эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн ажлын хариуцлага хүлээх төвшинг сүүлийн 10 жилд тэнцвэртэй байлгах. Эмэгтэйчүүд өндөр албан тушаалд дэвших, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хариуцлага хүлээх боломж хуулийн дагуу бодит амьдрал дээр эрэгтэйчүүдийнхтэй адил байгаа эсэхийг шалгах.

Парламент

- ▷ Парламент дахь батлан хамгаалах буюу үндэсний аюулгүй байдлын хороодын урьд нь байсан болон одоогийн бие бүрэлдэхүүнийг шалгах, эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага ямар байгааг шалгах,
- ▷ Үүнээс гадна тухайн хороо хүйсийн ялгааны асуудал дээр анхаарч байгаа эсэх, хүйсийн ялгааг тэнцвэржүүлэх, хүйсийн ялгааны эмзэг асуудалд анхаарал хандуулж байгаа эсэхийг шалгах.

*НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын, Эмэгтэйчүүд, Энх Тайван ба Аюулгүй Байдал” илтгэлээс авсан зөвлөмжүүд.
2002 оны 10 сар*

III ХЭСЭГ

Аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн

8 дугаар бүлэг

ЗЭВСЭГТ ХҮЧИН

Зэвсэгт хүчин нь түүхийн турш байсаар ирсэн бөгөөд улсыг хамгаалах илд бамбай нь болдог гэж үздэг. Тодруулга №17-оос 2002 оны дунд үед дэлхийн цөөн хэдэн улс л цэргийн салбаргүй байсан байна.

Тодруулга №17

Зэвсэгт хүчин байдаггүй улсууд

Зарим оронд зэвсэгт хүчин байдаггүй. Үүнд Өмнөд далайн Науру, Малдивес, Кирбати, Самао, Соломоны арлууд, Тувалу, Палау, Вануату зэрэг жижиг улсууд, Карибын тэнгисийн Гэгээн Винсент болон Гренадинес, Гэгээн Китс болон Невис, Гэгээн Лучиа, Доминика, Гренада зэрэг улсууд багтдаг ажээ. Зэвсэгт хүчингүй улсуудын тоонд Коста Рика, Исланд, Таурициус, зүүн Тимор, Сомали (арми бүрэлдэн бий болох төвшинд байна), Андорра, Сан Марино, Гаити зэрэг улсууд орно. Эдгээр орны ихэнх нь парламентын анги нэгжүүдтэй байдаг (Жишээ нь Үндэсний Гвард, Хилийн Гвард гэх мэт).

Зэвсэгт хүчний үүрэг

Дэлхийн II дайнаас хойш Аюулаас хамгаалах салбарт гарсан хөгжил нь дэлхийн улс орнуудын зэвсэгт хүчинд ихээхэн нөлөөлсөн. Цэргийн хүчинд шинэ үүрэг даалгавар бий болсон ч урьдын үндсэн үүргээ өөр маягаар биелүүлэх шаардлага гарч ирсэн. Өнөөгийн байдлаар Зэвсэгт хүчин нь дараахь даалгаврыг гүйцэтгэх нь түгээмэл байдаг. Үүнд:

- ✓ Улс орны, бүр өргөн утгаар нь авч үзвэл иргэдийн тусгаар байдал, халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах;
- ✓ Олон улсын энхийг сахиулах, энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- ✓ Гамшиг тохиолдоход улс орныхоо төлөө хөдлөхөд бэлэн байх;
- ✓ Дотоодын аюулгүй байдлын үүрэг даалгавар (онцгой байдал бий болсон үед хууль ёсыг сахиулах зорилгоор иргэний хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад туслах);

- ✓ Үндэстэн бүрэлдэн бий болох явцад оролцох (нийгмийн үүрэг).

Зэвсэгт хүчин дээрх даалгавруудыг ямар төвшинд хэрхэн биелүүлэх нь улс бүрд харилцан адилгүй байх бөгөөд тухайн улсын үндэсний хууль тогтоомжийн цар хүрээ, тухайн үед үүсэн бий болсон аюулгүй байдалд заналхийлсэн нөхцлүүдээс шалтгаална.

Улс орны халдашгүй дархан байдал, нийгмийг хамгаалах нь

Шинээр бий болж буй аюулаас хамгаалах салбарын хөгжил, шинэ аюул заналхийллээс гадна уламжлалт үүрэг даалгавар болох эх орноо эсвэл холбоотон орныг харийн түрэмгийллээс хамгаалах нь Зэвсэгт хүчний үндсэн үүрэг хэвээрээ байгаа билээ. Энэ үүрэг даалгаварт улс орны газар нутаг, улс төрийн халдашгүй байдлыг хамгаалаад зогсохгүй, нийт нийгмийг хамгаалах асуудал хамрагдана.

Хүйтэн дайны төгсгөлөөс эхлэн улс төр, цэргийн эрх мэдэлтнүүд үндэсний халдашгүй дархан байдалд, харийн цэргийн түрэмгийллээс гадна, алан хядлага, иргэний дайн, зохион байгуулалттай гэмт хэрэг, компьютерийн сүлжээгээр дайралт хийх /кибер гэмт хэрэг/, авилгалд өртөх зэрэг цэргийн бус аюул занал нүүрлэдэг болохыг мэдэж авсан (Тодруулга №18-ыг үзнэ үү). Ихэнх улсын Зэвсэгт хүчинд шинэтгэл явагдаж байна. Тодруулга №18-д нөлөө бүхий гурван том шинэчлэлийн тухай өгүүлжээ.

Тодруулга №18

Батлан хамгаалах салбарын шинэчлэл: Ямар зорилготой вэ?

1990-ээд оноос ихэнх цэргийн анги нэгтгэлүүдийг шинэчилсэн. Ийм шинэчлэлийг өөр хоорондоо ялгаа бүхий гурван зорилгод хүрэх үүднээс явуулдаг байна.

▷ Ардчилах үйл явц

Урьд нь коммунист системтэй буюу дарангуйлах дэглэмтэй байсан, эсвэл улс төрийн хямрал гарсан орнуудад батлан хамгаалах салбарын шинэчлэл хийх болсон гол шалтгаан нь ардчиллын үйл явц байсан.

- Зэвсэгт хүчнийг нь ардчилсан сонгуулийн дагуу сонгогдсон улс төрийн удирдагчийн удирдлагад оруулаагүй тохиолдолд ардчилах үйл явцад аюул учруулж болзошгүй;
- Цэргийн хэрэгцээ, шаардлагыг хангахдаа нийгмийн бусад салбарын хэрэгцээ шаардлагатай уялдуулах.

▷ Аюулгүй байдлын шинэ орчинтой зохицох

- Цэргийн төсөв, цар хүрээг аюулгүйн салбарт шинээр төрөн гарч буй аюул заналхийлэлтэй уялдуулан өөрчлөх;
- Цэргийн салбарыг энхийг сахиулах гэх мэт шинэ үйл ажиллагаанд бэлэн байлгах.

▷ Олон улсын харилцаа эрчимжих

Зэвсэгт хүчин нь зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулах бус, бусад орны цэргийн хүчинтэй үйл ажиллагаа хамтран явуулах нь ихсэж байгаа билээ. Олон улсын хамтын ажиллагаа нь НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаа гэх мэт түргэн хугацааны дайчилгааны арга барилд тулгуурласан, эсвэл удаан хугацаагаар, бие даасан байгууллагын хэлбэрээр (жишээ нь НАТО) явагдаж болох ба үүний зэрэгцээ хоёр улсын хамтын гэрээний дагуу хийгдэж болох юм.

- Зэвсэгт хүчний тодорхой хэсгийг олон улсын командлалд шилжүүлэх буюу зохион байгуулалтын хувьд олон улсын цэргийн хүчний нэг хэсэг болгох;
- Зэвсэгт хүчин бусад улсын Зэвсэгт хүчинтэй хамтран цэргийн тоног төхөөрөмж, бэлтгэл сургуулалт, хэвлэл мэдээлэл, удирдлага болон хянах системийн чиглэлээр хамтарсан үйл ажиллагаа явуулах чадварыг дээшлүүлэх.

Олон улсын байнгын цэргийн нэгжүүд:

- Герман, Голландын 1 дүгээр корпус;
- Балтийн батальон (Латви, Литви, Эстон) ;
- Польш, Герман, Данийн корпус;
- Словак, Унгар, Румын, Украин улсуудын хамтарсан олон үндэстний инженерийн батальон (“TISA” батальон).

Олон улсын энхийг сахиулах ажиллагааг дэмжих нь

Зэвсэгт хүчнийхэн хоёр шалтгааны улмаас энхийг сахиулах ажиллагаанд оролцдог. Нэгдүгээрт, хямрал гарахаас зайлсхийх, бүс нутгийн тогтворгүй байдал, эдийн засгийн

хямрал, үй олноор хяналтгүй дүрвэх явц бий болохоос урьдчилан сэргийлэх шалтгаанаар, хоёрдугаарт, хямрал гарч буй бүс нутагт хүний аюулгүй байдлыг хангах, энгийн ард иргэдийг хамгаалах зорилготой байдаг. Сүүлийн үед гарсан зэвсэгт мөргөлдөөнд хүний эрхийг зөрчих, энгийн ард иргэдийг егүүтгэх явдал их гарсны улмаас олон улсын байгууллагууд хүний аюулгүй байдал, тэр тусмаа хүний эрх чөлөөг хангах асуудлыг өөрсдийн бодлогодоо чухалчлан үзэж байна. Энхийг сахиулах ажиллагаанд оролцоноор Зэвсэгт хүчнийг бэлтгэх, туршлага хуримтлуулах шинэ боломж гарч ирж байгаа юм.

Гамшгаас учирсан хор хохирлыг арилгах

Аль ч оронд газар хөдлөлт, үер, их хэмжээний түймэр, хот суурин газарт нисэх онгоц осолдох зэрэг байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гай гамшиг тохиолдож болно. Ийм онцгой байдлын үед гамшгийн хор хөнөөлийг багасгах ажилд Зэвсэгт хүчнийг дайчлах хэрэгтэй болдог. Зэвсэгт хүчин дэг журам тогтоох, хоол хүнс, эм болон бусад зүйл түгээх, харилцаа холбоо, тээврийн шугамын үйл ажиллагааг хэвийн болгох үүрэгт ажлыг хүлээнэ. Зэвсэгт хүчнийхнийг энэ ажилд татан оролцуулснаар энгийн ард иргэдэд эерэг сэтгэгдэл төрүүлэх, ингэснээрээ тэдний нэр хүнд өсөх магадлалтай.

Хууль хэрэгжүүлэгч иргэний байгууллагуудад туслах нь

Зэвсэгт хүчний үүрэгт ажлын тоонд хууль хэрэгжүүлэх иргэний байгууллагуудад туслах ажил мөн хамрагддаг. Харин Зэвсэгт хүчнийг энэ ажилд туслуулах асуудал нэлээд маргаантай байдаг. Нийтэд аюул заналхийлсэн, үүний эсрэг хууль хэрэгжүүлэх иргэний байгууллагууд, цагдаагийн байгууллага дангаараа тэмцэж чадахгүй болсон тохиолдолд л цэргийн хүч шаардагдана. Ийм аюул занал нь террорист халдлага, зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхи хууль бусаар хил нэвтрүүлэх, хил дамжуулан худалдах зэрэг тохиолдолд нүүрлэж болох юм. Харин Зэвсэгт хүчнийг энэ ажилд татан оруулснаар дараахь аюул нүүрлэж болох магадлалтай. Үүнд:

- ✓ Зэвсэгт хүчнийг хянах иргэний хяналт шалгалт алдагдах;

- ✓ Зэвсэгт хүчнийг хэт улс төржүүлэх;
- ✓ Зэвсэгт хүчин түр хугацаагаар хэв журам тогтоож болох боловч, хямралын буюу эмх цэгцгүй байдлын үндэс болсон нийгэм, улс төр, эдийн засгийн шалтгааныг өөрчилж чадахгүй;
- ✓ Зэвсэгт хүчин байлдааны үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байдгаас бус улс төрийн үүрэг даалгавар биелүүлэх, энгийн ард иргэдтэй харьцах харьцаанд онцгойлон бэлтгэгдээгүй байдаг;
- ✓ Цагдаагийн байгууллага, зэвсэгт хүчний хооронд үүрэг хариуцлагын хувьд давхардах өрсөлдөх зүйл бий болно.

Тодруулга №19

Өмнөд Африкт Зэвсэгт хүчнийг иргэний хуулийн хэрэгжилтэнд ашигласан тухай

Өмнөд Африкийн Үндэсний Батлан Хамгаалах Газар нь олон нийтийн хэв журам бүр мөсөн алдагдаж, Өмнөд Африкийн Цагдаагийн байгууллагын хүчин чадал мөхөсдсөн тохиолдолд буюу үндэстнээ авран хамгаалах нөхцөл байдал үүссэн үед Зэвсэгт хүчнийг татан оролцуулсан байна. Зэвсэгт хүчнийг улсын дотоод үйл ажиллагаанд оролцуулах нь парламентын хяналт болон үндсэн хуулиар заагдсан эрх үүргийн дагуу шийдэгдэх асуудал бөгөөд хуулиар зохицуулагдана.

Эх сурвалж: „Ардчилсан тогтолцооны үеийн батлан хамгаалалт“, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндэсний Батлан Хамгаалахын Цагаан ном

Нийгмийн үүрэг хариуцлага

Зэвсэгт хүчин, ялангуяа мэргэжлийн бус армид улс орны өнцөг булан бүрээс ирсэн, янз бүрийн нийгмийн давхарга, үндэстэн ястны хүмүүстэй хамтран ажилдгаараа улс орны бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулдаг гэж үздэг. Энэ нь цагаачлалын урт удаан хугацааны түүхтэй орнуудад цэргийн амьдрал нь янз бүрийн үндэстэн ястныг нэг үзэл санаагаар хүмүүжүүлж байдгаараа онцлогтой байдаг. Армийн өөр нэг чухал үүрэг хариуцлага бол цэргийн боловсролоос гадна ерөнхий боловсрол олгох боломжийг нээж өгдөг. Ингэснээр ирээдүйд ажиллах боломж бага буюу боломжгүй байсан хүмүүсийн хувьд цэрэгт явснаар давуу талтай болно. Үүнээс гадна цэргийн газар ялангуяа хөгжиж буй орнуудад зах хязгаар нутагт иргэний засаг захиргааны ажилд, мэдлэг

боловсрол бүхий өндөр настнаар хичээл заалгах, эмнэлгийн урьдчилсан болон анхан шатны тусламж үзүүлэх, экологийн сүйрлээс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээ авч үйл ажиллагаанд нь тусалдаг.

Дээр дурдсан цэргийн албаны нийгмийн үүрэгт ажил нь арми нийгмийн хөгжилд хэрхэн эерэг хэлбэрээр хувь нэмрээ оруулж болохыг харуулж байна. Зарим оронд нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд Зэвсэгт хүчин сөрөг үр дагавартайгаар оролцож байсан жишээнүүд нэлээд бий. Жишээ нь зарим оронд Зэвсэгт хүчин улс төрийн амьдралд хутгалдан төр засагт заналхийлэх байдал бий болно. Мөн Зэвсэгт хүчин бизнес харилцаанд нөлөөллөө тогтоон улсын төсвийн орлогоосоо гадуур нэмэгдэл орлоготой болж, ардчилсан хяналт, шалгалт ч үгүй болж болно.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Армийн үүрэг даалгавар

- ▷ цэргийн үйл ажиллагаанд:
 - цэргийн хууль тогтоомж, дүрэм журмыг нарийн тодорхойлох;
 - үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд бодлого нь зохицсон байх;
 - нийгмийн зүгээс нэн түрүүн шаардлагатай аюулгүй байдлын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх;
 - зэвсэгт хүчний тэргүүн зэргийн үүрэгт ажил болох үндэсний халдашгүй дархан байдал, олон улсын хууль тогтоомжийн биелэлт, хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах зэрэг үйл ажиллагаанд цэргийн бус үүрэгт ажил нь саад учруулахгүй байх.

Батлан хамгаалах салбарын шинэчлэл

- ▷ Парламентын хариуцлагатай хороодууд батлан хамгаалах салбарт хийгдэх гэж буй буюу хийгдэж буй шинэчлэлийн талаар илтгэл сонсох, холбогдох нөлөөллийн шинжилгээтэй танилцах нөхцлөөр хангах, энэ талаар асуудал дэвшүүлэх.

Зэвсэгт хүчнийг иргэний хууль хэрэгжүүлэлтэд татан оролцуулах нь

- ▷ Зэвсэгт хүчнийг иргэний хууль хэрэгжүүлэлтэд оролцуулах нь хүсээд байх зүйл биш боловч өөр аргаар зохицуулж болохгүй тохиолдолд парламент үүнийг зөвшөөрч болох талтай;
- ▷ Зэвсэгт хүчнийг иргэний хууль хэрэгжүүлэлтэд оролцуулахдаа:
 - Ямар тохиолдолд оролцуулах;
 - Оролцооны хэв маяг, хэр хэмжээ;
 - Хугацаа;
 - Ямар тохиолдолд аль анги, нэгтгэлийг татан оролцуулах;
 - Зэвсэгт хүчнийг оролцуулах, оролцоог таслан зогсоох шийдвэр гаргах байгууллага;
 - Тухайн үед хууль тогтоомж зөрчих, хүний эрхийг хөсөрдүүлэх явдал гарсан тохиолдолд таслах шүүх байгууллага зэргийг хуулинд тодорхой зааж, зохицуулж өгөх, эрх мэдлийг хязгаарлан тогтоох шаардлагатай.
- ▷ Нэгжлэг явуулах, гэрийн хорионд оруулах, гал нээхээс өмнө зохих зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байхыг хуульчлах.
- ▷ Ийнхүү Зэвсэгт хүчнийг татан оролцуулснаар хүний эрх, эрх чөлөөг эдлэх боломжид үзүүлэх нөлөөг хянах, тэнцвэржүүлэх, парламентын болон бусад хэлбэрийн механизмыг бий болгох.

9 дүгээр бүлэг

Улсын бусад цэрэгжсэн байгууллагууд

Улсын бусад цэрэгжсэн байгууллагууд (УБЦБ) гэсэн үг нь уг үгийг хэрэглэж байгаа улс орон болон хууль тогтоомжийн дэг жаягаас шалтгаалан янз бүрээр ойлгогдож болох юм. Ямар ч болов УБЦБ-т хувийн хэвшлийн цэрэгжсэн байгууллагуудаас ялган салгаж ойлгох шаардлагатай. Лондон хотноо төвтэй Олон Улсын Стратеги Судалгааны Хүрээлэнгийн тодорхойлсноор УБЦБ-д (хагас цэрэгжсэн гэх ч бий) цагдаагийн байгууллагууд, гаалийн хяналт, хил хамгаалалтын газрууд хамрагдана гэжээ. Гэхдээ эдгээр байгууллагууд нь цэргийн бэлтгэл сургуулилттай, Зэвсэгт хүчний адил тоноглогдсон, дайны байдлын үед цэргийн байгууллагын удирдлагын доор үйл ажиллагаа явуулах ёстой байвал УБЦБ-д хамруулан тооцно гэжээ.

Дэлхийн бараг бүх улс оронд цэргийн анги, нэгтгэлийн хажуугаар УБЦБ байдаг. Ингэхдээ эдгээр байгууллагууд нь Зэвсэгт хүчинтэй нягт холбоотой, зарим тохиолдолд цэргийн анги, нэгтгэлээс тоног хэрэгсэл хүлээн авдаг, тэдний сургалтанд хамрагддаг, цэргийн баазад нэвтрэн орох эрхтэй, үүнээс гадна тусламж авах боломжтой байдаг байна.

УБЦБ нь иргэдийн улс төрийн үйл ажиллагааны үеэр зохистой бус хэрэгсэл ашигласан, эсвэл хүний эрхэнд халдсан тохиолдол олноор гарч байсан. УБЦБ-ыг бий болгосноор иргэний цагдаа, Зэвсэгт хүчний хоорондын зөрчил ихэсдэг. Иймээс ч эдгээр байгууллагуудын үүрэг, нөхцөл байдлыг нарийн тодорхойлох шаардлагатай. УБЦБ-ыг олон улсын аюулгүй байдлын үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах нь чухал бөгөөд парламент нь үүнтэй холбоотой хууль тогтоомжийг баталж, засгийн газраар мөрдүүлэх хэрэгтэй. Тухайн улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд нь парламентаас УБЦБ-д тавих хяналтыг зөвшөөрөх шаардлагатай. Учир нь улсаас санхүүжиж байгаа аливаа байгууллагыг парламентын хяналтад байлгах ёстой гэсэн утгаараа ч биш, эдгээр байгууллагуудыг янз бүрийн зорилгод, хяналтгүйгээр ашиглаж болох боломжтой учраас,

болзошгүй аюулаас сэргийлэхийн тулд энэ шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Тодруулга № 20			
Улсын бусад цэрэгжсэн байгууллагуудын тухай сонгон авсан орнуудын жишээ			
Улс	Зэвсэгт хүчин дэх нийт ажилчин, албан хаагчдын тоо	Улсын бусад цэрэгжсэн байгууллагуудын ажилчин, албан хаагчдын тоо	Улсын бусад цэрэгжсэн байгууллагуудын хэлбэр
Финлянд АНУ	31,700 1,365,800	3,400 53,000	Хилийн Гвард Иргэний Агаарын хяналт
Оросын Хоблооны Улс	1,004,100	423,000	Хилийн Гвард, Дотоод Явдлын яамны анги нэгтгэл, ОХУ-ыг хамгаалах анги, Холбооны Аюулгүйн Алба, Холбооны Мэдээлэл, Харилцааны алба, Төмөр замын анги гэх мэт.
Марокко	198,500	42,000	Цагдаагийн байгууллага, Туслах хүч г. м.
Франц	294,430	94,950	Цагдаагийн байгууллага
Итали	250,600	252,500	Карабиниери, Дотоод явдлын яамны Олон Нийтийн Аюулгүй байдлын Гвард
Турк	609,700	220,200	Цагдаагийн байгууллага/ Үндэсний гвард, Далайн эргийн

Буркино Фасо	10,000	4,450	Гвард Цагдаагийн Байгууллага, Аюулаас Хамгаалах байгууллагууд
Чили	87,000	29,500	Карабинеро
БН Солонгос Улс	683,000	3,500,000	Иргэний Хамгаалалтын Корпус, Тэнгисийн Цагдаагийн байгууллага
Индонез	297,000	195,000	Цагдаагийн байгууллага, Тэнгисийн цагдаагийн газар, орон нутгийн цэргийн хүчний туслах байгууллагууд
Эх сурвалж: IISS, Цэргийн тайлан 2000-2001, Лондон			

Улсын бусад цэрэгжсэн байгууллагуудын үүрэгт ажил

УБЦБ нь маш олон төрлийн үүрэгт ажилтай байдаг бөгөөд эдгээрээс түгээмэл хэдийг нь доор жагсаавал:

- ✓ Хил хязгаарын хяналт, үүнд эд бараа болон хүн ардыг хууль бусаар хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих,
- ✓ Бослого, хямрал гарахаас сэргийлэх,
- ✓ Онцгой байдлын үед дэг журам тогтоох, улсын тэргүүн болон чухал ач холбогдол бүхий байгууламжуудыг хамгаалах, жишээ нь цөмийн үйлдвэр.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Урьдах болон дараахь бүлгүүдийн холбогдох хэсгийг уншина уу.

10 дугаар бүлэг

Цагдаагийн байгууллагын ТОГТОЛЦОО

Ардчилсан орнууд дахь цагдаагийн байгууллага

Цагдаагийн байгууллага (ЦБ) нь ямар ч тохиолдолд хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ёстой. ЦБ нь хэрэгжүүлэх гэж байгаа хуулиндаа өөрсдөө захирагдана. Түүнчлэн цагдаагийн байгууллагын үүрэг гэмт хэрэг шүүн таслах тогтолцооны өмгөөлөх, шүүх, цагаатгах зэрэг байгууллагуудынхаас ялгаатай байх ёстой. Сайн засаглалын үүднээс авч үзвэл аливаа улс орон, нийтийн аюулгүй байдлыг хангахдаа хувь хүний эрх чөлөө, хүний эрхийг эрхэмлэх ёстой байдаг. Ардчилсан нийгмийн гишүүн цагдаагийн байгууллагаас шударга, төвийг сахисан, урьдчилан таамаглаж болохуйц үйлдлийг хүлээж байдаг. Цагдаагийн байгууллагын хүчийг олон нийтийн асуудал шийдэхэд ашигласнаар улс орон дахь ардчиллын чанарыг харуулж өгнө.

Тодруулга №21

Цагдаагийн байгууллагын ардчилсан үйл ажиллагааны гол хэлбэрүүд

- ▷ Цагдан сэргийлэх ажиллагаанд хуулийн заалтыг эрхэмлэн, мэргэжлийн ёс зүйн журмын дагуу үйл ажиллагаа нь явагдах ёстой;
- ▷ Ардчилсан хэлбэрийн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь хүний эрхийг дээдлэн хүндэлж, олон нийтийн аюулгүй байдлыг бий болгохыг чармайх;
- ▷ Цагдаагийн хариуцлагад ил тод байдал, дотоод ба гадаад хяналт шалгалтын механизм хангагдсан байх;
- ▷ Ардчилсан хэлбэрийн цагдан сэргийлэх үйл ажиллагаа нь доороос дээш чиглэсэн байх ба хувь хүмүүсийн, нийгмийн бүлэглэлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон нийтийн итгэл татсан, тэдний сэтгэлд нийцсэн, дэмжлэгийг хүлээсэн байх ёстой. Тиймээс энэ нь ил тод байдал, харилцан яриан дээр үндэслэгдсэн байх учиртай ба ихэнх оронд цагдаагийн

байгууллага нь төвлөрсөн бус удирдлагатай байж ингэснээрээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн түргэн шуурхай, зохистой үйл ажиллагаа явуулах боломжтой болдог байна.

Онцгой хамгааллын хэрэгцээ

Цагдаагийн байгууллага нь хууль хэрэгжүүлэх салбарын хамгийн чухал хэрэгсэл бөгөөд нийгмийн зүгээс ногдуулсан үүрэгт ажлаа биелүүлэхдээ хууль ёсоор албадан шаардах монополь эрхтэй байна. Хэдийгээр энэ нь хууль ёсны эрх боловч зарим цагдаагийн ажилтнууд энэ эрхээ хүч хэрэглэх, хүний эрхэнд халдах, дарамт учруулах, авилгал авах зэргээр буруугаар ашиглах байдал ажиглагддаг. Иймээс ардчилсан нийгэм дэх цагдаагийн байгууллага нь улс төрчид, хүнд сурталтан, цагдаагийн байгууллагын бус, нийгмийн эрх ашгийг хамгаалах онцгой хамгааллын үүрэг хүлээнэ. Цагдаагийн байгууллагын санхүүжилт нууц байдаг бөгөөд үйл ажиллагааны хувьд хараат бус, хууль хэрэгжүүлэхдээ төвийг сахисан, мэргэжлийн төвшинд үйл ажиллагаа нь явагддаг байх ёстой. Цагдаагийн ажилтнууд нь мэргэжлийн ёс зүйн журамд захирагдаж, үүнийг эрхэмлэх ёстой. Энэхүү ёс зүйн журмын заалтанд хүний амь насыг хүндэтгэх, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны зорилгод хүрэхийн тулд хүч хэрэглэх зайлшгүй шаардлагатай болсон тохиолдолд, хуулинд зөвшөөрөгдсөний дагуу хүч хэрэглэх ба ингэхдээ хүч хэтрүүлэн хэрэглэхгүй байх зарчмыг дээдлэх ёстой. Улс төрийн болон шүүхийн өмнө хүлээх гадаад хариуцлагаас гадна цагдаагийн байгууллага нь дотоод хариуцлага хүлээх тогтолцоотой байна. Цагдаагийн буруутай үйл ажиллагаа, олон нийтийн санал шүүмжлэлийг дотооддоо хянан шалгах тогтолцоо цагдаагийн мэргэжлийн байгууллагуудад заавал шаардлагатай.

Тодруулга №22

Аюултай байдал бий болох нөхцөл

Аюулаас хамгаалах хүчнийг ардчилсан бус хэв маягаар удирдах нь аюулаас хамгаалах салбарт нэн түрүүн эрхэмлэх зүйлсийн харьцааг алдагдуулах эрсдэлд хүргэж болох юм. Олон оронд Зэвсэгт хүчний аюулгүй байдалд илүүтэй анхаарснаас болж засгийн газар нь цагдаагийн байгууллагыг хэт цэрэгжүүлэх (ингэснээр цагдаагийн байгууллага Зэвсэгт хүчний хоорондын ялгаа арилах) эсвэл цагдаагийн байгууллагын санхүүжилт

багассанаас болж ард иргэдийн аюулгүй байдал, тайван амьдралын баталгааг хангах чадваргүй болсон байдаг. Ялангуяа бага орлогтой оронд цагдаа болон бусад хүчний байгууллага зохисгүй өчүүхэн цалин хөлс, хязгаарлагдмал буюу ямарч сургалтгүй, авилгалд автсан удирдлага ба бичиг үсэг үл мэдэх явдал өндөр төвшинд байдаг. “Ардчилал дөнгөж эхлэж буй орнуудад сонгуулаар сонгогдсон тэргүүлэгчид ихэнх тохиолдолд албан тушаалдаа хэвээр байхын тулд цэргийн анги нэгтгэлүүдийг хамруулсан хүчний байгууллагуудын хандлагаас их хамааралтай байдаг. Учир нь тухайн орнуудад хүчний байгууллагууд нийгэмд хамгийн хүчирхэг байдаг юм. Чухам ийм шалтгааны улмаас тэргүүлэгчид хүчний байгууллагуудын эрх мэдлээс өөрсдөө хамаардаг тул тэдний ил тод байдал болон санхүүгийн хариуцлагатай хандлагыг бүрдүүлэхэд идэвхтэй эсэргүүцдэг байж болно”.

Эх сурвалж: Хүний хөгжлийн тайлан, 2002

Дэмжигч олны санаачлага

Цагдаагийн байгууллагад хяналт тавих үйл ажиллагааг доороос нь дээш чиглэсэн хууль зүйн механизмын тусламжтайгаар сайжруулж болох юм. Ингэхдээ хүний эрхийн төлөө байгууллагууд нь анхан шатны төвшинд цагдаагийн байгууллага олон түмний итгэлийг олоход туслах үйл ажиллагаа явуулбал үр дүнтэй байдаг. Цагдаагийн үйл ажиллагааны талаар иргэдийн санал шүүмжлэлийг хүлээн авах иргэний хяналтын байгууллага байгуулснаар цагдаагийн байгууллага нь өөрсдийн үйлчилгээ үзүүлж байгаа хэсгийн захиргаанд тайлагнах үүрэгтэй. Зарим тохиолдолд иргэний аюулаас хамгаалах сайн дурын бүлгүүд, тухайн хэсгийн удирдагчдыг оролцуулсан орон нутгийн аюулгүйн зөвлөл байгуулах нь орон нутгийн цагдаагийн үйлчилгээг сайжруулахад эерэг нөлөөлөлтэй байна. Хэв журам сахиулагчид, иргэний сайн дурын бүлэглэлүүдийг цагдаа, тагнуулын байгууллага, Зэвсэгт хүчний түрэмгий үйл ажиллагаанаас хамгаалах хууль тогтоомж зайлшгүй шаардлагатай.

Тодруулга №23

Эритрэа дахь цагдаагийн үйл ажиллагаа: хөгжиж буй орны жишээ

Цагдаагийн байгууллага болон засгийн газрын хоорондын харьцаа нь олон янзын дүр зургийг харуулж болох талтай. Үүнийг

тайлбарлахдаа хууль мөрдүүлэхийн тулд хүч хэрэглэж болох, мөн нийт ард иргэдэд зориулсан үйлчилгээ үзүүлэх гэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны хоёр үндсэн зарчмыг хэрхэн баримталж байгааг авч үзэх хэрэгтэй. Эритрея шиг хөгжиж буй гэж нэрлэгддэг орнуудын хувьд дээрх асуудал хурцаар тавигддаг. Энэ улс 30 жилийн турш Этопиос салан тусгаарлах тэмцэл явуулж байгаа бөгөөд 1998, 1999 онуудад тэмцэл дахин эхэлснээр уг тэмцэл дуусах болоогүй байгаа нь харагдсан юм. 1990-ээд оны эхээр цагдаагийн хүчнийг байгуулахдаа урьд нь чөлөөлөх армид байсан 5000 гаруй офицерыг татан оролцуулсан. Ингэх шалтгаан нь Улс төрийн эрх мэдэлтнүүдийн дунд урьд нь армид алба хааж байсан хүмүүс Этиопийн ч, Эритреягийн цэрэгт алба хааж байсан байна.

Эрүүгийн гэмт хэргийн мөрдөн байцаалтын арга хэлбэр, түүнээс гадна цагдаагийн академийн барилга, сургалтын төлөвлөгөө гээд бүхий л зүйлсд Голландын цэргийн хүчин тусламж үзүүлсэн. Хандивлагч улсын хувьд, тухайн улсын цэргийн эрх дархтнуудын хувьд ч соёл, түүх, ёс заншлын шугамаар харилцан солилцоо хийх шаардлага гарч ирсэн. Учир нь цэргийн алба хааж байсан хүмүүс, энгийн нэг сэргийлэхийн ажил хийгээд явж байгаа хүмүүсийн хүчийг хэдийд яаж хэрэглэх талаар ойлгох ойлгоц маш ялгаатай болох нь харагдсан. Голландын засгийн газраас санхүүжүүлсэн солилцооны төслийн зорилго нь дэг журам, хууль дүрмийг мөрдүүлэхийн тулд хүч хэтрүүлэн хэрэглэхгүй байх цагдаагийн ардчилсан үйл ажиллагааг бодит утгаар ойлгуулахад чиглэгдсэн байсан.

Эх сурвалж: Casper W. Vroom, Маастрихтийн Их сургууль, Голланд, Эритреягийн Цагдаагийн байгууллагын соёлын солилцооны төсөлд оролцогч, 2002 он.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Ардчилсан нийгэм дэх үйл ажиллагааны хүрээ

- ▷ Цагдаагийн байгууллагыг үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн заалтын хүрээнд явуулдаг болгох;
- ▷ Ард иргэд хэн боловч цагдаагийн ажилтан шударга, төвийг сахисан, үлгэр жишээч байдагт итгэсэн, үүргээ ёс зүйн баримт бичгийн дагуу биелүүлдэг болгох, үүндээ НҮБ-ын Хууль хэрэгжүүлэгч ажилтнуудын үйл ажиллагаагаа явуулдаг баримт бичгүүдийг мөрдлөг болгодог байх (Тодруулга №65-ыг үзнэ үү) .

Сургалт

- ▷ Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа хүч хэрэглэх шаардлага гарвал хэтрүүлэн хэрэглэхгүй байх зарчим баримталдгийг мэргэжлийн сургалтанд тусгасан байх ба сургалтанд ардчиллын болон ёс зүйн хувьд эрхэмлэх зүйлс, хүний эрх, хүйсийн ялгааны асуудлыг нэмэн оруулах (7 дүгээр бүлгийг үзнэ үү).

ҮI, ҮII, ҮIII хэсгийн санхүү, боловсон хүчин, эд материалын эх сурвалжийн талаар өгсөн зөвлөгөөг үзнэ үү.

11 дүгээр бүлэг

Нууц байгууллагууд ба Тагнуулын алба

Тагнуулын алба нь (зарим тохиолдолд аюулаас хамгаалах алба гэж бас нэрлэдэг) улс орны аюулгүй байдал, түүний язгуур эрх ашгийг хэрхэн хамгаалах талаар мэдээллийн бие даасан шинжилгээ хийдгээрээ ямар ч улс орны хувьд улс төрийн тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Энэ байгууллага нь хууль хэрэгжүүлэх салбараас хамааралтай байдаг ч үйл ажиллагааг хянахад парламент чухал үүрэг гүйцэтгэнэ.

Олон улсыг хамарсан терроризмын үйл ажиллагаа, хар тамхины наймаа, хууль бусаар хил нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус цагаачлал зэрэг улс орны дотоодын аюулгүй байдалд заналхийлж байгаа эрсдэлүүд тагнуулын байгууллагын хүчин чадлыг сайжруулахыг улам бүр шаардаж байна. Нэн ялангуяа 2001 оны 9 дүгээр сарын 11-нд болсон терроризмаас хойш тагнуулын үйл ажиллагаа маш чадварлаг байх шаардлага нэмэгдсэн. Дээрх хэрэг явдал болсноос хойш хэд хэдэн орны засгийн газар интернэт, цахилгаан холбооны утас, факсын харилцаа зэргийг хянах зэргээр тагнуулын албаддаа илүү эрх мэдэл олгосон байна (Терроризм гэсэн 20 дугаар бүлгийг үзнэ үү).

Шинээр гарч ирж байгаа технологиуд нь сэжигтэй этгээдүүдийг хараа хяналтандаа байлгах, илрүүлэх, баривчлах үйл ажиллагааг сайжруулах боломжийг өргөтгөж өгсөн бөгөөд тагнуулын байгууллагын өөр хоорондын болон гадаадтай харилцах хамтын ажиллагаа өргөжсөн. Тагнуулын байгууллагуудын эрх мэдэл ихэсхэд иргэдийн эрх чөлөө, хүний эрхийг тэнцвэртэй байлгах асуудал парламентаас шалтгаална.

Тагнуулын байгууллагын мөн чанар

Тагнуулын байгууллагын мөн чанар нь мэдээлэл олж авах, түүнд дүн шинжилгээ хийхэд оршино. Энэ үйл ажиллагаа нь дээд зэргийн нууцлалтай байхыг шаарддаг. Нөгөө талаас

олж авсан мэдээллийг ардчилсан улс төрийн хүрээнд буруугаар ашиглах боломжтой байдаг. Энэ тохиолдолд тагнуулын алба нь өөрийн хамгаалах ёстой нийгэм, улс төрийн тогтолцоонд өөрөө аюул учруулж эхэлнэ. Ийм учраас засгийн газрын хяналт шалгалтаас гадна, парламентын ардчилсан хяналт байх зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Сайн үйл ажиллагаатай, хүч тэнцвэржсэн тогтолцоо бий болгож чадсанаар засгийн газар, парламент тагнуулын албыг өөрийн улс төрийн сонирхолд ашиглахаас урьдчилан сэргийлж чадна.

Ардчилсан нийгэмд тагнуулын алба нь үйл ажиллагааны хувьд үр өгөөжтэй, улс төрийн хувьд төвийг сахисан байхыг эрмэлзэх ёстой бөгөөд мэргэжлийн ёс зүйд захирагдаж, хуулийн хэмжээнд олгогдсон эрхийн хүрээнд, үндсэн хуулиар заасан хэм хэмжээний дагуу бусад улсын ардчиллын практикийн дагуу үйл ажиллагаа явуулна.

Тагнуулын байгууллагын ардчилсан хяналт нь тагнуулын байгууллагыг улсын мэдэлд байгуулан, тодорхой, нэг бүрчлэн заасан ажлын хүрээг парламентаар баталж өгснөөр эхлэнэ. Байгууллагын дүрэмд тагнуулын албаны эрх мэдлийн хязгаар, үйл ажиллагааны аргачлал, ямар тохиолдолд тайлагнах ёстойг зааж өгнө.

Тодруулга №24

Парламентаас Тагнуулын албанд зориулан батлах тусгай төсөв: Аргентины жишээ

„Үндэсний тагнуулын албаны тухай (2001 оны 11 дүгээр сарын 27) хуулийн (дугаар 25.520) 37 дугаар зүйл: Үндэсний Конгрессийн хоёр танхимын хамтарсан хороо нь Тагнуулын албаны бүрэлдэхүүн тус бүрт зориулан батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, шалгалт хийх эрхтэй байна. Ийнхүү танхимуудын хамтарсан хороо нь өөрийн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд нэн түрүүнд дараахь зүйл орно:

1. Засгийн газраас Конгресст оруулсан Үндэсний төсвийн тухай хуулийн төслийн ярилцлагад оролцох, ингэхдээ Засгийн газарт шаардлагатай бүхий л бичиг баримтыг хүргүүлэх ба үүнд дараахь бичиг баримтыг заавал хавсаргасан байна; а) Холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулсан итгэмжлэгдсэн эрх бүхий хүмүүс танилцахыг зөвшөөрсөн

төсвийг хавсаргах; б) зорилго, хөтөлбөр, нэр бүхий зарцуулалтыг агуулсан хавсралт.

2. Энэ хуульд заагдсан тагнуулын байгууллагын бүхий л бие бүрэлдэхүүнээс тусламж хүсэх, харин эдгээр байгуулагууд нь төсвийн үндэслэл, илтгэл зэрэг өөрийн үүрэг даалгавартай холбоотой бүхий л мэдээллийг өгөх үүрэгтэй байна.
3. Хуулиар батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих;
4. Дараахь зүйлсийг багтаасан тайланг жил бүр Үндэсний Конгресст болон Ерөнхийлөгчид илтгэх. Үүнд: а) Тагнуулын байгууллагуудын төсвийн зарцуулалт хэрэгжилтийн талаар хийсэн судалгаа, үнэлэлт; б) Хамтын Хорооноос хяналт, шалгалтын үйл ажиллагаа хэрхэн явагдсан тухай нарийвчилсан тайлбар, шаардлагатай зөвлөгөө, зааварчилгааг хавсаргах.

Эх сурвалж: Аргентины тагнуулын үйл ажиллагааны тухай 25.520 тоот хууль, 2001 оны 11 дүгээр сарын 27.

Ихэнх орнуудад парламентын хяналтын хороо хэлбэрээр парламентаас тавих хяналтыг зохицуулсан байдаг. Батлан хамгаалах, зэвсэгт хүчний зэрэг урьд нь байсан хороодын үүрэгт ажилд тагнуулын албаны асуудлыг хамтатгах нь бий. Зарим оронд харин парламентын хороо, дэд хороодыг зөвхөн тагнуулын байгууллагуудад хяналт тавих зорилгоор байгуулдаг.

Парламентын хороод нь мэдээллийг үзэж танилцах, тагнуулын албаны дарга, тэргүүлэгчдийг томилох, төсвийн зарцуулалтад хяналт тавих эрхтэй байх ёстой (Тодруулга №24-ийг үзнэ үү).

Парламентын хяналтын хорооноос гадна эсвэл ийм хороо байхгүй тохиолдолд зарим оронд хууль хэрэгжүүлэгч байгууллага, засгийн газрын бүрэлдэхүүнээс гадуур тагнуулын албаны хяналтын байгууллага байдаг. Засгийн газар болон гүйцэтгэх салбарын дэргэдэх хяналтын байгууллага нь ихэнхдээ удирдлага, захиргааны эрх үүрэгтэй байдаг ба улс төрийн хүчнүүдийг багтаасан парламентын хянах хорооны үйл ажиллагаатай харьцуулахад хяналтын байгууллагаасаа хамааралтай болсон байх хандлага ажиглагддаг.

Тодруулга №25

Парламентын хороод нууцлал бүхий баримт бичигтэй харьцах практик үйл ажиллагаанаас

- ▷ Шаардлагатай тохиолдолд хороо хаалттай хуралдана.
- ▷ Нууцлалгүй асуудлын талаар олон нийтийн санал хэлэлцүүлгийн дараа болдог Парламентын нийтийн чуулганд илтгэл тавих.
- ▷ Одоо явагдаж байгаа үйл ажиллагаа, эсвэл тагнуулын албаны ажилчид, албан хаагчдийн нэрсийг илрүүлэхээргүй мэдээллийг авах эрхтэй байна.
- ▷ Хороо нь нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн тохиолдолд (олонхийн буюу дийлэнх олонхийн саналаар) мэдээлэл задлах шийдвэр гаргаж болно.
- ▷ Хороо нь шаардсан мэдээллээр үйл ажиллагаагаа хязгаарлаад зогсохгүй өөрийн санаачилгаар тагнуулын алба харъяалалд нь байдаг яамны сайдаас иж бүрэн ойлгоц авахад туслах материал шаардана.

Ардчилсан нийгэм дэх тагнуулын байгууллагуудын хэмжүүр үзүүлэлтүүд

Тагнуулын байгууллага, нууц албадыг хянах хяналтын хэлбэр нь хууль тогтоох уламжлал, улс төрийн тогтолцоо, бусад уламжлалт хүчин зүйлээс хамааралтай. Жишээлбэл Британийн нөлөөлөл дэх Коммон Ло хэмээх (нийтийн) хуульд захирагдаж байсан орнууд уламжлалаа даган аливаа хяналтыг шүүх, хяналтын байгуулагаас тавих нь хяналтыг илүү үр дүнтэй гэж үзэж байхад Европын эх газрын хуулийн тогтолцоо нөлөөлсөн орнууд, мөн сүүлийн жилүүдэд урьд нь дарангуйллын дэглэмд байсан орнуудад хууль тогтоох байгууллагын буюу парламентын хяналтыг илүү чухалчлан үздэг.

АНУ-д хяналтын тогтолцоо хууль тогтоох, гүйцэтгэх, хянах бүхий л салбарт байдаг. Зарим ардчилсан орнуудад омбудсман буюу иргэдийн төлөөлөгч гэсэн албан тушаал байдаг ба энэ нь гарсан гомдлын дагуу тагнуулын алба хүний эрхийг зөрчсөн үйлдэл гаргасан эсэхийг шалган судалж, дүгнэлтийг нийтэд мэдэгддэг байна (16 дугаар бүлгийг үзнэ үү).

Үүрэгт ажлын хүрээ

Тагнуулын албанд хяналт тавих ажиллагаа нь үүрэгт ажлын хүрээ төдийгээр хязгаарлагддаг. Энэ хязгаарлал нь үйл ажиллагааны хэлбэр (дотоодын, сөрөг, гадаадын тагнуулын үйл ажиллагаа), арга барилд хамаарна (үйл ажиллагаанд хэрэглэж буй арга барил, нууц үйл ажиллагаа).

Парламентын нээлттэй буюу хаалттай хэлэлцүүлэг

Ардчилсан нийгэм дэх тагнуулын албанд тавих хяналт ерөнхийдөө бусад салбартай харьцуулахад илүү хаалттай бөгөөд сул хөгжсөн байдаг. Парламентын дэргэдэх тагнуулын албаны үйл ажиллагааг хянах комиссын зөвлөлгөөн ихэнх тохиолдолд бүрэн хэмжээгээр нээлттэй олон нийтээр хэлэлцэгддэггүй. Энэ хорооны гишүүд нь өөрсдийн хүлээн авсан итгэмжлэлийг дээдлэн хүндлэнэ гэсэн тангараг өргөсөн байдаг учраас нэг талаар ардчилсан нийгэм дэх тагнуулын байгууллагын үйл ажиллагаа зүй зохистой, хууль ёсны дагуу байж, ажил тайлагнах үүрэгтэй байх, нөгөө талаар үндэсний аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хадгалах хоёрын хооронд тэнцвэрт байдал бий болгохыг чармайдаг.

Үүрэг даалгаврын хуваарилалт

Тагнуулын үйл ажиллагааг зөвхөн нэг байгууллага явуулахаас сэргийлснээр тагнуулын байгууллагыг хянах тогтолцооны эхлэл тавигддаг. Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын нэг адил бие даасан тагнуулын байгууллагууд байгуулах нь ач холбогдолтой бөгөөд хүнд суртлын аппарат бүхий өрсөлдөөнийг бий болгох боловч ардчилсан хяналтын утга санаанд яв цав нийцнэ. Энэ шалтгаанаар олон оронд дотоодын тагнуулын алба, цэргийн тагнуулын алба гэсэн байгууллагууд байдаг. Энэ хуваарилалт нь ардчилсан хяналт талаас авч үзвэл алс ирээдүйтэй боловч тагнуулын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг тарамдуулна. Үүнийг АНУ-д болсон халдлага харуулсан юм.

Тагнуулын албаны ажилтнуудыг бэлтгэх

Тагнуулын албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх нь хяналтын бас нэг чухал зорилго байдаг. Бэлтгэл

сургуулилалтын хүрээнд жинхэнэ мэргэжлийн төвшинд бэлтгэгдсэн, ардчиллын хэм хэмжээнд захирагддаг, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан бие хүнийг бэлтгэдэгээрээ ач холбогдолтой юм. Ардчилсан нийгэмд энгийн иргэдийг тагнуулын ажилд бэлтгэж, оролцуулахад хүчин чармайлт тавьдаг боловч цэргийн салбарт оролцуулдаггүй.

Мэдээллийн нууцлалыг задлах

Ардчилсан хяналт, ажлын тайлагналын өөр нэг хэлбэр нь тагнуулын үйл ажиллагааны тухай мэдээлэл хэсэг хугацааны дараа нийтэд хүрэх боломжийг бүрдүүлэх явдал юм. Үүнийг мэдээллийн эрх чөлөөний хуулиар баталгаажуулж болох ба нууцалсан материалыг хэсэг хугацааны дараагаар нийтэд хүргэх журмын дагуу гүйцэтгэнэ. Ажлын гүйцэтгэлийн дараахь ил тод байдал нь ардчилсан хяналт бий болох боломжийг нээж өгнө (21 дүгээр бүлгийг үзнэ үү).

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Парламентын хяналтын механизм

- ▷ Танай парламент тагнуулын бүхий л албадын үйл ажиллагааг хянах (Парламентын хороодын тухай 15 дугаар бүлгийг харьцуулж үзнэ) парламентын хороо, дэд хороотой болох;
- ▷ Дээрх хорооны мандат нь нарийн тодорхойлогдсон, эрх мэдлийн хязгаарлалт бага, хороодын гишүүд шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн мэдээллээр хангагдах боломжтой байх;
- ▷ Парламентын хороо үйл ажиллагаа явуулж олж мэдсэн зүйл, гарсан дүгнэлт, зөвөлгөөний талаар илтгэл тавих.

Хууль ёсны ардчилсан үйл ажиллагааны хүрээ

- ▷ Тагнуулын албаны тухай хуулинд дараахь зүйлүүдийг заавал тусгасан байх. Үүнд: хуулийн статус, мөрдлөг, үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, үүрэг даалгавар, даалгавар биелүүлэлтийн тайлан, тагнуулын албаны хяналт. Үүнээс гадна мэдээлэл олж авах тусгай арга барил, тагнуулын ажилтны биеийн байцаалт, тэмдэглэлийг хадгалах, тагнуулын ажилтны хууль ёсны статусыг хуулиар зохицуулах;
- ▷ Тагнуулын алба нь улс төрийн хувьд төвийг сахисан байр сууриаас, мэргэжлийн ёс зүйн баримт бичгийн дагуу, ардчиллын хэм хэмжээнд захирагдаж, иргэний хариуцлагаа ухамсарласны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхийг шалгах;
- ▷ Парламентаас тагнуулын байгууллагыг хянах алба нь тагнуулын байгууллагын ажилтнууд ардчиллын зарчим, хүний эрхийн талаарх сургалтанд хамрагдаж байгаа эсэхийг шалгуулах;
- ▷ Парламент нь төрийн гурван салбарт нэг нь нөгөөгөө нөхөх үүргийг хуульчлан батлах:
 - Гүйцэтгэх байгууллага нь тагнуулын албанд үүрэг даалгавар өгөх, эдгээрийн ач холбогдлын дарааллыг тогтоох хариуцлага хүлээнэ;
 - Парламент нь холбогдох хууль тогтоомжийг баталж, төсвийг хянах, засгийн газрын үүрэг хариуцлагын биелэлтийг хянах, тагнуулын үйл ажиллагааны саадгүй ажиллагааг хангах боловч харин тагнуулын байгууллагын үндсэн үйл ажиллагаанд оролцохгүй байна;

- Тагнуулын албаны ажилтнууд иргэд, байгууллагын хувийн өмч, хөрөнгөнд халдахыг зөвшөөрсөн эсэхийг хянах, тагнуулын хуулинд заасан үүргийнхээ хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналтын байгууллагаас хяналт тавих.

Ил тод байдал, ажлын тайлагнал

- ▷ Парламентаас тагнуулын байгууллагад хяналт тавих хороо нь гүйцэтгэх байгууллагаас боловсруулсан тагнуулийн үйл ажиллагааны ерөнхий бодлоготой танилцсан байна.
- ▷ Парламентаас тагнуулын байгууллагад хяналт тавих хороо нь тагнуулын байгууллага хууль ёсны дагуу, зохистой, хариуцлагатай үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд, үүний зэрэгцээ зохих ёсны итгэмжлэл төрүүлэхүйц, бас үр өгөөжтэй ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавина.
- ▷ Парламентын хороо нь тагнуулын байгууллагын үйл ажиллагааны талаар иж бүрэн мэдээлэлтэй байх, тагнуулын болон нууц албадын дарга нарыг томилох эрхтэй байна.

Итгэмжлэлтэй холбоотой асуудлууд

- ▷ Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь тагнуулын байгууллагын ажлын хариуцлага, тэдэнд тавих хяналтын чухал хэрэглүүр болно.
- ▷ Итгэмжлэл ба ажлын хариуцлагыг тэнцвэржүүлэх зорилгоор тусгай төсвүүдэд аудит хийнэ.
- ▷ Урьд нь нууцлагдаж байсан материалыг нийтэд зарлах хэмжүүр үзүүлэлтүүд, хугацааг хуулиар тогтоосноор ил тод байдлыг бий болгоно. Мэдээллийн эрх чөлөөний зарчмын дагуу олон нийтэд танилцуулж болох илтгэлүүдийн зөвшөөрлийг тодорхой үе шаттайгаар явуулна.

Терроризмын тухай 20 дугаар бүлэг, санхүүгийн эх сурвалжийн тухай ҮІ хэсгийг үзнэ үү.

12 дугаар бүлэг

Аюулаас хамгаалах салбар болон Цэргийн хувийн хэвшлийн байгууллагууд

Төр нь хүч хэрэглэх хууль ёсны монополь эрхтэй байдаг бөгөөд аюулгүй байдлын талаар үйлчилгээ үзүүлэх цорын ганц хүчин юм. Ингэхдээ дотоодын аюулгүй байдлыг хангах, гадаад аюул заналхийллээс сэргийлэх үүргийг хүлээнэ. Хэдий ийм боловч сүүлийн жилүүдэд дотоодын хямрал их гарах болсноос аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагааг хувьчлах шинэ үзэгдэл өргөн дэлгэр болж байна. Үүнтэй холбогдуулан аюулаас хамгаалахын салбарын төрийн бус байгууллагууд гарч ирснээр аюулаас хамгаалах салбарт тавих ардчилсан хяналтын уламжлалт хэлбэрийг шинэчлэх шаардлага гарч ирсэн.

1990-ээд оноос хойш аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн байгууллагууд шинээр төрөн гарсаар байна. Эдгээр байгууллагуудыг ихэнхдээ гурван том ангилалд багтаан үзэж болно. Үүнд: цэргийн хувийн хэвшлийн компаниуд, аюулаас хамгаалахын салбарын хувийн хэвшлийн байгууллагууд, хөлсний цэрэг. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд улсаас хяналт тавих нь чухал билээ.

Аюулаас хамгаалахын болон цэргийн хувийн компаниудын үүрэгт ажил, эдгээрээс учирч болох аюул

Аюулаас хамгаалахын болон цэргийн хувийн компаниудын үйл ажиллагааг хуульчлахаар зэхэж байгаа улсууд нь хямралын дараахь шатанд, эсвэл төрийн эргэлт гарсан орнууд байдаг. Эдгээр улсууд нь зохих цэргийн бэлтгэл, шаардагдах хүч байхгүйн улмаас ийм үйлдэл хийдэг. Мөн нийт ард түмний аюулгүй байдлыг хангах чадваргүй, аюулаас хамгаалах салбарт цор ганц ардчилсан хяналт бүхий хүч хэрэглэх монополь эрхийг эзэмшигч байх сонирхолгүй, эсвэл улс хоорондын хямралд өртөөд байгаа гэх зэрэг шалтгаанууд байдаг.

Дээрх шалтгаан байгаа тохиолдолд Аюулаас хамгаалахын болон цэргийн хувийн компаниудтай байх богино хугацааны үр дүн нь сайн нөлөөтэй байдаг. Ялангуяа мэргэжлийн ур чадвар, бэлтгэл сургууллалт хийх хүчин чадлыг үндэсний хэмжээнд сайжруулж, улс орон бүр өөрийн хүчинд итгэх итгэлийг бий болгоно. Ардчиллын үйл явцад нөлөөлөх сөрөг зүйл их байж болох бөгөөд үүнийг тодруулга №26-д харууллаа.

Олон нийтийн, ардчилсан сонгуулиар сонгогдсон байгууллагууд нь, юуны өмнө парламент улсын аюулаас хамгаалах тогтолцоонд зохих, үр өгөөжтэй хяналт тавих механизмыг бий болгохоос гадна, үйл ажиллагаандаа татан оролцуулж байгаа цэргийн буюу аюулаас хамгаалахын мэргэжилтнүүдэд бас хяналт тавих ёстой.

Тодруулга №26

Аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн компаниуд ба эдгээрээс ардчилалд учирч болзошгүй аюулууд

- ▷ Аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн компаниуд нь цэргийн болон аюулаас хамгаалах салбарт тодорхой хэмжээгээр тогтвортой байдал бий болгодог ч, удаан хугацаагаар авч үзвэл зарим засгийн газрын асуудал шийдвэрлэх гол арга зам нь цэргийн хүч хэрэглэх явдал болж болох юм.
- ▷ Гадаадын шинжээчдийг урьж авчирснаар тэдний цэргийн болон аюулаас хамгаалах ямар асуудлаар урьж байгаа, хэрхэн санхүүжих зэрэг асуудлууд гарч ирэх ба сайн засаглалын зүгээс авч үзвэл эдгээр асуудлуудыг нийтийн болон парламентын хэлэлцүүлгээр шийдэх ёстой.
- ▷ Ихэнх тохиолдолд аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн компаниуд нь зэвсгийн зуучлагч зэрэг халхавч доор үйл ажиллагаа явуулдаг.

Хөлсний цэрэг

Хөлсний цэргүүд нь нэлээд дээр үеэс нийгэмд гарч ирсэн үзэгдэл юм. Сүүлийн үед гарсан хямралуудаас харахад хөлсний байгууллагууд нь дэлхийн аль ч өнцөг булан бүрт үүсэн байгуулагдах боломжтой ажээ.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1989 оны 12 дугаар сарын 4-ний 43/ 34 дугаар шийдвэрээр батлагдсан 1989 оны „Хөлсний цэрэг дайчлах, тэднийг үйл ажиллагаандаа ашиглах болон санхүүжүүлэх, хөлсний цэрэг бэлтгэн сургуулилах үйл ажиллагааны эсрэг олон улсын конвенц“-ийн 1-дүгээр заалтанд хөлсний цэрэг гэсэн ухагдахууныг хэрхэн ойлгож болохыг нарийн тодорхойлсон байдаг. Энэ конвенц нь 2001 оны 10 дугаар сарын 20-иос хүчин төгөлдөр болсон боловч цөөн хэдэн орон л гарын үсэг зурсан байна. 1949 оны Женевийн Конвенцийн нэмэлт Протоколын 47 дугаар заалтын тодорхойлолтыг дээрх конвенцийн заалтаар өргөтгөсөн юм (Үүнд юуны өмнө аливаа улс орны төр засгийг түлхэн унагах болон бусад ямар нэг аргаар улсын үндсэн хуулиар тогтоогдсон хэв журмыг тогтворгүйжүүлэх эсвэл газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулах зорилго бүхий хүч хэрэглэсэн ажиллагаанд оролцуулахаар тусгайлан бэлтгэсэн хүмүүстэй холбогдох заалтыг оруулсан).

1 дүгээр зүйл, энэхүү конвенцийн зорилго

1. *Хөлсний цэрэг гэдэг нь а) гадны болон дотоодын зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахаар бүрдүүлсэн; б) дайсагналцах үйл ажиллагаанд, ашиг хонжоо олох зорилгоор оролцохоор бэлтгэгдсэн, мөн үнэн хэрэгтээ мөргөлдөөнд оролцож байгаа талууд материаллаг нөхөн төлбөр олгохоор амласан бөгөөд уг талын зэвсэгт хүчний адил төстэй албан тушаал, алба хааж байгаа хүмүүсийн цалингийн хэмжээний төлбөр олгохоор тогтоогдсон; в) мөргөлдөөнд оролцогч талуудын үндэсний харъяалал, эсвэл талуудын хянаж байгаа газар нутгийн оршин суугч биш; г) мөргөлдөөнд оролцогч талуудын зэвсэгт хүчний харъяалалгүй; д) мөргөлдөөнд оролцогч бус аль нэг улсаас уг улсын зэвсэгт хүчинд харъяалагддаг боловч албан ёсны үүрэг даалгавартай ирээгүй хүмүүсийг хэлнэ.*
2. *Дээрхээс бусад тохиолдолд хөлсний цэрэг гэдэгт*
 - а) *хүч хэрэглэхдээ:*
 - 1) *аливаа улс орны төр засгийг түлхэн унагаах болон бусад ямар нэг аргаар улсын үндсэн хуулиар тогтоогдсон хэв ёс журмыг тогтворгүйжүүлэх;*
 - 2) *аливаа улс орны газар нутгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахаар төлөвлөсөн үйл*

- ажиллагаанд оролцох зорилгоор орон нутгаас болон хилийн чанадаас дайчлагдсан; .
- б) их хэмжээний ашиг хонжоо олох хүсэлтэйгээр оролцож байгаа бөгөөд материаллаг нөхөн төлбөр, хөлс олгохоор тохиролцсон;
- в) тухайн үйл ажиллагаа явагдаж байгаа улсын үндэсний харъяалалгүй буюу оршин суугч биш; г) аливаа нэг улсаас албан ёсны үүрэг даалгавар өгч явуулаагүй,
- д) тухайн үйл ажиллагаа явагдаж буй орны зэвсэгт хүчний төлөөлөгч биш хүмүүсийг нэрлэнэ.

Олон улсын конвенцийн дагуу хөлсний цэрэг дайчилсан, ашигласан, санхүүжүүлсэн, тэдэнд бэлтгэл сургуулилалт хийсэн хэн боловч, ийм үйл ажиллагаа явуулахаар завдах, ийм үйл ажиллагаа явуулахаар завдсан хүмүүсийн холбоотон хэн боловч дээрх конвенцийн заалтыг зөрчиж байгаа юм. Харин засгийн газар нь тусгай үүрэг даалгавар биелүүлэх зорилгоор (байлдааны онгоц жолоодох, террористуудын эсрэг үйл ажиллагаа г.м.) нарийн мэргэжилтнүүдийг урьж авчирч болох юм.

Хувийн хэвшлийн цэргийн байгууллагууд

Хувийн хэвшлийн цэргийн байгууллагууд нь хөлсний цэргийн орчин үеийн, хувийн хэвшлийн хэлбэр юм. Эдгээр байгууллага нь цэргийн албан газрын үйлчилгээ, сургалтын чиглэлээр тодруулбал байлдааны болон байлдааны бус үүрэг гүйцэтгэн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Хууль зүйн үүднээс авч үзвэл эдгээр байгууллага нь аюулаас хамгаалах салбарт ажиллаж байгаад халагдсан, албанаас чөлөөлөгдсөн хүмүүсийг авч ажиллуулдгаараа маш нарийвчлан тогтоосон журамтай байдаг тул хөлсний цэргийн тодорхойлолтод хамрагдахгүй юм. Цэргийн хувийн компаниуд нь байлдааны болон бусад үйл ажиллагааг дэмжихээс гадна, зөвлөгөө өгөх, бэлтгэл сургууль хийх, зэвсэг худалдан авах, тагнуулын мэдээ цуглуулах, барьцаалагдагсдыг аврах зэрэг олон төрлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг. Эдгээр байгууллага нь үзүүлж байгаа үйлчилгээнээсээ үл хамааран зөвхөн хямралын үед буюу хямралын дараахь бүтээн босголтын үед засгийн газрын захиалгаар үйл ажиллагаа явуулдаг.

Хувийн хэвшлийн цэргийн компаний нэг тод жишээ бол АНУ-д байрлах MPRI юм. Энэ нь батлан хамгаалахын салбартай хийсэн гэрээний дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг компани бөгөөд ингэхдээ хуулийн гүйцэтгэх болон удирдах албан тушаалтныг бэлтгэх зэрэг батлан хамгаалах салбартай уялдсан зорилготой байдаг байна. Энэ байгууллагыг 1998 онд армийн ахлах дээд албаны офицерууд байгуулсан бөгөөд одоо хүртэл армид алба хааж байгаад халагдсан хүмүүс үйл ажиллагааг нь явуулдаг байна.

Хувийн хэвшлийн аюулаас хамгаалах компаниуд

Хувийн хэвшлийн аюулаас хамгаалах компаниуд нь бизнесийн үйл ажиллагаа, эд хөрөнгө хамгаалах үйлчилгээ үзүүлж ингэснээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулдаг. Аюулаас хамгаалах салбарын хувийн хэвшлийн компаниуд ийм хэлбэрээр орон бүрт байдаг ба сүүлийн үед эдгээр байгууллагаар үйлчлүүлэх нь өсөх хандлагатай байна. Ялангуяа улс төрийн хямрал гарч байгаа орнуудад бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс улсаас тэдэнд үзүүлж байгаа хамгааллыг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дээрх компаниудад ханддаг. Эдгээр байгууллагууд нь хямралд оролцохдоо цэргийн талаасаа бус эд, хөрөнгө хувь хүмүүсийг хамгаалах гэсэн утгаараа холбогддог. Ямар ч компаниуд нь цэргийн болон аюулаас хамгаалах аль чухал байгаа газарт үйлчилгээг үзүүлдэг.

Аюулаас хамгаалах салбарын хувийн хэвшлийн компаниудын ач холбогдол ихэсч, олноор гарч ирэх болсонтой холбогдуулан ардчилсан байгууллагууд болон парламентаас эдгээр байгууллагад тавих ардчилсан хяналтанд доод талын стандарт хэм хэмжээг бий болгох нь маш чухал юм. Ингэхгүйгээр ардчиллын үндсэн зарчмууд алдагдахад хүрнэ.

Парламентын гишүүний хувьд та хийж болох вэ?

Хууль тогтоомж

- ▷ Танай улс 1989 оны 12 дугаар сарын 4-ний 43/34 дугаар тушаалаар батлагдсан хөлсний байгууллагад хүч татах, үүнийг хэрэглэх, санхүүжүүлэх, бэлтгэх, сургуулилалт хийхийн эсрэг олон улсын конвенцийн гишүүн орон болох, мөн түүнчлэн холбогдох хууль тогтоомжийг зохих ёсны дагуу хэрэгжүүлэх;
- ▷ Аюулаас хамгаалах салбарын болон цэргийн хувийн хэвшлийн компаниудын үйл ажиллагааны хүрээг хуульчлах асуудал шийдэгдсэн эсэхийг хянах.

Хэм хэмжээг дээдлэх

- ▷ Аюулаас хамгаалах, цэргийн хувийн хэвшлийн компаниуд улс төрийн хямралтай улс оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа бол Аюулаас хамгаалах салбарын болон цэргийн хувийн хэвшлийн компаниудын танай улсын хууль тогтоомжид үндэслэгдэн явуулж байгаа ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын стратеги, гадаад бодлого, холбогдох олон улсын хууль тогтоомж, хэм хэмжээтэй уялдаж байгаа эсэхийг шалгах ажлыг парламентаар дэмжүүлэх;
- ▷ Хувийн хэвшлийн аюулаас хамгаалах салбарын болон цэргийн компаниуд нь зэр зэвсэг нийлүүлэх хорио тогтоосон бүсэд үйл ажиллагааг явуулахыг хуулиар хориглох.

Ил тод байдал

- ▷ Аливаа улс орнууд дах аюулаас хамгаалах салбарын болон цэргийн хувийн хэвшлийн компаниуд нь парламентын зөвшөөрөлгүйгээр өөрийн газар нутаг дээр үйл ажиллагаагаа явуулахгүй байх арга хэмжээ авах ба үүнд засгийн газрын хүсэлтээр ажиллах компаниудад хамаарна.
- ▷ Засгийн газраас аюулаас хамгаалах салбарын болон цэргийн хувийн хэвшлийн компаниудад зориулж байгаа төслийг парламентаар хянуулдаг болгох.

Хариуцлага хүлээх

- ▷ Аюулаас хамгаалах салбарын болон цэргийн хувийн хэвшлийн компаниудын үйл ажиллагааг засгийн газар хариуцаж парламентад ажлаа тайлагнана. Энэ нь хуулиар заагдаж, амьдралд мөн энэ маягаар хэрэгжих ёстой бөгөөд үйл ажиллагаа нь дотоод ч, гадаад ч явагдаж байсан мөн адил хүчинтэй байна.

IV ХЭСЭГ

Парламентын хяналт дахь үндэсний аюулгүй байдал

Төлөв байдал ба механизм

13 дугаар бүлэг

Парламентын сонгодог хяналтын төлөв байдал

Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт нь засгийн газар, аюулгүй байдлын албатай холбоотойгоор уг парламентын эрх мэдлээс хамаарна. Ийм нөхцөл байдалд эрх мэдэл гэдэг нь парламентад илэрхийлэгддэг шиг хүмүүсийн нийтлэг эрх ашгийн үүднээс засгийн газрын үйл ажиллагаа, эрх мэдэлд нөлөөлөх чадвар юм. Мөн парламентаас батлагдан гарсан бодлого, хууль тогтоомж, шийдвэр, төсвийн биелэлтийг хянах чадвар юм. Энэхүү эрх мэдэл зөвхөн үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд бус, бас парламентын дүрэм журам, туршлагын хүрээнд хэрэгждэг.

Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын сонгодог хяналт дараахь төлөв байдалтай байна. Үүнд:

- ✓ Гарцаагүй тодорхойлогдсон үндсэн хуулийн болон бусад хууль зүйн хүрээний эрх мэдэл;
- ✓ Туршлага;
- ✓ Үндэс суурь ба ур чадвар;
- ✓ Улс төрийн ашиг сонирхол.

Үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд дэх эрх

Аюулгүй байдлын салбарт тавих парламентын хяналтанд үндсэн хууль /үүнтэй адил бусад хуулиуд/ хамгийн чухал эрх зүйн үндэс болно. Тухайн улсын улс төр, эдийн засаг, соёл урлаг, нийгмийн байдлаас хамаарч үндсэн хууль улс орон бүрт харилцан адилгүй байхад ихэнх үндсэн хуульд дараахь нийтлэг зүйлсийг заасан байдаг. Үүнд:

- ✓ Дээд албан тушаалтан /ерөнхийлөгч, ерөнхий сайд буюу батлан хамгаалахын сайд зэрэг/ улсын аюулгүй байдлыг хариуцахаар;

- ✓ Дээд албан тушаалтан парламентын өмнө өөрийн үүрэгт ажлаа хариуцахаар.

Үндсэн хуулийн заалтууд хууль зүйн хамгийн өндөр статустай байдаг учраас аюулаас хамгаалах салбартай холбоотой парламентын эрх мэдлийг үндсэн хуульд тусгаж өгөх нь чухал юм. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь тийм ч хялбар биш байдаг. Нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол парламентын олонхийн саналыг авсан байх ёстой. Иймд энэхүү тусгай салбарт тавих парламентын эрх мэдлийг хамгаалах хамгийн сонгодог аргыг үндсэн хуульд заасан байна. Ийм эрх мэдлийг цаашид тодорхой хууль, парламентын дэг журмаар зохицуулж болох юм. Мөн парламентын хяналт, хариуцлагатай холбоотой нийгмийн хэм хэмжээ, туршлагыг хөгжүүлж болох талтай.

Тодруулга №27-д аюулгүй байдлын салбарт тавих парламентын эрхийн талаар өгүүллээ. Эдгээр эрхийг дараагийн бүлэгт авч үзэх болно.

Тодруулга №27

Аюулаас хамгаалах салбарт ардчилсан хяналтыг тогтооход парламентаас хэрэгжүүлж болох арга замууд

1. Ерөнхий эрх мэдэл

- Хууль санаачлах;
 - Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, дахин боловсруулах;
 - Дээд албан тушаалтнаас асуулт асуух;
 - Нотолгоо гаргуулахаар парламентын хуралд дээд албан тушаалтнуудыг дуудах;
 - Нотолгоо гаргуулахаар парламентын хуралд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон иргэдийг дуудах;
 - Нотолгоо гаргуулахаар парламентын хуралд шинжээчдийг дуудах;
 - Дээд албан тушаалтнаас баримт бичгийг авах;
- Парламентын лавлагаа гаргуулах;
 - Байцаалт явуулах.

2. Төсвийн хяналт

- Төсөвтэй холбогдолтой бүх баримт бичгийг шалгах;
- Батлан хамгаалах болон аюулаас хамгаалах салбарын төсвийн хөрөнгөнд өөрчлөлт оруулах, дахин хянаж үзэх эрх мэдлийг эдлэх;

- в. Төсвийн хяналтыг төлөвлөгөө, төсөл, чиг хандлагын төвшингөөр явуулах;
- г. Батлан хамгаалах, аюулаас хамгаалах салбарын нэмэлт төсвийн саналыг батлах /татгалзах/ эрх эдлэх.
- 3. Энхийг сахиулах үйл ажиллагаа /хилийн чанад дахь үйл ажиллагаа:/ батлах, татгалзах тухай парламентын эрх**
- а. Цэргүүдийг хилийн чанад руу илгээхээс өмнө шийдвэр гаргах;
- б. Хилийн чанад дахь үйл ажиллагааны эрх авах: НҮБ-аас эрх олгох;
- в. Үйл ажиллагааны төсөв батлах;
- г. Оролцож буй цэргийн албан хаагчдын эрсдлийг тооцох;
- д. Холбогдох дүрэм журмыг баталгаажуулсан байх;
- е. Тушаал/хяналтын холбоотой байх нөхцлийг бүрдүүлэх;
- ж. Үйл ажиллагааны хугацааг тогтоох;
- з. Гадаадад үүргээ биелүүлж буй цэргүүд дээр зочлох эрхтэй байх.
- 4. Ханган нийлүүлэлт, бэлтгэл**
- а. Ханган нийлүүлэлтийн талаар парламентад мэдэгдэх албан тушаалтны үүрэг;
- б. Гэрээг батлах /гэрээнээс/ татгалзах эрх;
- в. Ханган нийлүүлэлтийн дараахь шатлалуудыг хянах;
- шинэ тоног төхөөрөмжийн хэрэгцээг гаргах;
 - үйлдвэрлэгчдийг харьцуулж сонголт хийх;
 - нөхөн төлбөр болон хохиролгүй болгох асуудлыг хэлэлцэх.
- 5. Батлан хамгаалах, аюулгүй байдлын ерөнхий бодлого: батлах, татгалзах эрх**
- а. Албан хаагчдын тухай төлөвлөгөөг батлах/татгалзах эрх эдлэх;
- б. Ажиллах хүчний дээд хэмжээг тогтоох эрхтэй байх;
- в. Цэргийн дээд албан тушаалтныг/жанжин штабын дарга/ томилох асуудлыг батлах/татгалзах эрхтэй байх буюу зөвшилцөх эрх эдлэх.
- 6. Батлан хамгаалах /аюулаас хамгаалах/ салбарын албан хаагчид**
- а. Боловсон хүчний төлөвлөгөөг батлах, татгалзах эрхтэй байх;
- б. Ажиллах хүчний дээд хязгаарыг тогтоох эрх эдлэх;
- в. Цэргийн өндөр хэмжээний уулзалтыг батлах /татгалзах/ эрх буюу зөвлөх эрх.

Туршлага

Бүх нөхцөл байдал, харилцан ажиллагааг хуулиар зохицуулж үл болно. Иймд харилцан итгэлцэл, хүндлэл гэх мэт нийгмийн хэм хэмжээнд түшиглэн парламентын

хяналтын дадлага, туршлагыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой. Парламентын гишүүдийг бүхэлд нь хамруулж аюулгүй байдлын асуудлаарх шинэ дэвшил хөгжлийн тухай мэдээлэл өгөх нь зөвхөн эрх зүйн хариуцлага, илэрхий байдал төдий биш, хүмүүсийн хооронд харилцан яриаг бий болгож байгаа хэрэг билээ.

Үндэс суурь ба ур чадвар

Аюулаас хамгаалах салбарт хяналт тавих парламентын чадамж нь цаг хугацааны хүчин зүйл, ур чадварын төвшин, мэдээллээс хамааралтай.

Цаг хугацааны хүчин зүйл

Аюулгүй байдлын асуудал болон аюулаас хамгаалах салбарын асуудалтай холбогдох засгийн газрын бодлого, шийдвэрийн талаарх цаг үеийн мэдээллийг парламент авч байх нь чухал юм. Засгийн газар асуудлыг шийдэж эцсийн шийдвэрийг гаргасан тохиолдолд парламент зөвхөн засгийн газрын шийдвэрийг батлах буюу уг шийдвэрээс татгалзахаас өөр сонголт хийдэггүй.

Улс орон хямралд орсон буюу онц байдал үүссэн тохиолдолд засгийн газар маш шуурхай ажиллаж, зөвхөн болсон явдлыг л парламентад мэдээлдэг. Энэ нь парламентаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хэм хэмжээнээс давсан асуудал юм.

Хэтийн болон урт хугацааны бодлогын асуудал хэлэлцэх үед парламентад батлан хамгаалахын төсөв, зэвсэг нийлүүлэлтийн талаарх шийдвэр буюу батлан хамгаалахын үйл ажиллагаа зэрэг чухал асуудлуудыг судлах, хэлэлцэх хангалттай цаг хугацаа бий.

Парламентын гишүүдийн хувьд цаг хугацааны асуудлыг шийдэж болох хамгийн үр дүнтэй арга бол сонгодог төлөвлөгөөг боловсруулах явдал юм. Аюулаас хамгаалах салбарт хяналт тавих сонгодог төлөвлөгөөний зарчмыг тодруулга №28-аас үзнэ үү.

Тодруулга №28

Парламентаас аюулаас хамгаалах салбарт тавих хяналтанд зориулсан сонгодог төлөвлөгөө

Парламентын гишүүд өдөр тутмын мэдээллээр хангагдаж байдаг. Тэдний хэлэлцэх асуудлын ихэнх хэсгийг засгийн газраас товлоно. Цаг хугацааг хожих хамгийн үр дүнтэй арга бол парламентын хяналтын хувьд сонгодог төлөвлөгөө боловсруулах явдал юм. Аюулгүй байдлын асуудалтай холбогдолтой сонгодог төлөвлөгөөнд дараахь зүйлс орно. Үүнд:

Хэлэлцэх асуудлын хүрээ: Парламентын гишүүд иргэдийн үзэл бодол, хэрэгцээг улс төрийн хэлэлцэх асуудалдаа цаг үргэлж тусгахыг хичээх ёстой.

Хамгийн сүүлийн үеийн шинэ үйл явдал: Аюулгүй байдал, цэрэг, армийн асуудлаар хамгийн сүүлийн үеийн дотоод болон олон улсын шинэ үйл явдлуудыг парламентын гишүүд мэдэж байх ёстой. Эдгээр үйл явдлуудыг зөвхөн засгийн газрын шугамаар бус төрийн бус байгууллага болон их, дээд сургууль зэрэг шугамаар олж авч болно.

Дадлага: Аюулаас хамгаалах салбараас зохион байгуулсан үйл ажиллагаанаас суралцах хэрэгтэй.

Байнгын хяналт: Парламент нь аюулгүй байдлын бодлого шинэчлэгдэхэд хамгийн сүүлийн үеийн бодлого, үйл ажиллагаа, дадлага зэргийг хянаж байхыг засгийн газраас шаардах ёстой.

Мэдээлэл, ур чадвар ба парламентын ажлын хэсэг

Парламентаас аюулаас хамгаалах салбарт сонгодог хяналт тавихад парламент доторх болон түүний эрхийн хүрээний үндэс суурь, ур чадвар шаардагдана. Гэвч парламентын ур чадвар засгийн газар, аюулаас хамгаалах салбарын ур чадвартай ховорхон тохиолдолд дүйцнэ. Ихэнх тохиолдолд парламент нь засгийн газар аюулгүй байдлын асуудлыг хариуцдаг батлан хамгаалах яам болон бусад яамдуудад өөрийн цомхон судалгааны ажлын хэсэгтэй байдаг. Зарим нэгэн парламент жишээлбэл Аргентиний Конгресс нь парламентын гишүүд, парламентын ажлын хэсэг, ялангуяа аюулгүй байдал, батлан хамгаалахын хороотой байнга зөвлөлдөж, зөвлөгөө өгч байдаг цэргийн харилцан ажиллагааны албатай байдаг. Мөн цэргийн болон энгийн

албан хаагчид мэргэжлийн, төрийн болон тусгай албан хаагчдын хувьд батлан хамгаалах яаман дээр тогтвор суурьшилтай ажиллаж байхад парламентын гишүүд сонгуульт хугацаагаар ажилладаг. Гол асуудал бол парламент ихэнхдээ тэдний хяналтанд байдаг байгууллага болох засгийн газар, цэргийн байгууллагаас мэдээлэл авч байгаад оршино. Энэ нь парламентын гишүүд засгийн газар, цэргийн байгууллагуудад сөрөг үр дагаврыг бий болгож байна. Аюулгүй байдлын туршлага, үйл ажиллагаа, соёл, боловсрол, хуулийн нууцлаг байдал нь нөхцөл байдлын улам даамжруулж байна.

Аюулаас хамгаалах салбартай холбоотой парламентын гишүүдийн ур чадварыг хэрхэн дээшлүүлж болох тухай зарим нэгэн зөвлөгөөг тодруулга №29-д тусгав.

Тодруулга №29

Аюулгүй байдлын асуудлаарх парламентын ур чадварыг дээшлүүлэхэд зориулсан практик арга барил, механизм

- ▷ Парламентын гишүүдийн мэдлэг, туршлага дээр тулгуурлан Аюулгүй байдлын асуудлаар үйл ажиллагаагаа явуулдаг парламентын тусгай хороо байдаггүй бол ийм хороог байгуулах, парламентаас уг батлан хамгаалах асуудлыг хариуцсан хороог ханган нийлүүлэлт, боловсон хүчний асуудал, төсөв, энхийн үйл ажиллагаа гэсэн салбаруудтай байхаар төлөвлөх.
- ▷ Дотоодын болон олон улсын семинарт оролцох, судалгааны аялалд хамрагдах, аюулгүй байдлын албаны бэлтгэл ажилтай /тусгай болон тагнуулын албаны тухай 11 дүгээр бүлгийг үзнэ үү/ танилцах, парламентын гишүүдэд зориулсан сургалт, хуралд оролцох: Мөн энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож буй цэргүүд байгаа орнууд руу аялах, парламентын гишүүдэд товчхон мэдээлэл өгөх;
- ▷ Бусад орны парламентын гишүүдтэй дадлага, туршлагаасаа хуваалцах, олон улсын парламентын чуулганы хурлын үеэр санал солилцох;
- ▷ Чадварлаг, мэргэжлийн парламентын ажлын хэсэгтэй байх;
- ▷ Сүүлийн үеийн мэргэжлийн номын сан, баримт бичиг/судалгааны төв, электрон мэдээллийн сантай байх;
- ▷ Төрийн бус байгууллагын гадаадын мэргэжилтэн, чөлөөндөө гарсан цэргийн офицерээс мэдээлэл авах /иргэний нийгмийн тухай 6 дугаар бүлгээс үзнэ үү/;

- ▷ Парламентын гишүүд аюулгүй байдлын асуудлаар олон улсын болон бүсийн хэлэлцээрийг зохион байгуулах;
- ▷ Нэг жилийн дотор дэд хороодын судалж болох аюулгүй байдалтай холбоотой хоёр буюу гурван сэдвийг сонгох;
- ▷ Парламентын гишүүдээс аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар бүх намын төлөөлөл оролцсон хэсэг байгуулах: ийм бүлэг энэ асуудлаар албан бус үүрэг гүйцэтгэж болно.

Улс төрийн ашиг сонирхол

Парламентын хяналтын эрх зүйн үндэс бүрдсэн, парламентад энэ асуудлыг шийдэх хангалттай арвин туршлага, ур чадвар байсан ч аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналтыг баталгаатай гэж үзэж болохгүй юм. Парламентын гишүүдийн улс төрийн ашиг сонирхол нь аюулаас хамгаалах салбарт тавих парламентын зохистой хяналтанд чухал үүрэгтэй байдаг. Аюулаас хамгаалах салбарт тавих хяналтанд улс төрийн эрх ашиг сул байх нь дор дурдсан хүчин зүйлээс хамаарна. Үүнд:

- ✓ Намын дэг журам: эрх барьж буй намын парламентын гишүүд нь гүйцэтгэх албан тушаалтны эрх мэдлийг хадгалан үлдэхийг хүсдэг бөгөөд олон нийтийн шүүмжлэлээс хол байлгах сонирхолтой байдаг.
- ✓ Сонгогчдын ашиг сонирхол/ ашиг сонирхолгүй байх: ихэнх орнуудад сонгогчдын олонх нь аюулгүй байдлын асуудлыг тэр бүр сонирхдоггүй. Үүнтэй холбоотойгоор ихэнх парламентын гишүүд дахин сонгогдох үүднээс аюулгүй байдлын асуудалд цаг зав зарцуулах сонирхолгүй байдаг.
- ✓ Тухайлбал тагнуулын хорооны гишүүний сонгуультай парламентын гишүүдийг мэдээллээ нууцлахыг аюулгүй байдлын албанаас шаарддаг.

Ийм нөхцөл байдлын улмаас хов жив буюу аюулгүй байдал алдагдах зэрэг онц ноцтой байдал үүсээгүй тохиолдолд дээд албан тушаалтны бодлого, үйл ажиллагаанд хяналт тавихад парламентын чадвар сул байдаг. Гэвч дээд албан тушаалтны бодлого, үйл ажиллагааг хянаж байх нь аливаа парламентын гишүүний үндсэн хуульд заасан үүрэг юм.

14 дүгээр бүлэг

Парламентаас аюулаас хамгаалах салбарт хэрэгжүүлэх механизм

Бүхий л хууль зүйн тогтолцоонд бодлого хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, бие хүнийг хамгаалах буюу хууль бус үйл ажиллагаа явуулах, албан тушаалаа урвуугаар ашиглах, шударга бус явдлыг илрүүлж хор хөнөөлийг арилгах талаар мэдээлэл олж авах арга хэрэгслээр парламентыг хангадаг. Мөн парламентын гишүүд үндсэн хууль буюу бусад хууль зүйн механизмыг хэрэгжүүлэх арга туршлагаас суралцах буюу хэрэгжүүлж болно.

Парламентын гишүүд Засгийн газраас дараахь 3 хэлбэрээр хууль зүйн мэдээлэл авах боломжтой. Үүнд:

- ✓ Парламентын хэлэлцүүлэг
- ✓ Парламентын асуулт болон асуулга
- ✓ Парламентын лавлагаа

Аюулгүй байдлын тухай парламентын хэлэлцүүлэг

Аюулгүй байдлын тухай парламентын хэлэлцүүлэг нь Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын асуудлаар тусгай мэдээллийг олж авах, санал бодлоо солилцох боломжийг бүрдүүлдэг. Аюулгүй байдлын бодлогын тухай парламентын хэлэлцүүлэг нь гол төлөв таван өөр нөхцөл байдалд болно:

- ✓ Удирдах албан тушаалтны тавьсан батлан хамгаалахын жилийн төсвийн саналыг хэлэлцэх;

- ✓ Батлан хамгаалахын сайд буюу гадаад хэргийн сайд зэрэг холбогдох сайдуудын албан болон албан бус мэдээллийг сонсох;
- ✓ Үндэсний батлан хамгаалахын тоймтой холбогдолтой батлан хамгаалахын цагаан номын танилцуулга буюу үндэсний батлан хамгаалахын гол тулгуур бусад баримт бичгүүдийг хэлэлцэх;
- ✓ Ихэвчлэн сонгуулийн дараахь Засгийн газрын хөтөлбөртэй уялдаа холбоотой бусад асуудлыг авч үзэх;
- ✓ Парламентын хэлэлцүүлэг явуулахад хүргэсэн мэдээлэл, аюулгүй байдлын асуудал болон гамшиг гэх зэрэг аливаа тодорхой асуудлуудыг хэлэлцэх.

Тодруулга № 30

Дээд албан тушаалтанд хяналт тавих парламентын бүтэц, дэг журмын нийтлэг шинжүүд

Ерөнхий хэлэлцүүлэг

“Зарим орнуудын Үндсэн хуульд дээд албан тушаалтан ажлын тайлангаа үе үе парламентад тавьж байхыг шаардсан заалт бий. Ихэнх улс орнуудад бодлогын ерөнхий асуудлууд шатчилсан шалгалттай шууд бус хамааралтай байна. Хэрэв аливаа гишүүн уг асуудлыг тодорхойлж хөндөж тавьсан тохиолдолд хэлэлцүүлгээр орж шийдэгдэнэ.”

▷ Асуулга /Interpellation/

“(…) Асуулга гэдэг нь энгийн парламентын системд мэдээлэл олох, хяналт тавихад зориулагдсан хэвшмэл журам юм. Асуулга нь парламентын гишүүн аливаа нэгэн сайдад түүний тэргүүлж буй яамны ажлын талаар буюу засгийн газрын тэргүүнд ерөнхий бодлогын асуудлаар хандана. Асуулга нь хоёр онцгой шинж чанартай байна: нэгдүгээрт, ерөнхий хэлэлцүүлэгт түлхэц болох; хоёрдугаарт, улс төрийн зөвшилцлийг бий болгох, учир нь хэлэлцүүлгээр засгийн газраас гаргасан тайлбарыг хангалттай буюу хангалтгүй гэж үзэхэд санал хураалт явуулна. Асуулга явуулахад сайд нар ажлаа шууд тайлагнадаг учраас хамгийн үр дүнтэй журам юм. Энэ нь мэдээлэл олж авах энгийн арга замаас гадна хяналтын шууд хэлбэр болно (…)

▷ **Түр хойшлуулах санал**

“Английн системд хэдийгээр “түр хойшлуулах санал” үүнтэй адил байдаггүй боловч асуулгын журам тодорхой бус байдаг. Завсарлагын эхлэл засгийн газарт асуудлыг дэвшүүлэхээс өмнө түр завсарлах саналыг шууд явуулах ба гэхдээ санал хураалт явагдахгүй (...).”

▷ **Асуулт**

“Асуултын (...) үйл явц нь удирдлагуудаас тодорхой мэдээллийг асууж шалгаах, оролцохыг шаардах, шаардлагатай бол албан тушаалаа урвуулан ашиглах явдлыг илчлэх, хохиролгүй болгох арга замыг хайхад оршино. Мөн парламентад өргөн барьсан эрх зүйн болон санхүүтэй холбоотой бэрхшээлтэй асуудлыг парламентын гишүүдэд ойлгомжтой болгох үүднээс дэлгэрэнгүй мэдээллийг авах шаардлагатай байдаг. Уг үйл явц нь парламентын сөрөг хүчинд засгийн газрын эмзэг асуудлыг нээлттэй болгох арга зам болохоос гадна тэдэнд удирдлагын хувьд давуу талыг бий болгоно. Энэхүү журмын нийтлэг онцлог нь парламентын гишүүн бүхэлдээ чөлөөт агент болохын хувьд асуулт тавих эрхээ эдлэх замаар уг асуудалд ханддаг.

▷ **Асуултын хороод:** Тодруулга №32-д үзнэ үү.

*Эх сурвалж: Michel Ameller, Парламентын гишүүн
Парламентын эхлэл холбоо, 1966*

Аюулгүй байдалтай холбогдолтой парламентын асуулт болон асуулга

Бичгээр буюу амаар асуулт тавих нь парламентын байцаан тодруулах үүргийн хэлбэр бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааг хянахад хамгийн өргөн ашиглагддаг парламентын нэгэн хэлбэр юм.

Асуулт нь аюулаас хамгаалах салбарт сонгодог хяналт болохуйц хэлбэртэй байх ёстой. Гол төлөв аюулгүй байдалтай холбоотой парламентын асуултууд:

- ✓ Засгийн Газраас батлан хамгаалах, аюулаас хамгаалах салбарт баримтлах бодлого болон бусад аюулгүй байдлын ерөнхий асуудлын талаар цаг үеийн, шинэчлэгдсэн, үнэн зөв мэдээллийг олж авах боломжоор парламентын гишүүдийг хангах;

- ✓ Аюулгүй байдалтай холбогдолтой асуудлаар парламентаас баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад парламентад туслах;
- ✓ Батлан хамгаалах болон аюулгүй байдлын асуудалд олон нийтийн анхаарлыг чиглүүлэх, ялангуяа асуултыг амаар тавьж хариултыг телевизээр цацах, аль эсвэл парламентаар дахин хэлэлцүүлэх буюу үндэсний албан ёсны мэдээлэлд нийтлэх /тодруулбал парламентын асуултын мэдээллийн үүрэг нь парламентын хүрээгээр хязгаарлагдахгүй: асуултууд хэвлэл мэдээлэл, ТББ-ууд, иргэний нийгэм зэрэг олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой;
- ✓ Засгийн газрын хэлэлцэх асуудлыг аюулгүй байдлын асуудалд чиглүүлэх буюу нөлөөлүүлэхээр дэмжих;
- ✓ Сөрөг хүчний гишүүд тэдэнтэй холбогдох аюулгүй байдлын асуудлаар буюу хангалттай мэдээлэл авч чадахгүй ч гэсэн асуулт тавихыг зөвшөөрөх;
- ✓ Аюулаас хамгаалах салбартай холбогдолтой парламентын асуудлууд ихэнх тохиолдолд маш чухал байдаг. Парламентын асуултуудад хариулт өгөх үүрэг бүхий сайд хариулт өгөхдөө тийм ч дуртай бус байдаг. Иймэрхүү хандлага аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагааны онцлог байдлаас хамааралтай. Үндэсний аюулгүй байдалтай холбоотой баримт бичгүүд ихэвчлэн зэрэглэлтэй байдаг учраас парламентын гишүүдэд ч, олон нийтэд ч хүртэх боломж тэр бүр бүрддэггүй.

Тодруулга №31

Сонгодог асуулт тавихад зориулсан зөвлөгөө

- ▷ **Төгс бэлтгэл:** Аюулгүй байдлын асуудал, ялангуяа техниктэй (гүйцэтгэх ажилтай) холбоотой асуултуудад хариулт авах боломжгүй байдаг. Цэргийн албан хаагч буюу цэргийн газар ажиллаж байсан хүнтэй албан бус харьцаа тогтооход тустай байдаг.
- ▷ **Тодорхой хэллэг:** Зарим нэгэн үл ойлгогдох хэлбэрийн асуултуудад хангалтгүй буюу дутуу хариулт өгөх болдог.

▷ **Цаг хугацаа:** Асуулт тавих үе нь уг асуултын үр ашиг, нөлөөний хувьд цаг хугацаа чухал байх бөгөөд хэвлэлд нийтлэх цаг хугацаа ч үүнд хамаарна.

Гэвч гүйцэтгэх албан тушаалтны баримт бичигт зэрэглэл тогтоох эрх мэдлийг хуулиар заасан байдаг. Баримт бичгийг зэрэглэх үйл ажиллагаа ойлгомжтой хялбар байх ёстой бөгөөд аль баримт бичигт зэрэглэл тогтоох, нууцыг хадгалах хугацаа, мөн зэрэглэл тогтоох ба тогтоохгүй байх нөхцөл зэргийг шийдэх үүрэг бүхий хүн тодорхой байх ёстой.

Албан байгууллагын асуудлыг авч хэлэлцэхэд парламентын сонгодог асуултын хувьд дараахь хүчин зүйлс бий болно. Үүнд:

- ✓ Парламентын гишүүний хувьд хангалтгүй хариулт авсан буюу нэмэлт тодруулга хэрэгтэй бол гүйцэд асуулт тавих боломж;
- ✓ Асуултын цагийн үеэр аюулгүй байдалтай холбогдон гарсан асуудлаар парламентын гишүүд хэлэлцүүлэг санаачлан явуулах боломж;
- ✓ Парламентын гишүүд өөрсдөө асуулт асуух дэгийн боломжийг ашиглах гишүүдийн сонирхол: олон нийт парламентын асуултын цагт оролцох буюу үүнийг радио, телевизээр сонсож, үзэх боломж;
- ✓ Хэлэлцүүлэгтэй холбоотой нийтлэл болон ямарч тохиолдолд асуулт хариулттай холбоотой нийтлэлүүд олон нийтэд хүрэх боломжтой байх.

Аюулгүй байдлын асуудлаар парламентын тусгай лавлагаа

Парламентын хороод хууль тогтоох үүргээсээ гадна засгийн газрын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцдог. Засгийн газрын үйл ажиллагааг нэгээс дээш хороо хянаж, ихэнх тохиолдолд тайлан мэдээ болон цаг үеийн мэдээ хэвлэн гаргах арга замаар ажлыг нь хянаж байх ёстой. Парламентын тусгай лавлагаа нь шүүхийн лавлагааны зарлан дуудах бичгийн нэгэн адил үйлчлэх чадвартай байна.

Лавлагааны хороодын үндсэн мөн чанар, давуу талууд

- ✓ Аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудлаар лавлагаа өгөх хороодын ажиллагаа нь энхийг сахиулах үйлсэд онцгой ач холбогдолтой байх бөгөөд тэдгээрийн давуу талууд хэмжээлшгүй юм. Ялангуяа:
- ✓ Лавлагааны хороодын оршин тогтнол нь олон нийтэд улс төрийн эерэг дохио мэт ойлгогдож болно.
- ✓ Лавлагааны хороод нь аюулаас хамгаалах албатай холбоотой улс төрийн эмзэг асуудлуудыг нарийвчлан хянахад нөлөө бүхий арга хэрэгсэл болж болно.
- ✓ Эдгээр хороод нь аюулгүй байдлын тодорхой асуудлаарх засгийн газрын бодлогод үнэлэлт өгөх, засгийн газар болон танхим бүхэлдээ хүлээн зөвшөөрөх хандлагыг санал болгож болно.

Тодруулга №32

Парламентын лавлагааны хороодын үндсэн шинж чанарууд

“ . . . Онцгой асуудлуудыг судлахад судалгааны хороод маш өргөн хүрээтэй ажилладаг. Ийм зорилгоор парламент өөрсдийн гишүүдийн хяналтыг зөв хэрэгжүүлэхийн тулд мэдээ цуглуулж, тайлан бэлтгүүлж, хэрэгтэй гэж үзвэл хэлэлцүүлэг явуулж шийдвэр гаргадаг.

Лавлагаа эхлүүлэх эрх нь гүйцэтгэх албан тушаалтны явуулж буй аливаа үйл ажиллагааг парламентад мэдээлж байх ёстой гэсэн зарчмын мөн чанар болно (. . .)

Зарим оронд лавлагааны хороодын хувьд үр ашигтай лавлагаа явуулахад бэрхшээлтэй байдаг. Шүүхийн үйл ажиллагаанаас бусад үед хүмүүст шахалт үзүүлэх эрх байдаггүй. Энэ нь засгийн газрын дээд албан тушаалтан хороодын үйл ажиллагааг цомхотгох, лавлагааны нөлөөг багасгах нөхцлийг бүрдүүлнэ. Парламентын лавлагааг нөлөөтэй болгох хамгийн шилдэг арга бол тангараг өргүүлж баримтжуулах явдал юм (...)

Лавлагааны хороодод энгийн ажилтан иргэд баталгаа гаргахад онцгой бэрхшээлтэй байдаг. Учир нь тэд өөрсдийн ажилладаг салбарын сайдтай эвсэн нэгддэг. Парламентын гишүүний асуултад хариулахгүй байх хугацаа хир зэрэг удаан үргэлжилж чадах вэ? Зарим оронд холбогдох хэлтсийн үйл ажиллагааны талаар

баталгаа өгөхийг байнга шаарддаг. Шаардлагатай мэдээллээр хангах нь олон нийтийн аюулгүй байдалд хор хөнөөлтэй буюу олон нийтийн үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй, хэлмэгдүүлэх хор уршигтай бол үүнийг шаардахгүй байж болно.

Ямар ч систем байсан хороодын лавлагаа явуулах үйл ажиллагаа нь баримт олох, судалгаа хийхэд тулгуурлах бөгөөд гол үүрэг нь танхимд тайлан өгөх явдал юм. Танхимын хувьд лавлагаа болон мэдээллээс хэрэгцээтэй үр дүнг гаргаж тавих нь чухал үүрэг болдог.

Эх сурвалж: Michel Ameller. Парламент. ПХХ, 1966

Лавлагааны хорооны бас нэгэн онцгой шинж чанар бол тэдгээрийн бүрдэл байдаг. Дийлэнх олонхийн эсрэг сөрөг хүчний парламентын гишүүдийн хэсэг лавлагааны үр дүнд чухал нөлөөтэй байдаг.

Лавлагааны эрх парламент болон парламентын хорооноос хамааран харилцан адилгүй байна. Дараахь эрх мэдэл гол цөм нь болно. Үүнд:

- ✓ Сэдэв ба парламентын лавлагааны хүрээг сонгох;
- ✓ Цэргийн бааз болон аюулгүй байдлыг хангах бусад байгууллагуудад зочлох /17 дугаар бүлгийг үзнэ үү/;
- ✓ Ерөнхийлөгчийн тамгын газар, засгийн газрын хэрэг эрхлэх газар, жанжин штабаас маш нууц болон дээд зэрэглэл бүхий баримт бичгүүдийг цуглуулах;
- ✓ Ерөнхийлөгчийн тамгын газрын гишүүн, засгийн газрын хэрэг эрхлэх газрын гишүүн, цэрэг болон иргэдээр тангараг өргүүлж баталгаа гаргуулах;
- ✓ Олон нийтийн болон хаалттай хуралдаан зохион байгуулах.

Сомали дахь Канадын цэргийн үйл ажиллагаатай холбогдолтой Канадын парламентын лавлагаа бол жинхэнэ тод жишээ юм /Тодруулга №33-ыг үзнэ үү/.

Тодруулга №33

Сомали дахь Канадын цэргийн хүчний үйл ажиллагааны лавлагааны хороо: аюулгүй байдлын асуудлаарх парламентын тайланд олон нийтээс үзүүлсэн нөлөө

1993 онд Сомалид болсон Канадын явган цэргийн үйл ажиллагааны үеэр болсон үйл явдлууд олон Канад хүмүүсийг маш ихээр цочирдуулсан билээ. Сомалийн дайрагсдыг Белэт Хуен дахь Канадын нэгтгэлд буудсан, Канадын нисэх хүчний хорооны командлалын цэргүүдийг баривчилсан хэргээр өсвөр насны нэгэн хүүхдийг үхтэл нь балбаж зодсон, баривчлагдсан канад цэргүүдийн нэг нь амиа хорлох оролдлого хийсэн, гол мэдээллийг нуун дарагдуулах буюу өөрчлөх гэсэн тохиолдол мэдэгдэж байсан зэрэг үйл явдлууд болсон юм. Үүний зэрэгцээ Канадын нисэх хүчний цэргүүдийн оролцсон зэвүүцэл төрүүлэхүйц үйл ажиллагаа бүхий видео хуурцагнууд гарч ирсэн. Уг үйл явдлыг судалж байсан цэргийн лавлагааны зөвлөл Канадын стандарттай харьцуулахад хангалтгүй гэсэн дүгнэлтийг Засгийн газраас нь гаргасан. Иймээс Канадын парламентад хэргийн лавлагааны газар олон нийтэд нээлттэйгээр байгуулагдсан.

Цар хүрээ ба эрх мэдэл - Хэргийн лавлагааны газар дээд албан тушаалтан, гэрчүүдэд зарлан дуудах хуудас өгөх, байцаалт явуулах, зөвлөх болон шинжээч хөлслөн ажиллуулах, нотолгоо олох зэрэг ажлыг гүйцэтгэх үүрэг өгдөг. Байцаалт явуулах эрх мэдэл нь Сомали болон Үндэсний Батлан хамгаалах төв штабт чухам юу болсныг тодорхойлох зарчмын механизм байсан. 116 гэрч Канадын телевизээр цацсан нээлттэй хуралдаанаар үг хэлж лавлагаа өгсөн. Энэ хэргийн цар хүрээ зөвхөн Сомалид болсон үйл явдлаар хязгаарлагдаагүй бөгөөд гол утга нь тушаал өгөх тогтолцоо, сахилга бат, дэг журам, Канадын зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Үндэсний батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, шийдвэрүүдийг хамарсан юм. Үүнтэй холбогдох дараагийн шатны арга хэмжээ бол үйл ажиллагааны бэлтгэл, өрнөл болон Сомалийн үйл ажиллагааны дараахь үе шатуудтай холбоотой олон чухал асуудлуудыг эргэн харахад хүргэсэн байна.

Шүүх ажиллагаа бус - Өмнө нь хувь хүнийг байцаах, хариуцлагад татах зэргээр дуусгавар болж байсан үйл явдал, байгууллагыг хянах, хариулт авах зэргээр байцаалт явагдсан боловч байцаах үйл ажиллагаа нь шүүх үйл ажиллагаанд тулгуурлагдаагүй. Лавлах үйл ажиллагааны хамгийн анхны зорилго бол эдгээр байгууллагуудад ажиллаж байгаа хувь хүмүүстэй харьцахаасаа илүү Канадын зэвсэгт хүчин, Үндэсний батлан

хамгаалах салбарын байгуулалт, уг байгууллагуудтай холбоотой албан байгууллагын тогтолцооны асуудалд чиглэгдсэн. Гэхдээ тушаалын дагуу хувь хүний гүйцэтгэж буй үйл ажиллагаа, зохион байгуулах арга хэлбэрийг шалгах үйл ажиллагаанд чиглэгдсэн.

Үр дүн - Хоёр жилийн ажлын үр дүнд дараахь асуудлуудыг хамарсан өргөн хэмжээний маш урт тайлан гарсан. Үүнд: Сомали дахь үйл ажиллагааны үеийн Канадын зэвсэгт хүчин, Үндэсний батлан хамгаалах салбарын бүтэц, зохион байгуулалт, Канадын цэргийн тушаалын хамаарлын ач холбогдол, цэргийн соёл, ёс зүйн талаар хэлэлцүүлэг явуулах, Канад дахь цэрэг, иргэний харилцаа гэх мэт. Үүнтэй холбогдуулан засгийн газар, Канадын зэвсэгт хүчний бодлого, үйл ажиллагааг нэлээд өөрчлөх талаар гол зөвлөмжүүдийг гаргасан.

Эх сурвалж: Профессор, доктор Donna Winslow. Канадын Парламентын лавлагааны зөвлөх. 1996 он.

15 дугаар бүлэг

Парламент дахь батлан хамгаалах буюу аюулгүй байдлын хороод

Аюулаас хамгаалах салбарын бэрхшээлтэй асуудлуудын дунд аливаа парламент түүний дээд албанд нөлөөлөх гэж байгаа бол сайтар боловсруулсан хорооны бүтэц чухал байр суурийг эзэлдэг. Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт зөвхөн ганц хороотой бус бөгөөд парламент бүрт өөр өөр нэрээр нэрлэгдсэн хэд хэдэн хороотой байдаг /Зарим үед тэдний бүрэн эрх нэгдмэл байх тохиолдол ч бий/.

Заримдаа хамтарсан хуралдаан хийдэг хороодын дийлэнхээс дор өгүүлбэл:

- ✓ Аюулгүй байдалтай холбоотой /үүрэг даалгавар, зохион байгуулалт, албан хаагчид, цэргийн үйл ажиллагаа, санхүүжилт, цэрэг татлага болон дайчилгаа/ бүх асуудлыг хариуцдаг батлан хамгаалах хороо /заримдаа зэвсэгт хүчний буюу үндэсний батлан хамгаалах хороо, аюулгүй байдлын хороо буюу аюулгүй байдал, гадаад хэргийн хороо зэрэг нэртэй байна/;
- ✓ Энх тайвны төлөөх үйл ажиллагаанд оролцох шийдвэр гаргадаг буюу улс үндэстний газар нутаг, олон улсын аюулгүй байдал, олон улсын болон бүсийн байгууллага, хэлэлцээр буюу зохион байгуулалттай үйл ажиллагаанд оролцохыг зөвшөөрөх зэрэг үйл ажиллагаа явуулдаг гадаад бодлогын хороо;
- ✓ Аюулаас хамгаалах салбарын байгууллагуудын санхүү болон төсвийн асуудлаар эцсийн шийдвэр гаргадаг хороо. Харин олон нийт батлан хамгаалахын болон үндэсний төсвийн тайланд хяналт тавьдаг хяналтын хороог сонгоно;
- ✓ Байнга нууцлаг ажиллаж байдаг тагнуулын үйл ажиллагааны хороо /буюу дэд хороо/;

- ✓ Ялангуяа зэвсгийн үйлдвэрлэл болон худалдааны үйл ажиллагаатай холбогдолтой үйлдвэрлэл, худалдааны хороо: /нөхөн төлбөр ба хохиролгүй болгох/;
- ✓ Шинжлэх ухаан, технологийн хороо /цэргийн судалгаа болон хөгжил/;
- ✓ Цагдаа, хил хамгаалалтын болон зарим үед цэргийн байгууллагатай холбоотой асуудлыг хариуцдаг дотоод /дотоод хэргийн/ хороо.

Эрх мэдэл ба арга барил

Парламентын хороод гадаадын эх сурвалжаас нотолгоо цуглуулах, хүлээн авах эрх мэдлээрээ маш их ялгаатай байдаг. Зарим парламентын хороод, жишээлбэл Британийн нийтийн танхимын байнгын хороод, АНУ-ын Конгрессийн хороодтой нэгэн адил нотолгоо цуглуулах эрхийг дангаараа эдэлдэггүй. Энэ нь гадаадын эх сурвалжаас нотолгоо авах эрх бараг л хязгаарлагдмал байдаг гэсэн үг юм.

Зарим парламентын хороод хууль санаачлах, шинэ хуулийн төслийг батлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй байхад зарим хороод хууль тогтоохгүйгээр зөвхөн гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааг хянах үүрэгтэй байдаг.

Аливаа хорооны туршлага, чадамжийн төвшин нь өөрийн бүрэн эрхийг үр дүнтэй гүйцэтгэхэд чухал нөлөөтэй байдаг: Жишээ нь уг хороонд үйлчилж буй штабын ажилтны тоо, чадварын төвшин, тогтвортой байдал: судалгааны чадвар ба түүний шинж чанар /ерөнхий болон мэргэжлийн: парламентын судалгааны томоохон хэсэг болон тусгай хэсэг/: мэдээллийн үнэлгээ ба холбогдох тус дөхөмтэй баримт бичгүүд олох, дахин боловсруулах чадвар /шинжээч дуудах чадвар: байцаалт болон лавлагаа явуулах чадвар. /дэлгэрэнгүй мэдээллийг 14 дүгээр бүлэг дэх парламентын арга барил ба хэрэгсэл хэсгээс үзнэ үү/

Тодруулга №34

Батлан хамгаалах буюу аюулгүй байдлын асуудлаарх парламентын хорооны үндсэн үүргүүд

Аюулгүй байдлын бодлого

- ▷ Батлан хамгаалахын сайдын бодлогын талаар илтгэлийг сонсох, мэдээлэл авах;
- ▷ Батлан хамгаалахын сайдын хариуцсан бодлогын шинж чанартай үүргийг үе үе шалгах;
- ▷ Ямар нэгэн аргаар батлан хамгаалах яамны хууль зүйн мэдээллийн эрх чөлөөг дагаж мөрдөж буй байдал, парламентад хийсэн мэдээллийн чанарыг хянаж байх;
- ▷ Аюулаас хамгаалах салбартай холбоотой цэргийн болон иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хянах.

Хууль тогтоомж

- ▷ Засгийн газраас оруулсан аливаа хуулийн төслийг авч хэлэлцэх, мэдээлэх, парламентаас шийдвэр гаргуулах;
- ▷ Батлан хамгаалах яамны хүрээнд хийгдэх олон улсын болон бүсийн хэлэлцээр, үйл ажиллагааг авч хэлэлцэх;
- ▷ Боломжтой бол сайдын хүсэлтээр шинэ хууль санаачлан шинэ хуулийг өргөн барих буюу хуулийн төсөл боловсруулан гаргах.

Зардал

- ▷ Батлан хамгаалах яамны үндсэн үнэлгээ, жилийн зардлыг шалгах, тайлагнах;
- ▷ Батлан хамгаалах яамнаас өргөн барьсан нэмэлт үнэлгээ бүрийг авч хэлэлцэх, цаашид анхаарч үзэх шаардлагатай бол парламентад тайлагнах;
- ▷ Шаардлагатай гэж үзвэл үнэлгээ хийх чадварлаг албан тушаалтныг хөлслөх.

Удирдлага ба зохицуулалт

- ▷ Боломжтой бол холбогдох албан тушаалтны /цэргийн дарга, нэртэй, нөлөөтэй албан хаагч/ хийсэн гол уулзалт бүрийг баталгаажуулж, тайлагнах;
- ▷ Батлан хамгаалах салбарын дотоод зохион байгуулалтыг авч хэлэлцэх, эцэст нь парламенттай холбогдох тусгай иргэдийн төлөөлөгчдийн шугамаар парламентын анхаарлыг гарч болзошгүй үйл ажиллагаанд чиглүүлэх.

Эх сурвалж: Их Британий Парламентын Хяналтын тухай Хансард Нийгэмлэгийн Зөвлөлийн илтгэлд тулгуурлав. 2001 он.

Дараахь тодруулга №35-д Норвегийн парламентын үйл ажиллагааны арга барилыг жишээ болгон үзүүллээ.

Тодруулга №35

Норвегийн парламент /Стортинг/-ын гадаад харилцаа болон батлан хамгаалах хорооны хамтарсан хуралдаан

“(…) Гадаад хэргийн өргөтгөсөн хорооны үүрэг бол засгийн газартай гадаад бодлого, худалдааны бодлого, үндэсний аюулгүй байдлын бодлогын талаар чухал асуудлуудыг хэлэлцдэг. Эдгээр хэлэлцүүлгүүдийг чухал шийдвэр гаргахаас өмнө явуулах ёстой. Онцгой тохиолдолд өргөтгөсөн хороо парламентад зөвлөгөө өгч болно.

Өргөтгөсөн хороо нь гадаад хэргийн байнгын хорооны жирийн гишүүд, Стортингийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, батлан хамгаалахын байнгын хорооны дарга зэрэг сонгуулийн хорооноос томилогдсон 11 гишүүдтэй байна. Уулзалт болох үед намын бүлгүүдээс эн тэнцүүхэн төлөөллүүд оролцож болдог.

Үүнтэй нэгэн адил зарчмыг баримтлах сонгуулийн хороо эзгүй хойгуур буюу түр орхих үед төлөөлөх ёстой орлогчдыг сонгоно.

Уг хорооны дарга онц шаардлагатай гэж үзэх буюу ерөнхий сайд, гадаад хэргийн сайд болон уг хорооны гишүүдийн гуравны нэг нь шаардлагатай гэж үзвэл хуралдааныг зохион байгуулж явуулдаг.

Онц чухал шаардлагагүй тохиолдолд уг өргөтгөсөн хорооны үйл ажиллагаа нууц байдаг. Энэ хороо болон бусад хороодын хамтарсан хуралдаан мөн нууц байна. Уг хороог хуралдуулах тухай зар хүртэл нууц байхыг дарга нь шийдвэрлэж болно.

Гадаад хэргийн өргөтгөсөн хорооны хурлын хэлэлцэх асуудал нь уг хорооноос доод тал нь 6 гишүүн хүсэлт гаргаснаар Стортингийн хуралд хэлэлцүүлэхээр тавигдаж болно. Уг хороо Стортингийн хорооны авч хэлэлцсэн асуудал үнэхээр бодитой эсэхийг хэлэлцэх бөгөөд ийм тохиолдолд энэ талаар тэргүүлэгчиддээ мэдэгдэнэ. Стортинг уг хурлыг олон нийтийн дунд хийх үү эсвэл хаалттай хийх үү гэдгийг шийднэ. Стортингийн шийдвэр засгийн газрын гишүүнээр дамжуулж мэдээлэгдэнэ. Стортингийн шийдвэрээр уг асуудлын талаарх хэлэлцүүлэг маш шуурхай явагдана. Саналыг хороодод танилцуулахгүй байж болно.

Эх сурвалж: Норвегийн парламентын дэгийн дүрэм-ийн 13 дугаар бүлэг. Стортингийн тухай: <http://www.stortinget.no/g>

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Танай парламент буюу танхим дахь батлан хамгаалахын асуудал хариуцсан хороо

- ▷ Дараахь зүйлс хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавихын тулд уг хороо болон байж болохуйц дэд хороодын бүрэн эрхийг үзвээс:
 - сайтар тодорхойлогдсон эсэх;
 - бүх асуудлыг авч үзэхийг уг хороонд зөвшөөрсөн эсэх;
 - аюулгүй байдалд шаардагдах гадаад хэрэг, нисэх хүчин /усан цэргийн аюулгүй байдал, үйлдвэр, цахилгаан хангамж зэрэг бусад яамны бодлого буюу аюулгүй байдлын бодлоготой уялдаж байгаа эсэх.

Сонгодог парламентын хороо

- ▷ Танай парламент буюу танхим дахь эрх мэдэл бүхий хороод хуулиар болон тодруулга №34-д өгүүлсэн шиг арга барил, үйл ажиллагаагаар хангагдсан эсэхийг батлах;
- ▷ Батлан хамгаалахын чухал салбар болох төсөв, цэрэг дайчилгаа, албан хаагч, энхийг сахиулах үйл ажиллагаа зэрэгт зориулсан дэд хороодыг байгуулах асуудлыг хэлэлцэх;
- ▷ Аюулаас хамгаалах салбарын мэдээллийн бодлого болон ялангуяа батлан хамгаалахын зардалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах хууль санаачлах;
- ▷ Уг хороод шинжээчдийн зөвөлгөөтэй дүйцэхүйц хангалттай материал олж авч байгаа эсэхийг шалгах;
- ▷ Аюулаас хамгаалах салбар дахь парламентын хяналтын талаар олон улсын төвшинд хүрэх шилдэг үйл ажиллагааг хянах, харах.

16 дугаар бүлэг

Омбудсмен /Иргэдийн төлөөлөгч/

Аюулаас хамгаалах салбарыг удирддаг чөлөөт байгууллагуудын дунд засгийн газрын болон олон нийтийн байгууллагын талаар хувь хүмүүсийн гаргасан гомдол, саналыг хүлээж авдаг иргэдийн төлөөлөгч чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдлагын буруу үйл ажиллагаанаас үүдэн гарсан бүхий л асуудлыг хариуцах ерөнхий эрх мэдэл бүхий иргэдийн төлөөлөгчтэй улс орнууд бий. Зарим орон яг адилхан үүргийг гүйцэтгэдэг комиссын гишүүд буюу олон нийтийн санал гомдлын хороотой байдаг /Нигери улс/. Гэхдээ зарим оронд мэргэжлийн иргэдийн төлөөлөгч зэвсэгт хүчний асуудлыг хариуцдаг.

Тодруулга №36

Засгийн газрын болон олон нийтийн байгууллагын эсрэг хувь хүмүүсийн гаргасан гомдол, саналыг хүлээж авдаг иргэдийн төлөөлөгч /омбудсмен/

“ ... Иргэдийн төлөөлөгч нь төрийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа буюу хэлэлцэгддэггүй үйл ажиллагааны талаар олон нийтээс ирүүлэх санал гомдлыг хариуцдаг. Иргэдийн төлөөлөгчийг парламентаас сонгох буюу парламенттай зөвшилцөн засгийн газрын тэргүүн томилно. Иргэдийн төлөөлөгчийн үүрэг бол олон нийтийн эрх зөрчигдөх, доромжлогдох, алдаа, хайхрамжгүй байдал, шударга бус шийдвэр гаргах, төрийн удирдлагыг хөгжүүлэхийн төлөө гаргасан буруу удирдлагаас төрийг хамгаалах, засгийн газрын үйл ажиллагаа, засгийн газар, түүнд алба хаагчдыг олон нийтэд илүү ойр байлгах үүрэгтэй. Иргэдийн төлөөлөгчийн газрыг үндсэн хуулиар байгуулж, бусад хууль тогтоомжоор дэмжих буюу хууль зүйн тогтоолоор байгуулна.

Иргэдийн төлөөлөгч ард түмний эрхийг хамгаалах дараахь бүрэн эрхтэй байна. Үүнд:

1. Засгийн газрын удирдлага хуульд нийцэхгүй буюу шударга бус үйлдэл хийсэн эсэхийг судлах;
2. Судалгаагаар удирдлагын шударга бус үйл ажиллагааг илрүүлбэл уг удирдлагыг зайлуулах талаар зөвлөгөө өгөх;

3. Онцгой тохиолдолд засгийн газар болон гомдол гаргагчид өөрийн үйл ажиллагаагаа тайлагнах, хэрэв онцгой тохиолдлын талаар гаргасан зөвлөмжийг засгийн газар хүлээн зөвшөөрөхгүй бол хууль тогтоох байгууллагад хандаж болно. Ихэнх агент ажлынхаа жилийн тайланг ерөнхийд нь олон нийт болон хууль тогтоох байгууллагад тавьдаг.

Иргэдийн төлөөлөгч засгийн газартай холбоотой асуудлаар шийдвэр гаргах эрхгүй байна. Харин иргэдийн төлөөлөгч өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгч болно. Гол төлөв хувийн салбарын иргэдийн төлөөлөгч нэлээд олон төрийн байгууллагад өөрийн гэсэн ерөнхий эрх мэдэлтэй байна. Зарим оронд хуулийн байгууллага, цагдаа, цэрэг зэргийг хамарч байхад зарим оронд эдгээрийн нэг буюу хоёр нь онцгойлон хасагдана.

*Эх сурвалж: Олон Улсын Омбудсмений Хүрээлэнгийн Мэдээллийн лавлагаа. <http://www.law.ualberta.ca/centres/iol/>
Мөн НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Хорооны Газар. Хэргийн хавт ас №19. Хамгаалалт, бэхжүүлэлт ийн Үндэсний Хүрээлэн.*

Батлан хамгаалах салбар дахь иргэдийн төлөөлөгч

Тусгай байгууллагын хувьд батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгч нь Финлянд, Норвеги, Португал, Герман зэрэг оронд батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгч, Изриальд цэргийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол хариуцсан офицер, Канадын Үндэсний батлан хамгаалах департамент болон Зэвсэгт хүчний иргэдийн төлөөлөгч, Австралийн батлан хамгаалах хүчний иргэдийн төлөөлөгч зэрэг өөр өөр нэртэй байдаг.

Тодруулга №37

Сонгон авсан орнууд дахь батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчийн хяналт

Улс	Эрх мэдэл	Үүрэг	Тайлан ба улс төрийн албан тушаалтны үүрэг
Австрали	-Батлан хамгаалах хүчний иргэдийн төлөөлөгчийг сайд нарын	Австралийн батлан хамгаалах хүчний гишүүдийн	-парламентад суугаа төлөөний сайдад жилийн ажлын тайланг тавих;

Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт

	шийдвэрээр томилно	аливаа буруу үйлдлийг хянах	
Канад	Батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчийг сайд нарын зөвлөлийн шийдвэрээр томилно	Үндэсний батлан хамгаалах департментийн ажилтан, албан хаагчид ба Канадын Зэвсэгт хүчний гишүүдийн эрхийг хамгаалах	-онцгой тохиолдолд Үндэсний Батлан Хамгаалахын Департмент буюу Канадын Зэвсэгт хүчинд тайлан тавих, үйл ажиллагааны талаар сайдад жилийн тайланг тавих; -Төвийг сахигч ба бодит зөвлөл. Батлан хамгаалахын сайдын удирдлагаас хараат бус байх;
Норвеги	Батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчийг Норвегийн парламентын хүрээнд сонгоно	Цэрэг хүний эрх ашгийг хамгаалах, батлан хамгаалах байгуулалтын төрөл бүрийн салбарын хүрээнд илэн далангүй, итгэлцэлтэй уур амьсгалыг бий болгох, зөрчилдөөнийг шийдвэрлэхэд анхаарлаа төвлөрүүлэх	Сайн дураар холбогдох олон нийтийн байгууллагад зөвлөмж, үнэлгээ, шүүмжлэл өгөх;

Парламент болон иргэдийн зүгээс Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд хяналт тавих нэмэлт арга барилыг иргэдийн төлөөлөгч төлөөлдөг. Цэргийн иргэдийн төлөөлөгч (агент)-ийн гол үүрэг бол аюулгүй байдлыг ялангуяа цэргийн салбарыг хариуцсан сайдын өмнөөс мэдэгдсэн шүүхийн шийдвэр буюу хийсэн алдааг судлах явдал юм.

Улс төрийн систем дахь зэвсэгт хүчний иргэдийн төлөөлөгчийн газрыг байгуулах асуудал улс бүрт харилцан адилгүй байдаг. Батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчийг парламентаас томилж парламентад тайлан тавина. /Герман,

Швед/ Аль эсвэл батлан хамгаалахын сайд томилно. /Израил, Канад/ Зарим иргэдийн төлөөлөгчийн албан өрөө парламентын байгууламж дотор байрлана. /Германы зэвсэгт хүчний парламентын офицер, тодруулга №38-ийг үзнэ үү/ Аль эсвэл парламентын байгууламжийн гадна байрлаж болно./Швед/

Зэвсэгт хүчнийхэн энгийн иргэд буюу цэргүүдтэй буруу харьцаа үүсгэсэн тохиолдолд иргэд болон цэргүүд лавлагаа эхлүүлэх талаар иргэдийн төлөөлөгчөөс зөвлөмж авч болно. Мөн парламентын гишүүд мэдүүлсэн гомдол болон доромжлолыг шалгахыг иргэдийн төлөөлөгчөөс хүсэж болно. Иргэдийн төлөөлөгчийн судлах хэргүүд ихэвчлэн чөлөөлөгдсөн, түр хойшлуулсан, шаардлага бүхий цэргийн алба, цэргийн албын үеэр шилжүүлэлт, жижүүрлэх, хоолны дэглэм, цэрэг татлага, эзгүй байх, сахилга батын болон торгуулийн хэрэг зэрэг байдаг. Иргэдийн төлөөлөгч гомдлыг зөв гэж тогтоовол уг байгууллагаас шийдвэрээ дахин өөрчлөх, дахин хэлэлцэж үзэхийг санал болгодог.

Иргэдийн төлөөлөгч ба нууцлал

Аюулаас хамгаалах салбарын мөн чанарыг авч үзвээс зарим мэдээллийг үндэсний аюулгүй байдалтай холбоотой шалтгаанаар олон нийтэд тарааж болдоггүй. Ихэнх орон хуульдаа иргэдийн төлөөлөгч үндэсний аюулгүй байдлын асуудалтай хэрхэн харьцах талаар заалт оруулж өгсөн байдаг. Гол төлөв маш нууцын журам баримтлах үед иргэдийн төлөөлөгч цэргийн баазын аливаа ноцтой хэргийн баримт бичгүүдийг хүлээлгэн өгнө. Гэхдээ иргэдийн төлөөлөгч судалгаанаас олсон зүйлээ олон нийтэд мэдээлэх ёсгүй.

Тодруулга №38

Германы Парламентын Зэвсэгт хүчний тусгай эрхт төлөөлөгч

Герман зэвсэгт хүчнийг 1950-иад онд дахин байгуулснаар парламентын хяналтын чухал хэсэг нь Зэвсэгт хүчний тусгай эрхт төлөөлөгч болсон. Бие хүнийг зэвсэгт хүчинд зүтгэх болно гэсэн зүйлийг үндсэн хуульд оруулж өгөхийн тулд Германы Үндсэн хуульд 45-ын 6 гэсэн заалтыг оруулж өгсөн. Үүнд заахдаа:

“... Парламентын тусгай эрхт төлөөлөгч нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний үндсэн эрхийг хамгаалах, парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд Парламент ад \Бундестаг\ туслах үүрэгтэйгээр сонгогдоно. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх заалтууд “Зэвсэгт хүчин дахь Парламентын тусгай эрхт төлөөлөгчийн тухай хууль”-д тодорхой тусгагдсан байдаг.

Парламентын тусгай эрхт төлөөлөгч нь парламентын тусгай албыг төлөөлөх бөгөөд хууль тогтоох байгууллагын гишүүн байна. Тэрээр Парламент болон батлан хамгаалах хорооны заавраар тодорхой асуудлаар судалгаа явуулах ба анхаарал татсан асуулт байвал өөрийн шийдвэрээр ажиллаж болно.

Албан тушаалын тусгай үүргийн дагуу тусгай эрхт төлөөлөгч нь батлан хамгаалах яамны ажлыг хянадаг. Өөрт холбогдох агентлаг, байгууллага, албан хаагчдаас мэдээлэл болон сүүлийн үеийн бичлэгүүдийг шаардан авах эрхтэйн зэрэгцээ дурын тохиолдолд зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчний болон байгууллагуудын удирдлага, агентлаг, төв штаб, хороо зэргээр айлчилж уулзалт хийж болно. Албан үүргээ гүйцэтгэж буй албан хаагч болон цэргийн албан тушаалтнуудаас парламентын тусгай эрхт төлөөлөгч гомдол хүлээн авсан тохиолдолд үйл ажиллагаагаа эхлүүлж болно. Зэвсэгт хүчинд ажиллаж буй хэн нэг нь өөрийн асуудлыг шийдүүлэхээр албаны шугамаар бус, өргөдөл гаргасан учир ялгаварлуулах буюу сахилга бат алдсан гэж хохироолгүйгээр шууд тусгай эрхт төлөөлөгчид хандаж болно.

Эх сурвалж: <http://www.bundestag.de/>

Иргэдийн төлөөлөгч: армид итгэл нэмэгдүүлэх эх үүсвэр

Жишээ нь 1915 онд байгуулагдсан Шведийн Зэвсэгт хүчний иргэдийн төлөөлөгчийн хэлснээр батлан хамгаалах салбарт итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлснээр энэ салбар хүчирхэг болж байна гэжээ. Мөн иргэдийн төлөөлөгч армийн дотоод зохисгүй байдлын эсрэг цэрэг, эмэгтэйчүүдийг хамгаалахад тодорхой хамгаалалтыг бий болгосон. Ерөнхийд нь үүнийг тодорхойлбол аюулаас хамгаалах салбартай холбоотой иргэдийн төлөөлөгчийн гол ололт бол цэргийн шатлан захирах ёсыг эвдэх буюу армийн бэлэн байдлыг бууруулахгүйгээр удирдлагын үйл ажиллагаанд хамгийн ойлгомжтой энгийн хяналтыг бий болгон хүмүүсийн итгэлийг нэмэгдүүлсэн байна.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Иргэдийн төлөөлөгчийн газар

- ▷ Танай оронд ийм нэгэн байгууллага хараахан бий болж амжаагүй бол ийм төрлийн байгууллага байгуулахыг дэмжих үзэл бодлыг урьдчилан бэлтгэх;
- ▷ Ийм янзаар улс орны иргэдийн төлөөлөгчийн туршлага судлах, холбогдох бичиг баримт цуглуулах, гарын авлага болгох зүйлс цуглуулахаар дараахь хаягаар орж үзэж болно: <http://www.ombudsmaninternational.com>

Батлан хамгаалах болон аюулгүй байдлын салбар дахь иргэдийн төлөөлөгч

- ▷ Танай оронд ийм төрлийн алба хараахан үүсч бий болоогүй бол ийм байгууллага байгуулах үзлийг бэхжүүлэх явдлыг урьдчилан бэлтгэх;
- ▷ Батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчтэй орнуудын туршлагаас судалж мэдээлэл цуглуулах;
- ▷ Урьд өмнө батлан хамгаалахын иргэдийн төлөөлөгчтэй байсан бол түүний холбогдох хугацаа, үүрэг, парламентад мэдээлэхтэй холбогдох ерөнхий журам, харьцангуй ижил аюулгүй байдлын төвшинтэй орнууд дахь байгууллагуудтай харьцуулсан төсөв, эх сурвалж, үр дүн зэргийг шаардах.

17 дугаар бүлэг

Аюулгүй байдлын албаны бэлтгэл байдалтай танилцах

Хамаарал

Аюулаас хамгаалах салбартай ойр дотно байх нь бүхий л парламентын гишүүдийн хувьд чухал байдаг. Энэ нь онолын мэдлэг, практик үйл ажиллагаан дээр тулгуурлах ёстой бөгөөд аюулгүй байдлын албыг сайтар ойлгох талаар ажлын туршлагыг судлах шаардлагатай. Ийм үзэл бодлын үүднээс парламентын гишүүд аюулгүй байдлын албаны бэлтгэл байдалтай танилцах нь улс төрийн болон цэргийн тэргүүн нарын хооронд харилцан яриа өрнүүлж, ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэхэд тустай арга зам юм. Ийм айлчлал нь цэргийн хүний өдөр тутмын асуудлыг ухамсарласан байдлыг бэхжүүлэх, улс төрийн тэргүүнүүд цэргийн хүмүүсийн сайн сайхны төлөө анхаарал халамж тавих, цэргийн энх тайвны төлөөх үйл ажиллагааны талаарх тэдний сонирхол зэргийг илтгэн харуулж байгаа юм.

Тодруулга №39

Аргентины жишээ

Улс төрчид цэргийнхэнтэй санал бодлоо солилцохоор цэргийн бааз, цэргийн нэгтгэл, ангид айлчлал хийдэг. Эдгээр уулзалтууд энэ хоёр байгууллагын хооронд үл итгэлцэх явдал, хардалт сэрдэлтийг арилгах, улс төрчдөд зэвсэгт хүчний удирдлагын талаар мэдээлэл олж авахад тусалдаг. Цэргийн асуудлыг сайтар ойлгох боломжийг парламентын гишүүд, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний хоорондын харилцааны үр дүн өгдөг. Аюулаас хамгаалах салбарын асуудал болохоор дүрэм журам, цаг хугацаа зэрэг нь бусад салбараас өөр байдаг бөгөөд улс төрчид айлчлал, уулзалтын үр дүнгээс энэ бүхнийг ойлгоход тустай.

Эх сурвалж: Pablo Carlos. Martinez. Парламент ын үүрэг хариуцлага ба Зэвсэгт хүчнийг шинэчлэн байгуулах нь: Аргент ин улсын т үршлага.
<http://www.pdgs.org>

Хорих төв болон шоронд хоригдлуудын аюулгүй байдлыг хангах асуудал тухайн байгууллагын ажилтны хяналтан дор

байдаг. Ийм тусгай нөхцөл нь тэднийг хүний эрхийг зөрчих, доромжлолд өртөөх зэрэг эмзэг асуудалд хүргэдэг. Харамсалтай нь тамлах, эрүү шүүлт тулгах зэрэг үйлдлүүд шорон болон хорих төвд элбэг тохиолддог. Иймд эдгээр байгууллагуудад тусгай хяналтын механизмыг хэрэгжүүлэх нь зайлшгүй байдаг. Хамгийн үр дүнтэй арга бол парламентын гишүүд эдгээр газруудад айлчлал хийж, бодит үнэнийг үзэж харах, доромжлолыг таслан зогсоох болон хүчирхийллийн эсрэг тэмцэх зорилготойгоор судлагаа явуулах явдал юм.

Тодруулга №40-д хорих төвд айлчлах арга барилыг НҮБ-ын эрүү шүүлтийн эсрэг конвенцийн нэмэлт протоколоор тайлбарлав.

Тодруулга №40

Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн нэмэлт протокол нь аюулгүй байдлын албанд хийх айлчлалын боломжийг өргөтгөдөг

2002 оны 12 дугаар сарын НҮБ-ын ерөнхий чуулганаар эрүү шүүлт, бусад хэрцгийг балмад, хүнлэг бус авир гарган доромжлолын эсрэг НҮБ-ын Конвенцийн албан бус протоколыг баталжээ. Протоколоор улс орнууд өөрсдийн хорих газраа нээлттэй байлгаж, зүй зохисгүй харьцааг багасгах талаар үүрэг оногдуулахаар үндэсний болон олон улсын шинжээчид чөлөөтэй нэвтрэх үүд хаалгыг нээсэн байна.

Холбогдох мэдээллийг www.unhchr.ch хуудаснаас харна уу.

Үр дүнтэй айлчлалын нөхцөл байдал

Цэргийн бааз буюу цэргийн нэгтгэл, анги зэрэг аюулаас хамгаалах салбарт хийх парламентын гишүүдийн айлчлалыг холбогдох яам буюу батлан хамгаалахын сайд зохион байгуулна. Төлөвлөгдөөгүй буюу зохион байгуулалтгүй айлчлал армид итгэл муутай, шатлан захирах ёсыг үл тоосон болон армийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зэрэг сөрөг үр дагавартай. Мөн айлчлалуудад янз бүрийн улс төрийн намын төлөөлөгчдийг хамруулах ёстой бөгөөд бэлтгэлийг сайтар хангасан байвал зохино.

Иймэрхүү айлчлалын хязгаарлалт нь аюулгүйн албаны дарга үзүүлэхийг хүссэн газрыг л зөвхөн парламентын хороо үзнэ.

Ийм айлчлалд асуудлын жинхэнэ бодит чанарыг дэлгэн харуулж чаддаггүй бөгөөд нөхцөл байдлыг тэдний овоо хараанд эргэлдүүлэх ялангуяа санхүүгийн бэрхшээл байгааг харуулахад л оршдог. Энэ нь 3 төрлийн айлчлалаар харагдаж болно: Армиас хүсэлт гаргаж зохион байгуулсан айлчлал, парламентаас санал болгож урьдчилан мэдэгдсэн айлчлал, парламентаас хүсэлт гаргаж богино хугацаанд хийсэн айлчлал /нэг өдөр/.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Аюулаас хамгаалах салбарт айлчлал хийх тухай хуулиас

- ▷ Аюулаас хамгаалах салбарт /хилийн чанадад албан үүргээ гүйцэтгэж байгаа цэргүүд/ хийх парламентын айлчлалыг хуулиар зааж тогтоох;
- ▷ Аюулаас хамгаалах салбарт парламентын төлөөлөгчид айлчлал хийх тухай хууль байхгүй тохиолдолд парламентын гишүүд урьд өмнө ийм айлчлалд хамрагдаж байсан эсэх, ямар зарчмаар хэрхэн, яаж, ямар үзүүлэлтээр бүрэлдэхүүнийг сонгож байсан, ямар нөлөөтэй зэргийг анхаарах;
- ▷ Дараахь тодорхойлсон журмуудыг батлах:
 - Аюулаас хамгаалах аль салбарт зочилж болох;
 - Айлчлалыг байнга зохион байгуулах, ямар нөхцөлд айлчлал хийж болох;
 - Үндэсний цэргийн бааз, нэгтгэл, ангид парламентын айлчлал тогтмол хийх ба бодит туршлага судлах;
- ▷ Ийм айлчлалын талаар дэлгэрэнгүй бичсэн ажлын тайланг парламент, түүний холбогдох хороо болон парламентын хэлэлцүүлгээр оруулсан эсэхийг анхаарах;
- ▷ Урьд өмнөх айлчлалуудын үр дүнг гаргах;
- ▷ Танай улс НҮБ-ын эрүү шүүлтийн эсрэг конвенц болон нэмэлт протоколыг баталж гарын үсэг зурсан эсэхийг анхаарах.

Айлчлалд оролцох парламентын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

- ▷ Төлөөлөгчид аль нэг талыг баримтлагч бус, парламент дахь олонх болон сөрөг хүчнийхнээс шударга тэнцүү оролцоог бий болгосон эсэхийг анхаарах;
- ▷ Төлөөлөгчид аль болохоор хүйсийн тэнцвэрийг баримталсан эсэхийг анхаарах.

Айлчлалд бэлтгэх

Цаашид үүсэж болох үр дагавараас сэргийлэхийн тулд парламентаас хийх айлчлал нь батлан хамгаалах яамтай уялдаа холбоотой эсэхийг анхаарах.

Парламентад тайлагнах

- ▷ Нарийвчилсан тайланг парламент болон холбогдох хороонд өгч хэлэлцүүлсэн эсэхийг анхаарах;
- ▷ Аюулгүй байдлын холбогдох албан тушаалтнууд уг тайланд ажиглалт хийхээс өмнө урьдчилан нэмэлт хийсэн эсэхийг анхаарах;

Үр дүн ба нийтлэл

- ▷ Айлчлалын бүрэлдэхүүнээс гаргасан ололт, санал зөвлөмж, парламентын холбогдох шийдвэр гарч олон нийтэд түгээхэд бэлэн гэсэн шийдвэр гарсан эсэхийг анхаарах.

V ХЭСЭГ

**Аюулгүй байдлын албанд
тавих хяналтаас:
Онцгой нөхцөл ба үйл
ажиллагаа**

18 дугаар бүлэг

Улсын онцгой байдал

Дайн болон дотоодын зөрчил, мөргөлдөөн бусад онц аюултай үед асуудлыг шийдвэрлэх тусгай үйл ажиллагаа явуулж, хүч хэрэглэх ч тохиолдол гардаг. Ийм үйл ажиллагааг засгийн газрын ардчилсан тогтолцоонд ямар нэгэн байдлаар нөлөөлөлгүйгээр явуулах ёстой.

Дайн болон онц байдлын хэд хэдэн хэлбэрт цэргийн хүчээр хариу өгөх шаардлагатай болдог бөгөөд нэн ялангуяа дайны байдал зарлах хэрэгтэй болдог. Ийм нөхцөл байдалд цэргийн болон аюулаас хамгаалах салбар бүхэлдээ олон улсын дүрэм журмыг дагаж мөрдөх, ялангуяа олон улсын энэрэнгүй ёсны дүрэм журмыг сахих, мөн явуулж буй үйл ажиллагаа нь ардчилсан хяналтын дор явагдахын зэрэгцээ хүний эрхийн асуудлыг дагаж мөрдөх хэрэгтэй. Энэ тухай НҮБ-ын Хүний эрхийн хорооноос 2001 оны 8 дугаар сард гаргасан иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээний 4 дүгээр зүйлийн ерөнхий тайлбар №29-д тодорхой заасан байдаг.

Дайны байдал

НҮБ-ын дүрмийн 2.4-р зүйлд:

“Нэгдсэн Үндэст ний Байгууллагын бүх гишүүн олон улсын харилцаандаа хүчээр сүрдүүлэх буюу хүч хэрэглэх үйлдлийг цээрлэнэ...” гэж заажээ.

Аливаа нэг улс өөр нэгэн улсын эсрэг хүч хэрэглэх явдлыг хатуу хориглосон. Дайн, байлдаан хийхээр заналхийлэх, зөрчилдөөний үеэр эрхээ хэтрүүлэн хэрэглэх зэрэг олон улсын хориог аюулаас хамгаалахын гүйцэтгэх албаныхан биелүүлж байгаа эсэхийг шалгах нь парламентын нэгэн үүрэг юм. Швейцарь зэрэг төвийг сахигч орнууд гадаад харилцааны үйл ажиллагааны маргааныг шийдвэрлэх арга зам бол дайн хийх явдал гэдгийг үл зөвшөөрдөг. Мөн Япон улс нь үндсэн хуулиндаа /1946/ цэрэг армитай байх явдлаас эрс татгалзсан цорын ганц улс юм. Одоогийн байдлаар Унгар болон бусад орнууд улс үндэстэн хоорондын зөрчлийг дайн байлдааны аргаар шийдвэрлэхээс татгалзаад байна.

Дайн байлдааны үед үндсэн хуулийн заалтаас шалтгаалан парламент доод тал нь 3 өөр чиглэлээр шийдвэр гаргана.

1. Парламент дайны байдал зарлаж болохыг үндсэн хуулиар заасан байж болно. Өнөө үед бодит амьдрал дээр дайн байлдаан аливаа сануулга дохиогүйгээр эхэлж болох талтайг үйл явдлуудын өрнөл нь парламентыг ийм шийдвэр гаргахад хүргэж бас болох талтай болохоор энэ шаардлага харьцангуй мэт санагдаж болно.

2. Аливаа дайны үйл ажиллагаа болон энхийг сахиулах үйлсэд оролцохоос өмнө гүйцэтгэх дээд байгууллага парламентаас зөвшөөрөл авах ёстойг үндсэн хуульд заасан байна. Энэхүү заалтын дагуу парламент аливаа олон улсын дайн байлдаан, гадаадад цэрэг илгээх асуудлыг хэлэлцэж баталдаг.

3. Гүйцэтгэх албан тушаалтан парламенттай урьдчилан зөвшилцөхгүйгээр дайны үйл ажиллагаанд оролцох болсноо парламентад мэдэгдэх ёстойг үндсэн хуулиар заасан байна. Ихэнх үндсэн хуульд зааснаар бол парламентад мэдэгдэл хийх ёстой гэсэн байна.

Улсын онц байдал

Янз бүрийн нөхцөл байдлын улмаас улс үндэстний хямрал буюу улсын онц байдал үүсэж болно. Үндсэн хууль болон хууль эрх зүйн үүднээс авч үзвэл үндсэн хуулийн заалтыг зөрчсөн зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, тахал зэрэг олон нийтийн эмх замбараагүй байдал, эдийн засгийн хямрал зэргээс хамааран улсын онц байдал зарлаж болох ба ийм нөхцөл байдлууд нэлээд олон тохиолддог.

Зөвхөн онцгой нөхцөл байдалд улсын онц байдал зарлах бөгөөд тодорхой зарчмыг баримтлах ёстой. Үүнд ардчилсан зарчмыг хэзээ ч умартаж үл болно. Энэ талаар тодруулга №41-ээс үзнэ үү. Онц байдал гэдэг нь улс үндэстний үндсэн хууль, эрх зүйн байдалд заасан заалтаас хамаарна. Дээд албан тушаалтан улс төрийн намын үзэл бодлын төлөө онц байдал зарлахыг үндсэн хууль болон бусад хуулиар хориглодог. Мөн цэргийн нөхцөл байдал тогтоохыг үндсэн хууль болон холбогдох хуулиудад хүчин төгөлдөр бус болохыг зааж өгнө.

Тодруулга №41

Улсын онц байдал: Зорилго ба зарчим

“Онц байдалтай тэмцэх тусгай үйл ажиллагааг хууль зүйн бүх тогтолцоонд заасан байна. Гэвч хямралтай тэмцэхэд ач холбогдол бүхий түр зогсоох буюу арилгах эрх зөвхөн түр зуурын шинж чанартай байх бөгөөд хуучин байдалд нь эгүүлэн оруулах ба үндсэн эрхийг хадгалахад оршино.

Олон улсын зарчим

“Улсын онц байдлаас шалтгаалан үүсч болох олон улсын зарчмыг дараахь байдлаар томъёолж болох юм. Үүнд:

Хууль ёсны зарчим нь нэг талаас улсын онц байдал ба баталж гаргасан онц байдлын хэм хэмжээний мэдэгдэл хооронд, нөгөө талаас улсын онц байдал ба улсын дотоод хууль тогтоомжийн мэдэгдэл хооронд илэрч гарч ирэх ёстой. Мөн энэхүү зарчим дотоод хууль тогтоомж, олон улсын хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

Тунхаглалын зарчим гэдэг нь онц байдлыг олон нийтэд зарлах хэрэгцээг хэлнэ.

Харилцааны зарчим гэдэг нь улсын онц байдлын үеэр хүний эрхийн тухай НҮБ-ын тусгай мэдэгдэл шиг холбогдох асуудлыг бусад улс оронд мэдэгдэх үүргийг хэлнэ.

Түр зуурын зарчим гэдэг нь улсын онц байдлыг зарлах онцгой нөхцөл байдал болон цаг хугацааны хязгаарыг хэлнэ.

Онц байдлын зарчим гэдэг нь олон нийтэд илт одоогоор буй болоод буй хямрал, одоогоор болоод байгаа буюу нүүрлэх гэж буй аюулыг хэлнэ.

Харьцааны зарчим нь хямралын төлөв байдлын онцлогийг тодорхойлно.

Бодит бус зарчим гэдэг нь халдлага үүсч болох үндсэн онцгой байдлыг хэлнэ.

“Парламент нь улсын онц байдал зарлах, үүнтэй холбогдон гарах асуудлыг шийдэхгүй орхигдуулах, хууль тогтоох эрх, эрх мэдэлтэнг хянах эрхийг тодорхой хэмжээгээр багасгах асуудлыг шийдэхдээ, ул үндэстэй баримтан дээр тулгуурлах шаардлагатай. Мөн парламент уг онц байдлыг зарлах, улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх үүргээ гүйцэтгэх ёстой.

Улсын онц байдлын хууль ёсны мөн чанар

“... Хууль ёсны мөн чанар нь хуулийн зарчмын хүрээнд явагдахаар батлагдсан хэм хэмжээ, үйл ажиллагаа бөгөөд хяналттай шууд хамааралтай юм.

Парламентын үүрэг хариуцлага

“Улс үндэстний тусгаар тогтнол, тогтвортой байдалтай холбоотой аливаа эрхийн тухай зарчим бол хууль тогтоомжийн нэгээхэн хэсэг гэдэг нь тодорхой юм. Иймд дэлхий дахины бүх хуулийн систем улсын онц байдлыг тунхаглах буюу дээд албан тушаалтан зарлиг гаргасан бол түүнийг хүлээн зөвшөөрөхөд парламент идэвхтэй оролцох ёстой. Уг зорилго бол дээд албан тушаалтныг онц байдлын хэм хэмжээг батлах онцгой бүрэн эрхээ эдлэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Улсын онц байдалтай холбоотой хууль ёсны заалтын зэрэглэл

“Улсын онц байдлыг удирдан чиглүүлэх зарчим нь үндсэн хуулийн хэм хэмжээний асуудал байх нь ач холбогдолтой гэдэг нь туршлагаас ажиглагдсан. Зарим хууль тогтоомжинд шууд бус үтгээр “улсын онц байдал зарлах үед ямар ч эрх мэдэлтэн хууль ёсны үүргийг хүлээхгүй байж болно” гэж заасан байхад ихэнх хууль тогтоомжинд энэ талаар тодорхой заасан байна.

Эх сурвалж: 1993 онд Будапешт хот ноо Хүний эрхийг хамгаалагч сэдвээр хуралдсан Олон улсын Парламент чдын Холбооны чуулган дээр ноён L.Desroux хийсэн илтгэл, НҮБ-ын Хүний эрхийн болон улсын онц байдлын тухай тусгай мэдэгдлээс.

Урт хугацаагаар үргэлжлэх онц байдал

Урт хугацаагаар үргэлжлэх онц байдлыг парламентаас хэдэн арван жилээр үе үе шинэчилж байдаг бөгөөд энэ байдал аюулаас хамгаалах байгууллагууд дахь иргэний нийгмийн зарчмыг аюулд өртүүлэх, мөн эдгээр байгууллагууд ардчиллыг аюулд хүргэж болзошгүй юм. Ингэснээр парламентыг сул дорой, хүчин мөхөс байдалд хүргэнэ. Хэд хэдэн оронд бий болсон онц байдлыг харахад аюулаас хамгаалах салбарт хяналт тавьдаг парламентад шууд заналхийллийг ил тодоор илэрхийлэхэд хүрдэг байна.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Улсын онц байдлын тухай хууль

- ▷ Улсын онц байдлын хэлбэрийг үндсэн хууль болон бусад хуульд сайтар тодорхойлж өгсөн эсэхийг шалгах;
- ▷ Улсын онц байдлыг парламентын хэлэлцүүлэг болон дахин санал хураалт явуулж сунгахгүй тохиолдолд энэ нь гурав буюу зургаан сарын хугацаатай байна;
- ▷ Улсын хуульд онц байдалтай холбоотой хууль ёсны, харилцааны, тунхаглалын, түр зуурын, онц байдлын, харьцааны, халдашгүй байдал нь олон улсын зарчмуудад тулгуурласан эсэх;
- ▷ Улсын онц байдлын үеэр мөрдөгдөж буй хүний эрхийн хууль, үндсэн хуулийн баталгаа, хүмүүнлэгийн хуулийг хүндэтгэн үзэж байгаа эсэхийг анхаарах;
- ▷ Улсын онц байдлыг зарлах буюу арилгахтай холбоотой дээд албан тушаалтан, парламентын бүрэн эрхийг үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлж өгсөн эсэхийг анхаарах.

Парламент улсын онц байдлын үед

- ▷ Улсын онц байдал үүсэхэд аюулгүй байдал, хүний эрхийн салшгүй байдлыг хүндэтгэн үзэх үндэслэлээр дээд албан тушаалтныг хянах парламентын эрхийг бүрэн баримталдаг эсэхийг анхаарах.

19 дүгээр бүлэг

Дотоодын аюулгүй байдлыг сахин хамгаалах

Дотооддоо аюулгүй байх, олон нийт эмх цэгцтэй байх нь нийтийн сайн сайхны төлөөх үндсэн асуудал юм. Олон нийтийн хувьд ялгаварлан гадуурхах буюу тухайн нутаг дэвсгэр дээр амьдарч буй цагаач иргэд, гадаадын хүмүүсийг ялгаварлахгүйгээр хандана. Улс төрийн манлайлагч буюу улс төрийн хүчний зорилгын тусын тулд тэдэнд үйлчлэх үүрэг бүхий аюулаас хамгаалах салбарынхан ангилал үүсгэж үл болно.

Хууль тогтоомжийн ерөнхий үндэслэл, шинж чанар

Хуулийн бүхий л тогтолцоо нь улсын онц байдлыг зарлаж үл болох нөхцөл байдлыг илтгэн харуулсан хуулийн зарим хэлбэртэй байх бөгөөд бодит заналхийлэл буюу дотоодын аюулгүй байдал, олон нийтийн эмх цэгцтэй байдалд аюул учруулж болзошгүй тохиолдлыг тэр бүр заасан байдаггүй.

Алхам алхмаар өөрчлөгдсөнөөр хууль тогтоомж дээд албан тушаалтнуудад давуу эрх олгох бөгөөд хуулиар тодорхой зааж өгөх хэрэгцээтэй буюу зарим нэгэн нөхцөлд аюулд өртөж болох үндсэн эрхийг хамгаалах тухай эрхийн заалтыг хязгаарлах буюу түр зогсоож болно.

Хязгаарлах буюу түр зогсоох эрх гэдэгт мэдээллийн эрх чөлөөний эрх, олон нийтийн жагсаал хийх эрх, эрх чөлөө, орогнол хүсэх эрхүүд багтана. Олон улсын хуулиар амьдрах эрх, эрүү шүүлт тулгах ёсгүй эрх буюу аливаа бие махбодийн шийтгэл, хүмүүнлэг бус шийтгэл хүлээх ёсгүй эрх зэрэг эрхүүдийг хориглоно. Цагаач иргэд, сэтгүүлчид, улс төрийн зүтгэлтнүүд, хүний эрхийг хамгаалагчид, орогнол хүссэн хүмүүс, дүрвэгсэд, шашны болон үндэсний цөөнх зэрэг нь тусгай хяналтан дор байх ёстой.

Холбогдох эрсдэлүүд

Дотоодын аюулгүй байдал, нийтийн эмх цэгцтэй байдлыг сахиулах хуультай холбоотой дараахь эрсдэлүүд тохиолдоно. Үүнд:

- ✓ Дээд албан тушаалтны тодорхой хэрэгцээнд тохирох тайлбарыг зөвшөөрсөн хүчирхийллийн чанартай чөлөөт тодорхойлолт;
- ✓ Дээд албан тушаалтан болон аюулаас хамгаалах салбарын хэд хэдэн байгууллагыг жинхэнэ хяналт, засаг захиргаа, шүүхээр баталгаажуулаагүй хэт их, урт хугацааны эрхээр хангах;
- ✓ Дотоодын аюулгүй байдал, нийтийн эмх цэгцтэй байдлыг сахин хамгаалах нь олон нийтийн үйл ажиллагааг хянах, тэдний эрхийг хязгаарлахад хүргэх ба хүн амын нэг хэсэг бүлэг, улс төрийн манлайлагч аюулаас хамгаалах салбарын эрх ашгийг хэт илүү хамгаалахад хүргэх;
- ✓ Цагдаагийн хүчний цэрэгжилт нь дотоодын хууль, дэг журмыг хамгаалагч, цэргийнхэн хоорондын ялгааг арилгах, гадаад аюулгүй байдлыг сахин хамгаалагч болно. Ийм хүчнийг санхүүжүүлэхгүй бол аюул учруулж болзошгүй бөгөөд шийтгэл авахгүйн тулд хээл хахууль өгөх, аюулгүй байдлыг зүй бусаар хамгаалах зэрэг сөрөг талуудтай юм. Цагдаагийн хүчний цэрэгжилтийн бас нэгэн аюул бол цагдаагийн байгууллагыг дотоодын аюулгүй байдал, нийтийн эмх эмц цэгцтэй байдлыг хянаж, сөрөг үзэгдэлтэй тэмцэхийн оронд үл хамгаалах хэрэгсэл болгон ашиглаж болох талтай. Мөн Зэвсэгт хүчнийг нийтийн эмх цэгцтэй байдлыг хянахад байнга ашиглах нь цэргийг улс төржүүлж буй хэрэг билээ;
- ✓ Дээд албан тушаалтны эрх мэдэл маргаантай байгаа тохиолдолд хууль ёсны, парламентын үйл ажиллагааг зогсоох.

Аюулгүй байдал, нийтийн эмх цэгцтэй байдлыг зохицуулах арга хэмжээнд аюулаас хамгаалах салбарын бие бүрэлдэхүүн зарим үед хүний эрхийг зөрчих тохиолдол гаргаж болох талтай. Зарим үед шийтгэл хүлээхгүй байх

явдал ч гарна. Дараахь эрхүүд үе үе зөрчигдөж байна. Үүнд: амьдрах эрх, эрүү шүүлт тулгуулахгүй байх эрх, хүнлэг бус, доромжилсон заналхийлэл, арбитрийн баривчилгаанаас эрх чөлөөтэй хоцрох, хуулиар тогтоосон хараат бус шүүхэд шударгаар шүүх эрх, үзэл бодлын эрх чөлөө, үг хэлэх, нэгдэх эрх г.м.

Тодруулга №42

Ардчилал ба аюулгүй байдлыг бэхжүүлэх

Түүхийн явцад хөгжиж буй олон оронд төр барьж буй засгийн газрууд ардчилсан хөдөлгөөнийг эсэргүүцэж, ухрах алхам хийсэн бөгөөд ардчилал нь олон нийтийн эмх цэгц, хувийн аюулгүй байдалтай уялдахгүй гэж маргасаар ирсэн. Гэхдээ энэ үзлийн эсрэг үзэл бодол үнэн болохыг тэмдэглэсэн. Улсын аюулаас хамгаалах салбарыг хувь хүний аюулгүй байдалтай сөргүүлэн иргэний ардчилсан хяналтаар зохицуулах нь чухал юм. Ийм хяналтгүйгээр хувь хүний аюулгүй байдлыг хамгаалах нь хамгийн аюултай зүйл гэж үзнэ.

Эх сурвалж: НҮБ-ын Хүний хөгжлийн илт гэлээс, 2002 он /хуудас 87/

Зарим улс орнууд ардчиллыг бэхжүүлэх тухай тодорхой хууль тогтоомж батлан гаргасан. Аргентинд "Ардчиллыг батлан хамгаалах" тухай 1984 оны 23.077-р хуульд эрүүгийн хуулийг өөрчилж, ардчилсан тогтолцооны эсрэг тодорхой эрүүгийн зөрчлийг бий болгон заасан. Үүнд үндсэн хуулийг хүндэтгэх буюу ардчилалд заналхийлэх зорилготой үйл ажиллагаа явуулдаг хууль бус байгууллагуудыг шийтгэх зэрэг.

Дотоодын аюулгүй байдал, нийгмийн эмх цэгцтэй байдалд заналхийлсэн хүмүүсийг цагдан хорих тухай

Дотоодын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахиулах тухай бүх хуулиудад заналхийлсэн, хор хөнөөл учруулсан хүмүүсийг хорих тухай заасан байдаг. Иймд энэ тухай заасан доод тал нь хоёр зүйлийн хууль тогтоомж бий.

- ✓ Үндэсний аюулгүй байдалд илт заналхийлсэн аливаа хүнийг хорих тухай хууль: ийм нөхцөлд хорих ялыг ихэнх тохиолдолд шүүх гаргадаг бөгөөд зарим онцгой

тохиолдолд дээд албан тушаалтан дангаараа ийм тушаал гаргаж болно.

- ✓ Дээд албан тушаалтны үзэж байгаагаар үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн аливаа хүнийг цагдан хорих тухай хууль, мөн дээд албан тушаалтан өөрийн эрх мэдлийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг аюулд өртүүлэхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих талаар зөвшилцөх тухай хууль.

Англи улсын бүрэлдэхүүн болох орнууд хоёрдугаар зүйлтэй холбоотой зарим хэлбэрийн хуультай байдаг. Ийм хуулийн дагуу гүйцэтгэх албан тушаалтан хууль тогтоогчийн болон шүүхийн оролцоо, зөвшилцөөгүйгээр хууль ёсны баталгааг хойшлуулах эрх эдлэхээр заасан. Үүний нэг нь үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хүмүүсийг хорих тухай захиргааны болон яамны шийдвэрийг гаргах бүрэн эрх юм. Заналхийлсэн хүмүүсийг урт болон богино хугацаагаар дээд албан тушаалтны мэдэлд байлгах ба хугацааг өөрчилж болох буюу тодорхой бус хугацаатай байж болно. Зарим хуульд зөвлөх мөн чанартай байж болох ба дээд албан тушаалтны хориог цуцлах талаар тушаал гаргах байгууллагыг байгуулж болохыг заасан байдаг. Үүний бүтэц нь уг албан тушаалтны зэрэг дэвээс хамааран өөр өөр байна.

Ихэнх оронд колончлолын үеэс уламжлагдан ирсэн ийм хуулийн талаар нэлээд яригдаж байгаа бөгөөд иргэний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөтэй, дээд албан тушаалтан, аюулгүй байдлыг сахиулах байгууллагууд, ялангуяа цагдаагийн байгууллагатай зөвшилцөхгүйгээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь өнөө үед тулгамдсан асуудал болоод байна.

Тодруулга №43

Ноцтой үр дагавартай мушгин гуйвуулах явдал

Засгийн газар аюулаас хамгаалах хүчиндээ итгэж байхад аюулаас хамгаалах хүчин зарим тохиолдолд өөрийн орны иргэд, хөрш орны аюулгүй байдлыг алдагдуулах гол шалтгаан болдог. Дотоод яамны цэрэг, цэрэгжүүлсэн цагдаа, тагнуулын алба орон нутгийн улс төрийн тэмцэлд түйлширч байхад иргэний ардчилсан хяналтыг бэхжүүлэх хүчин чармайлт байнга аюулд өртөж байна.

Эх сурвалж: НҮБ-ын Хүний хөгжлийн илт гэлээс, 2002 он /хуудас 87-92/

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Дотоодын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахиулах тухай хууль

- ▷ Аюулгүй байдал, нийгмийн хэв журам гэдэг нь зөвхөн хүний сайн сайхны төлөө зориулагдсан бөгөөд улс төрийн намын үзэл бодлыг хамгаалах хэрэгсэл, шалтгаан мэтээр ойлгогдож болохгүйг байнга санаж явах, хүч хэрэглэх буюу хэтрүүлэгтэй цэрэгжилтийг хориглох ёстойг анхаарах нь зүйтэй;
- ▷ Дээд албан тушаалтан парламентад тайлангаа тавих бөгөөд түүний хууль зүйн хэм хэмжээг бүрэн эрхийнх нь дагуу тодорхойлж өгөх ёстой;
- ▷ Эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах буюу хүч хэтрүүлэх тохиолдол гарсан нөхцөлд аюулаас хамгаалах салбар захиргааны болон хуулийн хүрээнд уг асуудлыг авч үзэх ёстойг анхаарах;
- ▷ Ардчилсан нийгмийн батлан хамгаалах тухай хуулийн тохироо болон ашиг сонирхлыг судлах.

Парламентын хяналт

- ▷ Дотоодын аюулгүй байдал, нийтийн хэв журамтай холбогдох асуудлыг парламентаар байнга хэлэлцэж, энэ салбарт гарч буй хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж байгаа эсэхийг шалгах;
- ▷ Парламентын эрх мэдэл бүхий хороод хэрэгтэй мэдээллийг авахдаа эрх мэдлийнхээ хүрээнд эх сурвалж болон бүх арга барилыг ашиглаж, дотоодын аюулгүй байдал, нийтийн хэв журмын талаар сонгодог хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгах, шаардлагатай гэж үзвэл эх сурвалж, арга барилыг дээшлүүлэх бодлого баримтлах, үүний дотор туршлага судлах гэх мэт;
- ▷ Боломжтой, хэрэгцээтэй үед холбогдох асуудлаар олон нийтийн яриа хэлэлцүүлэг явуулах;
- ▷ Дотоодын аюулгүй байдал, нийтийн хэв журам, хүний эрх, үндсэн эрх чөлөөтэй холбоотой явуулж буй үйл ажиллагааны үр дүнгийн талаар ТББ-уудтай ярилцлага явуулах.

20 дугаар бүлэг

Терроризм

“Терроризм нь улс орон иргэдээ түүнээс хамгаалах ёст ой халдлагын нэгэн хэлбэр юм. Ийм халдлагын үед Улс орон иргэдээ хамгаалах нь улс орны хийвэл зохих үүргийн нэг юм. Мөн улс орнууд т терроризмын эсрэг үйл ажиллагааг хүний эрхийг зөрчих явдлыг зөвт гөх буюу нуун далдлах үйл ажиллагаа болгон хувиргах ёсгүйг онцлон анхаарах ёст ой”.

“Дот оодын аюулгүй байдалд заналхийлж, бидний эрхэм эрх чөлөөг золиосолж, амгалан тайван байдлыг алдагдуулж, ардчилсан төрийн суудлыг зэврүүлж байна”.

Эх сурвалж: НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Копи Аннаны хэлсэн үгнээс, 2001 оны 11 дүгээр сарын 21

Терроризм нь олон улсын, бүс нутгийн мөн дотоодын аюулгүй байдалд заналхийлж байдаг. Терроризм нь гол төлөв зохион байгуулалттай гэмт хэрэг учраас түүний эсрэг үйл ажиллагаа явуулах нь төвөгтэй байдаг. Цагдаа, хилийн хяналтаас тагнуулын байгууллага хүртэл, санхүүгийн салбар дахь үйл ажиллагаанаас эрүүгийн хууль, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээтэй асуудал юм.

9 дүгээр сарын 11-ний үйл явдлаас хойш ихэнх улс орон дээр өгүүлсэн салбаруудад хуулиа бэхжүүлэх шаардлага нэн хэрэгцээтэй болохыг ухаарсан. Ялангуяа тагнуулын байгууллага, мэдээллийн технологийн хамтарсан үйл ажиллагаатай холбоотой улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх болсон. Мэдээж энэ бүхэн хүний эрх, иргэний эрх чөлөөгөө эдлэхэд эрсдэлтэй байх нь ойлгомжтой.

Алан хядах үйл ажиллагааг хянах олон улсын хамтын ажиллагаатай холбогдолтой НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1373 дугаар тогтоолд 2001 оны 9 дүгээр сарын 28-нд батлагдсан: Тодруулга №44-г үзнэ үү. Санхүүгийн хөрөнгөнд хяналт тавих асуудлыг онцлон тэмдэглэсэн. Мөн энэхүү 1373

дугаар тогтоолоор террорист болон террорист бүлэглэлүүдийн дотоодын болон хил дамжих хөдөлгөөнөөс хамгаалах зорилготойгоор хилийн хяналт, биеийн байцаалт, аялалын баримт бичгүүдэд хяналт тавих нь чухал нөлөөтэй болохыг онцолжээ. Уг тогтоолд террорист бүлэглэлд гишүүд элсүүлэх, террористуудад буу зэвсэг, тоног төхөөрөмж нийлүүлэхийг хориглох, улс хоорондын хамтын ажиллагааны журмаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих тухай заасан байна. Террорист үйл ажиллагааг дэмжсэн буюу санхүүжүүлэх, төлөвлөгөө зохиох, бэлтгэх зэрэг гэмт үйлдэлд оролцсон бол хуулийн өмнө хариуцлага хүлээх бөгөөд сөрөг үйл ажиллагаа явуулсан террорист халдлага дотоодын хууль тогтоомжоор ноцтой эрүүгийн хэрэгт тооцогдох тул гарцаагүй шийтгэл хүлээнэ гэжээ. Иймд олон улсын болон дотоодын хууль дүрмийн дагуу мэдээлэл солилцох, террорист халдлагаас сэргийлэхийн тулд захиргааны болон хуулийн асуудлаар хамтран ажиллахыг уриалсан. Мөн уг тогтоолд зөвлөлийн бүх гишүүдээс бүрдсэн Аюулгүйн зөвлөлийн хороо нь зохих зөвлөгчийн хамтын оролцоотойгоор хэрэгжүүлэх асуудалд хяналт тавихыг оруулж өгсөн байна.

Тодруулга №44

9 дүгээр сарын 11-ний үйл явдалд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс өгсөн хариу

Аюулгүйн Зөвлөл (. . .)

3. Бүх улс орныг

а. Ялангуяа террорист сүлжээний үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл солилцох явдлыг, эрчимжүүлэх арга замыг эрэлхийлэх; аялалын албан бичгүүдийг хуурамчаар болон дуурайлган хийх; гар буу, тэсрэх бодис, багаж төхөөрөмж: мэдээллийн технологийг террорист бүлэглэл ашиглах; үй олноор хөнөөн устгах зэвсэг эзэмшиж заналхийлэх;

б. Террорист халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын болон дотоодын хууль дүрмийн дагуу мэдээлэл солилцох, зохион байгуулалт болон хуулийн асуудлаар хамтран ажиллах;

в. Террорист халдлагаас урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааны эсрэг хориг арга хэмжээ авах талаар ялангуяа хоёр талын болон олон талт гэрээ хэлэлцээрийг байгуулан ажиллах;

г. 1999 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн терроризмын санхүүжилтийг хориглох Олон улсын конвенц зэрэг терроризмтэй

холбогдох олон улсын конвенц, протоколд чадах хэмжээгээр оролцох;

д. Аюулгүйн зөвлөлийн 1269 \1999 оны\, 1368 \2001 оны\ дугаар тогтоол, терроризмтэй холбоотой олон улсын конвенц, протоколтой холбогдолтой хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх;

е. Террорист халдлагад оролцож, зохион байгуулж, төлөвлөж байгаагүй, орогнол хүссэн хүмүүсийг хамгаалах зорилгоор цагаачийн статус олгохоосоо өмнө хүний эрхийн олон улсын стандартаар холбоотой олон улсын болон дотоодын хуулиудын холбогдох заалтуудтай уялдуулан арга хэмжээ авах;

ё. Олон улсын хуультай уялдаа холбоотойгоор цагаачийн статусыг террорист халдлага зохион байгуулсан гэмт этгээд урвуугаар ашиглахгүй байх, улс төрийн үндэслэлээр хэрэг тулгагдсан террористууд гадаад оронд тэр улсын хуулийг зөрчсөн гэдгээс татгалзахад шалтгаан болохгүй байхыг анхаарах.

Эх сурвалж: НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн т огт оол 1373, S/RES/ 1373. 2001 оны 9 дүгээр сарын 28.
<http://www.un.org/Docs/scres/2001/sc2001.htm>

1999 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн НҮБ-ын Ерөнхий чуулганаар террорист халдлагыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенци батлагдсан бөгөөд террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхэд оролцсон аливаа улс оронд тэр улсын хуулийг зөрчсөн этгээдийг барьж өгөх, сэжиг бүхий санхүүгийн шилжүүлэг гарч ирсэн үйлдлийг батлахыг гэрээ байгуулсан бүх улсаас шаардсан байна. 2002 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн байдлаар 132 орон уг конвенцид нэгдэж гарын үсэг зурсан бөгөөд 26 улс хэлэлцээрт гарын үсэг зурах бэлтгэл үйл ажиллагаагаа хангаад байна. Уг конвенцийг 2002 оноос хэрэгжүүлж эхэлжээ.

9 дүгээр сарын 11-ний халдлага

Террорист халдлагад хандах тогтвортой хандлага, хүний эрх, аюулгүй байдал хоёуланд нь хандах хандлагыг засгийн газар баталж хяналт тавих нь парламентын хувьд чухал юм. Парламентын гишүүдийн үзэл бодлоор терроризмтай тэмцэх асуудал бол эрх чөлөө, аюулгүй байдал хоорондын тэнцвэрийг олох, терроризмын эсрэг үйл ажиллагааны шинэчлэн боловсруулсан хандлага, хууль юм.

Терроризмыг албан ёсоор тодорхойлох нь

Өнөөдөр дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн, терроризмыг тодорхойлсон тодорхойлолт хараахан гарч ирээгүй билээ. Олон улсын байгууллагууд терроризмын ерөнхий тодорхойлолтыг гаргаж ирэх болтол терроризм гэдэг тодорхойлолт үргэлжилсээр байх болно. Олон улсын хуулиар бол үндэсний эрх чөлөө, гадаадад мэргэжил эзэмших тусгаар тогтнолын төлөө тэмцэл нь хуулиар заасан эрх бөгөөд ийм зорилт террорист үйл ажиллагааг агуулахгүй билээ. Цаашилбал, Олон Улсын Парламентчдын Холбоо зэрэг олон улсын байгууллагууд терроризмыг аливаа шашин, үндэстэн, иргэншлээр тодотгохгүй бөгөөд мөн нэрээр нь зөвтгөх ёсгүйг давтан тэмдэглэсэн. Терроризмыг тодорхойлох өөр нэгэн арга бол олон улсын байгууллагуудаас байнга бууруушаадаг террористуудын үйл ажиллагаатай ижил төрлийн халдлагыг тодорхойлж болно. Үүнд: ялангуяа гэм зэмгүй иргэдийн оролцсон эмх замбараагүй халдлага буюу нууц агент ба бага ястангуудын гаргасан аливаа эмх цэгцгүй халдлага зэрэг багтана.

Террорист халдлагуудыг иргэдийн эсрэг эмх замбараагүй халдлага, хүн төрөлхтний үнэт зүйлсийг үл ойшоох байдал, олон нийтэд зориулагдах онцгой байдал зэргээр нь тодорхойлдог. Террорист үйл ажиллагаанд онгоц хулгайлах, машин дэлбэлэх, хорлон сүйтгэх ажиллагаа, алан хядах, үй олноор нь хөнөөх зэрэг ердийн аргууд бий. Тасралтгүй үргэлжлэх террорист үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг, зэр зэвсгийн байнгын нийлүүлэлт, зарим үед олон улсын зохион байгуулалттай сүлжээ /back-up/ шаардлагатай байдаг. Гурав дахь орнууд террористуудад тусламж үзүүлж, нутаг дэвсгэртээ нуун далдалдаг. Тодруулга №45-д терроризмд чиглэгдсэн тогтвортой хандлагын зарим нэгэн онцгой хэсгийг терроризмын эсрэг тэмцэх арга хэмжээ, хуулиар заасан эрхийг хамгаалах зэргийг үзүүлэв. Тодруулга №37-д терроризмын эсрэг арга хэмжээг зөвхөн терроризмтай тэмцэх бус, мөн шинэ үеийн терроризмын өлгий болсон орнуудын нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжилтэй тэмцэх шаардлагын талаар дурджээ.

Тодруулга №45

Терроризмын эсрэг тэмцэл

34. . . Үндэсний эрх чөлөө, гадаадад мэргэжил эзэмших, тусгаар тогтнолын төлөө тэмцэх нь олон улсын шийдвэрт тусгагдсан хууль ёсны эрх бөгөөд энэхүү зорилго нь терроризмыг бий болох нөхцлийг бүрдүүлэхгүй хэмээн бага хурлаас хүчингүй болгожээ. Гэвч уг бага хурлаар ямар ч тэмцэл ялангуяа гэм хоргүй хүмүүсийг оролцуулсан, эмх замбараагүй халдлагыг зөвтгөхгүй буюу зохион байгуулалттай терроризмын аливаа хэлбэрийг зөвшөөрөхгүйгээ онцлон тэмдэглэжээ.

37. Уг бага хурлаас эдийн засаг, нийгмийн хөгжил, ардчиллыг бэхжүүлэхэд төлөвлөсөн хэмжээгээр тодорхойлсон терроризмын эсрэг аюулгүй байдлын онцгой чухал шаардлагыг онцлон тэмдэглэхийг хүссэн.

Эх сурвалж: 1995 оны 11 дүгээр сард Малт а, Валет т а, Газар Дундын Тэнгис дэх Аюулгүй байдал, хамт ын ажиллагааны тухай Олон Улсын Парламентчдын 3 дугаар хурлаас гаргасан баримт бичгээс

Терроризмын эсрэг Австри /эрүүгийн шүүхийн төслийн догол мөр 278 б/, Герман /эрүүгийн хуулийн догол мөр 129а/, Канад зэрэг орнуудын хуульд дараахь зүйлс тусгагджээ:

- Террорист үйл ажиллагааны хязгаарлагдмал нэрс: аллага, барьцаалах, нисэх онгоцыг хууль бусаар булаан авах, дэлбэрэлт, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэх гэх мэт гэмт хэргийн шинж чанартай үйл ажиллагаа, заналхийлэл: гэмт хэрэг гэдэг нь Герман, Канад, Австрийн хуулиар хууль бус үйл ажиллагааг хэлнэ;
- Террорист байгууллагыг санхүүгийн хувьд буюу бусад хэлбэрээр удирдах буюу дэмжих нь хууль бус үйл ажиллагаа /Герман, Австри, Канад/;
- Улс төр, үзэл бодол буюу шашны шалтгааны улмаас үүсэх террорист ажиллагаа /Канад/;
- Нийтийг заналхийлэх, сүрдүүлэх, засгийн газар, олон нийтийг тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг шаардах, тусгай үйл ажиллагаа явуулахыг хойшлуулах зэрэг террорист ажиллагааны төлөвлөгөө /Канад/;

- Халдлагын улмаас хүмүүст хохирол учруулж үхэлд хүргэх, бусниулах, хэн нэгний амьдралыг үхлийн ирмэгт хүргэх, хохирол учруулах, нийгмийн болон хувийн тодорхой тогтолцоо, үйл ажиллагааг нураах зэргээр террорист зорилгод чиглүүлэх үйл ажиллагаа /Канад/;
- Ардчиллыг сэргээх буюу дахин сэргээн тогтоох, хүмүүнлэгийн хуулийг хамгаалах зэргээр мөрдөх үйл ажиллагааны хязгаарлалт /Австри/. Ийм хуулийн заалтууд гэмт хэрэгт татагдахаас урьдчилан сэргийлж байдаг.

Терроризмын эсрэг хуулийн гол зорилго нь терроризм хувь хүн болон байгууллагад хохирол учруулах, халдах явдалтай холбоотой гэсэн нийтлэг шинжтэй байна. Мөн хуулиудад терроризмын үйл ажиллагаанд ямар хүчин зүйлс багтах талаар хязгаарлаж заасан байна. Террорист үйл ажиллагаа явуулах нь хууль бус төдийгүй террорист бүлэгт хамрагдах /гишүүн болох, дэмжих буюу дарга нь байх/ нь террорист үйлдэл мөн гэж үздэг.

Парламентын хяналтын зүгээс терроризмын жинхэнэ тодорхойлолтыг терроризмын эсрэг шинээр гарсан хуулиудад тусгаж өгөхийг чухал гэж үздэг. Нэг талаар террорист байгууллагын үйлдэж болох үйлдлээс хамгаалах аргыг тодорхой зааж өгч болохгүй ч нөгөө талаар терроризмын тодорхойлолт хууль ёсны ардчилсан эсэргүүцлийг шүүмжлэхээр сүрдүүлсэн өргөн хүрээг хамрахгүй байх хэрэгтэй. Эндээс ардчилсан нийгэм дэх халдлагыг ямар хугацаанд хянаж үзэх вэ гэсэн асуулт гарч ирнэ. Энэ асуултад улс орнуудын хууль санаачлагчид хариулахдаа нийгэм бүр өөрсдийн хуулийн хүрээнд энэ асуудлыг зохицуулах ёстой гэдэг. Энэ асуултыг авч үзэх үед халдлагын зорилгыг хуулиар тодорхойлох ёстойг анхаарвал зохистой. Хэрэв халдлагыг зөвтгөх юм бол халдлагын ноцтой байдал, халдлагын зорилго хоёрын нэгээхэн хэсэг нь болно.

Мөн терроризмын эсрэг арга хэмжээ нь террорист халдлагатай холбоотойгоор тэнцвэртэй байх ёстой юу гэсэн хоёр дахь асуулт гарч болох юм. Терроризмын эсрэг хуулийн зорилго бол террорист үйлдэлд оролцогчдын эсрэг нөлөөтэй үйл ажиллагааг явуулахад цагдаа болон бусад аюулгүй

байдлыг сахин хамгаалах байгууллагуудад туслах зорилготой байдаг учраас байгууллага болон хүний үг хэлэх жинхэнэ эрхийг хязгаарлах зорилго агуулах, улс төрийн сөрөг хүчнийг хязгаарлах, өөрчлөх үйл ажиллагаа байж үл болно.

Терроризмын эсрэг гурван хандлага

Террорист халдлагын эсрэг нийгэм болон төрийн байгууллагуудыг хамгаалах зорилгоор 3 үйлдлийг аюулгүйн алба хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- ✓ **Терроризмын эсрэг арга хэмжээ:** хүмүүс, олон нийтийн амьдрал ахуй, барилга байгууламж, дэд бүтцийг тулгамдсан асуудлаас ангижруулах арга хэмжээ авах;
- ✓ **Терроризмыг таслан зогсоох арга хэмжээ:** террористуудыг халдлага зохион байгуулахаас өмнө тодорхойлж, зогсоох арга хэмжээ авах;
- ✓ **Хямралаас гаргах ажлыг удирдан зохион байгуулах:** террорист халдлагын дараа сэргээн босгох, тусламж үзүүлэх байдлыг /хор хөнөөл, аюулгүй байдал/ тогтворжуулах.

Терроризмын эсрэг ихэнх үйл ажиллагаанууд ихэнхдээ: 1/ үндэстний хууль тогтоомж, чиглэл, хөрөнгийн хуваарилалт; 2/ дотоодын аюулгүй байдал; 3/ гадаадынхан, 4/ аялал болон хилийн хяналт, 5/ санхүүгийн байдал, 6/ олон улсын хамтын ажиллагаа, 7/ атом, хими биологи (АХБ)-ийн зэвсгийн аюултай холбоотой байдгийг судалгаа шинжилгээний үр дүн харуулсан. Эдгээр урт жагсаалтыг терроризмын эсрэг арга хэмжээний жагсаалт гэж авч үзэж болох юм.

Үндэсний хууль тогтоомж, чиглэл, төсөв

- Терроризмын эсрэг тусгай хуулийг батлах буюу одоо байгаа хуулиа боловсронгуй болгох;
- Байгууллагуудын үйл ажиллагаанд зориулж нэмэлт сан хуваарилах /цагдаа, хилийн хяналт, үндэсний нисэх хүчин, үндэсний эрүүл мэндийн газар, үндэсний шуудан холбоо, цэргийн салбарт зориулж/;
- Орон нутгийн аюулгүй байдлын албадуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг өрнүүлэх;

- Орон нутгийн болон үндэсний, холбоотны хэмжээнд аюулгүй байдлын албаны цагдаа, цэрэг, тагнуулын алба, хилийн харуул, хамгаалалт/ янз бүрийн бодлогыг зохицуулах үйл ажиллагааг урт хугацаагаар ажиллаж буй албан хаагч болон зохицуулах төвд хариуцуулах;
- Гааль, татварын байгууллагад ажиллаж буй хүмүүсийн талаарх мэдээллийг тагнуулын болон хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилчдад өгөх.

Дотоодын аюулгүй байдал

- Интернэт, утас, факсын холбоог зохих хяналтын байгууллагад мэдэгдэхгүйгээр сэм чагнах /жишээлбэл шүүх/;
- Харилцаа холбооны талаар мэдээлэл авахыг хүссэн хууль хэрэгжүүлэх агентлагуудад үйлчлүүлэгчдийнхээ мэдээллийг /жишээлбэл нэг жилийн туршид/ хадгалахыг харилцаа, холбооноос шаардах;
- Сэжиглэгдэж буй хувь хүнд мэдэгдэхгүйгээр банк, интернэтэд холбогч байгууллага, зээл олгогч байгууллагуудын электрон бичлэгүүдийг авах;
- Иргэний мэдээллийн талаар хэд хэдэн мэдээллийн сантай холбогдон илүү үр дүнтэй компьютерийн эрэлт хайлтын үйл ажиллагааг мэдээлэх;
- Цагдаагийн ажилтнаас бусад хүний зөвлөсний дагуу цагдаагийн газарт буй мэдээллийн системээс хувь хүний хавтаст хэргийг харах;
- Илүү мэдээлэл авахын тулд урт хугацаагаар цагдан хорих;
- Үндэсний мөрдөх тогтолцоог /биеийн байцаалтыг танилцуулах/, бий болгох.

Гадаадынхан /цагаачлагч, орогнол хүсэгч, гадаадын иргэн/

- Гадаадын иргэн, гадаад хүмүүсийн тухай мэдээллийн сан байгуулахыг аюулгүй байдлын албанд даалгах;
- Өвөрмөц ёс заншилтай хувь хүмүүсийг анхаарлын төвд байлгах /арьсны өнгө/;
- Орогнол хүсэгч нь террорист халдлагад оролцсон гэж сэжиглэгдэж байгаа бол асуудлыг шүүхийн хүрээнд авч үзэх;

- Холбогдох байгууллага /яам/ уг хүнийг үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн гэж тодорхойлсон бол түүнд орогнол өгөхөөс татгалзах;
- Цагаачлах буюу орогнол хүссэн асуудалд хурууны хээг хадгалах /10 жил хүртэлх хугацаагаар/;
- Террорист халдлагад оролцсон бөгөөд улсаас гарч яваагүй хүмүүсийг хорих;
- Виз хүсэх үйл ажиллагааны хяналт шалгалтыг нэмэгдүүлэх: виз хүссэн болон орогнол хүссэн хүмүүсийн улс төрийн байдлыг шалгах.

Аялал ба хилийн хяналт

- Хилийн хяналтыг чангатгах;
- Иргэний нисдэг тэрэгний багийг бэлтгэх;
- Сум нэвтрэхгүй кабин бүхий хаалгыг суурилуулах;
- онгоцны буудлуудад бүх ачааг 100 хувь шалгаж нэвтрүүлэх;
- Биеийн байцаалт, паспортын биометрийн үзүүлэлтийг нэмэх;
- Өртөмтгий нэвтрэх цэгүүдэд /усан боомт, тунель, нисэх онгоцны буудал зэрэг/ байнга хяналт шалгалт явуулах;
- Нэвтрэх цэгүүдэд хяналт шалгалт гаргах.

Санхүү, эдийн засаг

- Санхүүгийн шилжүүлгийг шалгах;
- Мөнгө угаах, луйвар зэргээс сэргийлэхийн тулд банк болон кредитээр үйлчилгээ явуулдаг байгууллагуудад тавих хяналтыг сайжруулах;
- Төв мэдээллийн санд хамгаалалт, тооцооны талаар мэдээлэл /банкны тооцооны мэдээллийн солилцоо/ өгч байхыг банкуудаас шаардах, банкны шилжүүлэг террорист үйл ажиллагаанд зориулагдаж буйг мэдэж байсан буюу сэжиглэж байсан тохиолдолд уг шилжүүлгийн талаар мэдэгдээгүй бол гэмт хэрэг гэж үзэх;
- Санхүү, эдийн засгийн яаманд санхүүгийн тагнуулын алба байгуулах буюу ажлыг нь үр дүнтэй болгох.

Олон улсын хамтын ажиллагаа

- Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, жишээ нь Европын баривчлах шүүхийн тогтоолоор оргон гарсан гэмт этгээдийг барьж нутагт нь эргүүлэн буцаах;
- Терроризмын эсрэг асуудлын тухай олон улсын хэлэлцээрийг үндэсний хууль тогтоомжийн байгууллагад танилцуулах;
- Олон улсын аюулгүй байдалд туслах хүчний үйл ажиллагааны нэгээхэн хэсэг Афганистанд цэрэг байрлуулах;
- НҮБ-ын терроризмын тухай конвенцид гарын үсэг зурж нэгдэн орох;
- Олон улсын төвшинд үйл ажиллагаа явуулдаг аюулгүй байдлын албадууд хоорондоо мэдээлэл солилцох;
- Террористуудын үүр буюу өлгий болсон улс орнуудад хөгжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор терроризмын үндсэн шалтгааныг цохон тэмдэглэх.

Атом, хими, биолог (АХБ)-ийн заналхийлэл

- Цөмийн зэвсэг, химийн, биологийн, цацрагийн төвийг илүү үр дүнтэй болгон байгуулах: эдгээр салбарт гарч буй амжилтуудыг зохицуулах, төрөл бүрийн вакцинуудыг үйлдвэрлэх, хадгалах;
- Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг өндөржүүлэх тохирох эм тариаг ханган нийлүүлэх;
- Цөмийн зэвсгийн тоног төхөөрөмжөөс хамгаалах явдлыг нэмэгдүүлэх /доогуур нисдэг жижиг нисдэг тэргийг хайх радарын тоног төхөөрөмжийг суурилуулах/.

Хүний эрх, аюулгүй байдлын зохистой тэнцвэр

Олон оронд байгаа эдгээр хэм хэмжээнүүд түр зуурынх биш бөгөөд урт хугацааны туршид нөлөөтэй байх нь чухал юм. Иймд терроризмын эсрэг хэм хэмжээнүүд онцгой биш бөгөөд нийгмийн хэвийн амьдралд байдаг арга хэмжээнүүд болно. Эдгээр хэм хэмжээнүүдэд үг хэлэх эрх, байгууллага, хувийн эрхэнд нөлөөлж байгаа юу гэдэг нь чухал байдаг. Терроризмын эсрэг хэм хэмжээнүүдийн үргэлжлэх онцлогийг авч үзвэл эдгээр хэм хэмжээнүүд урт хугацаанд чиглэгдсэн

болохоор улсын онц байдал буюу онцгой нөхцөл байдлууд нь тохиромжгүй байдаг.

Мөн терроризмын эсрэг хэм хэмжээнүүд хууль хэрэгжүүлэх агентлаг, тагнуулын байгууллага хоорондын үндсэн ажил үүргийн хуваарилалтыг тодорхойгүй болгодог. Цагдаагийн байгууллага буюу хууль хэрэгжүүлэх агентлаг, тагнуулын алба нь өөр өөр бодлого үйл ажиллагаа явуулдаг. Цагдаагийн байгууллагын үүрэг бол хууль, хэв журмыг сахиулах бол тагнуулын алба нь нүүрлэж болох аюул, заналхийлэлтэй холбоотой мэдээллийг цуглуулдаг. Цагдаагийн байгууллага хэрэг гарсан талаар нотолгоо олж батлахаас өмнө урьдчилан сэргийлэх тагнуулын үйл ажиллагаа явуулдаггүй бол тагнуулын алба сэжигтэнг зогсоох буюу баривчлах эрхгүй байдаг. Ардчилсан засаглалын үзэл бодлоор тагнуулын алба өөрсдийн иргэдийг тагнах үйл ажиллагаа явуулж үл болно. Олон улс оронд терроризмын эсрэг тэмцлийн шаардлагууд дотоодын гэмт хэргийн судалгааг дэмжих тагнуулын арга барилыг ашиглах тухай хязгаарлалтыг багасгах шалтгаан болдог учраас ажил үүргийн энэ хэсэг хүндрэлтэй болох болсон.

Шүүх хяналтын байгууллагад мэдэгдэхгүйгээр иргэдийг ажиглалтанд авахыг аюулаас хамгаалах салбарт зөвшөөрч байгаа явдал нь гурав дахь хүндрэлтэй асуудлын нэг юм. Энэ нь хүний эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа хэрэг. Ажиглалт хийх үйл ажиллагааны талаар мэдэгдээгүй тохиолдолд засгийн газар, түүний агентлагууд өөрсдийн үйл ажиллагаагаа хариуцах ёстой болохыг ТББ-ууд болон агент барьж чадаагүй бол иргэдийн хувьд хүндрэлтэй болж байгаа хэрэг билээ.

Дөрөвдүгээрт, орогнол хүсэгчид болон гадаадынхан терроризмын эсрэг үйл ажиллагааны бай болох явдал юм. Энэ нь хүн бүр хуулиар тэгш эрхтэй байх ёстой гэдэг хуулийн хэм хэмжээг алдагдуулсан нийгэм дэх өөр өөр үндэсний бүлгүүдийн уур амьсгалыг хурцдуулж болох аюултай юм.

Эдгээр хэм хэмжээнүүд терроризмын эсрэг тэмцэх үр дүнтэй тэмцэл боловч төдийлөн үр дүн өгдөггүй, хамгаалах ёстой гэж бодож байтал амьдралын хэв маягт хохирол учруулж болох талтайг парламент ухамсарлаж байх ёстой. Өөрөөр хэлбэл үнэмлэхүй аюулгүй байдал гэдэг нь бодит бус байдаг

төдийгүй мөн хүсүүштэй бус байдаг нь ардчиллын гол ухагдахуунтай зөрчилдөн үнэмлэхүй эрх мэдэл рүү хөтөлнө. Ийм учраас хуулийн бүх тогтолцоонд эрх мэдэлтэнд олгох тусгай эрх мэдлүүдийг хязгаарласан байдаг. Өнөөдөр терроризмтай тэмцэх явдалд эрх чөлөө, аюулгүй байдлын хурцадмал байдал парламентад ноцтой асуудлыг бий болгож байна. Эрх чөлөө, аюулгүй байдлыг тэнцвэржүүлэх нь зөвхөн дээд албан тушаалтны үүрэг бус гэдэг нь тодорхой болсон бөгөөд хүний эрхийг илэрхийлэгч, баталгаажуулагчийн хувьд парламент энэ талаар нууц хяналтыг явуулах шаардлагатай.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Терроризмтай тэмцэх тухай

- ▷ Асуудлыг зөвхөн хамгаалах, аюулгүй байдалд чиглүүлэх бус, мөн дотоодын зөрчилдөөн зэрэг үндсэн шалтгаанд тулгуурлан терроризмтай тэмцэх өргөн арга замыг дагаж мөрдөх, Соёлын солилцооны хэлэлцүүлэг явуулах, энх тайван, харилцан ойлголцлын замаар бүс нутгийн зөрчлийг арилгах нь терроризмаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд ач холбогдолтой болохыг анхаарах,
- ▷ Бүс нутгийн олон тооны зөрчилдөөний үндэс суурь нь шашны буруу урсгал буюу үндэстний гэсэн тодотголтой олонх, цөөнхийн асуудалтай холбоотой байсан. Ийм маргаанд зэвсэгт хүчин оролцох тохиолдол байсан бөгөөд оролцохгүй явдал ч мөн байсан. Парламентын цөөнхийн гишүүд батлан хамгаалах, тагнуул, шүүх хэргийн хорооны гишүүд байна. Парламент цөөнхийг хамгаалах тусгай хороо, шүүх байгуулна.
- ▷ Танай улс террорист халдлагыг санхүүжүүлэхийг хориглосон олон улсын 1999 оны 12 дугаар сарын 9-ний конвенци зэрэг терроризмтай холбоотой олон улсын протокол, конвенцид нэгдэн орсон эсэхийг шалгах. Эдгээр гэрээ, конвенцид нэгдэх болон холбогдох хууль, бодлогод тусгаж өгөх бололцоог хангах.
- ▷ Терроризмыг арилгах тухай конвенци болон цөмийн терроризмын үйлдлийг хориглох НҮБ-ын Ерөнхий чуулганы конвенцийг батлах үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулах,
- ▷ Үндэсний эв нэгдлийг илэрхийлэн, террорист халдлагын улмаас үүдэн гарсан хохирлыг нөхөн төлөх талаар хуулийн хэм хэмжээг батлуулах талаар ажиллах,
- ▷ Терроризмын эсрэг хуульд иргэний болон улс төрийн эрх эдлэх, аюулгүй байдлын зөв тэнцвэртэй шаардлагыг тусгасан эсэхийг анхаарах: холбогдох салбар бүрт терроризмын эсрэг хуулийн нөлөөлөх чадвар: уг хуулийг хэрэгжүүлэх зардал.

18 дугаар бүлгээс улсын онц байдал, 19 дүгээр бүлгээс дотоодын аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахин хамгаалах тухай өгүүлсэн зөвлөмжийг үз.

21 дүгээр бүлэг

Аюулгүй байдал, мэдээллийн технологи: Шинэ тоног төхөөрөмж, маргаантай асуудлууд

Мэдээлэл технологийн шинэчлэлүүд аюулгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ шинээр заналхийллийг бий болгодог. Өмнөх бүлэгт хөндөгдсөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2001 оны 1373 дугаар тогтоолоор олон улсын энх тайван, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл, олон улсын терроризмтэй холбоотой мэдээллийн технологийн давхар ашиглалтыг олон улсын байгууллагуудад хандсан тодорхой баталгаа болохыг харуулсан.

Сүүлийн хэдэн арван жилд олон улсын янз бүрийн байгууллагууд олон улсын аюулгүй байдалд заналхийлсан үйлдэл, гэмт хэргийг өдөөн хатгасан мэдээллийн технологийг ашиглах явдлыг хамгаалах арга замыг хайх үйл ажиллагаа явуулж байна. Үүний зэрэгцээ хүний эрх, эрх чөлөөнд халдах замаар технологийг ашиглаж буй улс орнуудыг болиулах талаар заавар зөвлөгөө өгөх журмаар ажиллаж байна.

Эдгээр маргаантай асуудлуудад хариу өгөх хуулийг бий болгоход парламентын гишүүдийн сонирхол татаж болохуйц зүйлүүдийг дор дурдлаа.

Кибер гэмт хэрэг

Одоогоор интернэтийн гэмт хэрэг гэж юу болох талаар яригдсаар байгаа бөгөөд ихэнх тохиолдолд компьютерийн вирус, хакеруудтай холбоотой мэдээллийн технологийн маш олон төрлийн гэмт хэрэг, заналхийллийг энэхүү хэллэгээр илэрхийлж болно. Сүүлийн хэдэн жил энэ салбарт хүмүүсийн сонирхол их татагдаж байгаа боловч компьютерийн гэмт хэрэг гэдэг нь шинэ зүйл биш бөгөөд компьютер гарсан цагаас хойш ийм хэргүүд байсан билээ. Одоогоор өөрчлөгдсөн зүйл гэвэл интернэт маш их түгээмэл

болсон учраас довтлогчид өсөх хандлагатай болсон. Интернэт маш олон талын ашиг тусай учраас Дэлхийн дахины Веб нь олон нийтийг өргөнөөр хамруулах болсон. Үүний зэрэгцээ хэрэглээ ихэссэнээр асуудал ихсэх хандлагатай болсон. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл зарим нэгэн жирийн кибер гэмт хэрэг гарахгүй өдөр гэж үгүй болсонд оршино.

2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Европын зөвлөлөөс кибер гэмт хэргийн тухай конвенцийг баталсан бөгөөд анх таван улс, үүний дотор Европын зөвлөлийн 3 улс нэгдэж гарын үсгээ зурсан бөгөөд одоогоор нэгдэх хүсэлтэй орнууд нэгдэж байгаа юм. 2002 оны 5 дугаар сарын байдлаар уг конвенцид Европын Зөвлөлийн 29 улс гарын үсэг зурсан бөгөөд гишүүн бус 4 улс нэгдэн орсон байна. Уг конвенци нь олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, тохирох хууль тогтоомжийг батлах замаар нийгмийг хамгаалахад тулгуурласан гэмт хэргийн нийтлэг бодлогын шаардлагыг танихад үндэслэгджээ.

Мэдээллийн системийн аюулгүй байдал

Боломжтой аргаар, бололцоо бүхий салбарт мэдээллийн системийг ашиглах өсөлт олон улсын байгууллагуудыг холбогдох эрсдэлд оруулж байгаа юм. 1992 оны 11 дүгээр сард Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллагын зөвлөлөөс мэдээллийн системийн аюулгүй байдалд зориулж төлөвлөсөн дэлгэрэнгүй гарын авлагыг гаргасан.

- ✓ Мэдээллийн системийн эрсдэлтэй талуудыг ухамсарлаж, эдгээр эрсдлүүдийг урьдчилан харах боломжтой хамгаалалтыг нэмэгдүүлэх;
- ✓ мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах харилцан шүтэлцээ бүхий хэм хэмжээ, ажлын түршлага, журмыг хөгжүүлж хэрэгжүүлэхийн тулд улсын болон хувийн салбарт ерөнхий уялдаа холбоог бий болгох;
- ✓ эдгээр хэм хэмжээ, ажлын түршлага, журмыг хөгжүүлж, хэрэгжүүлэхэд улсын болон хувийн салбар хоорондын хамтын ажиллагааг дээшлүүлэх;
- ✓ хэрэглэгдэж, холбогдож буй мэдээллийн систем болон түүний үйл ажиллагаанд итгэх итгэлийг бэхжүүлэх;

- ✓ мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангахын тулд олон улсын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллагын зөвлөлөөс “Энэхүү ерөнхий удирдамж нь улсын хууль тогтоомжид байнга тусгагддаг, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хүндэтгэн аливаа засгийн газрын эрхэнд нөлөөлөхгүй” гэж баталсан.

Компьютераар программчлагдсан хувь хүний мэдээллийн файл

1990 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий чуулганаас компьютераар программчлагдсан хувь хүний мэдээллийн файльтай холбоотой ерөнхий удирдамжийг батлан гаргасан. Хэдэн жилийн өмнө буюу 1980 оны 9 дүгээр сард Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн байгууллагаас хувийн буюу хувь хүний мэдээллийг хамгаалах ерөнхий заавартай холбоотой зөвлөмжийг баталсан байна. Мөн 1981 онд Европын зөвлөлөөс хувь хүний мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан гаргасан хувь хүнийг хамгаалах конвенцийг батлан гаргажээ. Тодруулга №46-г үзнэ үү.

Тодруулга №46

Хувь хүний мэдээллийг автоматаар боловсруулахтай холбогдуулан гаргасан хувь хүнийг хамгаалах конвенци

“Энэхүү конвенци нь анх удаа хувь хүний мэдээллийг цуглуулж боловсруулах зүй бус явдлын эсрэг хувь хүнийг хамгаалах, мөн үүний зэрэгцээ хувь хүний мэдээллийг түгээх явдлыг зохицуулах олон улсын арга хэрэгсэл юм. Мөн хувь хүний мэдээллийг цуглуулж боловсруулахтай холбогдон баталгаа өгч зохих хууль ёсны хамгаалалт гаргаж өгөхгүй, хүнийг арьс өнгө, улс төрийн байдал, биеийн эрүүл мэнд, шашин шүтлэг, бэлгийн амьдрал, гэмт хэргийн байдал зэргээр ялгаварлан эдгээртэй холбогдолтой мэдээлэл боловсруулахыг хууль бус гэж зарласан. Уг конвенцид хувь хүн өөрийнх нь тухай аливаа мэдээлэл орсон эсэхийг мэдэх эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл засаж залруулж болох тухай заажээ.

Конвенцид батлан хамгаалах, аюулгүй байдлын чухал шийдвэрлэх асуудал мөрдөгдөж байгаа тохиолдолд байж болох хязгаарлалтыг заажээ. Мөн хуулиндаа тэгш эрх бүхий хамгаалалтын тухай тусгаж өгөөгүй улс оронд хувь хүний мэдээллийг боловсруулахад зарим нэгэн хязгаарлалтын талаар уг конвенцид тусгажээ.

Эх сурвалж: Европын зөвлөлийн вэб сайт . <http://conventions.coe.int>

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Мэдээллийн технологийн тухай хууль тогтоомж

- ▷ Мэдээллийн технологи, кибер гэмт хэрэгтэй холбоотой зохих хуулиуд хэрэгжиж байгаа эсэх, эдгээр технологиуд маш хурдацтай хөгжиж буй болохоор холбогдох асуудлуудыг байнга шинэчилж дахин боловсруулж байгаа эсэхийг хянах;
- ▷ Танай улс олон улсын болон бүсийн холбогдох конвенцид нэгдэн орж, үүнтэй холбоотой бодлого, хууль тогтоомжийг гаргасан эсэхийг хянах;
- ▷ Мэдээллийн технологийг ашиглах болон кибер гэмт хэрэгтэй холбоотой бодлого, хууль тогтоомжуудад хүний эрх, үндсэн эрх чөлөөг хадгалахын чухлыг тусгаж өгсөн эсэхийг анхаарах;
- ▷ Аливаа дутагдал, доголдолтой байдлыг арилгах, засгийн газарт парламентын асуулга явуулах, тусгай гишүүдийн тооцоог шалгаж байцаалт явуулахыг шаардах хэлбэрээр зохих арга хэмжээг авах.

Парламентын арга барил, сурвалж

- ▷ Парламентын хороо буюу дэд хороо мэдээллийн технологи болон уг үйл ажиллагаатай холбоотой асуудал, үндсэн хөгжилтэй хир зэрэг холбоотой ажиллаж байгааг хянах;
- ▷ Байнгын хорооны бүрэн эрх бүхий уг асуудлыг хариуцсан хороо буюу дэд хороог байгуулах, шаардлагатай алхмыг хийх;
- ▷ Эрх мэдэл бүхий парламентын бүрэлдэхүүн үйл ажиллагаа явуулах сурвалж, туршлагын хувьд ямар төвшинд байгаа эсэхийг тодорхойлох;
- ▷ Энэ салбарт үйл ажиллагаа, хэлэлцүүлэг явуулж, хөгжил дэвшлийг дагаж мөрдөж байх албан бус парламентын хэсэг байгуулах боломжийг судлах. Ийм хэсэг аль ч талыг баримтлах ёсгүй бөгөөд боломжтой бол хоёр танхимтай байж болно.

22 дугаар бүлэг

Олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа

Одоогийн олон улсын нөхцөл байдалд зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхэд Нэгдсэн Үндэстний дүрмийн VI бүлэг /Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх/ буюу VII бүлэг /Энх тайванд заналхийлэх, энх тайвныг түйвээх, түрэмгийлэл үйлдэх тухайд авах арга хэмжээ/ дахь заалтуудад тусгагдсан арга замаар явуулж байна. Эдгээр заалтуудад тулгуурлан НҮБ-аас ийм үйл ажиллагааг /НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааг дэс дараатай явуулах тухай тодруулга №48-д үзнэ үү, НҮБ-ын энхийг сахиулах сургалтын тухай тодруулга №50-д үзнэ үү/ зохион явуулахад зориулагдсан бодлого, үйл ажиллагаа тодруулга №47-д өгөгдсөн тайлбаруудыг үзнэ үү/ журмыг боловсруулан гаргажээ. Олон улсын аюулгүй байдалд нөлөөлөх хөгжлийн дагуу улс орон бүр ийм үйл ажиллагаанд оролцох болдог.

Гадаадад энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох тухай

Энхийг сахиулах, энхийг хэрэгжүүлэх буюу энхийг тогтоох үйл ажиллагаанууд Аюулгүйн Зөвлөлийн зөвшөөрлийн дагуу гишүүн орнуудын оролцооноос шалтгаална. Тогтвортой бус бүсүүдэд аюулгүй байдал, энхийг тогтоох зорилготойгоор улс орнууд өөрсдийн цэргийн хүчийг гадаад дахь үйл ажиллагаанд оролцуулдаг. Аливаа цэргийн үйл ажиллагаа олон улсын дүрэм, зарчмын дагуу явагдах ёстой гэдгийг хэлэх нь чухал юм. НҮБ-ын дүрмийн V бүлэгт тусгагдсан хамгийн чухал зүйл бол үндэсний аюулгүй байдлын бодлого, олон улсын тогтоомжийг агуулсан явдал юм.

Сайн засаглалын үзэл баримтлалын үүднээс авч үзвэл парламент, засгийн газрын тэнцвэр, хяналтын системийн хүрээнд парламент зэвсэгт хүчнийг гадаадад томилох шийдвэр гаргахад оролцох боломжоор хангагдсан байх ёстой гэдэг нь хуульд нийцүүштэй, зүйтэй асуудал юм.

Тодруулга №47

Энхийг тогтоох, энхийг сахиулах, энхийг хэрэгжүүлэх, энхийг байгуулах тухай НҮБ-ын тайлбарууд

Энхийг тогтоох тухай

Энхийг тогтоох гэдэг нь талууд дайсагналцахаа больж, маргаанаа энхийн журмаар тохиролцох явдлыг ухуулах дипломат аргыг хэлнэ. НҮБ-аас талууд зөвшөөрсөн тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон үүргээ гүйцэтгэх ёстой. Ийм замаар энхийг тогтоох үйл ажиллагаанд дайсагнах явдлыг төгсгөл болгохоор нэг тал нөгөө талын эсрэг хүч хэрэглэхийг хатуу хориглодог.

Энхийг сахиулах тухай

1948 оноос хойш НҮБ-аас энхийг сахиулах 54 үйл ажиллагаа явагджээ. Сүүлийн 12 жилд эдгээр үйл ажиллагааны 41-ийг Аюулгүйн Зөвлөлөөс удирдан явуулсан байна. Одоогоор энэ салбарт Нэгдсэн Үндэстний энхийг сахиулах 15 үйл ажиллагаа явагдаж байна.

Энхийг сахиулах үйл ажиллагаа нь нэгдүгээрт улс хоорондын зөрчилдөөнийг авч үзэх бөгөөд зэвсэгт халдлагыг хяналтанд авч шийдвэрлэхийн тулд НҮБ-ын шийдвэрээр улс орнуудаас цэргийн албан хаагчдыг элсүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Өнөөдөр энхийг сахиулах хүчний үйл ажиллагаа ихэвчлэн иргэний дайн, улсын дотоод зөрчлийг арилгахад чиглэгдэж байна. Нэгдсэн Үндэстний энхийг сахиулагч цэргийн албан хаагч, цагдаа, бусад хүмүүсийн үүрэг бол дайсагналцсан талуудыг дайсагналаа зогсоож энх тайвны замаар асуудлыг шийдвэрлэхэд оролцох явдал юм.

Үүнд энх тайвны хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, тасралтгүй үргэлжлэх буудалцааныг хяналтанд авах, буферын бүсийг байгуулах, засгийн газар, ТББ-ууд, орон нутгийн иргэдийн бүлгээс тусдаа ажилладаг улс төрийн хүрээлэн байгуулах, хуучин дайчдыг халж тэднийг нийгмийн салбаруудад хуваарилах, сонгууль зохион явуулах, хөгжлийг дэмжих үйл ажиллагаа зэрэг орно. НҮБ нь өөрийн арми, цагдаа байхгүй бөгөөд гишүүн улс орнууд сайн дураар цэрэг, зэвсгээр хангадаг. Сонгуулийг ажиглагч, хүний эрхийг хянагч болон бусад иргэд албан хаагч бус маягаар ажилладаг. Энхийг сахиулагчдын хамгийн хүчтэй зэвсэг бол тэдний үргэлж биедээ авч явах ёстой бүрэн эрхийн мандат юм. Энхийг сахиулах үйл ажиллагаа нь маш эрсдэлтэй байдаг. 1948 оноос

хойш НҮБ-ын 1650 цэрэг болон энхийн сахиулагчид үүргээ биелүүлж яваад амь эрсэдсэн байна.

Энхийг хэрэгжүүлэх тухай: Энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа энхийг сахиулах үйл ажиллагаатай ижил үү?

Энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Аюулгүйн Зөвлөл тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд шаардлагатай арга хэмжээ авах эрхийг гишүүн орнууддаа олгодог. Талуудын зөвшилцөөг шаарддаггүй. Маш цөөн тохиолдолд энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Жишээлбэл, Персийн булангийн дайн, Сомали, Руанда, Гайти, Босни ба Герцогвен, Албани, Зүүн Тимор зэрэгт. Эдгээр энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд нь НҮБ-ын хяналтан дор явагдаагүй бөгөөд нэг буюу хэд хэдэн орнууд жишээлбэл Зүүн Тиморт Австрали улс /1999 он/, Босни ба Герцогвенд /1995 оноос/ болон Косовад /1999/ НАТО-аас цэргүүдийг удирдан, НҮБ хавсрах удирдлагын үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байна.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалах тухай Нэгдсэн Үндэстний дүрэм нь энхийг сахиулах, энхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гол тулгуур баримт бичиг юм.

Энхийг байгуулах тухай

Энхийг байгуулах гэдэг нь зөрчилдөөний дараа улс үндэстэнд энх тайван байдлыг бий болгоход туслах зорилготой үйл ажиллагаа юм. Төрийг байгуулах, дахин сэргээх үүргээс шалтгаалан эдгээр үйл ажиллагаа нь бүрэн хэмжээний эрхтэй байна.

Хүмүүнлэгийн үйл ажиллагаа

Ийм үйл ажиллагаа нь иргэний дайн, өлсгөлөн, үер, бороо, салхи, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг тохиолдсон үед хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэхэд оршино. Ихэнх улсын засгийн газар, төрийн бус байгууллагууд /ТББ/, НҮБ-ын агентлагууд асуудлыг зохицуулах арга замыг эрэлхийлэх бөгөөд зарим тохиолдолд зохицуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвхөн цэргийн хүчийг байрлуулж туслалцаа авах шаардлагатай болдог.

*Эх сурвалж: НҮБ-ын вэб сайт дахь холимог бүлгээс.
<http://www.un.org>*

Засгийн газар болон ард түмний сонирхол бол уг үйл ажиллагааны ардчилсан ёс, олон түмний дэмжлэгийг нэмэгдүүлэх парламентын хэлэлцүүлэг, санал зэрэг парламент цэргийн хүчээ гадаад руу явуулах үйл

ажиллагаанд бололцооны хэрээр оролцож болно гэж хэлж болох юм.

Гадаад руу цэргийн хүч илгээх үйл ажиллагааг шийдвэрлэхэд парламентын оролцоо

Олон улсын хямралыг шийдэх боломж ба шинэ заналхийлэлтэй тэмцэх хүрээнд гадаад руу цэргийн хүч илгээх нь чухал боловч зарим улсын парламентын үүрэг хязгаартай, заримд нь бүр энхийн төлөөх үйл ажиллагаанд оролцохыг батлах үед парламентын үүрэг оролцоо байхгүй байдаг. Аюулгүй байдлын асуудлыг ардчилсан хяналтаар хамгаалахын тулд хамгийн багаар бодоход үүний тал хувь нь ч гэсэн өөрчлөгдөх ёстой юм.

Энэ талаар гурван өөр нөхцлийг тодорхойлж болох бөгөөд тус бүрт нь парламентын үүрэг, шууд оролцоог сайн засаглалын үүднээс бэхжүүлж болох юм.

Парламентын батламж /нөлөө бүхий оролцоо/

Зөвхөн парламентын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчнийг гадаад руу илгээдэг. Парламент хэлэлцүүлэг явуулах, уг сэдвээр санал хураах эрхтэй /АНУ/ байх нөхцөл болон ийм үйл ажиллагааны үндэслэл болон эрхийг тусгасан тусгай хууль батлах зайлшгүй шаардлагатай /Швед/ нөхцөл хооронд өчүүхэн ялгаа бий. Хоёр нөхцөл хоёулаа энхийг сахиулах үйл ажиллагаа болон хүмүүнлэгийн туслалцааны ардчилсан хууль ёсыг шаардаж байна.

Цаг хугацаа бол батлан хамгаалах асуудлын гол утга учир бөгөөд парламентын дэг журам гол төлөв хурдан шаламгай бус, зөвшөөрлийн нөхцлийг хэрэгжүүлэхэд тийм ч хялбар бус байдаг. Иймд ихэнх тохиолдолд гадаадад цэрэг явуулах үйл ажиллагаанд парламент оролцох нь нэгдүгээрт тавигдах асуудал биш юм. НҮБ-ын дайны эрх мэдлийн шийдвэрт Конгресс гадаадад цэрэг явуулахад хугацааг 92 өдрөөс илүү байж болохыг зөвшөөрдөг. Парламент зөвшөөрөл өгөхөөс өмнө цэргүүд аль хэдийн үйл ажиллагаа эхлүүлсэн бол энэ байдал үүнд хамаарна. Үүний эсрэг Голландын үндсэн хуулийн 100 дугаар зүйлд зааснаар олон улсын хууль, хэв журмыг бэхжүүлэх буюу хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчний

сонирхол буюу цэрэг дайчлахтай холбоотой бүх мэдээллийг парламент урьдчилан авахад цэргийн хүчийг гадаад руу явуулахад парламент, засгийн газар хоорондын хамтын ажиллагааг шаардсан байдаг.

Гадаад руу цэрэг илгээх тухай парламентын хязгаарлагдмал, маргаантай үүрэг оролцоо /хязгаарлагдмал оролцоо/

Үндсэн хууль болон бусад хуулиар парламентын үүргийг хязгаарлан заасан байдаг. Тодорхой чиглэлээр гадаад руу цэрэг илгээх тухай парламент хэлэлцүүлэг явуулах эрхтэй байдаг. Гэвч дээд албан тушаалтны шийдвэрийг өөрчлөх эрхгүй байдаг. Мөн энэ сэдвээр парламент санал хураах үйл ажиллагаа явуулж үл болно.

Ийм нөхцөлд засгийн газар парламентад зөвхөн дараа нь мэдэгддэг. Холбогдох шийдвэрийн талаар парламентад санал хураалт явуулах эрх байдаггүй боловч гадаад руу цэрэг илгээх асуудлаар ардчилсан хууль ёсыг хөгжүүлэх хэлэлцүүлэг явуулж болно.

Парламентын эрхийг хязгаарласан тохиодолд гадаад руу цэрэг илгээх үйл ажиллагаанд оролцохгүй байж болно. Гэвч гадаад руу цэрэг илгээх асуудлаар засгийн газар, парламент хэлэлцүүлэг явуулах бөгөөд зарим оронд санал хураалт явагддаг болохыг бодит амьдралын туршлагаас харж болно.

Шийдвэрлэх үйл ажиллагаанд парламентыг үл оролцуулах /үүрэггүй/

Энэ нь гадаад руу цэрэг илгээх тухай асуудлыг парламент хэлэлцэхгүй бөгөөд түүнээс гаргасан зөвшөөрөл шаардлагагүй гэсэн үг юм. Гадаад руу цэрэг илгээх асуудал зөвхөн гадаад бодлогын баримтлах шийдвэр бөгөөд энэ шийдвэрийг дээд албан тушаалтан бүрэн эрхийн хүрээнд гаргадаг. Тэгэхээр парламент шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохгүй.

Парламентад хэрэгжүүлэх боломжтой бусад аргууд

Парламент шийдвэр гаргахад оролцох эрхгүй буюу зөвхөн хязгаарлагдмал оролцоотой ч гэсэн доод тал нь 4 арга замаар засгийн газарт шууд бус утгаар шахалт үзүүлж болно. Үүнд:

- ✓ Дээд албан тушаалтнаас гадаад руу цэрэг илгээх асуудалтай холбоотой парламентын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг тайлбарлахыг парламент шаардаж болно. Гэвч парламентад засгийн газрын олон улсын гэрээний тухай бүрэн мэдэгдээгүй тохиолдолд засгийн газрын шийдвэртэй маргаж чадахгүйд хүрнэ.
- ✓ Төсөвт өөрчлөлт оруулах асуудлаар дээд албан тушаалтан болон парламентын хооронд маргаан гарч болно. Төлөвлөгдөөгүй энхийн төлөөх үйл ажиллагаанд парламентаас одоо буй төсөвт нэмэлт сан гаргахаар батлах ёстой. Ингэж парламент хөрөнгөөрөө шалтаглан үзэл бодлоо илэрхийлэх боломжтой. /Францад болсон шиг/
- ✓ Парламентын оролцоо зөвхөн гадаад руу цэрэг илгээх тухай хэлэлцүүлэг явуулах, санал хураах нь чухал биш юм. Энхийн төлөөх үйл ажиллаганы үеэр парламентын гишүүд уг үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэхээр засгийн газарт хандах, мөн парламентын гишүүд гадаадад буй цэргийн хүчний баазад айлчилж болно. /17 дугаар бүлгээс үзнэ үү/
- ✓ Дараа нь гаргах үзэл бодлын үүднээс энхийн төлөөх үйл ажиллагаа дууссаны дараа парламент асуулга явуулж, засгийн газраас уг үйл ажиллагааны талаар асууж болно.

Тодруулга №48

НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааг алхам алхмаар хийх ажиллагаа

НҮБ-д өөрийн гэсэн арми байдаггүй. Энхийг сахиулах үйл ажиллагаа бүр шинэ нөхцөл байдлыг шаарддаг болохоор уг нөхцлийг биелүүлэхийн тулд ажиллагаа зохион байгуулах ёстой. Аюулгүйн зөвлөл шинэ үйл ажиллагааг зохион байгуулах, бүтцийн асуудлыг зохион байгуулдаг.

Аюулгүйн Зөвлөлийн 15 гишүүн тухайн орон нутаг дахь энхийг сахиулах үйл ажиллагаа явуулах бүрэн эрхийн асуудлыг шийддэг. Ийм шийдвэрт доод тал нь 8 санал авах хэрэгтэй бөгөөд Аюулгүйн Зөвлөлийн одоогийн 5 гишүүн орны /Хятад, Франц, ОХУ, Их Британи, АНУ/ нэг нь эсрэг санал өгвөл хориглож болно. Ерөнхий нарийн бичгийн дарга үйл ажиллагаа хэрхэн явагдаж дуусах, энэ тухай тайланг тавих асуудлын талаар зөвлөмж гаргадаг. Энхийг Сахиулах үйл ажиллагааны газар /ЭСҮАГ/ нь дэлхий дахинд НҮБ-ын энхийг сахиулах өдөр тутмын үйл ажиллагаа, удирдлага, ар талыг хариуцан ажилладаг.

Ерөнхий нарийн бичгийн дарга уг хүчний даргыг сонгох бөгөөд гишүүн орнуудаас цэрэг, цагдаа бусад хүч гаргах боломжтой эсэхийг асуудаг. Хангамж, тоног төхөөрөмж, унаа хөсөг, ар талын албыг гишүүн орнууд буюу хувиараа гэрээлэгч этгээдээс гаргуулж болно. Тусламж үзүүлэх иргэдийн штаб онцгой үүрэг даалгавар гүйцэтгүүлэхээр албан хаагч томилох, гишүүн орнуудаас албан хаагч татах, орон нутаг, олон улсаас хувь хүмүүсийг НҮБ-ын системийн хүрээнд оролцуулах үйл ажиллагааг явуулна.

Тусгай үйл ажиллагаанд цэрэг армия оролцуулах нь гишүүн орнуудын өөрсдийн хүсэл сонирхлоос шалтгаална. Цэрэг татлага явуулахад шаардагдах цаг хугацаанд тулгамдсан санхүүгийн эх үүсвэрийн боломж, стратегийн бололцоо нөлөөлнө. 1973 онд НҮБ-ын Аюулгүйн хүчний хоёр дахь элемент нь Ойрх Дорнодод 24 цагийн дотор цэрэг татлага явуулж байсан. Гэвч маш холимог мандаттай, ар тал хүндрэлтэй, энхийг сахиулагчид эрсдэлтэй асуудалтай тулгарах үед шаардлагатай хэсгийг цуглуулахад хэдэн сар хэрэгтэй болдог.

Эх сурвалж: НҮБ-ын вэб сайт . <http://www.un.org>

Тодруулга №49

Энхийн төлөөх үйл ажиллагаанд оролцох дүрэм журам

Гадаадад цэрэг илгээхийг парламентаас батлахдаа зөвшөөрөгдсөн цэргийн тоо хэмжээ болон ямар нөхцөл байдалд юу хийх ёстой зэргийг заасан байдаг. Өөрөөр хэлбэл оролцох журам дүрмийг тодорхойлно гэсэн үг юм. Оролцох дүрмээс онцгой байдалд хохирол учруулж болзошгүй хүч хэрэглэж болох тухай төлөвлөгөөнд тусгагдсан хязгаарыг мэдэж авах болно. Эдгээрийг хувь хүн дээр үндэслэн авч үзсэн бөгөөд цэргүүдэд өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай хамгаалалтыг зөвшөөрсөн хүч хэрэглэхийг боломжоороо хязгаарлахыг хичээсэн. Өөрийгөө хамгаалах үндсэн нөхцлийг дэмжих ёстой. Оролцооны дүрэмд

цэргүүд үйл ажиллагааны болон тактикийн хүчин зүйлийг дэмжих ёстойг заажээ. Тэд үйл ажиллагааны болон улс төрийн утга агуулгыг, мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэр зэрэг олон улсын хууль дүрмийг маш болгоомжтой дагаж мөрдөх ёстой.

Оролцох дүрэм нь зөрчил мөргөлдөөн, хурцадмал байдал сөргөлдөөнийг шийдвэрлэхэд шаардагдах хүчийг хэрэглэх аргыг тодорхой заасан үзүүлэлттэй байх ёстой. Эсэргүүцлийн төвшингийн үүднээс хамааран оролцох дүрмийг тодорхойлох нь хор хөнөөлийг багасгах эсэргүүцлийн хүчний янз бүрийн төвшинд шаардлагатай хүчийг хэрэглэх тактикийн эрхийг олгодог. Ийм тохиолдолд оролцох дүрэмд хүч хэрэглэх дараахь төвшингүүдийн болзол тавьж болно. Үүнд:

- Цэргүүд зөвхөн өөрөө өөрийгөө хамгаалах;
- Цэргүүд өөрсдийгөө хамгаалах, иргэдийн амь насыг хамгаалах;
- Цэргүүд өөрсдийгөө болон иргэдийн амь насыг хамгаалах, зорилгоо тодорхойлох/эмнэлэг, гүүр гэх мэт/;
- үйл ажиллагааны зорилгыг биелүүлэхийн тулд шаардлагатай бүх аргыг ашиглах.

Мөн үүний зэрэгцээ оролцох дүрэмд энхийг сахиулах ажиллагааны үеэр хэрэглэж болох зэвсгийн төрлийг заасан байх ёстой. Зэвсгийн төрөлд зэвсэггүй байхаас эхлэн усан онгоц, онгоц, пуужингийн технологиуд гэх мэт хүнд зэвсэг хүртэл зааж болно.

Цэргүүдийг энхийг сахиулах ажиллагаанд бэлтгэх тухай

Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох нь аливаа цэргийн хүчнээс шаардах үүргээс гадна цэргүүдийг стандартын дагуу бэлтгэж сургуулилалт хийх, заавар зөвөлгөө өгөхийг шаарддаг.

Цэргүүд тэсрэх бөмбөгний талаар тусгай мэдлэгтэй байх, иргэдтэй харьцах чадварыг /орон нутгийн хэлээр ярьдаг, ойлгодог/ эзэмшсэн байх, орон нутгийн зан заншил, ёс суртахууны талаар мэдлэгтэй, хүний болон энэрэнгүй ёсны хуулийн тухай ойлголттой, тодорхой ажиллагаанд оролцох дүрмийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай гэдэг нь үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах зүйл юм. Энхийг сахиулах ажиллагаанд хүч хэрэглэх хориотой бөгөөд зарим үед цэргийн хүчнүүд буу зэвсэг биедээ авч явах шаардлагагүй байдаг.

Энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бэлтгэл хангалттай хангагдаагүй бол төлөвлөгөөний төвшинд тусгай сургуулилалт хийх шаардлагатай. Ийм нөхцөлд цэргүүдийг тээвэрлэхэд хүндрэлтэй байдаг бөгөөд зарим үед улсын материалын бэлтгэлийг дийлж давахааргүй болгоно.

Эцэст нь хэлэхэд, удирдах болон ар талын төвшинд илүү цагаар сургалт явуулж бэлтгэх шаардлагатай байдаг. Олон улсын үндэстний цэргүүд нэгдсэн хяналтан дор нэг газарт үйл ажиллагаа явуулж болох ба үүнд удирдах тушаалын хэлбэр л өөрчлөгдөнө. Өөр өөр улсын зэвсэгт хүчин, Улаан Загалмайн Олон Улсын Хороо зэрэг байгууллагууд хамтран ажиллах нь чухал байдаг.

НҮБ-аас явуулж буй энхийг сахиулах үйл ажиллагаанд цэргүүдийн тушаалыг зөвхөн Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрээр хязгаарлахгүй бөгөөд оролцох дүрэм, НҮБ-ын үйл ажиллаганы дүрэм, НҮБ-ын удирдан чиглүүлэх ёс зүй, НҮБ-ын олон үндэстний хүчний бүх удирдлагуудын шийдвэрээр явагдана.

Тодруулга №50

Энхийг сахиулах НҮБ-ын сургалт

Энхийг сахиулах ажиллагааны газрын нарийн бичгийн дарга нарын газрын дэргэд байгуулагдсан сургалтын алба заавар зөвөлгөө өгөх, шинжээч гаргах, энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй гишүүн орнуудад мэдээлэл өгөх үйл ажиллагааг явуулна. Уг алба олон жилийн туршид явуулсан энхийг сахиулах ажиллагааны туршлагаас олж авсан стандарт журам, мэдлэгийг түгээх зорилгоор материал, сургалтын хичээлийг боловсруулдаг. Мөн цэргийн коллеж, олон орны үндэсний болон бүсийн сургалтын төв, энхийг сахиулах ажиллагаатай хамтран ажилладаг. НҮБ-ын Сургалтанд туслах баг ба сургалтын дамжаа нь энхийг сахиулах сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд гишүүн орнуудад тусалдаг. Удирдан чиглүүлэх ёс зүй болон янз бүрийн гарын авлага, заавруудыг нэгдсэн стандартад хүргэхэд зориулж үйл ажиллагаа явуулна.

Эх сурвалж: НҮБ-ын вэб сайт . <http://www.un.org>

Гадаадад хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах, цэрэг илгээх шалгуур үзүүлэлт

Засгийн газар, парламентаас цэргүүдийг гадаадад илгээх шалгуур үзүүлэлтийг боловсруулна. Шалгуур үзүүлэлтийг ил тод байлгах нь энхийн ажиллагааг дэмжих, олон нийтийг нэмэгдүүлэх шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод байдлыг өсгөнө. Энд хоёр төрлийн үндсэн шалгуур үзүүлэлт байна /Дараахь тодруулгаас үзнэ үү/. Энхий шалгуур нь улс төрийн утга агуулга, үйл ажиллагааны төрлийг илэрхийлнэ. Хоёр дахь шалгуур үзүүлэлт нь үйл ажиллагаа, мандат, тушаал, цэргүүдийн байрлах хугацаа, төрөл зэрэгт чиглэнэ.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Энхийг сахиулах ажиллагааны агуулга, үйл ажиллагааны төрлийг илэрхийлсэн ерөнхий шалгуур

- ▷ Парламент буюу холбогдох хороо дараахь асуудалд анхаарлаа төвлөрүүлж байгаа эсэхийг шалгах:
 - тухайн улсын олон улсын өмнө авсан амлалт;
 - энхийг сахиулах ажиллагааны нэгээхэн хэсэг болох цэргүүдийг илгээх, хүлээн авах боломж;
 - аливаа тусгай нөхцөл байдалд зориулан гаргасан үндэслэл /оролцож буй оронд хүний эрхийг зөрчих явдал/;
 - дэлхий болон бүс нутгийн энхийг сахиулах ажиллагааны үндсэн утга агуулгыг илэрхийлэх;
 - дэлхийн болон бүс нутгийн энхийг сахиулах ажиллагаанд цэргүүдийг оролцуулах тухай үндсэн дүрэм;
 - цэргийн хүчийг тэнцвэртэй ашиглах;
 - үр ашигтай улс төрийн шийдэл гаргах заалтууд;
 - төрийн эрх мэдэлтний хязгаарлалт;
 - энхийг сахиулах ажиллагаанд оролцох зарчмыг олон нийт дэмжих, эс дэмжих;
 - боломжоороо асуудлыг хяналтанд байлгахтай холбогдолтой аливаа зарчим, дэг журам;
 - энхийг сахиулах цогц ажиллагааг хянахын тулд ажиллагаа дууссаны дараа бүх мэдээллийг парламент хүлээн авах.

Энхийг сахиулах ажиллагаатай холбоотой тусгай шалгуур

- ▷ Парламент болон холбогдох хороо дараахь асуудалд анхаарлаа хандуулж байгаа эсэхийг шалгах:
 - энхийг сахиулах арга хэмжээний цөм, мандатын тайлбар;
 - оролцож буй цэргийн албаны төрөл;
 - ажиллагааны цэргийн бололцоо;
 - цэргийн хэсэг, материалын бололцоо, тохиромж;
 - холбогдох цэргийн албан хаагчдад учирч болох эрсдлүүд;
 - үйл ажиллагааны төлөвлөгдсөн хугацаа, шаардлагатай үед гарч болзошгүй шалгуур;
 - төсвийн хамаарал;
 - асуудалд хандах олон нийтийн хандлага.

Энхийг сахиулах ажиллагаатай холбоотой парламентын дэг журмыг хэрэглэх нь

- ▷ Шаардлагатай бол парламент:
 - энхийг сахиулах ажиллагааны тухай олон нийтийн сонсгол явуулах;
 - энхийг сахиулах ажиллагааг явуулах талаар санал асуулга явуулах;
 - энхийг сахиулах ажиллагаанд оролцсон аливаа албан хаагчийн эрхийг зөрчсөн бол баривчлахыг шаардаж болохыг хянах.
- ▷ Одоо явагдаж буй энхийг сахиулах ажиллагааны талаар парламентын асуулга, сонсгол явуулах журмыг ашиглах талаар бүү эргэлз.

*Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт
тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт*

VI ХЭСЭГ

Санхүүгийн эх үүсвэр: аюулгүй байдал дахь үр ашигтай төсвийн хяналт

23 дугаар бүлэг

Аюулгүй байдал ба мөнгөний чадавх

Парламент ба аюулгүй байдалтай холбоотой төсвийн үйл ажиллагаа

Дэлхий нийтэд аюулгүй байдлын төсвийн хангамжийг батлах, хяналт тавих талаар парламентын гол үүргийг хуулиар заасан байдаг. Энэхүү үүрэг улс төрийн шалтгаан болон боломжоос хамааран улс орон бүрт харилцан адилгүй байдаг. Бодит амьдрал дээр парламент нөлөө бүхий шийдвэр гаргахдаа дутмаг байх бөгөөд парламентаас явуулж буй үйл ажиллагаа нь аюулгүй байдлын тодорхой хуваарилалт, зарцуулалт дахь тодорхой бус байдал, зарим нууцлаг байдлын улмаас хязгаарлагдмал байдаг. Батлан хамгаалахын төсвийн эргэлтийн бүх санаачлагыг зэвсэгт хүчин, дээд албан тушаалтнуудын гарт өгөх замаар урт хугацааны туршид бий болсон аюулгүй байдлын салбар дахь дээд албан тушаалтны сайн засаглалын соёлыг парламентын үйл ажиллагаагаар хаагдуулдаг.

Парламентын гишүүд улсын төсвийн чадавхийг аюулгүй байдлын салбарын хяналтын хэрэгсэл мэтээр дутуу үнэлж, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөлт оруулж шинэчлэх ёсгүй. Хуваарилалт нийтийн хүртээл болохуйц хамгийн шилдэг аргаар “мөнгөний чадамж”-ийг ашиглаж болох юм.

Тодруулга №51

Төсөв: ардчилсан засаглалын гол хэрэгсэл

“Улсын төсөв нь зөвхөн орлого, /төсөвлөгдсөн/ зарлагыг нэгтгэсэн баримт бичиг биш бөгөөд жилийн явцыг дүгнэн дээд албан тушаалтны гаргасан хамгийн чухал бодлогын илрэл бөгөөд үндэсний бодлогыг агуулсан үндсэн үнэлгээ юм. Төсөв нь улсын нийгэм эдийн засгийн бодлогын талаар засгийн газрын үзэл бодлыг илэрхийлдэг ба засгийн газрын санхүү, эдийн засгийн үндсэн зорилгын тунхаглал бөгөөд нийгэм эдийн засгийн тэргүүлэх байр суурийг илтгэдэг. Уг төсвөөр засгийн газрын цаашдын зорилго болон хийж гүйцэтгэсэн ажилд үнэлгээ өгч болдог.

“Төсөв нь сайн засаглал, тодорхой байдал, хариуцлага, ил тод байдлыг бий болгоход шийдвэрлэх чухал баримт мөн. Төсөвлөгдсөн зарлагыг илүү нарийвчлалтай болгосноор парламент болон нийт ард түмэн “мөнгө хаашаа урсаж байгааг мэдэж” болно. Ийм маягаар ил тод байдлыг бий болгоно. Мөн засгийн газар мөнгө зарцуулах буюу улсын орлогыг өсгөхөөс өмнө парламент төсвийг баталж, сайд нарыг парламент болон парламентын хороодын өмнө ажлаа хариуцахыг даалгана.

“Ил тод, тодорхой байдал нь үндсэн хуулиар заасан шаардлага байх ёстой бөгөөд ялангуяа үүнийг улсын төсөвтэй холбоотой үйл ажиллагаагаар заах ёстой. Төсвийн дотоод үйл ажиллагааны ил тод, тодорхой байдал нь ардчиллын амин чухал зүйл юм.”

Эх сурвалж: Парламент болон төсвийн үйл ажиллагааны т алаарх Олон Улсын ПХХ-ны семинарын ерөнхий мэдээлэл. 2000 оны 5 дугаар сар Найроб.

Парламент аюулгүй байдлын асуудал болон аюулаас хамгаалах салбарт хандахдаа төсвийн эргэлтийн дөрвөн гол үе шатанд үндсэндээ анхаарлаа хандуулдаг.

Төсөв-бэлтгэх: энэ үе шатанд дээд албан тушаалтанд хэд хэдэн зорилгоор мөнгө хуваарилах санал тавина. Гэвч парламент болон парламентын гишүүд янз бүрийн албан болон албан бус аргаар уг үйл ажиллагаанд оролцож болно.

Төсөв-батлах: энэ шатанд парламент олон нийтийн ашиг сонирхол, мөнгөний хуваарилалтын зохицолдоог судалж шийдэх ёстой бөгөөд тодорхой сэдвээр тусгай лавлагаа явуулж аюулгүй байдалтай холбоотой мөнгө зарцуулах асуудлыг гүйцэтгэх болно.

Биелүүлэлт буюу зарцуулалт: энэ үе шатанд парламент засгийн газрын зарцуулалтанд хяналт тавих, ил тод, тодорхой байдлыг нэмэгдүүлэх болно. Тодорхой асуудлыг дараахь хэсгээс үзнэ үү. Нэмэлт төсөв шаардлагатай тохиолдолд парламент өртөг хэтрүүлэхээс хамгаалахын тулд шаардагдах уг нэмэлт төсвийг хянаж, сайтар судалж үзнэ.

Хяналт шалгалт: энэ үе шатанд засгийн газраас хуваарилсан мөнгийг буруу ашигласан эсэхийг судалж үзэх бөгөөд парламент үе үе бүх төсвийг сайтар нягталж, хариуцлага, үр ашиг, нягт нямбай байдлыг хангасан үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг шалгана.

Тодруулга №52

Яагаад парламент төсвийн асуудалд идэвхтэй байр суурь эзэлдэг вэ?

Сөрөг хүчин төсвийн талаар өөр сонголт хийх санал боловсруулж, төсвийн хэлэлцүүлэг явуулж болно. Хуулиар төсвийн санал хураахдаа дийлэнх олонх сонгогдсон тухай тунхаг бичиг болон бодлогын хэрэгжүүлэлт хоорондын итгэл, нягтралыг зөвшөөрөх оноогоор хэмжин дээд албан тушаалтны үйл ажиллагаанд итгэл хүлээлгэдэг.

Төсвийн хяналт бол засгийн газрын бодлогод нөлөөлөх хамгийн чухал арга хэрэгслийн нэг билээ. Төсвийн хяналтын тогтоолын дагуу дээд албан тушаалтанд төлөөс олгож төсвийн эргэлтийг дуусгавар болгоно.

Эх сурвалж: 2001 оны 11 дүгээр сард Малигийн Бамакод болсон Парламент ба Төсвийн үйл ажиллагаа, хүйсийн үзэл бодол сэдэвт Олон улсын ПХХ-ны семинарын ерөнхий илт гэлээс

Батлан хамгаалахын төсвийн зарцуулалт

Дэлхийн янз бүрийн улс орон дахь батлан хамгаалахын төсвийн зарцуулалтын үзүүлэлтийг дараахь жишээгээр үзүүлэв. Дэлхийн хүйтэн дайны үед ихэнх орнууд “энхийн ногдол ашиг” хэмээн нэрлэгдэх зүйлд мөнгө хуваарилж байсныг харуулсан ба батлан хамгаалахын төсвийн зарцуулалтын бууралтыг ажиглаж болно. Гэвч Ази, Африкийн бусад орнууд энэ үеэр өөрсдийн орны батлан хамгаалахын төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлж байсан байна.

Тодруулга №53

Дэлхийн зарим орны ДНБ дахь батлан хамгаалахын төсвийн зарцуулалт /хувиар/

	1985	2000	2001
НАТО-ийн орнууд:	4.0	2.2	2.2
АНУ	6.5	3.0	3.2
Их Британи	5.2	2.4	2.5
Франц	4.0	2.6	2.6
ХБНГУ	3.2	1.6	1.5
НАТО-ийн бус Европийн орнууд	4.3	2.8	2.3

ОХУ	16.1	5.0	4.3
Ойрх дорнод ба Хойд Африкийн орнууд	11.9	6.7	7.2
Төв ба Хойд Азийн орнууд	4.3	5.2	3.8
Зүүн Ази ба Австралийн улсууд	6.4	3.5	3.3
Япон	1.0	1.0	1.0
Карибийн тэнгис болон Латин Америкийн орнууд	3.2	1.7	1.7
Сахар ба Африк	3.1	3.8	3.4
Эритр	н.а	30.0	20.9
Нийт:	6.7	3.6	3.5

Эх сурвалж: 2002-2003 оны цэргийн т айлан, Лондонгийн Ст рат егийн судалгааны олон улсын хүрээлэн.

Аюулгүй байдлын төсөв боловсруулах тухай

Үр дүнтэй төсөв боловсруулахад хариуцлага болон ил тод байдал чухал нөхцөл болно. Хариуцлагаас чөлөөлөх хамгийн шилдэг арга бол төсөв боловсруулахдаа ил тод байдлыг баримтлах явдал юм. Зохих ёсны хариуцлага, ил тод байдлыг үр дүнтэй төсөв боловсруулах зарчмаар хөгжүүлж болно.

Дээд бүрэн эрх - парламентаас дээд албан тушаалтанд зарцуулалтын эрх олгох ёстой.

Нэгтгэл - парламентад бүх орлого, зарцуулалтыг төсвийн нэгдсэн бичиг баримт болгон хүргүүлэх.

Тогтмол хугацаа - Дээд албан тушаалтан парламентад төсвөө оруулах жил бүрийн тогтсон цаг хугацааг баримтлах ёстой. Мөн тогтмол цаг хугацаанд мөнгөний хуваарилалтыг зарцуулах цаг хугацааг тодорхойлж өгөх хэрэгтэй.

Тодорхойлолт -Төсвийн зүйл нэг бүрийн тоо, тайлбарыг засгийн газрын төсвийн зарцуулалтанд тодорхой тусгаж өгөх ёстой. Иймээс төсвийн зарцуулалтанд тайлбар тодорхой биш байж болохгүй бөгөөд төсвийн зүйл нэг бүртэй холбоотой сан тодорхойгүй байж үл болно.

Хууль ёс -Төсвийн бүх зарцуулалт болон үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах ёстой.

Тогтсон бүтэц - Парламентад байнга хүргүүлдэг нэмэлт зарцуулалтын төлөвлөгөө нь хүмүүст ойлгомжтой, зохион байгуулалттай байхаар дээд албан тушаалтан парламентад танилцуулах хэрэгтэй.

Тодорхой байдал - Аюулгүй байдлын ялгаатай талуудыг тусгасан улсын төсөв бүх орлого зарлагыг илтгэсэн төгс боловсруулагдсан байна. Аюулгүй байдлын бүх албаны төсвүүд, цэргийн, улсын бусад цэрэгжсэн байгууллагууд, цагдаа, тагнуулын алба, дээд албан тушаалтны удирддаг хувийн цэргийн компаниудын төсвийг оруулан тооцно.

Ил тод байдал - Иргэн бүрт /хувь хүн буюу байгууллага/ төсвийн талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох ёстой. Энэ нь төсвийн бүх баримт бичгүүд тогтсон бүтэцтэй, тухайн улсын өнцөг булан бүрт олж унших боломжтой байхыг хэлнэ. /хуулбарыг орон нутгийн номын санд хүргүүлэх гэх мэт/.

Тогтмол байдал - Бодлого, төлөвлөгөө, төсвийн орлого, гүйцэтгэлийн зарлагын хооронд тодорхой сүлжээг бий болгох шаардлагатай.

Арга ба төгсгөл - Төсвийг тайлбарлахдаа 1/ эх үүсвэрийн орлого, 2/ гүйцэтгэл ба хүрэх байсан зорилгын боломж, 3/ төлөвлөгөөний үр дүн зэргээр төсвийн зорилгыг тодорхойлох ёстой. Уян төсөвт эдгээр гурван хэмжүүрийн аль нэгийг өөрчилж болно.

Үнэндээ эдгээр зарчмуудыг орчин цагийн оновчтой төсөв боловсруулахад чанарын үзүүлэлт болгон авч үзэж болно. Парламентын гишүүд аюулгүй байдлын асуудлаар зохих ёсны мэдээллээр дутмаг байхад батлан хамгаалахын төсвийн эргэлтэнд нийгэм эдийн засгийн, хөгжлийн асуудлуудыг тусгах боломжгүй юм.

Аюулгүй байдлын зохистой төсөв боловсруулах нөхцлүүд

Аюулаас хамгаалах салбар дахь парламентын хяналтыг нэмэгдүүлэх зохистой төсөв боловсруулах янз бүрийн хүчин

зүйлсүүд бий. Эдгээр хүчин зүйлсүүдээс үндсэн хуулийн болон бусад хууль зүйн хүрээ, мөнгөний ханш, төсвийн дэг журам, цаг хугацаа ба иргэний нийгэмтэй холбогдох зэрэг нь илүүцтэй юм шиг байдаг.

Үндсэн хуулийн болон бусад хууль зүйн хүрээ

Аюулаас хамгаалах салбарт хяналт тавих парламентын эрхийг үндсэн хууль болон нэмэлт хуулиудад тодорхой тусгаж өгөхийн зэрэгцээ парламент нь засгийн газраас мэдээлэл тогтмол авч байх хуулийн заалт гаргах ёстой бөгөөд засгийн газраас мэдээлэл авах эрх мэдлээ хуулийн дагуу эдлэх ёстой. Аюулаас хамгаалах салбарын төсвийн хүрээнд тавих парламентын хяналтыг парламентын улс төрийн онцлогт шингээсэн байх ёстой. Үүнд нэлээд зүтгэл, хүчин чармайлт шаардагдана.

Мөнгөний ханш

Төсвийн үйл ажиллагаанд үндсэн хоёр төрлийн мөнгөний ханш байх ёстой.

- ✓ нөлөөлөх байдал: бодлогын зорилгыг ухамсарлах /зөв юм хийж байгаа юу/.
- ✓ үр дүнтэй байх: боломжтой эх үүсвэрийг ашиглан бодлогын зорилгоо ухамсарлах /эдийн засгийн хувьд зөв юм хийж байгаа юу/.

Тодруулга №54

Төлөвлөх ба хөтөлбөр, төсөв боловсруулах систем /ТХТБС/

Төлөвлөх ба хөтөлбөр, төсөв боловсруулах систем /ТХТБС/-ийг 1960-аад оны эхэн үеэр батлан хамгаалахын төсвийн хөгжилд /одоо ихэнх оронд хэрэглэж буй/ анх АНУ ашиглажээ. Нийтлэг ТХТБС-ийн эргэлт нь зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүн, үүргийг тодорхойлохын тулд үндэсний ашиг сонирхол, заналхийллийг судалдаг шиг аюулгүй байдлын орчин дахь төлөвлөгөөний эхний үе шатаас бүрдэнэ. Эдгээр хойшлуулшгүй чухал хүчин зүйлийг авч үзэн хөтөлбөрөө боловсруулдаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэгэн хэлбэр болох хөтөлбөрт тодорхой зорилгыг тусгаж өгдөг. Хөтөлбөр нь санхүүгийн эх үүсвэрээр тодорхойлогдох зорилготой холбоотой ажилладаг эргэлтийн чухал сүлжээ юм. Ийм аргаар

ТХТБС хэрэгцээний дагуу эх үүсвэрийг хуваарилж ажиллах бөгөөд өгөгдсөн төсвийн шаардлагын дагуу төлөвлөгөө, хөтөлбөрөө боловсруулдаг. Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай чухал хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөр боловсруулах нь чухал юм. Өгөгдсөн зорилгыг биелүүлээгүй үед үр дүнг дүгнэхдээ эхний ээлжинд онц шаардлагатай зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Эргэлтийг тооцоолоход жилийн эцэст зорилгоо яам болон нийгэм хэрхэн тодорхойлж чадсанаар хэмжүүрийг гүйцэтгэх явдал юм. Ингэж нөөцийг хуваарилах үр дүнтэй арга замд хөтлөгдөх болно.

Эх сурвалж: Kate Starkey, Andri van Meulen. Батлан хамгаалахын төсвийн ил тод байдал. Интернэтээс авав. Мэдээлэл ба Аюулгүй байдал номны V Хэсэг, IV Бүлэг. 2000 он. Батлан хамгаалах нь инженерийн шинжлэх ухаан.

Орчин үеийн төсвийн онолоор батлан хамгаалахын төсөвт мөнгөний ханшийг анхааралдаа авч байгаа эсэхийг шалгахын тулд хөтөлбөр, зорилготойгоо зарцуулалт нь холбоотой байх ёстой. /Тодруулга №54-г үзнэ үү/. Мөн зарлага холбогдох салбарын бодлого, зорилттой холбоотой байна /энхийг сахиулах, боловсрол зэрэг/. Мөн бүх зарлагыг бүгдийг нь багцалж ангилж ёстой. Цаашилбал, парламент мөнгөний ханшийн төвшинг хяналт шалгалтын/дараагийн бүлгээс үзнэ үү/ тусламжтайгаар хянаж чаддаг байх. Энэ нь засгийн газар зарлагдах төсөв бус орлогодох төсвийг парламентад илтгэхийг хэлж байгаа юм. ТХТБС мэтийн төсвийн зүй зохистой тогтолцоо нь аюулгүй байдлын салбарууд төлөвлөгөөгөө нууц байдлаас ил тод болгож чадвал зөвхөн боломжтой юм.

Төсвийн дэг журам

Засгийн газар нь парламентаас баталсан хууль зүйн хүрээний дүрэм журам, төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд төсвийн дэг журам чухал болохыг онцлон хэлэх нь зүйтэй юм. Парламент төсвийн дэг журамтай холбоотой дараахь элементүүдийг авч үзнэ. Үүнд:

- ✓ Батлан хамгаалахын төсөв/зарлагын тооцоололт/, үнийн төвшингийн хөгжилтэй холбоотой харилцаа;
- ✓ Төсвийн зарцуулалттай холбоотой дээд доод хязгаарыг тогтоож хяналтын хэмжүүрийг хэрэглэх;
- ✓ Дутуу болон илүү зарцуулалтаас урьдчилан хамгаалахын тулд төсвийн хэрэгжүүлэлтэнд хэм хэмжээг баримтлах;

- ✓ Батлан хамгаалахын төсвийг илүү болон дутуу зарцуулсан тохиолдолд санхүү, эдийн засгийн сайд Засгийн газарт мэдэгдэх ёстой;
- ✓ Батлан хамгаалахын төсвийн илүү зарцуулалтыг тэнцэтгэх дүрэм: батлан хамгаалахын төсвийн хүрээнд илүү зарцуулалтыг тэнцэтгэх буюу засгийн газрын бусад төсвөөс тэнцэтгэх.

Хугацаа ба үе шатлал

Аюулаас хамгаалах салбарт төсвийн үр дүнтэй зөв аргыг хэрэглэхийн тулд санал хураалтаас өмнө батлан хамгаалахын төсвийн саналыг сайтар хянаж үзэхэд хангалттай хугацаа өгөх нь чухал юм. Хамгийн бага нь 45 хоногоос 3 сар хүртэлх хугацаа өгөхөд хангалттай бөгөөд энэ хугацаанд парламент батлан хамгаалахын нэгдсэн төсвийг хянаж чадах юм.

Дараахь хэд хэдэн шалтгааны улмаас батлан хамгаалах төсвийн бодлогын тухай тодорхой заалт, цаг хугацааны дэлгэрэнгүй мэдээлэл чухал байдаг. Үүнд:

- ✓ Энэхүү мэдээлэл нь олон нийтийн хэлэлцүүлэг явуулахад тэдний мэдлэгт хэрэгцээтэй байна;
- ✓ Аюулгүй байдал болон засгийн газрын бусад зарлагын хооронд өөрчлөлт, шинэчлэлт, тэнцвэржүүлэлт хийх хэрэгцээ, сул дорой байдлын тодорхойлолтыг хөнгөвчилнө;
- ✓ Аюулаас хамгаалах салбарт төсвийн ил тод удирдлага хийх нь олон нийт болон парламентын хариуцлагыг нэмэгдүүлж, засгийн газарт итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ.

Иргэний нийгэм ба харилцаа холбоо

Парламент санхүүгийн шалгалт болон хяналт хийлгэхээр иргэний нийгмээс төсөв, санхүүгийн төлөвлөлтийн шинжээчийг авдаг. Энэ нь байнга хүндрэл учруулж байдаг аюулгүй байдлын төсөвтэй холбоотой төсвийг хянахад ашиг тустай байж болох талтай юм. Төсөв боловсруулах үйл ажиллагааны ил тод байдал мэдээллийн хуулийн эрх чөлөөнд тулгуурлан явагдах ёстой.

Сургалт ба туршлага

Эцэст нь хэлэхэд парламент гишүүд болон парламентын тамгын газрын ажилчдаа сургах, тэднийг судалгаа хийх боломжоор хангаж чадварыг нь дээшлүүлэх хэрэгцээтэй байдаг. Ардчилсан засаглал, парламентын үр дүнтэй аргыг хэрэгжүүлэхийн тулд Олон Улсын Парламентын Холбооноос парламентын гишүүд болон аппаратын ажилчдад зориулсан бүсийн болон дэд бүсийн хэмжээнд семинар зохион байгуулахын /www.ipu.org хаягаар орж үзнэ үү/ зэрэгцээ гарын авлагууд бэлтгэн гаргаж байна.

Тодруулга №55

Батлан хамгаалахын төсвийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг:

Испанийн батлан хамгаалахын 2002 оны төсөв

Бараа ба үйлчилгээ

- Хоол
- Дэд бүтцийн байгууламж
- Бензин
- Үйлчилгээ: ус, цахилгаан, утас гэх мэт
- Хувцаслалт
- Тэтгэмж
- Унаа, тээвэр
- Сургалт
- Эмнэлгийн тусламж
- Бусад үйл ажиллагааны зардал
- Санхүүгийн бусад зардал
- Одоогийн шилжүүлэг
 - Олон улсын байгууллагууд
 - Автономит бие
 - Бусад шилжүүлэг
- Үндсэн хөрөнгө оруулалт
 - Зэвсэгт хүчний өөрчлөлт, шинэчлэлт
 - Буу зэвсэг, материалын хангамж
 - Судалгаа ба дэвшил хөгжил
 - Бусад хөрөнгө оруулалт
- Хөрөнгийн шилжүүлэг
- Санхүүгийн шилжүүлэг

*Эх сурвалж: Испаний батлан хамгаалах яам, Испаний Батлан
Хамгаалахын 2002 оны төсөв*

Аюулаас хамгаалах салбарын төсөв боловсруулах ил тод байдал, хариуцлага

Аюулгүй байдлын эсрэг ил тод байдал

Шийдвэр гаргахдаа ил тод байх нь гаргасан шийдвэр олон нийтийн хүсэл, бодлогын зорилготой нийцэж байх замаар хийх нь маш чухал юм. Батлан хамгаалахын төсөв боловсруулах ил тод байдал нь парламент үр ашигтай арга замаар хяналт хийхэд тустай байдаг. Энэ нь аюулаас хамгаалах салбарт нийгмийн итгэлийг бэхжүүлдэг. Батлан хамгаалахын төсөв боловсруулахдаа ил тод бус байгаа нь заримдаа төсөв зохиох хэлбэр буюу аюулгүй байдлын зорилгыг муу тодорхойлсонтой холбоотой илэрдэг. Мөн үндэсний хууль зүйн хяналтын байгуулагуудад олон талт дэг журмын туршлага дутагдалтай, олон нийтийн мэдээллийн тухай заалт үндсэн хуульд дутуу заагдсан, ил тод байдлаас илүү нууцлаг байдлыг сонгох биократ үзэл суртал байгаа зэрэгтэй холбоотой юм. Хууль зүйн хяналтын удирдлага болон хууль санаачлагчид эдгээр тогтолцооны дутагдалтай талуудыг тодорхойлох шаардлагатай юм. /дараагийн бүлгээс үзнэ үү/.

Тодруулга №56

Аюулгүй байдлын төсөв боловсруулахад ил тод байх гол бэрхшээлүүд

“Удирдах төвшингөөс цөөн тооны хэдэн хүнийг томилж, аюулгүй байдлын бодлого, нөөцийн талаар шийдвэр гаргуулахад төсөв боловсруулах асуудал дээр ил тод байдал, хариуцлагын дутагдалтай талууд ажиглагддаг. Санхүү эдийн засгийн яамны тодорхой ажилтнууд болон гүйцэтгэх албан тушаалтнууд шийдвэр гаргадаггүй бөгөөд тэдний гаргасан шийдвэрийг гэж үздэг. Улсын үндсэн хуульд хяналт тавьж болох эрх бүхий парламентын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм нь тогтсон журмаар ар талд ажилладаг”.

Аюулаас хамгаалах салбар тус бүрийн ажилтнууд, үйл ажиллагаа, тоног төхөөрөмжтэй холбоотой бүх зардлуудыг төсөвт тусгах, уг төсвийн зарцуулалтыг хэрхэн санхүүжүүлэх тухай заасан байх ёстой. Аюулгүй байдлын ихэнх төсвүүдийн дотоод хуваарилалт, нийт зарцуулалт тодорхой бус байдаг. Үйл ажиллагааны томоохон төсөвтэй орнуудын засгийн газар нарийн нягт мэдээллийг

хангалтгүй авсан байдаг учраас төлөвлөгөө, гүйцэтгэлтэй харьцуулахад хариуцлага сул байдаг. Батлан хамгаалах яам болон бусад гүйцэтгэх салбарын ажилтнууд батлан хамгаалахын бодлого, төсөв боловсруулах, хангамжийн тухай зохих шийдвэр гаргах талаар тодорхой мэдлэгтэй байх шаардлагатай. Төсөвтэй холбогдох асуудлыг авч үзвэл заримдаа цэрэг, иргэний харилцаанд урт хугацааны үндсэн өөрчлөлт оруулахыг шаардсан улс төржсөн хэлбэртэй байна.

Эх сурвалж: Хүний хөгжлийн илтгэлээс, 2002 он. Хуудас 89-91

Хянаж болохуйц ба хянаж үл болохуйц батлан хамгаалах, аюулгүй байдалтай холбоотой зардлууд

Аюулаас хамгаалах салбарыг хянаж энэ салбарт мөнгө зарцуулах, эсвэл засгийн газрын өөр салбарт зарцуулах хэрэгтэй болохыг шалгаж тогтоох юм бол парламентыг санхүүгийн бололцоогоор хангах төсөвтэй холбогдох баримт бичгийг шалгаж үзэх нь зүйтэй. Парламентад зөвхөн мөнгөний дүнг өгөх нь зөв төсөв боловсруулах зарчмын нэг болох онцгой зарчмыг зөрчиж байгаа явдал юм. /Дээр өгүүлснээс харна уу/ Онцгой чухал мэдээллийг парламентад өгөөгүй тохиолдолд парламент батлан хамгаалахын төсвийг хянаж шалгах үндсэн хуулийн эрх үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх юм.

Парламент батлан хамгаалахын төсөвтэй холбогдолтой бүх баримт бичгийг хянаж үзэх ёстой. Дани, Люксембург зэрэг зарим оронд парламент төсвийн хамгийн нарийвчлалтай мэдээллээр хангагдсан байдаг. Гэхдээ Франц, Грек, Польш зэрэг орнуудын парламентын батлан хамгаалах асуудлын хороо л зөвхөн батлан хамгаалахын төсвийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авсан байдаг. Сайн засаглалын үзэл бодлын үүднээс авч үзвэл парламентын хороо буюу парламент төсвийн бүх баримт бичгийг хянах ёстой. Үүнтэй нэгэн адил зарчим бусад салбар буюу онцлон хэлбэл тагнуулын албанд ч мөн хамаарах ёстой.

Аюулгүй байдлын албаны төсвийн ангилал нь ялангуяа мэдээллийн эрх чөлөөний хуультай /тодруулга №57-г үзнэ үү/ нийцэж байх ёстой.

Аюулгүй байдлын төсвийн саналыг авч хэлэлцэн, санал хураалт явуулах үед өөрчлөлт оруулах засгийн газрын эрх албадан зарцуулалт /урьд жилүүдэд гарын үсэг зурсан

хангамжийн гэрээ/ болон эрхийн хөтөлбөрүүдээр /цэргийн хүмүүст зориулсан эмнэлгийн тусламж ба тэтгэвэр/ хязгаарлагддаг. Эдгээр зардлууд зөвхөн урт хугацаатайгаар л өөрчлөгдөж болно.

Тодруулга №57

Аюулгүй байдлын төсөв дахь ангиллын гурван төвшин

Парламентын гишүүд батлан хамгаалахын хуваарилалттай холбоотой онцгой нөхцөл байдлын мэдээллийн нууцлаг байдал ба хариуцлагын хооронд тэнцвэржүүлэлтийг бий болгох шаардлагатай. Төсвийн саналыг дараахь байдлаар ангиллын өөр өөр төвшинд хувааж үзэх нь нэгэн арга билээ. Парламентад өргөн барих батлан хамгаалахын ерөнхий төсөв: батлан хамгаалах асуудлын дэд хорооноос хянаж байх хөрөнгө болон үйл ажиллагааны зардлууд, цэргийн зардлууд; хяналтын хорооны гишүүдийн төлөөллийн хэсгээс хянаж байх цэргийн ангиллын дээд төвшинтэй холбоотой зардлууд. Энэхүү хороо нь ангилагдсан баримт бичгүүдэд үндэсний нууцын тогтоолд зааж тогтоосон дэг журмын дагуу хяналт тавих ёстой.

Эх сурвалж: Ravinder Pal Singh. Зэвсгээр хангах асуудлыг шийдвэрлэх тухай үйл ажиллагаа. 1998 он. I хэсэг, Оксфорд.

Улсын санг зүй бусаар удирдах, гажуудах явдлын эсрэг ил тод байдал

Засгийн газар улсын санг зөв удирдаж байгаа эсэхийг хянах гол үүргийг парламент гүйцэтгэдэг. Зүй бус удирдлага ялангуяа техникийн нэгдсэн асуудал, стратегийн аюулгүй байдлын хэрэгцээ зэрэг чухал шинж чанаруудыг тусгасан аюулаас хамгаалах салбарт хуваарилсан төсөвтэй холбоотойгоор гарч байдаг.

Батлан хамгаалахын төсөв боловсруулахад ил тод байдал, хариуцлагыг баримтлах аюулаас хамгаалах салбарт тавигдах аливаа үр ашигтай парламентын хяналтанд байвал зохистой юм. Ил тод байдал бол сайн засаглалын үндэс болох хариуцлагын өмнөх нөхцөл байдал юм. Иймээс эдгээр хоёр үзэл баримтлал нь бүх төсвийн эргэлтийн гол цөм нь юм.

“Батлан хамгаалахын төсөв боловсруулах үйл ажиллагаанд гол төлөв ил тод байдал,

*хариуцлага дут агдалт ай бол т ухайн улсын
зэвсэгт хүчний хэмжээ, чадвар, хүчний т ухай
мэдээллээр хангах ёст ой байдгийн нэгэн
адил илүү ил тод байдал цэргийн
зарцуулалт анд анхаарлаа хандуулж,
зөрчилдөөнийг бий болгох үл ойлголцол,
т одорхой бус байдал гарахыг багасгах
болно.”*

*Paul George, “1990-ээд оны бат лан
хамгаалахын зардлууд: Хөгжиж буй орнуудын
т өсөв ба санхүүгийн бодлогын асуудлууд”
2002 он.*

Цэргийн салбарын илүү зардлыг голдуу ядуурлын хуваарилалт, нийгмийн хөгжил зэрэг чухал хэсэгт зориулдаг болох нь ажиглагддаг. Нийгмийн аюулгүй байдал нь улсын татварын оролцооны бүрдлээр явагддаг учир хэрхэн яаж зохион байгуулах төлөвлөгөө гаргадаг тухай мэдээллийг иргэдийн төлөөллүүдэд өгдөг. Хөгжиж буй орнуудад улсын татварын орлогыг буруу ашиглах явдал байдаг нь онцгой хохирол учруулдаг. Сайн засаглалын зорилгын үүднээс засгийн газар аюулаас хамгаалах салбартай холбоотой асуудлаар нийтийн санаа бодлыг авч байх нь зүйтэй юм. Парламентаас батлан хамгаалахын төсвийн тэнцвэрийн хөгжил, аюулгүй байдлын хэрэгцээг хангаж байх ёстой. Дараахь тодруулгад үзүүлснээр батлан хамгаалахын төсөвт парламентаас үр ашигтай хяналт тавихад бэрхшээлтэй хэд хэдэн асуудлууд бий.

Тодруулга №58

Аюулгүй байдлын төсөвт үр ашигтай хяналт тавихад гарч болзошгүй асуудлууд

- ▷ **Үндсэн хуулийн дутагдалтай тал** – Аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагааг хянах талаар парламентын гишүүдэд бүрэн эрх олгоход үндсэн хуулийн тодорхой хүрээний дутагдалтай талууд ажиглагддаг хүндрэлүүд бий.
- ▷ **Мэдээллийн хомсдол** - Үндсэн хуулийн дутагдалтай тал гэдэг нь мэдээллийг нээлттэй байлгах мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн дутагдалтай тал юм. Иймд хуулийн хүрээний дутагдалтай тал болон тодорхойгүй байдал хяналт тавих парламентын явцад саад учруулдаг. Үүний үр дүнд улс

болон парламент ардчилсан эрүүл системийн хүрээнд олгогдох хариуцлагаас ухардаг.

- ▷ **Аюулгүй байдлын төсвийн зарцуулалт ба орлогын эх үүсвэр** - Онцгой үйл ажиллагаанд /ялангуяа цэргийн байгууллагуудын үйл ажиллагаанаас орж ирэх ашиг зэрэг худалдааны шинж чанартай үйл ажиллагаа/ зориулагдах аюулгүй байдлын төсвийн зарцуулалт орлогын эх үүсвэрийн жинхэнэ шинж чанар, ашгийн тухай асуудлыг парламент буюу яамны албан хаагчид хүртэл байнга мэдэх албагүй. Эдгээр үйл ажиллагааг аюулгүй байдлыг санхүүжүүлэх арга замын нэг гэж парламентад мэдээлэх ёстой.
- ▷ **Батлан хамгаалахын зардлыг нуун дарагдуулах тухай** - Тэтгэвэр, дэд бүтэц, тээвэр зэрэг салбарт зориулах батлан хамгаалахын зарцуулалт зарим тохиолдолд бусад яамдуудын /нийгмийн халамж, байр, төмөр зам зэрэг салбарууд/ төсөв рүү шилжүүлэгддэг. Энэ нь батлан хамгаалахын төсвийн хүрээнд илэрхийлэгдэхгүй бөгөөд жинхэнэ батлан хамгаалахын зардал биш бөгөөд бодит байдлыг гажуудуулахад хүргэдэг явдал юм.
- ▷ **Хэвлэл мэдээлэл сул дорой байх тухай** - Зарим оронд парламент болон аюулаас хамгаалах салбарын үйл ажиллагааг цаг ямагт мөшгин дагаж байх ёстой хэвлэл мэдээллийн аппарат сул дорой ажиллах явдал гардаг. /туршлага багатай, эх үүсвэр муутай/ Энэ нь аюулгүй байдлын болон тэдний төлөөллүүдийн үйл ажиллагааны тухай нийт ард түмэн, тухайн цаг үеийн мэдээллийг гажуудуулахад хүргэдэг явдал үүсгэдэг.
- ▷ **Зөв хяналт тавихад бага цаг хугацаа өгөх** - Өмнө нь дурдаж байсан шиг батлан хамгаалахын төсвийн хяналт хийхэд бага цаг хугацаа өгөх нь үр ашигтай парламентын хяналт тавихад хүндрэл үүсгэдэг.
- ▷ **Дэд бүтэц, туршлага, бүрэлдэхүүний дутагдалтай тал** - Дэд бүтэц, туршлага, бүрэлдэхүүнээр хомс орны парламент нь бүх шаардлагыг биелүүлэхэд дээд албан тушаалтан нь ард түмний өмнө хариуцлага хүлээхийг шаарддаг.

Ардчиллыг сэргээж буй орнуудын төсвийн хяналт

1990-ээд оноос Европыг донсолгосон ардчиллын давалгаанаас хөгжлийн чиг хандлага, парламентын хяналтын үйл ажиллагаа нь ялангуяа ардчиллыг сэргээж буй орнуудтай холбоотой гэдгийг нотлон харуулсан юм. Тодруулга №59-д дурдсан Зүүн Өмнөд Европын орнуудын төсвийн үйл ажиллагааг нягтлан үзвээс эдгээр улсуудад улс

төрийн тогтолцоог илүү ил тод, хариуцлагатай цар хүрээнд холбосон байдаг.

Тодруулга №59

Зүүн Өмнөд Европын зарим орнуудын батлан хамгаалахын төсвийн тухай /2001 оны байдлаар/

Албани: 2000 оны 10 дугаар сард Төсвийн удирдлагын газрыг байгуулсан. Батлан хамгаалахын бодлогын баримт бичигт 2008 он хүртэлх батлан хамгаалахын ерөнхий хэрэгцээг хэвлэн нийтэлсэн. Батлан хамгаалах яам нь төсвийн үйл ажиллагаагаа хариуцаж ажилладаг.

Болгар: Батлан хамгаалахын төсвийг сүүлийн арван жилийн турш Үндэсний Ассамблей /Болгарын парламент/ шийдэж байна. Уг Ассамблей аюулаас хамгаалах салбар дахь парламентын хяналтын чадавхаа байнга дээшлүүлнэ гэсэн ерөнхий хандлагатай ажилладаг.

Хорват: Төсвийг засгийн газар санаачлан парламентаар батлуулах бөгөөд дараа нь албан ёсны хэвлэлд нийтлэн гаргадаг. Төсөв боловсруулах үйл ажиллагаа санхүүгийн яамнаас батлан хамгаалахын яамаар дамжин 7 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд явагдана. Парламент зөвхөн батлан хамгаалахын нийт төсвийн хэмжээг шийдвэрлэх бөгөөд бүтцийн эрх мэдлийн асуудал парламентад хамааралгүй байдаг.

Македони: Батлан хамгаалахын яам санал боловсруулж санхүүгийн яам руу явуулна. Энэ шатанд улсын чадвартай дүйцүүлэхээр бусад яамдуудтай харилцан яриа хийнэ. Дараа нь төсвөө засгийн газарт барина. Засгийн газар өөрчлөлт оруулахаар бол өөрчлөлт хийсний дараа төсвийг парламентад хүргүүлнэ. Батлан хамгаалахын сайд цагдаа ба батлан хамгаалах хороонд төсвийн саналыг тавина. Санал хураасны дараа төсвийг ерөнхийлөгчийн зарлигаар батална. Батлан хамгаалахын төсөв нь ДНБ-ий 2.12 хувийг эзэлдэг.

Румын: 2000 оны 1 дүгээр сараас эхлэн батлан хамгаалах яам Төлөвлөлт, Хөтөлбөр, Төсөв, Үнэлгээний Системийг /ТХТҮС/ хэрэгжүүлж эхэлсэн. Үүний гол зорилго нь батлан хамгаалахын салбарын бүх үйл ажиллагаатай холбоотой ил тод байдлыг дээшлүүлэх явдал юм. Төсөв боловсруулах үйл ажиллагаанд хамааралтай хэд хэдэн хороо парламентад бий. Үүнд: батлан хамгаалах, нийтийн дэг журам, үндэсний аюулгүй байдал, санхүү ба банк. Батлан хамгаалах яам холбогдох парламентын, хуулийн,

олон нийттэй харьцах харилцааны хэлтэстэй байдаг. Батлан хамгаалахын төлөвлөгөөний гол баримт бичгийг интернэтийн сүлжээнд тавьсан байдаг.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Төсвийн эргэлтэн дэх аюулаас хамгаалах салбар

- ▷ энгийн төсвийн эргэлтийн гол дөрвөн үе шат болох төсвийн бэлтгэл, төсвийг батлах, гүйцэтгэл, зарлагын хяналт бүхий аюулаас хамгаалах салбарт парламент анхаарлаа хандуулж байгаа эсэхийг анхаар;
- ▷ Хууль ёсны хяналтын байгууллагуудын хяналтыг батлах;
- ▷ Парламент болон бусад хяналт шалгалтын байгууллагуудын хяналт нь төсвийн хэрэгцээ, зарлагын /гүйцэтгэх хяналт/ бодлогын зорилготой холбоотой байх ёстой.

Аюулгүй байдлын төсвийг ил тод болгох парламентын үр ашигтай үйл ажиллагаа

- ▷ Энэ бүлэгт дурдсан үр ашигтай төсөв боловсруулах зарчимтай холбоотой төсөв боловсруулахыг шаардах;
- ▷ Аюулгүй байдлын төсвийн санал нь зөв, ач холбогдолтой, ил тод хэлбэрээр боловсруулагдан хүргэгдэж байгаа эсэхэд хяналт тавихад парламентад туслах зорилготой тусгай шинжээчдийн туслалцааг авахыг хичээх;
- ▷ Аюулгүй байдлын алба парламент, батлан хамгаалахын зардлыг хүчин төгөлдөр үнэлж, санхүүгийн орлого, гүйцэтгэлийн зарлага хоорондын харилцааг ойлгохуйц санхүүгийн төлөвлөлт, төсвийн орчин цагийн арга барилыг хэрэглэж байгаа эсэхийг шалгах;
- ▷ Тодруулга №58-д жагсаасан үзүүлэлтүүдийг ашиглан парламент дахь нөхцөл байдал тодорхойлж, аливаа сүл дорой байдлыг арилгах улс төрийн хүчин зүйлс хир зэрэг боломжтой болохыг судлан үзэх.

24 дүгээр бүлэг

Аюулгүй байдалтай холбоотой улсын төсвийн зардлыг хянах нь

Парламент ба Үндэсний аудитын газар

Аюулгүй байдлын төсөвт парламентаас тавих үүрэг нь баталсан үүргээсээ ялгаатай байдаг. Парламент аудит болон хяналт шалгалтын үүргээ хэрэгжүүлэх ёстой. Тэгэхдээ парламентад хүргэгдэж буй бүхэл бүтэн хяналтын тооцоонууд ардчилсан үйл ажиллагааны нэгээхэн хэсэг бөгөөд хяналтын үйл явц хяналтын тоо, хяналтын гүйцэтгэлийг хамрах ёстой гэдгийг ухамсарласан байх хэрэгтэй. Аюулгүй байдлын албаны тооцоо болон жилийн тайлан нь өмнөх төсвийн жилд мөнгө хэрхэн зарцуулагдсаныг парламент шалгаж болох чухал эх сурвалж юм.

Хяналтын үүргийнхээ хүрээнд парламент үндсэн хуулийн дагуу байгуулагдсан дээд албан тушаалтан, хууль эрх зүйн салбараас тусдаа ажиллах байгууллага болох үндэсний хяналт шалгалтын газрын /заримдаа Ерөнхий хянан шалгагч, Үндэсний Аудитын газар, Төсвийн газар буюу Тооцооны танхим зэрэг нэртэй байж болно/ туслалцааг авч байх ёстой.

Ерөнхий аудит нь

- ✓ парламентаас сонгогдож, тодорхой хугацаатай ажиллана;
- ✓ өөрийн үүргээ хараат бус байдлаар гүйцэтгэх хуулийн туршлагатай мөн эх сурвалжтай байна;
- ✓ парламентад тайлан тавих тусгай эрх мэдэлтэй байх бөгөөд ямар ч үед зарцуулалтын аливаа хэргийн талаар ажилладаг өөрийн төсвийн хороотой байна.

Эрх мэдлийг хуулиар зааж өгөх ба албан хаагч ба улс төрч улсын санг буруу удирдах ба гажуудуулсан асуудлыг

парламентаар авч хэлэлцэх ба буруу үйл ажиллагаа явуулж гажуудуулсан бол хэрхэн засч залруулах вэ гэдгийг парламент шийдэх ёстой.

Тодруулга №60

Ерөнхий Аудит

Дээд албан тушаалтан, хууль, шүүхийн байгууллагын хараат байсан ч гэсэн аудитын газар бүрэн биеэ даасан, жинхэнэ автономит байх нь чухал юм. Мөн үүргээ биелүүлэх хангалттай орчин бүрдсэн байх ёстой. Ерөнхий аудитч гурван үүрэгтэй байна. Үүнд:

Санхүүгийн хяналт шалгалт

Хяналт шалгалтын газар нь эрх барих болон улсын бүх байгууллагуудын санхүүгийн ажиллагааны эмх цэгцтэй, үнэн зөв байдал болон бүрэн гүйцэд эсэхийг шалгаж, санхүүгийн бүх үйл ажиллагаа улсын сангийн дүрмийн дагуу явагдаж байна уу гэдгийг шалгана. Энэхүү хяналт тавих үүргийн хүрээнд Хяналт шалгалтын газар төлбөр тооцоог хариуцаж буй улсын байгууллагын нягтлан бодогч, албан хаагчдыг шүүх үүргээ гүйцэтгэх ёстой. Тэд хариуцлагаасаа чөлөөлөгдөх буюу уг албан тушаалаасаа татгалзсан тохиолдолд тэдний хариуцаж байсан мөнгийг мөн шалгана. Аливаа зүй бус хэрэглээ буюу гажуудуулах явдал гарсан тохиолдолд Хяналт шалгалтын газар илрүүлсэн тайлангаа шүүхийн байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

Хууль зүйн хяналт шалгалт

Улсын бүх орлого, зарлага нь төсөв зохицуулах хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг Хяналт шалгалтын газар шалгана.

Улсын санг зөв ашиглах нөхцлөөр хангах

Сайн засаглалын ашиг сонирхлын үүднээс үүргээ биелүүлж буй орчин үеийн хяналт шалгалтын газар нь дараахь гурван гол үндэслэлээр улсын санг зөв ашиглах нөхцлийг хангах ёстой. Үүнд:

- 1/ Мөнгөний ханш: нөөцийг ашиглахдаа чанар болон тооны хувьд зөв хэрэглээгээр хангах;
- 2/ Зорилго болон зорилтоо биелүүлэх үр ашигтай арга хэрэглэх;
- 3/ Үр дүнг үзэхийн тулд нөөцийг зөв ашиглах талаар нөлөө бүхий арга хэрэглэх.

Хяналт шалгалтыг хяналт шалгалтын газрын санаачлага буюу парламентаас хүсэлт гаргасны дагуу дахин явуулна.

Эх сурвалж: Парламент болон төсвийн үйл ажиллагаа, хүйсийн үзэл бодол сэдэвт Олон улсын ПХХ-ны ерөнхий т айлан. 2001 оны 10 дугаар сар. Мали, Бамако.

Батлан хамгаалах салбарын төсвийн хяналт

Батлан хамгаалах салбарын төсвийг хянаж шалгах нь парламентын хувьд үнэхээр хүндрэлтэй асуудал юм. Үүнд аюулгүй байдалтай шууд холбоотой үйл ажиллагаа болон шууд бус холбоотой худалдаа, үйлдвэр, харилцаа холбоо, мөнгөний шилжүүлэг зэрэгтэй холбоотой хяналтын тайлангийн дүн шинжилгээ багтдаг. Хамгийн гол бэрхшээлтэй асуудал бол хоорондоо харилцан холбоогүй үйл ажиллагаануудын дунд холбоос үүсгэх явдал юм.

Ялангуяа аюулгүй байдал, батлан хамгаалах, дотоод хэрэг, худалдаа, аж үйлдвэр, мөн харилцаа холбоо, санхүүгийн яамдууд парламентаас тэдэнд хуваарилсан мөнгийг хэрхэн зарцуулсан болохыг бүхэл бүтэн баримт бичиг бүхий тайлангаар парламентад тогтмол тавьж байх ёстой. Парламентад өргөн барихдаа хороодын жилийн тайлан, парламентын хороодоос шалгасан шалгалтын дүн, яам бүрийн хяналтанд орсон жилийн тооцоо, парламентын хороод бүрээр хянагдсан тусгай хэлэлцүүлэг зэргийг агуулсан байна.

Хяналт шалгалтын үйл явц төсвийн эргэлт хуулийн хүрээнд явагдаж, үр дүнтэй зарлагдаж, тодорхойлсон зорилгод нь нөлөөлсөн зэрэгт парламент үнэлгээ өгөхөд тусална.

Тодруулга №61

Аюулаас хамгаалах салбарт тавьж буй парламентын хяналт дахь Их Британий Үндэсний хяналт шалгалтын газрын үүрэг

Их Британий Үндэсний хяналт шалгалтын газар /ҮХШГ/ нь 1983 онд бие даасан байгууллага болон байгуулагдсан бөгөөд Хянан шалгагч ба ерөнхий аудит удирддаг. Энэ байгууллага засгийн газрын хөрөнгийн зарцуулалтын талаар парламентад тайлан тавьдаг. ҮХШГ нь санхүүгийн шалгалт хийж мөнгөний үнийн талаар тайлан тавьдаг.

▷ **Санхүүгийн шалгалт**

Хуульд зааснаар хянан шалгагч, ерөнхий аудит, ҮХШГ засгийн газрын харъяа байгууллага, агентлагуудын тооцоонд хяналт шалгалт хийж үр дүнг нь парламентад тайлагнах үүрэгтэй. Бусад аудитын нэгэн адил хянан шалгагч ба ерөнхий аудит нь материалын талаар худал мэдүүлгээс чөлөөлөгддөг ч тооцооны талаарх үзэл бодлоо илэрхийлэхийг шаарддаг. Мөн тооцооны шилжүүлэгт парламентын зохих эрх мэдэл байгааг батлах шаардлагатай. ҮХШГ материалын талаар худал мэдүүлэг байгааг тодорхойлж гаргасан тохиолдолд хянан шалгагч ба ерөнхий аудит үзэл санаагаа тусгайлан илэрхийлж болно. Тооцоонд аливаа материалын талаар алдаа буюу зүй бус байдал байхгүй бол хянан шалгагч ба ерөнхий аудит бусад тодорхой зүйлийн талаарх тайланг парламентад бэлтгэн өгч болно. Ийм тайланг ерөнхий танхим дахь Улсын тооцооны хороо авч хэлэлцэх болно.

▷ **Мөнгөний ханшийн хяналт**

Хянан шалгагч ба ерөнхий аудит мөнгөний ханшийн тухай засгийн газрын байгууллага, бусад газруудын эх сурвалжаас авсан 50 гаруй тайланг жил бүр парламентад тайлагнадаг байна. ҮХШГ эдийн засаг болон улсын үр ашигтай, нөлөө бүхий зарцуулалтыг шалгаж тайлагнадаг. Тайлангууд нь гүйцэтгэл сул буюу илүү чанартай байгаа талаар мэдээлэхийн зэрэгцээ үр ашигтай өөрчлөлт хийж болохуйц зөвөлгөө өгөхөд чиглэгддэг. Сүүлийн гурван жилд өгөгдсөн бүх зөвөлгөөний ачаар 1.4 тэрбум паундыг засгийн газар хэмнэж чадсан гэж ҮХШГ үзэж байна. Батлан хамгаалахын мөнгөний үнийн тайланд сүүлийн үед нисдэг тэрэгний байршил, байлдааны тодорхойлолт, газрын зэвсгийг засах янзлах, нөөцийн бууруулалт, яамны төв байрыг дахин засварлах зэрэг зүйлс тусгагддаг байна. Мөн хамгийн томоохон 30 төслийн үйл явцын талаар тайлагнадаг.

▷ **Парламенттай харьцах харилцаа ба хариуцлагын тогтолцоо**

Үндэсний аудитын алба нь парламент тэр дундаа парламентын улсын тооцооны хороотой холбогдох харилцаа нь парламентын тус албаны ажлын гол хэсэг болдог. Хуульд заагдсны дагуу Хянан шалгагч ба ерөнхий аудит нь ерөнхий танхимын ажилтан байх ба түүний бүх ажил парламентад хүргэгдэх замаар хариуцлагын тогтолцоо бий болно. Улсын хөрөнгийг засгийн газрын төв байгууллага зарцуулж байгаа болохоор Хянан шалгагч ба ерөнхий аудит мөнгөний үнэ, тогтмол байдал, ёс журмын талаар парламентад мэдээлэх эрхтэй байна. Улсын тооцооны Хороо тухайн байгууллагын ахлах ажилтны тайланд дурдсан баримт мэдээллээс нотолгоо авсны дараа засгийн газраас өгөх ёстой хариу зөвөлгөө өгдөг байна. Мөн ҮХШГ улсын төсвийн

зарцуулалттай холбоотой парламентын гишүүдийн 400 гаруй асуултанд хариулт өгсөн байна.

Эх сурвалж: Том Макдоналд. Ахлах хянан шалгагч, Батлан хамгаалах, Үндэсний Хяналт Шалгалтын Газар, Их Британи, 2002 он

Хяналт шалгалтын газрын онцгой элементүүд

Парламентын хяналтын хамгийн чухал хэрэгслийн нэг бол хяналт шалгалтын газар юм. Энэхүү газар нь нөлөө бүхий байхын тулд дараахь шинжүүдийг агуулсан байх ёстой.

- ✓ Хууль ёсны хяналтын байгууллагын эрх мэдэлтэн төсвийн хороонд бус парламентын тооцооны хороонд тайлан тавина;
- ✓ Шийдвэрийг ойлгомжтой болгохын тулд тусгай баримт бичгүүдэд хяналт тавьдаг бөгөөд ийм баримт бичгүүдэд улсын лавлагаа хийдэггүй;
- ✓ Аюулаас хамгаалах салбар, батлан хамгаалахын удирдлага, техник, санхүү, хууль зүйн талын туршлага бүхий олон талт дэг журмын эрх мэдэлтэй байна.

Тодруулга №62

Грузиний парламент ба төсвийн хяналт

2001 оны сүүлчээр Грузины парламент 2002 оны төсвийн тооцооны асуудлыг парламентын хэлэлцүүлгээр оруулах асуудлын талаар ерөнхий зүйл дээр санал зөрүүтэй байсан болон хэлэлцүүлэг явуулах цаг хугацаа бага гэсэн шалтгаанаар нэг сараар хойшлуулах шийдвэр гарсан. Учир нь парламентад төсвийн санал маш оройтож ирсэн яг энэ үед Америкийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар батлан хамгаалах яам батлан хамгаалахын эхний төсвийн хөтөлбөрийг хийснээр парламентын гишүүдэд зэвсэгт хүчний бүтцийн үндсэн элементүүдийг судлах боломж олдсон бөгөөд батлан хамгаалахын зарцуулалтын талаар үзэл бодлоо илэрхийлсэн. НАТО-гийн стандартаар хийгдсэн төсвийн төсөлд бүх зардлыг гурван хэсэгт ангилсан байсан. Үүнд: албан хаагчид, байлдааны бэлтгэл, хангалт, хөрөнгө оруулалт.

Парламентын хяналтын үүднээс авч үзвэл гол асуудал 2002 оны 1 дүгээр сард парламент уг төсвийг баталсан бөгөөд нэгдүгээрт, ерөнхийлөгч, сангийн сайд, батлан хамгаалахын сайд нар батлан хамгаалахын зарцуулалтын талаар өөр өөр санаа бодолтой байгаагаар илэрхийлсэн. Хоёрдугаарт, хууль санаачлагчдын

тайлбарлаагүй төсвийн тоонд өөрчлөлт орсон. Гуравдугаарт, парламентын гишүүд батлан хамгаалах яамны албан хаагчдын цомхотголын санал болон үүнээс үүсэх санхүүгийн нөлөөний үр дүнгийн талаар ямар ч мэдээлэлгүй байсан. Үүний зэрэгцээ төсвийн хуульд тусгагдаагүй засгийн газрын агентлагуудын төсвийн хөрөнгө үнэндээ парламентын хяналтаас алга болсон юм.

Эцэст нь батлан хамгаалахын төсвийн хөтөлбөр нөлөөлсөн бөгөөд хөтөлбөр ёсоор 71 сая ГЕЛ /Грузин улсын мөнгөний нэгж/-ийг шаардсан байхад парламент батлан хамгаалахын зарцуулалтанд зориулж зөвхөн 38 сая ГЕЛ-ийг баталсан. Үүнээс үзэхэд ерөнхийлөгч болон үндэсний аюулгүй байдлын зөвлөл засгийн газрын байгууллагуудад төсвийн санг хэрхэн хуваарилах асуудлыг шийдэж байна. Энэ явдлаас парламент сургамж авч хэлэлцүүлэг явуулах, төсөв батлах замаар парламентын үйл ажиллагааг явуулж ардчилсан хяналт тавьж болох нь харагдаж байна.

Эх сурвалж: David Darchiashvili, *Грузины Парламент ын Судалгааны төвийн захирал, 2002 он.*

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Үр ашигтай тусгаар тогтносон хяналт

- ▷ Хяналтын дээд байгууллага байгуулахыг үндсэн хууль болон бусад хуульд зааж өгсөн эсэхийг дараахь байдлаар тоймлон шалгаж болно.
 - парламент болон үндэсний хяналтын байгууллага хоорондын харилцааны мөн чанар ба үндэс;
 - үндэсний хяналтын байгууллага, түүний гишүүд, албан хаагчдын бие даасан байдал, ялангуяа санхүүгийн хараат бус байдал хангагдсан төвшин;
 - хяналтын байгууллага болон парламентын тооцооны хорооноос гаргасан тайлангийн талаар засгийн газрын хариу арга хэмжээг парламент хянаж шалгах.
- ▷ Хяналт шалгалтын дүрмийн тухай гарын авлагын Лимагийн тунхаглалд заасан зарчмууд /Дээд хяналтын олон улсын байгууллагын вэб хуудаснаас харж болно. хаяг: www.intosai.org/ танай улсын хууль дүрэмд тусгагдсан эсэхийг шалгах.

Хуулийн хяналт, тогтмол хяналт, гүйцэтгэлийн хяналт

- ▷ Аюулгүй байдлын асуудлыг авч үзвэл эдгээр гурван төрлийг үндэсний хяналтын газар авч үзэх;
- ▷ Аюулгүй байдалтай холбоотой зардлыг хянах үйл ажиллагаа явагдах үед парламент хэрэгцээтэй бүх арга хэмжээг авч энэ салбарт мөнгө өгөхийг шалгаж үзэх;
- ▷ Хяналтын ихэнх тайланд санхүүгийн хяналтын асуултууд хязгаартай байдаг. Хууль хяналтын байгууллага шаардлагатай төслийн ажиллагааг нэг бүрчлэн, хэрвээ уг байгууллага өөрийн туршлагын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бол тусгай үнэлгээ хийлгэхээр зөвлөмж авах хэрэгтэй;
- ▷ Хууль хяналтын байгууллага аюулгүй байдлын санхүүгийн хороодын үйл ажиллагааг хянах ёстой.

ҮИИ ХЭСЭГ

Аюулаас хамгаалах салбар дахь хүний нөөцийн тухай: Мэргэшил ба ардчилсан хяналтыг хэрэгжүүлэх

25 дугаар бүлэг

Аюулаас хамгаалах салбарт ардчиллын ач холбогдлыг бэхжүүлэх

Зэвсэгт хүчний салбарт ардчиллын мөн чанар, боловсролын асуудлыг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр нийгэмд зөв замаа олж нэгдэх, ардчилалд айдас төрүүлэхгүй байх болно. Цэрэг арми нь зөв удирдлага, ардчилсан хяналтгүй, нийгэмтэйгээ уялдаа холбоогүйгээр ажиллах нь ардчилалд хор хөнөөл учруулдгийг дэлхийн янз бүрийн оронд болж буй үйл явдлын туршлагаас харж болно. Үүнд:

- ✓ үндсэн хуулиар заагдаагүй үүрэг хэрэгжүүлэх буюу цэрэг армийн арга хэмжээг ангилах;
- ✓ зөвшөөрөгдөөгүй цэрэг армийн буюу худалдааны үйл ажиллагаа явуулах;
- ✓ нийгмийн бусад салбарт хэрэгцээтэй нөөцийн ихэнхийг зарцуулах;
- ✓ улсын санг буруу ашиглах;
- ✓ хүний эрхийг зөрчих /дээрэм, хулгай, хууль бусаар дарамт шахалт үзүүлэх, хүчингийн гэмт хэрэг зэрэг/.

Аюулаас хамгаалах салбарын ажилтан албан хаагчдын дунд ардчилсан ёсыг бий болгох арга зам

Зэвсэгт хүчинд ардчиллын мөн чанарыг бэхжүүлэх, ардчиллын ач холбогдлыг ухаарч, хүндлэн дээдлэхэд цэргийн байгууллагууд болон бусад байгууллагуудын дунд хэрэгжүүлэх арга механизмуудыг үүсгэн байгуулах явдал юм. Эдгээр арга механизмуудыг зэвсэгт хүчинд тавих парламент, засгийн газар, иргэдийн хяналтыг гүйцэтгэхэд ашиглах юм.

Албан хаагчдын дунд ардчиллыг бэхжүүлэхэд дараах элементүүд тус дөхөмтэй байдаг.

Үндсэн хууль болон төрийн байгууллагад үнэнч байх

Сайн засаглалд төрийн үйлчилгээний ач холбогдол, хууль дүрмээ сахих ёс зүй, үндсэн хууль, төрийн байгууллагуудыг хүндлэх явдлыг аюулаас хамгаалах салбарт багтааж үзнэ. Цэрэг болон бусад хамгаалалтын хүчнийхэн тодорхой нэг улс төрийн албан тушаалтанд бус төрийн байгууллага, үндсэн хуулийн өмнө үнэнч байх тангараг өргөж батална. Үнэнч байх тухай “хувийн бус” шинж чанартай энэхүү тангараг нь аюулаас хамгаалах салбар тухайн засгийн газарт үнэнч шударга байх бус, хууль санаачлагчдын баталсан хууль болон үндсэн хуулийн өмнө үнэнч байхыг билэгдэж байгаа юм. Аюулаас хамгаалах салбарт тавих иргэдийн хяналтанд цэргийн тангарагийн мөн чанарыг ухамсарлах, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө юу хийх ёстойг заасан байх ёстой.

Аюулаас хамгаалах салбарын дотоод дүрэм

Аюулгүй байдлын дотоод журамтай холбоотой хууль зүйн хүрээг ардчилсан хяналтын үзэл бодлын үүднээс бэхжүүлэх нь чухал юм. Ингэхдээ дараахь зүйлсийг багтаана.

- ✓ Албан хаагчдын үндсэн хуулиар заасан эрхийг хязгаарлах;
- ✓ Цэргийн албаны хууль, цэргийн албаны тогтоол, цэргийн шүүхийн хууль зэргийг батлах буюу сэргээн батлах; Женевийн конвенцитай холбоотой гэрээнд хууль зүйн хүрээг тогтоох;
- ✓ Хууль бус дүрмийг мөрдөхгүй байхыг албан хаагч бүрт үүрэг болгох.

Ихэнх улс оронд бүх иргэдийн эрх, үндсэн эрх чөлөөг үндсэн хуулиар баталгаажуулсан байхад цэргийн тодорхой үүрэг даалгавар ёсоор харъяалагдах хуулиудаар эдгээр эрхийг хязгаарлаж болно. Иймд зарчмын хувьд цэргүүд бусад иргэдийн адил эрх эдлэх бөгөөд тэд дүрэмт хувцас бүхий

иргэд юм. Гэвч цэргүүд тусгай ангилсан баримт бичгүүдийг дүгнэх талаар үг хэлэх, цэргийн бэлэн байдлыг илэрхийлсэн хөдөлгөөний эрх, улс төрийн албан тушаалд сонгогдох эрхтэй байна. Цэргүүдийн иргэний эрх чөлөөг бүх оронд адил хязгаарладаггүй. Жишээлбэл, Скандивын орнууд болон Герман, Голландад цэргүүд үйлдвэрчний эвлэлд элсэж хамрагдах эрхтэй байдаг. Бусад орнуудад цэргүүд зөвхөн төлөөлөх байгууллагуудад элсэж, үйл ажиллагаанд нь хамрагдаж болно. Гэвч ихэнх тохиолдолд уг хязгаарын тухай харъяалагдах хуулиудад заасан байх ба энэ нь цэргийн албан хаагчийн тодорхой албан тушаал, үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой байна.

Цэргийн төлөөлөх байгууллага, холбоод

Ихэнх оронд сайн дурынхны ашиг сонирхлыг хамгаалах үйлдвэрчний эвлэлд элсэх, хамрагдах нь цэргүүдэд хориотой байдаг. Зэвсэгт хүчний доторх сахилга бат, эмх журмыг эвдэж магадгүй гэсэн үүднээс үйлдвэрчний эвлэлээс ангид байх зарчмыг баримталдаг. Гэвч бусад орнуудад Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын Конвенцийн 11 дүгээр зүйлд зааснаар цэргийн албан хаагч төлөөлөх байгууллага буюу холбоонд элсэж хамрагдахыг зөвшөөрсөн байдаг. Энэ нь Австри, Бельги, Чех, Дани, Финлянд, Герман, Унгар, Ирланд, Люксембург, Голланд, Норвег, Португал, ОХУ, Словени, Словак, Швед, Цвейцарь зэрэг орнуудад хамаарна. Эдгээр орнуудад цэргийн албан хаагчдад зориулсан төлөөлөх байгууллага, холбоод тусгай ангиллаасаа хамааран өөр өөр эрхтэй байна. Эдгээр нь батлан хамгаалахын сайдтай зөвлөх, зарим нь үүрэгт ажлын хугацааны талаар маргах эрхтэй байдаг. Бусад үед цэргийн албан хаагчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг бэхжүүлэх, цэргийн албан хаагч, ажил олгогч хоёрын хооронд хууль зүйн маргаан гарсан тохиолдолд гишүүдээ дэмждэг. Цэргийн албан хаагчдад зориулсан томоохон байгууллага Европын холбоонд бий. Брюсель дахь ЕВРОМИЛ нь хуулиар заагдсан цэргийн албан хаагчдын Европын байгууллага юм. Хоёр дахь нь Стокгольм дахь Цэргийн байгууллагын европын зөвлөл /ЦБЕЗ/ юм.

Тодруулга №63

Зэвсэгт хүчний мэргэжлийн штабын гишүүдэд зориулсан байгууллага, холбооны гишүүн байх эрхийн тухай Европын Зөвлөлийн зөвлөмж

1. Парламентын Ассемблей зэвсэгт хүчний мэргэжлийн гишүүдийг жирийн нөхцөлд байгууллагад гишүүнээр элсэх эрхийг, ажил хаях эрхийн хориглолтын хамт зөвшөөрсөн.

4. Өнгөрсөн жилүүдэд зарим гишүүн орнуудын арми цэрэг татлагын тогтолцоогоо жинхэнэ мэргэжлийн тогтолцоо болгон өөрчилсний үр дүнд цэргийн албан хаагчид жирийн ажилчид болж, ажил олгогч нь батлан хамгаалахын яам болсон бөгөөд хүний эрхийн тухай Европын конвенц, Европын нийгмийн байгууллагын дүрэмд заасан ажилчдын эрхийн дагуу сонгогдох бүрэн эрхтэй байх ёстой.

5. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн дүрэмт хувцастай иргэд болохын хувьд арми үйл ажиллагаа явуулаагүй үед албан ажлаа гүйцэтгэхийн зэрэгцээ ардчилсан байгууллагуудын хүрээнд тэдний мэргэжлийн ашиг сонирхлыг хамгаалах тодорхой байгууллагыг санаачлан байгуулах, нэгдэх, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох бүрэн эрхээ эдлэх ёстой.

6. Цэргийн албан хаагчид улс төрийн намуудад элсэх эрхээ эдлэх ёстой.

7. Иймд Ассемблей нь гишүүн орнуудын засгийн газраас:
- зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, цэргийн албан хаагчдыг ажлын байр, ажлын хөлстэй холбоотой асуудлаар маргах эрхийн хамт төлөөлөх байгууллагуудад хандахыг зөвшөөрөх;
- зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд байгууллагад нэгдэх эрхийн тухай шаардлагагүй хязгаарлалтыг арилгах;
- зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, цэргийн албан хаагчдад улс төрийн намын гишүүн байхыг зөвшөөрөх;
- эдгээр эрхийг гишүүн орнууд өөрсдийн цэргийн хууль, дүрэмдээ тусгах;
- цэргийн албан хаагчид хөдөлмөрийн болон бусад үйл ажиллагааны талаар маргаантай үед хандаж болох агентын газрыг бий болгох боломжийг судлаж үзэхийг зөвлөж байна.

8. Мөн уг Ассамблейгаас Европын нийгмийн дүрмийн 5 дугаар зүйлийг өөрчлөн дараахь байдалтайгаар засаж залруулах боломжтой эсэхийг Сайд нарын Зөвлөлд даалгахыг уриалсан. “Ажилтан, албан хаагчдын эрх чөлөөг бэхжүүлэн хамгаалах үүднээс тэдний эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах

орон нутгийн, үндэсний, олон улсын байгууллага байгуулах, тэдгээр байгууллагуудад нэгдэх, үндсэн хуулиар энэхүү эрх чөлөөг хаагдуулах буюу хаагдуулж ажиллахгүй байхыг талууд анхаарах ёстой. Энэхүү зүйлээр заасан баталгаа нь үндсэн хууль дүрмээр тодорхойлсон зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, цагдаа нарт хэрэгжинэ.

Зөвлөмж 1572/2002 он/Европын парламент ын ассемблейн ээвлэл, 2002 оны 9 дүгээр сарын 3.

Боловсролын асуудлын үнэ цэнэ, хэм хэмжээг нь ухааран бэхжүүлэх нь

Албан хаагчдын боловсрол нь үүргээ биелүүлэхэд бэлтгэгдсэн мэргэжлийн албан хаагчдыг бий болгох зорилготой байна. Энэхүү боловсрол нь улс төрийн хувьд төвийг сахих шинж төлөвтэй байх бөгөөд аливаа тохиолдолд улс төрийн үзэл бодол, ухуулах, сурталчлах элементийг агуулах ёсгүй. Үүнд ардчилсан ёс, үндсэн хууль, олон улсын ба хүмүүнлэгийн хууль, хүний эрхийн тухай хуульд заасан байна. Аюулгүй байдлын албаны боловсролын сургалтанд олон улсын хүмүүнлэгийн хууль, олон улсын хүний эрхийн хуулийг тусгах нь ялангуяа энэ салбарт ардчиллын ач холбогдолыг бэхжүүлэхэд тустай юм. Олон улсын хүмүүнлэгийн хуультай танилцахын тулд парламентын гишүүд 1999 онд ПХХ, Улаан загалмайн олон улсын хорооноос гаргасан “Олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндлэн дээдлэх” тухай парламентчдын гарын авлагыг олж авахыг хүсч буй нь гарцаагүй. Олон улсын хүмүүнлэгийн хууль болон олон улсын хүний эрхийн хуулийг хүндлэн сахихыг эрмэлзэж буй улс орнуудад Улаан загалмайн олон улсын хороо, НҮБ-ын Хүний эрхийн дээд газраас туслалцаа үзүүлнэ.

Улс төрд төвийг сахих, идэвхтэй бус оролцоо

Аюулгүй байдлын алба нь улс төрийн хувьд төвийг сахидаг учраас улс төрийн намуудад цэргийн хуаран дотор сурталчилгаа явуулахыг хориглодог. Зарим оронд идэвх зүтгэлтэй албан хаагчдад улс төрийн намын гишүүн байхыг зөвшөөрдөг. Харин бусад орнуудад ялангуяа хуучин коммунист орнуудад цэргийн албан хаагчдыг улс төрийн намд элсэхийг зөвшөөрдөггүй. Жишээлбэл, Польшид тагнуулын алба буюу цагдаа зэрэг дотоод яамны ажилчдыг улс төрийн намын гишүүнчлэлээс хасдаг. Ихэнх орнуудад

албан хаагчид парламентын гишүүн байж болдоггүй. Гэхдээ зарим оронд жишээлбэл Герман, Голланд зэрэг онуудад идэвх зүтгэлтэй албан хаагч орон нутгийн буюу бүс нутгийн ассемблейн гишүүн байж болдог.

Аюулаас хамгаалах салбар нийгмийн өнгө төрх болох нь

Зарчмын хувьд аюулаас хамгаалах салбарын бүх албан тушаалууд анги, давхарга, шашин шүтлэг, арьсны өнгө, хүйс, улс төрийн сонирхлыг харгалзахгүйгээр бүх иргэдэд нээлттэй байх ёстой. Хамгийн шилдэг албан тушаал дээр ажиллаж буй хамгийн шилдэг эрэгтэй, эмэгтэй албан хаагчид сонголтын гол шалгуур юм. Аюулаас хамгаалах салбарын албан хаагчид ялангуяа цагдаа, зэвсэгт хүчин зэрэг нь ихээхэн хэмжээгээр нийгмийн өнгө төрх болох нь ихэнх оронд ажиглагджээ. Эдгээр улс орнууд аюулгүй байдлын салбарт ажилд орох хүсэлтэй нийгмийн бүлэг хүмүүсийг зоригжуулах зорилготой тодорхой бодлого баримталдаг.

Хууль бус, зүй бус журмыг хуульчлах

Аюулаас хамгаалахын салбарын бүх хяналт, үүрэг хариуцлага, статус, цар хүрээ, үйл ажиллагаа, хамтын ажиллагаа, зорилго, тайлан тавих зэргийг хуулиар зохицуулдаг. Цэргийн албан хаагчдын тогтоол буюу цэргийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад тодорхой хуулиудаар цэргүүдийн дагаж мөрдөх ёстой журмыг хязгаарлан заасан байдаг. Ихэнх орнуудад эдгээр хуулиудаар цэргийн командлагч бүрт хуулиа дагаж мөрдөхийг үүрэг болгодог. Иймд тухайн командлагчийн эрхийг хязгаарлана. Цэргийн алба хаагчид хууль бус /гэмт хэргийн шинжтэй/ дүрмийг дагаж мөрдөж үл болно.

Удирдагчаасаа гэмт хэрэг үйлдэх тушаал авсан цэргийн албан хаагч өөрийн хийсэн үйлдлээ зөвтгөж үл болно. Мөн цэргийн алба хаагчид нь тэдний ажил үүрэгтэй холбоогүй хөндлөнгийн хүнийг хүндлэх явдлыг зөрчсөн тушаал биелүүлэх ёсгүй. Үүгээр цэргийн албан хаагч бүр дээд албан тушаалтнаас үүрэг авсан ч гэсэн өөрийн хийсэн үйлдлээ байнга хариуцах болно гэдгийг харуулж байна.

Цэргийн дээд удирдлагаас цэргүүдийн ардчилсан ёсонд үл нийцэх, үндсэн хуулиас гажууд, түүний эсрэг үйл ажиллагаа явуулах, эмх замбараагүй байдал үүсгэх зэрэг явдлыг олон нийтэд мэдээлж жишээ болгон харуулж байх ёстой. Ийм хуучин цэргийн дэглэм нь зэвсэгт хүчинд ихээхэн ач холбогдолтой юм. Жишээлбэл, Аргентин ардчилалд эргэн орсны дараа Аргентины цэргийн генералууд “төгсгөл арга замыг зөвтгөхгүй” бөгөөд “зүй бус тушаал өгч, уг тушаалыг дагаж мөрдөж байгаа хэн бүр боловч хуулиа зөрчиж байгаа болно” гэж цохон тэмдэглэсэн. Энэхүү мэдэгдлээр дээд удирдлагаас цэрэг бүр гэмт хэрэг, буруу үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх бөгөөд дээд албан тушаалтныхаа тушаалыг биелүүлсэн гэдэг үгээр сөргөлдөн маргахгүй байхыг тодорхойлж өгсөн юм.

Олон улсын хүмүүнлэгийн хууль, хүний эрхийг зөрчиж аливаа мэргэжлийн буруу үйл ажиллагаа явуулбал дээд албан газар буюу шүүхийн байгууллагаас шийтгэж болохыг илтгэн харуулсан.

Аюулаас хамгаалахын дээд албан тушаалтныг томилох шалгуурууд

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, тагнуулын албаны дарга зэрэг аюулгүй албаны дээд албан тушаалтныг батлан хамгаалах хэрэг эрхлэх газар буюу батлан хамгаалахын сайд томилдог. Зарим улс орнуудад энэ тухай парламентын хэлэлцүүлэг явуулж баталдаг байна. Дээд албан тушаалтнуудыг иргэний улс төрийн удирдлагын газраас томилдог боловч сонгох үйл явцад мэргэжлийн шалгуур үзүүлэлтүүд чухал байдаг.

Иргэн хүн аюулаас хамгаалахын дээд удирдлагад ажиллах нь

Сайн засаглалын үзэл баримтлалын үүднээс зэвсэгт хүчний дээд удирдлагад энгийн иргэн ажиллаж болно. Асуудлыг шийдвэрлэхэд тэнцвэртэй байдлыг баримтлахын тулд холбогдох сайдад зөвхөн цэргийн генералууд бус, мөн энгийн иргэд зөвөлгөө өгөх ёстой гэдэгт гол шалтгаан оршино.

Мэргэжлийн ёс зүй

Мэргэжлийн ажлын ёс зүйг практикаар, хууль дүрмээр, бодлогоор бий болгоно. Цэргийн албан хаагчид улсын байгууллага, үндсэн хуульд сайн дураар захирагдан ажиллах ёстой бөгөөд улсын албанд орж өөрсдийн үүрэг даалгавраа үр дүнтэй, идэвхтэй зүтгэлтэй биелүүлэхээс гадна улсын мөнгийг буруу ашиглаж үл болно. Мэргэжлийн ёс зүйг зөвхөн албан шахалтаар бус, сайн дураар дагаж мөрдөх замаар тодорхойлох нь чухал юм. Сайн дураар дагаж мөрдөх гэдэг нь цэргийн албан хаагчид нийгэм дэх ардчиллын ач холбогдлыг ухамсарласан болохоор улсын байгууллага, үндсэн хуультай холбоотой эерэг хандлагатай сүжиг бий болсон байдаг.

Ихэнх орнууд цэргийн албан хаагчдынхаа зан байдлыг зохицуулахын тулд удирдан чиглүүлэх хуулийг баталдаг. Германы зэвсэгт хүчний мэргэжлийн ёс зүйг тодруулга №64-д жишээ болгон үзүүлээ.

Тодруулга №64

Германы Зэвсэгт хүчний удирдлага ба иргэний боловсрол: Дотоодын удирдлагын зарчим

. . . Дэлхийн II дайны дараа Засгийн газрыг байгуулах тухай хэлэлцүүлгийн үеэр дотоод удирдлагын /ёс суртахууны удирдлага ба иргэний боловсрол/ бодлогоо зэвсэгт хүчнийг хуучин уламжлалаас нь ангижруулан шинэчлэх арга зам болгосон. Дотоодын удирдлагын зарчим нь нэг талаас Батлан хамгаалахын дотоод байгуулалт, нөгөө талаас улс нийгэм дэх түүний нэгдмэл байдалд ерөнхий удирдамж болсон гэж хүлээн зөвшөөрсөн.

. . . Үйлчилгээний албан хаагчдын нэг талаас иргэн хүний зүгээс шаардах хувь хүний эрх, эрх чөлөө, нөгөө талаас тэдний цэргийн албан үүргийн шаардлага хоорондын аливаа зөрчлийн төвшинг багасгахад дотоодын удирдлага үйлчилнэ. Дээд албан тушаалтны удирдлагын зан чанарыг үндсэн хуулийн үүргийн үндсэн дээр хувь хүн нийгмийг хүндлэн дээдлэхээр ухамсарлагдах ёстой ...

Гадаад талдаа гол зорилго нь иргэн хүн, бүх үйлчилгээний албан хаагчид, байгууллага болохын хувьд батлан хамгаалах салбарт улс, нийгмийн нэгдмэл байдлыг хөгжүүлэх явдал юм.

Дотоод удирдлагын зорилгууд:

- ▷ үйлчилгээний албан хаагчдад батлан хамгаалахын улс төрийн болон хууль зүйн үндэс суурь, мөн цэргийн үүрэг даалгаврын зорилго, утга учрыг бүрэн ухамсарлуулах;
- ▷ батлан хамгаалах ба үйлчилгээний албан хаагчдын нэгдмэл байдлыг улс, нийгэмд бэхжүүлэх, тэдний үүрэг даалгаврыг олон нийтэд ойлгуулж, ухамсарлуулах;
- ▷ үйлчилгээний албан хаагчдыг үүрэг даалгавраа ухамсартайгаар биелүүлэх хүслийг бэхжүүлэх, зэвсэгт хүчний дотор дэг журам, нягтралыг бий болгох;

Зэвсэгт хүчний дотоод бүтцийг хүн төрөлхтөн, үндсэн хууль, хууль зүйн хэв журмыг хүндлэн дээдлэх үндсэн дээр байгуулах, зэвсэгт хүчний үүрэг даалгаврыг үр дүнтэй гүйцэтгэх баталгаа өгөх хэрэгтэй.

Цэргийн өдөр тутмын амьдрал, дотоодын удирдлагын бодит мөн чанар, зорилгыг багц хуулиуд, тушаал, үйлчилгээний дүрэмд тусгаж өгдөг.

*Эх сурвалж: Герман Улсын парламентын вэб хуудас.
www.bundestag.de*

Олон улсын төвшинд ардчилсан нийгмийн цэргийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон хоёр төрлийн зохицуулах хуулийг өнөөдрийн байдлаар гаргасан. Анх удаа 1996 онд Ерөнхий ассемблей хууль хэрэгжүүлэх албан хаагчдад зориулж олон улсын хуулийг батлан гаргасан. Тодруулга №65-с үзнэ үү. Уг хууль нь ерөнхий шинж чанарыг агуулсан бөгөөд зөвхөн дүрэмт хувцастай албан хаагчдад бус мөн хууль хэрэгжүүлэх байгуулагуудад ажиллаж буй төрийн бүх ажилтан, ажилчдад зориулагдсан.

Тодруулга №65

Хууль сахиулах албаны ажилтнуудад зориулсан зохицуулах хууль

Ерөнхий Ассемблейн 1979 оны 12-р сарын 17-ны өдрийн 169-34-р тогтоолоор баталсан

Нэгдүгээр зүйл. Хууль сахиулах албаны ажилтан нь тэдний мэргэжлийн шаардлагын дагуу мэргэжлийн өндөр төвшинд олон нийтэд үйлчилж, бүх хүнийг хууль бус үйлдлээс хамгаалах замаар хуулийн дагуу өгөгдсөн үүргээ цаг ямагт биелүүлнэ.

Хоёрдугаар зүйл. Хууль сахиулах албаны ажилтнууд үүргээ биелүүлэх явцдаа хүнийг дээдлэн хүндэтгэх, бүх иргэдийн эрхийг хүндэтгэнэ.

Гуравдугаар зүйл. Хууль сахиулах албаны ажилтнууд албан үүргээ гүйцэтгэх явцад зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүч хэрэглэж болно.

Дөрөвдүгээр зүйл. Ажил үүргийн гүйцэтгэл буюу хуулийн хэрэгцээгээр зайлшгүй шаардлагатай нөхцлөөс бусад нөхцөлд нууцын зэрэглэлтэй үүрэг дээр ажиллаж буй хууль сахиулах албаны ажилтан нууц байна

Тавдугаар зүйл. Аливаа хууль сахиулах албаны ажилтан тамлан зовоох буюу бусад хэрцгий балмад үйлдэл, хүмүүнлэг бус доромжилсон шийтгэл тулгах, тэдгээрийг өдөөн хатгах, дэмжиж үл болно.

Зургадугаар зүйл. Хууль сахиулах албаны ажилтан асран хүмүүжүүлж буй хүмүүсийн эрүүл мэндийг бүрэн хамгаалах, ялангуяа шаардлагатай үед эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг яаралтай хийж гүйцэтгэнэ.

Долдугаар зүйл. Хууль сахиулах албаны ажилтан хээл хахууль авах аливаа үйлдэлд оролцож үл болно. Тэд ийм үйлдлийн эсрэг тэмцэнэ

Наймдугаар зүйл. Хууль сахиулах албаны ажилтан энэхүү хууль болон бусад хуулийг хүндлэнэ. Мөн өөрсдийн бүх бололцоог ашиглан аливаа зөрчлийн эсрэг тэмцэж, зөрчлөөс хамгаална. Энэхүү хуулийг зөрчих явдал гарсан буюу гарах гэж байгаа тохиолдолд хууль сахиулах албаны ажилтан дээд удирдлагуудад уг асуудлын талаар мэдээлэх бөгөөд шаардлагатай бол эрх мэдэл бүхий бусад байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

Тайлбар: Энэхүү хуулийн зүйл бүр нь энэ бүлэгт дурдагдаагүй тайлбартай байна. www.UN.org хаягаар орж баримттай танилцаж болно.

Хоёр дахь хууль бол Аюулаас хамгаалахын цэрэг-улс төрийн үзэл баримтлалд зориулсан хууль юм /Тодруулга №66-с үзнэ үү/. Энэхүү хууль нь аюулаас хамгаалах салбар дахь бүх албан хаагчдад зориулсан бөгөөд зэвсэгт хүчний албан хаагчдад заавар зөвлөмж болох юм. Цэргийн албан хаагчид нь хууль зүй, ардчилал, төвийг сахих байдал, хүний эрхийг хүндэтгэх, олон улсын хүмүүнлэгийн хуулийг сахих зарчмыг

дагаж мөрдөнө. Цэргийн албан хаагч хүмүүнлэгийн хуулийг зөрчсөн тохиолдолд хувь хүнийхээ үүднээс хариуцлагад татагдах болно гэдгийг тусгаж өгсөн. Гэхдээ улсын дотоодын хуулийн хүрээнд байнга хамрагдах асуудлуудыг авч үзсэн.

Ингэж энэхүү хууль улсын эрх мэдлийн хүрээнд чухал алхмыг илэрхийлдэг. Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын орнууд 1994 онд энэхүү хуульд гарын үсэг зурснаар эдгээр орнууд хэрхэн цэрэг татлага явуулах, сургах, боловсруулах, удирдах тухай асуудал дээр хамтран ажиллаж байна. Зэвсэгт хүчний цаашдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, зэвсэгт хүчинд зохистой ардчилсан хяналтыг бэхжүүлэх ёстойг уг хуульд зааж өгсөн нь чухал алхам болсон.

Тодруулга №66

Аюулаас хамгаалах албаны цэрэг-улс төрийн үзэл баримтлалын тухай Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын зохицуулах хууль /1994/: гол зарчмууд

- ▷ Тагнуулын алба, парламент цэрэг хоорондын, цагдаагийн зэрэг дотоод хүчний бодлогыг өргөнөөр агуулсан. Эдгээр заалтуудаар уг хүчнүүдийг ардчилсан үр дүнтэй хяналтанд ардчилсан хууль ёсны эрх мэдлийн дагуу удирдах улсын эрх үүргийг хамгаална /догол мөр 20-21/;
- ▷ Батлан хамгаалахын төсвийг хууль ёсоор батлах заалт ба цэргийн зардлыг хязгаартай хэрэглэхийг дэмжих. Зэвсэгт хүчинтэй холбоотой асуудлыг ил тод олон нийтийн болгох /догол мөр 22/;
- ▷ Зэвсэгт хүчин улс төрд төвийг сахих, /догол мөр 23/ зэвсэгт хүчний албан хаагч олон улсын хүмүүнлэгийн хуулийг зөрчсөн тохиолдолд хувь хүнийхээ үүднээс хариуцлага хүлээнэ /догол мөр 31/;
- ▷ Зэвсэгт хүчин нь дайн байлдаан, энхийн үед ч мөн олон улсын хууль дүрмийн дагуу удирдаж, сургаж, тоноглогдож байна /догол мөр 34/;
- ▷ Дотоодын аюулгүй байдлын үүрэг даалгаврыг гүйцэтгэх хүчний арга хэрэгжүүлэх шаардлагад зохицсон байх ёстой. Зэвсэгт хүчин иргэд буюу тэдний эд хөрөнгөнд хохирол учруулахгүй байх арга хэмжээг авна /догол мөр 36/;

- ▷ Зэвсэгт хүчнийг ашиглах нь иргэдийн эрхийг буюу тэдний үндэстэн, шашин, соёл, ёс зүйн тодорхойлолтыг энх тайван, хуулиар хэрэгжүүлэхийг хязгаарлаж үл болно /догол мөр 37/.

Эх сурвалж: Европ дахь Аюулгүй байдал, хамт ын ажиллагааны байгууллагын зохицуулах хууль. VI, VIII хэсэг. Мөн дараах байгууллагын хаяг www.osce.org болон зохицуулах хуулийн хаяг болох http://www.osce.org/docs/english/1990-1999/summits/buda94e.htm#Anchor_COD_65160.

Цэргийн шүүх

Цэргийн дэг журмын шаардлага нь цэргийн үүрэг даалгаврын нэгдсэн онцлогоос хамааран олон тооны нөхцөл байдалд тулгуурладаг. Цэргийн байгууллага гэмт хэргийн зан үйлд энгийн иргэдээс өөр байр сууринаас ханддаг. Энгийн иргэн ажлын байрнаасаа холдсон буюу ажлаа зөв гүйцэтгээгүй бол эрүүгийн шүүхэд үл татагдана. Ажил олгогч уг ажилтанг ажлаа муу хийдэг гэж ажлаас нь халж болох ба ажиллуулахаас татгалзаж болно. Гэхдээ уг ажилтанд эрүүгийн шүүхэд очих үндэс байхгүй.

Харин цэргийн албан хаагч ажлын байраа түр орхих буюу тодорхой стандарт, шаардлагын дагуу албан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд эрүүгийн гэмт хэрэгт татагдана. Иймэрхүү үйлдэл нь зөвхөн албан үүргийн алдаа бус бөгөөд аюулгүй байдал, бусад албан хаагчдыг аюулд өртүүлж байгаа хэрэг юм. Цэргийн бусад гэмт хэрэг болох залилан хийж цэрэгт татагдах, оргон зугатах, алга болох, жагсаал таслах, дээд командлалын офицерыг үл хүндэтгэх, үймээн гаргах, дайсанд туслах, албан үүргээ биелүүлж байхдаа унтах зэрэг нь иргэн хүнд байдаггүй, зөвхөн цэргийнхний хувьд онцлог гэмт хэрэг юм.

Энэ асуудлаар ямар гэмт хэрэг цэргийн шүүхээр орох, ямар гэмт хэрэг иргэний шүүхээр ордог тухай гол асуудлыг дэвшүүлсэн. Зарчмын үүднээс авч үзвэл цэргийн шүүх нь хязгаарлагдмал байдлаар ашиглагдах ба иргэний шүүх хянах ёстой. Цэргийн шүүх нь цэргийн албан үүргээ биелүүлэхдээ гаргасан гэмт хэргээр хязгаарлагддаг байх ёстой. Цэргийн хууль нь иргэний, эрүүгийн хуультай аль болох бага давхцаж байвал зохистой.

Ихэнх оронд цэргийн шүүх нь шүүхийн нэг хэсэг биш бөгөөд гэхдээ зэвсэгт хүчний удирдлага дахь шүүх нь дээд удирдлагын нэгээхэн хэсэг болно. Цэргийн шүүгчдийг үндсэн хуулийн заалт, шаардлагаар томилдоггүй. Гэвч цэргийн шүүхийн бүх хэргийг шүүхээр хянан шалгах ёстойг тунгаан үзэх нь үндэслэлтэй юм. Ихэнх орнуудад цэргийн шүүхэд зориулсан иргэний хэргийн шүүхийг байгуулах замаар явагдаж байна.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

1. Цэргийн албан хаагч нь үндсэн хууль, хууль дүрэм, улсын байгууллагад үнэнч байх тангараг өргөдөг. Гэхдээ хувь хүнд үнэнч байх тангараг өргөдөггүй.
2. Боловсрол бол аливаа цэргийн сургалтын стандартын нэг хэсэг мэт ардчилал, хүний эрх, хүмүүнлэгийн хуулийн хэм хэмжээнд үнэ цэнэтэй зүйл юм.
3. Цэргийн албан хаагч парламентын гишүүн байж үл болно.
4. Мэргэжлийн шалгуур үзүүлэлтээр цэрэг, албан хаагчдыг сонгоно.
5. Хууль бус, зүй бус үйлдлийг үл мөрдөх албан хаагчийн үүргийг хуулиар заасан байна.
6. Цэргийн ёс зүйг зохицуулах хуулиар дэмжсэн сайн дурын мөрдлөгөөр дагаж мөрдөхөөр тодорхойлно.
7. Цэргийн шүүхийн эрх мэдлийг аль болохоор хязгаарлах бөгөөд цэргийн шүүхийн шийдвэрийг иргэний гэмт хэргийн шүүхийн өмнө батлах болно.
8. Аюулгүй байдлын алба нь хуулийн өмнө болон түүний хэрэгжүүлэлтийн талаар, улсын гол элемент бүрийн өмнө хариуцлага хүлээнэ. /Энэ бүлгийн эхний хэсгээс албан хаагчийн хувь хүний хариуцлагын талаар үзнэ үү/. Аюулгүйн албаны дотоод хариуцлагын механизмыг буруу удирдлага, олон нийтийн гомдол зэрэгт дотоодын хяналт тавих замаар явуулахаар хуулиар заасан байна. Ийм механизм хэрэгжиж, үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавих; парламентаас хараат бус судалгааг шаардаж, эргэлзээтэй зүйлсийг илрүүлж байгаа эсэхийг шалгах.

Цэргийн албан хаагчдын иргэний эрх

- ▷ Цэргийн бэлэн байдал, улс төрд төвийг сахиж байхын тулд цэргийн албан хаагчдын иргэний эрхийг хуулиар хязгаарлах;
- ▷ Хүний эрхийг хасах явдал нь аюулгүй байдлын албаны нэгдсэн төлөв байдал, үүрэгтэй шууд холбоотой байдгийг ухаарах, жишээлбэл нийгэм дэх онцгой эрх бүхий хүчин;
- ▷ Хүний эрхийн тухай хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх нь дургүйцлийг арилгах үр дүнтэй шугамаар тэнцвэржүүлэх ёстой.

Дуулгавартай байх

- ▷ Цэргийн албан хаагчид, цэрэг татлагад оролцогчид хууль, ёс зүйн хэв журмыг сахих, олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хуулийн хэмжээ, хэв журмыг сахих үүргийг хуулиар зааж өгөх;
- ▷ Энэхүү үүргийг аюулгүй албаны дотоод журмаар зохицуулахыг хичээх.

Хээл хахууль ба хуулийн гажуудалт

- ▷ Аюулгүй байдлын ажлын байранд хээл хахууль, түрэмгийлэлтэй холбоотой хэтрүүлэг, цуу яриа гарсан тохиодолд шуурхай ажиллах;
- ▷ Зохистой хууль батлан гаргаж хойшлуулахгүйгээр хэрэгжүүлэх, санал асуулга явуулж болох юм;
- ▷ Цэргийн болон бусад аюулгүйн албаны албан хаагчид өөр ажил эрхлэх буюу хувиараа худалдаа наймааны ажил эрхлэхийг хориглосон хууль тогтоомж гаргах.

26 дугаар бүлэг

Аюулаас хамгаалах салбар дахь боловсон хүчний удирдлага

Цэргийн алба гэдэг нь бие махбодийн эрсдэл, байнгын нүүдэл суудал, гэр бүлээсээ хол байх зэрэг зарим нэгэн онцгой талуудтай мэргэжил юм. Парламентын гишүүд цэргийн алба гэдэг нь “ердийн нэгэн ажил биш” гэдгийг ухамсарлах ёстой. Зохистой цэрэг татлага, сонголт хийх, штабыг бүрдүүлэх, боловсрол, шагналын тогтолцоо зэрэг боловсон хүчний зөв удирдлага нь ардчилсан зарчмыг тууштай баримтлан, иргэн болон хуулиа дээдлэн хүндэлдэг аюулаас хамгаалахын мэргэжлийн салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Парламентын гишүүд мэргэжлийн аюулаас хамгаалах албыг байгуулж, бэхжүүлэхийг хянах ёстой. Ардчилсан, мэргэжлийн ажиллах хүчийг удирдах боловсон хүчний удирдлагын төлөвлөгөөг хөгжүүлж хэрэгжүүлэхийг баталгаажуулж, улсаас цэргийн албан хаагчийн цалин мөнгө, хөдөлмөрийн нөхцөл байдал, тэтгэвэр, тэтгэмж зэрэг асуудалд шударга хандаж байгаа эсэхийг шалгах ёстой.

Тодруулга №67

Боловсон хүчний удирдлага: парламентын гишүүдийн анхаарал тавих чиглэлүүд

Аюулаас хамгаалах албаны боловсон хүчний удирдлагатай холбоотой засгийн газрын дараахь саналуудыг парламентын гишүүдэд мэдэгдсэн байх ёстой.

Ерөнхий бодлогын асуудлууд

- ▷ Аюулгүйн албаны боловсон хүчний удирдлагын бодлогын асуудлыг парламентаас жилийн төсвийн төсөл буюу тусгай баримт бичиг болгож баталдаг уу?
- ▷ Улсын эдийн засаг, төсвийн үүднээс авч үзвэл боловсон хүчний удирдлага, бүтцийн бодлого нь бодит байдалтай нийцтэй байдаг уу?

Ерөнхий нөхцөл байдал ба хүчин чадал

- ▷ Парламентаас зэвсэгт хүчин, цагдаа, тагнуулын албанд ажиллах албан хаагчдын тооны дээд хэмжээг зааж өгдөг үү?
- ▷ Парламентаас албан тушаалаас нь хамааруулан цалин хөлсний дээд хэмжээг тогтоодог уу?
- ▷ Боловсон хүчний удирдлагын бодлогууд улсын хэмжээнд хэр зохимжтой явагддаг вэ?
- ▷ Парламент бүх албан тушаал, цалин хөлс, үүрэг, сул орон тоо зэргийн талаар холбогдох хангалттай мэдээлэл авдаг уу?
- ▷ Цэргийн албан хаагчдын цомхотголтой холбоотой нийгмийн үр дагаварт хандсан бодлогыг аюулаас хамгаалах албанаас гаргадаг уу?

Цэрэг татлага ба сонголт хийх

- ▷ Хуулиар зааж өгсөн тохиолдолд иргэн бүрт, ялангуяа эмэгтэйчүүдэд бүх албан тушаал нээлттэй байдаг уу?
- ▷ Аюулаас хамгаалах албаны цэрэг татлагын ил систем нь зөвхөн нийгмийн тусгай хэсэг албан тушаалд үйлчилж болох цэрэг татлагын хаалттай системтэй сэргэлдэх үү?
- ▷ Нэр дэвшигчдийг сонгоход мэргэжлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах үү?
- ▷ Аюулаас хамгаалах албанд сул орон тоо их байдаг уу?
- ▷ Эхний сонголт хийсний дараа хасагдсан хүмүүсийн тоон үзүүлэлт хэр зэрэг өндөр байдаг вэ?

Штаб бүрдүүлэх

- ▷ Цэргийн албан хаагчийг алдар гавъяа, дадлага туршлагыг нь харгалзан сонгох нь тэргүүлэх зарчим уу?
- ▷ Мэргэжлийн шатчилсан үнэлгээний тогтолцоо байдаг уу?
- ▷ Энэхүү тогтолцоо нь шударга, ил тод, үнэн байдаг уу?
- ▷ Аюулаас хамгаалах алба сонирхолтой мэргэжил үү?
- ▷ Албан хаагчийг цалинтай өөр ажил эрхлэхийг хориглодог уу?
- ▷ Ахлах удирдагч нар энэ талын сургалтын туршлагатай байдаг уу? Мөн гадаадад энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцдог уу?
- ▷ Жанжин штабын даргыг сонгох зэрэг дээд албан тушаалын хүнийг томилоход парламент буюу холбогдох парламентын хороо батлан хамгаалахын сайд, холбогдох сайд нарын саналыг авдаг уу?

Шагнах

- ▷ Аюулаас хамгаалах албыг хөдөлмөрийн зах зээл дээрх хувийн компаниудтай харьцуулахад цэргийн албан хаагчдын цалин бусад мэргэжлийн цалингаас хангалттай өндөр байдаг уу?
- ▷ Цалин хөлсийг цагт нь олгодог уу?

- ▷ Алдар гавъяа байгуулах ба сайн ажиллахад шагнаж урамшуулдаг уу?
- ▷ Албан хаагчийн ажлын жинхэнэ үзүүлэлт шагнахад нөлөөлөх үү?
- ▷ Шагналын тогтолцоо үүнийг хийж буй хүмүүс болон өргөн олонд ил тод байдаг уу?
- ▷ Тэтгэвэр, тэтгэвэрт гарах тогтолцооны тухай юу гэж заасан байдаг вэ?
- ▷ Ажиллаж буй албан хаагчийн цалин хөлс, ашигтай холбож үзэхэд тэтгэвэрт гарах тогтолцоо хангалттай байдаг уу? Тэтгэвэрт гарсан тохиолдолд юу хожиж, юу алдах вэ?

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Аюулаас хамгаалах албаны ажиллах хүчний зорилго ба хэмжээ

- ▷ Зэвсэгт хүчний ажиллах хүчний хэмжээг тодорхойлох зорилгууд улсын эдийн засгийн нөөцтэй тохирч байгаа эсэхийг шалгах.

Аюулаас хамгаалах албаны ажиллах хүчний шагнал

- ▷ Албан хаагчийн цалин, хөдөлмөрийн зах зээл дээрх шиг эдийн засгийн хувьд боломжийн, амьдралд хүрэлцээтэй эсэхийг шалгах;
- ▷ Цалин хөлс тогтвортой тавигдаж байгаа эсэхийг шалгах;
- ▷ Хангалтгүй цалин хөлс аюулаас хамгаалах албыг сонирхол татахуйц бус болгож чадварлаг залуухан ажилчдын урмыг хугалах магадлалтайг сайтар бодох хэрэгтэй;
- ▷ Цалин хөлсний хангалтгүй төвшин, цалин тогтворгүй тавих нь аюулаас хамгаалах албыг хээл хахууль, авилгал, хүчирхийллийн үүр болгож болохыг анхаарч ажиллах;
- ▷ Албан хаагчид болон лидерүүдийн цалин хөлсний давуу тал, давуу эрх нь аюулаас хамгаалах албыг улс төрийн нөлөө олох сонирхол, өдөөх түлхэх хэлбэртэй болгож болохгүй. Тэд засгийн газрын бусад салбарын ажилчдад өгөгдсөн санхүүгийн давуу тал, давуу эрхтэй тэнцвэртэй байж олон нийтэд мэдрэгдэх ёстой. Тэдний давуу эрх нь үйл ажиллагааны талбарт албан хаагчдаас шаардах нэгдмэл нөхцөл байдал, эрсдэлтэй үйл ажиллагаатай уялдах ёстой;
- ▷ Тэтгэвэрт гарах тогтолцоо хангалттай эсэхийг шалгах.

27 дугаар бүлэг

Цэргийн албанд татах ба шударгаар татгалзах

Бараг бүх улсын үндсэн хуульд улсыг батлан хамгаалах нь иргэн бүрт ногдсон үүрэг хариуцлага мөн гэсэн заалт бий. Зарим оронд энэхүү үүргийг засгийн газраас хэрэгцээтэй гэж үзвэл зэвсэг хүчинд алба хаахаар иргэн бүр бэлтгэгдэх ёстойг хуулиар албадан заасан байдаг. Цэрэг татлага ба иргэн бүр /эр хүн бүр/ цэрэгт албадлагаар татагдахыг үндсэн хуулиар заасан байхын зэрэгцээ дараахь хуулийн заалтууд байдаг. үүнд:

- ✓ хүн бүр цэргийн үүргийг гүйцэтгэх ёстой;
- ✓ албаны хугацаа;
- ✓ хугацаа сунгах, чөлөөлөх;
- ✓ цэрэг татлага явуулах журам;
- ✓ цэрэг татлагаас зайлсхийх /цэргийн алба хаахаас хууль бусаар татгалзах/ торгууль тавих;
- ✓ дээд ба доод насны хязгаар.

Мөн ихэнх улс орнуудад шударгаар татгалзах, дүйцүүлэх алба зэргээр цэргийн алба хаахаас татгалзах эрхийг хуулиар заасан байдаг.

Цэрэг татлагын ашигтай ба хүсүүштэй тал

Одоогоор ихэнх орнууд цэрэг татаж армия бүрдүүлсээр байна. Нэгэн чухал зүйл бол эдгээр улс орнууд цэрэг татлагыг үндэсний соёл, ардчиллын үнэтэй зүйл гэж үздэг. Өнөөдөр цэрэг татлага нь дэлхийн өнцөг булан бүрт маргаантай асуудал болоод байна. Орчин үеийн армийн цэрэг татлагын ашигтай, хүсүүштэй талын тухай санал асуулга нь зэвсэгт мөргөлдөөний шинэ мөн чанарыг харуулж байна. Хэд хэдэн орнууд цаашид цэрэг татлага явуулахаа таслан зогсоох хандлагатай байна. Түүхэнд цэрэг татлагыг

“бий болгосон” Франц улс хүртэл 2001 онд цэрэг татлага явуулах үйл ажиллагаагаа зогсоосон байна. Армийг цомхон, өндөр хүчин чадалтай, хөдөлгөөнтэй сайн дурынхны хүчнээр сольж болох талаар таамаглал дэвшүүлж байна.

Тодруулга №68

Дэлхийн өнцөг булан бүрийн цэргийн алба

Цэргийн албаны үүрэг хариуцлага: Зарим оронд цэргийн алба хаах насны доод хэмжээ 16, 17, 19, 20 нас байхад ихэнх оронд 18 нас байдаг. Орчин үед эмэгтэйчүүдийг цэргийн албанд татах болсон.

Цэргийн албаны хугацаа: 6 сараас 3 жил хүртэл байдаг.

Цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах ба цэргийн дүйцүүлэх алба: бүх улсын тал хувь нь шударгаар цэргийн албанаас татгалзах, цэргийн дүйцүүлэх албыг хүлээн зөвшөөрдөг. Цэргийн албанаас хууль бусаар татгалзсан ихэнх тохиолдолд шийтгэл болгож шоронд хорино.

Эх сурвалж: НҮБ-ын Хүний эрхийн Хорооны Зөвлөлийн 1995 оны 83 дугаар т огт ооолын дагуу Ерөнхий нарийн бичгийн даргын хийсэн мэдэгдэл. E/CN.4/1997/99

Цэрэг татлагын эерэг ба сөрөг нөлөө

Цэрэг татлагын талаар эерэг ба сөрөг нөлөөллүүдийг судлах үед парламентын гишүүд дараахь зүйлсийг тунгаан бодох хүсэлтэй байдаг.

Цэрэг татлагыг яагаад дэмжих вэ?

Цэрэг татлагатай холбоотой гардаг маргаанууд:

- ✓ Цэрэг татлага нь ардчиллын үзэл бодолтой нэгдмэл байдаг. Учир нь хуулиар тодорхойлсон иргэн бүрийн /ихэвчлэн эрэгтэй/ үүрэг хариуцлага, тэгш эрхийн тухай асуудлыг хөндсөн байдаг. Хүн бүр анги давхарга, шашин шүтлэг ялангуяа зарим оронд хүйс хамаарахгүйгээр алба хаах үүрэгтэй байдаг. Цэрэг татлагад эрчүүдээс илүү эмэгтэйчүүд татагдаж байна.
- ✓ Цэрэгт татагдсан цэргүүд бүгдээрээ дүрэмт хувцас бүхий иргэд бөгөөд тэдний оршин тогтнол зэвсэгт хүчнийг улсын доторх улс болохоос хамгаална. Ингэж цэрэг

татлага зэвсэгт хүчин, нийгмийн хооронд ардчилсан хяналт бий болно.

- ✓ Ерөнхийдөө цэргийн албанд татагдсан цэргүүдийн цалин хөлс сайн дураар татагдсан цэргүүдийн цалингийн төвшингөөс доогуур байдаг болохоор цэрэг татлагаар бүрдсэн арми, сайн дурын армиас хямд өртөгтэй байдаг.

Цэрэг татлагаар нийгмийн бүх давхаргын хүмүүсийг нэг дор цуглуулдаг. Иймээс цэргийн албанд татагдсан цэргүүдийн боловсролын төвшин, ажлын туршлага янз бүр байдаг. Нягтлан бодогч, инженерээс эхлээд сантехникч, фермийн эзэн хүртэлх мэргэжлийн хүмүүсийг зэвсэгт хүчинд оруулдаг. Эдгээр төрөл бүрийн боловсролын чадавх, ажлын туршлагыг зэвсэгт хүчин маш сайн дайчлах бөгөөд тэд энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцвол, мөн зөрчилтэй орнуудын дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулахад зэвсэгт хүчин хувь нэмрээ оруулахад ашигладаг.

Цэрэг татлагыг яагаад хэрэгсэхгүй болгож байна вэ?

Дэлхий дахины цэрэг татлагын талаар хийсэн бидний судалгаагаар цэрэг татлагыг хэрэгсэхгүй болгох зарчим дараахь шалтгаануудад чиглэгдэж байгаа бөгөөд цэрэг татлага явуулах тогтолцоо нь:

- ✓ Сүүлийн 25 жил буюу ялангуяа хүйтэн дайны төгсгөлөөр ихэнх орнууд цомхон зэвсэгт хүчинтэй болсон бөгөөд ингэснээр маш цөөн тооны хүмүүсийг цэрэгт татах хандлагатай болсон. Ялангуяа Евро-атлантын бүсийн орнууд армиа багасгасан. Африк, Азийн орнууд цөмийн дайны дараа армиа багасгахад энх тайвны ногдол ашгийг бага хэрэглэх нь ажиглагдсан.
- ✓ Зэвсэгт хүчин илүү мэргэжлийн болж дэвшилтэт технологиос хамааралтай болсон. Цэргүүд ярвигтай орчин үеийн зэвсгийн системийг эзэмшиж сурахаас өмнө урт хугацааны сургалтад хамрагдах болсон. Эдгээр системтэй танилцахын тулд цэргийн албанд татагдсан цэргүүд гол төлөв удаан хугацаагаар хамрагддаггүй болохоор арми сайн дурын мэргэжлийн цэргүүдэд илүү итгэх болсон

- ✓ Энхийг сахиулах үйл ажиллагаа нь цэргийн үндсэн ур чадварыг шаардахаас гадна тохиролцох болон бусад ур чадварыг мөн шаардана. Цэрэгт татагдсан ихэнх цэргүүд зөрчилтэй байсан орнуудад хүнд хэцүү энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцоход шаардагдах ур чадварын төвшин, туршлагыг эзэмшихэд шаардагдахуйц хугацаанаас бага хугацаагаар алба хаадаг.
- ✓ Зарим оронд үндсэн хуулиар улсын хилийг хамгаалахад цэрэгт татагдсан цэргүүдийг ашиглахыг хориглосон байдаг.

Тодруулга №69

Цэрэг татлагын дарамт

Цэргийн албанд албан бус захирах, захирагдах ёс хуучин ба шинэ цэргүүдийн хооронд үүсдэг. Хуучин цэргүүд шинэ цэргүүдэд цэргийн дүрэм, уламжлалыг зааж сургадаг болохоор албан бус захирах ёс нь чухал байдаг. Гэвч хуучин цэргүүд албан бус шатлан захирах ёсыг хувийн эрх ашгийн төлөө шинэ цэргүүдээр ажил хийлгэх тэднийг дарамтлах зэрэг үйлдлүүдийг хийдэг. Хэрэв офицер хангалттай хяналт тавихгүй **тохиолдолд** энэхүү албан бус захирах ёс бүхэлдээ хяналтаас гарч шинэ цэргүүд дарамт, бие махбодын хүчирхийлэл, сүрдүүлэг зэрэгтэй учрах болно. Цэрэг татлага явуулдаг орнуудын Европын Зөвлөлийн дагуу дарамт нь шинэ цэргүүдэд тохиолддог гол асуудлын нэг болоод байгаа төдийгүй зарим тохиолдолд шарх сорви үлдэх, үхэх, амиа егүүтгэх зэрэг үйлдэлд хүрч байна. Цэргүүдийг хамгаалах, цэргийн албаны нэр хүндийг унагахгүйн тулд офицерийн зүгээс хатуу анхаарал тавьж дарамтаас урьдчилсан сэргийлэх хэрэгтэй. Мөн дотоод ба гадаад хяналтын байгууллагууд онцгой хэргийг мөрдөж, цэргийн албанд хуулиар тогтоосон дүрэм журмыг мөрдүүлэх хэрэгтэй байдаг.

Эх сурвалж: Lona Kiss. Энхийн цагт цэрэг татлага явуулах эрх. 2001 он. www.dcaf.ch Мөн төв болон зүүн европын цэрэг татлагын эрхийн тухай Хар номноос үзнэ үү. 1996 он. [Http://www.xs4all.nl/~ecco/](http://www.xs4all.nl/~ecco/)

Шударгаар татгалзах /ШТ/ ба дүйцүүлэх алба

Зарим хүмүүс эх орноо хамгаалах үүргийн талаар шашин буюу хувь хүний итгэл үнэмшил зэрэг ёс суртахууны үндсэн дээр эргэлзээтэй ханддаг. Үүний улмаас эдгээр хүмүүс

улсын журам дүрмийг биелүүлэхгүйн улмаас өгөх хатуу шийтгэлийг амсах нь ердийн зүйл байдаг.

Сүүлчийн хагас зуунд зэвсэгт хүчинд нэгдэх, зэвсэгтэй явах эрхээс татгалзах тухай үзэл бодол гарч ирсэн төдийгүй өргөнөөр хүлээн зөвшөөрөх болсон. Зарим улсад үүнийг хуулиар зааж өгсөн байдаг. Энэхүү чиглэл нь Англи, Герман, Ирланд, Голланд, Бельги, Люксембург, Франц, Испани, Итали, Португал зэрэг орнуудад цэргийн зайлшгүй албыг дуусгавар болгосон байна.

Шударгаар татгалзсан хүмүүс зэвсэгтэй байх болон аливаа цэргийн сургалт, албыг эсэргүүцсэн хүмүүс байдаг. Татгалзсан бүх хүмүүс ухамсрын үүднээс ханддаг боловч тэдгээр хүмүүс өөрсдийн итгэл үнэмшлийн дагуу янз бүрийн шашин шүтлэг, философи, улс төрийн шалтгаантай байдаг.

Парламентын шийдвэр

Цэргийн албанаас татгалзах явдал газар авсан болохоор зарим орны парламент ямар нөхцөл байдалд цэрэг татлагад дуудагдсан иргэд энэ үүргээс зайлсхийж болохыг хуулиар зааж өгөхөөр шийдвэрлэсэн байна. АНУ болон баруун Европын бүх засгийн газрууд, хамгийн сүүлд Грек улс шударгаар татгалзах хуулийг 1997 онд хүлээн зөвшөөрсөн байдаг.

Шударгаар татгалзах явдлыг хүлээн зөвшөөрөөгүй орнуудад зайлсхийх буюу урвасан тохиолдолд гэмт хэрэг гэж үзэх бөгөөд хоёр удаагийн тохиолдолд маш хатуу шийтгэл оногдуулдаг байна. Зарим оронд энэ талаар гэмт хэргийн тусгай зүйл анги байдаг бөгөөд гол төлөв цэргийн хуулиар хамгаалсан байдаг.

Шударгаар татгалзах явдлыг хүлээн зөвшөөрөх тухай: хэн ямар үндэслэлээр шийдвэр гаргах вэ?

Шударгаар татгалзах журам нь тухайн хүн өөрийн итгэл үнэмшлээ хэрхэн хүндэлдэг, түүний амьдралд энэхүү итгэл нь ямар замаар нөлөөлдөг, энэхүү итгэл үнэмшил нь цэргийн албатай хэрхэн харшилдаг зэргийг тайлбарлах явдал юм.

Цэрэг татлагын үеэр шударгаар татгалзагч болохыг хүлээн зөвшөөрөх явдлыг Швейцарь, Болгар улсад хөдөлмөрийн яамны харьяа хороо, Словени улсад дотоод хэргийн яам, Хорват улсад хууль зүйн яам шийдвэрлэдэг байна.

Шударгаар татгалзах явдал нь хүний эрх болох нь

2000 оны 4 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998 оны 77-р тогтоолд заасан дүрэм болох Хүний эрхийн дэлхий дахины тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээрт заасан ухамсар, шашин, үзэл бодлын эрх чөлөөний эрхийг хуулиар заасан шиг цэргийн албанаас ухамсрын үндсэн дээр татгалзах хувь хүний эрхийг хүлээн зөвшөөрснөөр 2000 оны 34 дүгээр тогтоол болгон санал хураахгүйгээр баталсан.

1993 онд НҮБ-ын хүний эрхийн хороо шударгаар татгалзах нь уг хэлэлцээрийн 18 дүгээр зүйл болох “үхэх аюулд хүргэх хүч хэрэглэх үүрэг нь хэн нэгний шашин шүтлэг, итгэл бишрэлийг хүндэтгэх эрх, ухамсрын эрх чөлөөтэй харшилж болох юм” гэснээс үүсэлтэй гэдгийг аль хэдийн зарласан. Мөн НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “энэхүү эрхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн тохиолдолд ухамсартайгаар татгалзагчдын дунд тэдний итгэл бишрэлийн мөн чанарт тулгуурласан ялгаа гарахгүй билээ. Тэд цэргийн албыг гүйцэтгэхгүй болохоор ухамсартайгаар татгалзагчдын эсрэг ялгуурлах явдал гарахгүй юм” гэжээ.

Тодруулга №70

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998 оны 77 дугаар тогтоол: цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах тухай

Энэхүү Хорооноос хүн бүхэн амьд явах, аюулгүй байх, ухамсар, шашин шүтлэгийн, үзэл бодлын эрх чөлөөтэй байх,эсрэг ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхтэй гэдгийг иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээр, Хүний эрхийн дэлхий дахины тунхаглалд хүлээн зөвшөөрснийг харгалзан үзэж, цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах явдал нь шашин шүтлэг, ёс суртахуун, ёс зүй, хүмүүнлэгийн болон бусад санаанаас урган гарах, ухамсрын шалтгаан, зарчмаас үүсэлтэйг хүлээн зөвшөөрснөөр . . .

1. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын хэлэлцээрийн 18 дугаар зүйл, Хүний эрхийн дэлхий дахины тунхаглалын 18 дугаар зүйлд тус тус заасны дагуу хүн бүр шашин шүтлэг, ухамсар, үзэл бодлын эрх чөлөөгөө эдлэх хуультайн нэгэн адил цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах эрхтэйг анхаарч үзэх;
2. Зарим улс ухамсартайгаар татгалзах явдлыг эргэлзээгүйгээр хүчин төгөлдөр болгон хүлээн зөвшөөрсөн явдлыг анхаарах;
3. Шударгаар татгалзсан хүмүүсийг шашин шүтлэгийн улмаас ийм шийдвэр гаргасныг нь ялгаварлаж үзэхгүй байх явдлыг хүлээн зөвшөөрч, тодорхой нөхцөлд шударгаар татгалзах явдлыг шийдвэрлэх үүрэг бүхий биеэ даасан байгууллага байдаггүй улсуудад энэхүү тогтолцоог байгуулахыг уриалах;
4. Цэргийн зайлшгүй албаны тогтолцоо бүхий улс орнуудад шударгаар татгалзаж буй хүмүүст олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх иргэний шинж чанартай буюу байлдааны бус чанарыг агуулсан дүйцүүлэх албаны хэлбэрийг санал болгохыг сануулах;
5. улс орнуудад шударгаар татгалзсан хүмүүсийг шоронд хорих явдлаас татгалзах, цэргийн албыг гүйцэтгээгүй тохиолдолд өгөх шийтгэлээс зайлуулах зэрэг шаардлагатай арга хэмжээ авах ёстойг ойлгуулах, улс бүрийн цэргийн дүрэм журам, эцэст нь хуулийн дагуу шийтгэгдэх хүмүүсийг хэн нэгэн дахин шийтгэхгүй болохыг уриалах хэрэгтэй.

*Эх сурвалж: НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1998 оны
77 дугаар т огт оол*

Дүйцүүлэх алба

Шударгаар татгалзах статусыг хүлээн зөвшөөрсөн ихэнх орнууд цэргийн албыг дүйцүүлэх албаар гүйцэтгүүлэх тухай үндэсний албаны тухай хуульдаа заасан байдаг. Энэхүү дүйцүүлэх алба нь хоёр үндсэн хэлбэртэй байна. Үүнд:

- ✓ Зэвсэгт хүчинд зэвсэггүйгээр алба хаах;
- ✓ Нийгмийн халамжийн байгууллагууд болох эмнэлэг, асрамжийн газар, тахир дутуу хүмүүст зориулсан байгууллага болон зарим ТББ-ууд, Засгийн газар хоорондын байгууллагуудад ажиллах.

Дүйцүүлэх алба нь ихэвчлэн цэргийн албанаас урт хугацаатай байна. Жишээлбэл, Францад цэргийн алба 10 сар байхад дүйцүүлэх алба 20 сар байна. Австри улсад цэргийн алба зөвхөн 7 сар, дүйцүүлэх алба 12 сар, Болгар улсад цэргийн алба 6-9 сар, дүйцүүлэх алба 24 сар байна.

Тодруулга №71

Дүйцүүлэх алба: Швейцарь улс

Швейцарьулс бол баруун Европын орнуудаас одоог хүртэл цэрэг татлага явуулдаг улс юм. Цэрэгт татах үйл ажиллагааг үндсэн хууль /59.1-р заалт/, 1995 оны Цэргийн байгууллагын тухай хууль, 1995 оны Цэргийн албаны тухай хуулиар зохицуулдаг. Цэргийн албанд 20-42 насны эрэгтэйчүүдийг татах бөгөөд цэргийн өндөр цол хэргэмийг 55 наснаас дээш хүмүүст олгоно. Цэргийн алба эхлээд 4 сар, дараа нь хоёр жил тутамд 3 долоо хоног, мөн жил бүр буудлагын сургуультай байна.

1996 оны Дүйцүүлэх албаны тухай хуулиар ёс зүй, шашин шүтлэг, зан байдлын сэтгэл зүйн шалтгааны улмаас цэргийн албанаас ухамсартайгаар татгалзах эрхийг хүлээн зөвшөөрсөн. үйлдвэр, хөдөлмөрийн яам сонинд зар өгч цуглуулсан 120 офицерээс 3 хүнийг сонгон авсан уг хорооны шийдвэрийн дагуу хүсэлтийг хүлээн авна. Дунджаар цэрэг татлагад бүртгэгдсэн хүмүүсийн 5 хувь нь ухамсартайгаар татгалздаг. Ухамсартайгаар татгалзах эрхтэй хүмүүсийг хүлээн зөвшөөрдөггүй. Гэхдээ цэрэг татлагаас татгалзсан тохиолдолд 4-5 сараар шоронд хорих ялаар шийтгүүлнэ.

Ухамсартайгаар татгалзсан хүмүүсийг цэргийн албаны оронд энгийн алба хийж гүйцэтгүүлэх ёстой. Энэ нь олон нийтийн эрх ашгийн төлөө аливаа нэгэн улсын буюу хувийн байгууллагад 450 хоногийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Уг ажлыг эмнэлэг, залуучуудын төв, их сургуулиудын судалгааны төв, ойн аж ахуй зэрэгт хөдөлмөрлөж гүйцэтгэж болно.

Эх сурвалж: Шударгаар Татгалзах Европын Товчооноос /ШТЕТ/

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Цэрэг татлага буюу цэрэг татлагагүй байх

- ▷ Өөрийн улсын хувьд цэрэгт татах, цэргээс халах үйл ажиллагааг болгоомжтой тэнцвэржүүлэх;
- ▷ Үүнтэй холбоотойгоор энэхүү бүлэгт дурдагдсан элементүүдийг тогтоох, танай улстай хэр зэрэг холбоотойг ажигла.

Цэрэг татлага хараасан буюу доромжилсон халдлага болох нь

- ▷ Цэрэг татлага ямар нэгэн хараал зүхэл, доромжлол, хүчирхийлэл болох тохиолдолд хурдан шуурхай хөдлөх;
- ▷ Нухацтай санал асуулга явагдаж байгаа эсэх, зохистой шийдвэрийг удирдлагын зүгээс гарган хэрэгжүүлж буй эсэхийг шалгах;
- ▷ Танай улсад батлан хамгаалахын агент байдаггүй бол ийм агентыг байгуулах, харааж зүхсэн, доромжилсон халдлагын байдалтай тэмцэх үүргийг хариуцуулах талаар зөвлөх.

Шударгаар татгалзах статус

- ▷ Шударгаар татгалзах тухай танай улсын статусыг шалгах, аль болох хуулиар зааж өгөх буюу тухайн хуулиа сайжруулах;
- ▷ Уг асуудалд хандах бусад орны хууль зүйн туршлагатай холбогдох шинэ мэдээллийг тогтмол авах.

Дүйцүүлэх алба

- ▷ Танай оронд дүйцүүлэх албаны тухай хуулиар заагдсан эсэх, аль болох хуулиар заах тухай арга хэмжээ авах, тухайн хуулиа сайжруулах;
- ▷ Уг асуудалд хандах бусад орны хууль зүйн туршлагатай холбогдох шинэ мэдээллийг тогтмол авах.

*Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт
тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт*

VIII ХЭСЭГ

Материалын эх сурвалж зэвсэг нийлүүлэх болон зэвсгээр хөөцөлдөх тухай үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх

28 дугаар бүлэг

Буу зэвсэг ба цэргийн тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт

Ханган нийлүүлэлтийн бодлогыг үндэсний аюулгүй байдлын бодлого, батлан хамгаалахын төлөвлөгөө мэт өндөр зэрэглэлийн төлөвлөгөө, бодлого боловсруулж баримтлах ёстой. Цэргийн тоног төхөөрөмж буюу шинээр зэвсэг худалдан авах бүх хэрэгцээг үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн ямар нөлөөтэйг сайтар судалж үзсэний үндсэн дээр явуулна.

Үндэсний аюулгүй байдлын бодлого нь батлан хамгаалахын удирдлагын үйл ажиллагаанд тогтвортой байдлыг бий болгох бөгөөд батлан хамгаалахын урт хугацааны бодлогын шийдвэрт урьдчилсан таамаглалыг дэвшүүлдэг. Үндэсний батлан хамгаалах бодлогын зорилгыг батлан хамгаалахын салбарт хуваарилсан нөөцийг зэрэгцүүлэн хадгалах, батлан хамгаалахын салбар, нийгэм хооронд тэнцвэржүүлэлтийг бий болгох нь чухал юм.

Зэвсгээр хангахад ил тод байх нь

Ардчиллыг бэхжүүлэхэд гол төлөв төсөв боловсруулах асуудал, ялангуяа зэвсгийн ханган нийлүүлэлтийн асуудал улсад ил тод, хариуцлага хүлээхүйц байна. Улсад хариуцлага хүлээх үүднээс авч үзвэл бодлого, төлөвлөгөө, төсөв, зэвсгийн ханган нийлүүлэлтийн хооронд оновчтой холбоос байх нь чухал. Үүнийг бүх улсад хүлээн зөвшөөрдөггүй. Харамсалтай нь ихэнх орнууд зэвсгийн хангалтын асуудлыг хязгаарладаг.

Нөөц хуваарилах буюу ханган нийлүүлэх үйл ажиллагааг хуваарилахдаа парламентаас ийм үйл ажиллагааны тухай хууль дүрмийг хянан шалгаж үзэхээс гадна ялангуяа зарим төрлийн зэвсгийг хэрэглэх, худалдаалах, үйлдвэрлэлийг хязгаарлах олон улсын дүрэм журам, гэрээ болох 1968 оны зэвсэглэлээр үл хөөцөлдөх хэлэлцээр, 1997 оны галт бөмбөгийг шилжүүлэх, үйлдвэрлэх, хадгалах, ашиглахыг

хориглох болон түүнийг устгах тухай Оттавагийн конвенц, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн тогтоол зэргийг дагаж мөрдөх ёстой.

Мөн парламент олон жилийн турш батлан хамгаалахын гол тоног төхөөрөмжийн үнийг тооцоолохдоо хүндрэлтэй асуудалтай тулгарч болох юм. Ялангуяа бүтээгдэхүүнээ хамгийн боломжтой үнээр зарах сонирхолтой, ардчилсан хяналтанд бага анхаарал тавьдаг дотоод болон гадаад зэвсгийн нийлүүлэгчдэд эмзэг ханддаг хуучин зөрчилтэй байсан буюу хөгжиж буй орнууд хамрагддаг.

Ийм шалтгааны улмаас парламент зэвсгийн ханган нийлүүлэлтийг хариуцдаг тусгай хороо буюу дэд хороотой байх сонирхолтой байдаг. Ингэснээр зэвсэг нийлүүлэлтийн асуудалд ил тод байдлыг хөгжүүлж чадах бөгөөд дээд албан тушаалтныг ард түмэнд хариуцлагатай хандах явдлыг бий болгож чадах юм.

Засгийн газрууд гол зэвсгийг /нисдэг тэрэг, хуягт танк, их буу, радар болон удирдлагын систем, пуужин, байлдааны усан онгоц зэрэг/ худалдан авах хэрэгцээтэй холбоотой тоог зөвшөөрөх хүсэлгүй байдаг бөгөөд жижиг гар буу буюу галт зэвсэг болох 100 мм-ийн калибраас бага ангиллын зэвсгийг шилжүүлэх биедээ авч явахыг хориглох сонирхолтой байдаг нь парламентын хувьд асуудал болдог.

Зэвсэг ханган нийлүүлэх үйл ажиллагаан дээр засгийн газар зэвсгийн ханган нийлүүлэх төлөвлөгөө урт хугацаанд улс орныг санхүүгийн дарамтад оруулахгүй байхыг хангах үүднээс парламенттай хамтран ажиллах болно. Зэвсэг ханган нийлүүлэх хөтөлбөрийг улсын бусад онцгой асуудлуудын хүрээнд авч үзэх ёстой. Иймд зөвхөн цэргийн онцгой зүйлүүд бус бусад онцгой асуудлууд мөн шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамаарна. Парламент зэвсэг ханган нийлүүлэх нь нийгэмд хэрхэн нөлөөлөх, санхүүгийн ямар дарамттай тулгарах зэргийг хянах ёстой.

Тодруулга №72

Парламентын гишүүд яагаад зэвсэг ханган нийлүүлэх асуудалд санаа тавих ёстой вэ?

- ▷ Улсын сангаас тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулдаг;
- ▷ Зэвсгийн системийг шийдвэрлэх нь зөвхөн техникийн аюулгүй байдлын асуудал бус бөгөөд мөн мөнгийг бүү зэвсэг эсвэл тосонд зарцуулах ёстой юу, хэрэв бүү зэвсэгт зарцуулах бол ямар бүү зэвсэг, хэр зэрэг хэмжээгээр, хэрхэн зарцуулж болохыг шийдвэрлэх;
- ▷ Зэвсэг ханган нийлүүлэлт нь богино буюу урт хугацаанд улс эх орныг санхүүгийн дарамтанд оруулдаг болохыг анхаарах;
- ▷ Нийгмийн салбарын хэрэгцээний эсрэг зэвсгийн зарцуулалтыг парламентын хяналтаар тэнцвэржүүлэх шаардлагатайг тооцоолох;
- ▷ Зэвсгийн ханган нийлүүлэлтийн ил тод үйл ажиллагаа, парламентад хариуцлага хүлээх, хээл хахуулиас зайлсхийх, улсын санг үрэх, гажуудуулах;
- ▷ Парламентын ба улсын хяналт бүсийн зэвсэг ханган нийлүүлэлтийн эргүүлгийг аюулд учруулах явдлыг багасгах болно.

Тусгай нөхцөл байдал нууц байдлыг зөвтгөх үү?

Сайн засаглалын зарчим, ялангуяа ил тод байдал улсын бодлогын асуудлыг түүний дотор зэвсэг худалдаалах, ханган нийлүүлэлттэй холбогдох асуудлыг зөвлөх ёстой. Иймд тодорхой нөхцөлд батлан хамгаалахын шийдвэр гаргах явдлыг зөвшөөрөх, аюулгүй байдлын хэрэгцээг зөвтгөх хэрэгцээ байдаг.

Зэвсгийн худалдаа ба ханган нийлүүлэлтийн удирдлага нь ил тод байдал, улсад хариуцлага хүлээх зарчмын үндсэн дээр тулгуурлана. Захиалагч буюу зэвсэг нийлүүлж буй орноос тухайн асуудлыг нууцлахыг шаардсан тохиолдолд нууц байна. Хэрэв ийм нөхцөлд хээл хахуулийн үйл ажиллагаа явагдах бол хоёр тал энэхүү үйл ажиллагааг илрүүлж ийм үйл ажиллагаа гарахаас хоёул урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Тодруулга №73

Зэвсэг ханган нийлүүлэлтийн бодлого сул буюу нууцлалын өндөр зэрэглэл бүхий зэвсэг ханган нийлүүлэлтийн асуудал дараахь зүйлд хүргэж болзошгүй . . .

- ▷ Зэвсгийн системийг ханган нийлүүлэхэд хангалтгүй шалгалт хийх;
- ▷ Үндэсний болон бүсийн аюулгүй байдалд эрүүл бус үр дагавартай шийдвэрийг засгийн газраас баримтлах;
- ▷ Хөрш орнуудын талаарх төсөөлөл;
- ▷ Зэвсэг ханган нийлүүлэлт болон цэргийн зэвсэг нийлүүлэлттэй бүх шийдвэрт гажуудал гарах;
- ▷ Шаардлагагүй маргааны улмаас зэвсэгт хүчин улсын итгэлийг эвдэх.

Ханган нийлүүлэлтийн тухай тодорхой шийдвэр

Гол зэвсгийн системийн худалдаа хийх үед шийдвэр гаргах үйл ажиллагаагаар дараахь аргыг тодорхойлох ёстой.

- ✓ Үнэлгээ хийх үйл ажиллагаа;
- ✓ Батлан хамгаалахын хүчин чадлын урт хугацааны бодлого;
- ✓ Шинэ тоног төхөөрөмжид хэрэгцээтэй материалыг тодорхойлох;
- ✓ Зэвсэг ханган нийлүүлэлтийн төсвийн хуваарилалт;
- ✓ Техникийн чанарыг хангах, нийлүүлсэн зэвсгийн үзүүлэлтийг хянан шалгах;
- ✓ Үйлчилгээ, засвар, шинэчлэл зэрэг эргэлтийн бүх зардал;
- ✓ Тэнцвэржүүлэлт, нөхөн төлбөрийн саналыг дэвшүүлэх.

Эдгээр бүх шатанд парламентын хяналт шалгалт хийж, үйл ажиллагааг хянах нь дээд удирдлагын шийдвэрийн тогтолцоонд нөлөөлөх гажуудал буюу луйвар зэргийг багасгана. Үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхийн тулд парламент засгийн газраас зэвсгийн ханган нийлүүлэлттэй холбоотой бүх шатны мэдээллийг мэдээлж байхыг шаардах ёстой. Мөн парламент зэвсэг ханган нийлүүлэх тухай бүх гэрээг шийдвэрлэх эрхтэй байна. Зэвсэг ханган нийлүүлэлтийн асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагааны

бүх шатуудыг хянах хуулийн жишээ болгон Голландын парламентыг харуулав /Тодруулга №74-ийг үзнэ үү/.

Тодруулга №74

Батлан хамгаалах ханган нийлүүлэлтийн тухай Голландын бодлого: парламентын хяналт

Голланд улс нь батлан хамгаалахын зэвсэг нийлүүлэлтийн асуудлаар урт хугацаанд баримтлах уламжлагдан ирсэн парламентын хатуу хяналттай улс юм. Зарчмын хувьд 25 сая еврогоос дээш өртөгтэй /дунджаар 25 сая доллартай тэнцэх/ зэвсэг ханган нийлүүлэлтийн шийдвэрийг парламентаар авч хэлэлцдэг байна. Үүний зорилгыг олж эзэмших үйл ажиллагаа гэж нэрлэнэ. Олж эзэмших үе шатнаас шалтгаалан засгийн газар /батлан хамгаалахын материалыг хариуцагч батлан хамгаалахын төрийн нарийн бичгийн дарга/ А, Б, С, Д гэсэн 4 ангиллаас нэгийг сонгож явуулна. Нарийвчлан үзэхгүйгээр үндсэндээ ялгаатай үе шатанд шаардлагатай шинэ зэвсгийн системээс үйлдвэрлэгч У-с Х системийг худалдан авах зөв төслийг сонгоно.

Олж эзэмших үйл ажиллагааны үе шат бүрт парламентын шийдвэр нөлөөлөх болно. Хэрэв засгийн газар олж эзэмших /олж авах олон тооны системийг санал болгох/ буюу солих хэрэгцээг тохирсон бол парламент үүнийг өөрчлөх буюу эсэргүүцэж болно. Амьдрал дээр тэр бүр тохиолддоггүй боловч хамгийн сүүлчийн шийдвэр хүртэл өөрчлөгдөх буюу эсэргүүцэлтэй учирч болно. Ихэнх үед дотоод үйл ажиллагааны үеийн засгийн газрын зорилгод парламентад хэлцэгдсэн 4 зэрэглэл /А, Б, С, Д/ нөлөөлдөг.

100 сая еврог хол давсан төслийн /Томоохон төсөл гэгдэх/ гол журамд парламентад үе үе мэдээлэх тусгай журамтай байдаг. Үүний нэгэн жишээ бол Голландын засгийн газар Америкийн Ф-16-г залгамжлагч хамтарсан тулалдааны сургалтын үе шатуудад оролцсон. Гэхдээ бусад чухал төсөл болох Агаарын хөдөлгөөнт бригад зэрэг байна.

Голландын одоогийн байдлыг авч үзвэл хангалттай гэж үзэж болох юм. Санхүүгийн босго, зарим үед техникийн үйл ажиллагаа болох нарийвчилсан парламентын хяналтын тухай маргаан гардаг. Энэхүү үйл ажиллагааны цар хүрээнд хараат бус батлан хамгаалахын байгууллагаас засгийн газрын мэдээллийн хараат бус байдал, тэгш эрхийн тухай асуудал, баримт мэдээллийг хүсэх зэргээр асууж лавладаг. Эцэст нь үйлдвэрлэлийн үүрэг хариуцлага болон лобби, тэдний батлан хамгаалах хорооны гишүүдэд нөлөөлөх нөлөөллийн талаар үе үе маргадаг. Гэвч энэ талаар ямар нэгэн онцгой үйл явдал, шуугиан одоог хүртэл гараагүй байна.

Эх сурвалж: Голландын парламент ын гишүүн асан Jan Noekema. 2002 он.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Зэвсэг ханган нийлүүлэлтийг хянах

- ▷ Зэвсэг ханган нийлүүлэлтийг парламентаас хянах явдлыг хуулиар тогтоох;
- ▷ Батлан хамгаалахад тавих парламентын хяналт ойлгомжтой байхаас гадна ханган нийлүүлэлтийн бүх асуудлыг хамарсан онцгой бөгөөд тусгай хяналтыг:
 - аюулгүй байдлын хэрэгцээ,
 - бүс нутгийн зэвсгээр хөөцөлдөх асуудлаар сөрөг үйл ажиллагаа явуулах үүднээс бүс нутгийн улс төрийн үр дагавар,
 - төсвийн ядуурал/урт болон богино хугацааны/,
 - хувийн болон улсын салбарын үндэсний үйлдвэрт нөлөөлөх нөлөө зэрэгт тавих шаардлагатай.

Зэвсэг ханган нийлүүлэх ил тод байдал, хариуцлага

- ▷ Парламент зэвсгийн үйл ажиллагаа, цэргийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх асуудлаар санал бодлоо илэрхийлсэн эсэхийг шалгах;
- ▷ Парламент буюу холбогдох хороонд шаардлагатай үед үндсэн төрлийн зэвсэг, /нисдэг тэрэг, хуягт танк, их буу, удирдлага ба радарын систем, пуужин, байлдааны усан онгоц/, жижиг зэвсгийн төрлүүд /100 мм-ээс бага гар буу/, шинэ зэвсэг худалдан авах талаар нарийвчилсан, өдөр тутмын мэдээллийг мэдээлэхийг шаардах;
- ▷ Парламентад батлан хамгаалахын хүчин чадлын талаар урт хугацааны бодлогыг мэдээлсэн эсэхийг шалгах;
- ▷ Зэвсэг ханган нийлүүлэлтийн нууцтай холбоотой асуудлыг цэргийн нууцыг хадгалах үед хариуцлага хүлээх тухай хуулийн дагуу парламент болон холбогдох хороонд мэдээлсэн эсэхийг шалгах.

Ханган нийлүүлэх нөлөөллийн шинжилгээ

- ▷ Ханган нийлүүлэх төлөвлөгөөний тогтвортой байдлыг аюулаас хамгаалахын бодлоготой жиших;
- ▷ Парламентын судалгаа, зэвсэг нийлүүлэх санхүүгийн дарамтыг улсын бусад хэрэгцээ, нийгмийн тэргүүлэх салбартай харьцуулан судлах, улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал, хөгжилд нөлөөлөх тэнцвэргүй байдлаас хамгаалах;
- ▷ Зэвсэг ханган нийлүүлэх хүсэл зоригийг хамгаалах парламентын журмыг ашиглах, урт хугацаанд улс орныг санхүүгийн дарамтад оруулж болзошгүйг гэтлэх оновчтой төлөвлөгөөг парламент хамгаалах ёстой.

Ханган нийлүүлэлтийн хяналт шалгалт

- ▷ Батлан хамгаалахын бодлого, төлөвлөгөө, батлан хамгаалахын төсөв, цэргийн зэвсэг, тоног төхөөрөмжинд зарцуулах бодит зардал зэргийн тогтвортой байдлыг хянах;
- ▷ Гэрээг хэрэгжүүлсний дараа зэвсгийн эргэлтэд доод тал нь 3 үзүүлэлт /үе шат/ зэвсгийн системийн хянах хуучин зэвсэг нийлүүлэлтийн гүйцэтгэлийг удирдах.

Ханган нийлүүлэлтийг хариуцсан парламентын хороо

- ▷ Зэвсэг ханган нийлүүлэх парламентын хороо байгуулагдаагүй бол байгуулж бодлогын төлөвлөлт, санхүүгийн төлөвлөгөө, хяналт шалгалт, батлан хамгаалахын үйлдвэр, судалгаа, хөгжлийн хороотой онцгой харилцааг нэмэгдүүлэх;
- ▷ Үүнтэй холбогдуулан бусад парламент дахь ижил төстэй байгууллагын дүрэм журам, үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл цуглуулах, судлах;
- ▷ Танай парламентын байгууллага шинжээчдийн туршлага, зөвөлгөөг авах боломжтой эсэхийг судлах.

29 дүгээр бүлэг

Зэвсгийн худалдаа ба шилжүүлэг

Зэвсгийн худалдаа, зэвсгийн шилжүүлгийг хянахад парламент чухал үүрэг гүйцэтгэдэг. Зэвсэг ханган нийлүүлэлтийг удирдах дүрэм, журмыг үндэсний ханган нийлүүлэлтийн тухай хууль, улсын төсөв, санхүүгийн тухай хууль, гэрээ, маргааныг зохицуулах тухай хууль зэрэгтэй нийцүүлсэн байна. Зэвсгийн худалдаа, шилжүүлгийн бодлогын удирдах шинж чанар ба үүний хууль зүйн цар хүрээ нь ил тод байдал, хариуцлагын зарчим дээр тулгуурласан байна.

Тодруулга №75

Зэвсгийн шилжүүлэг: тодорхойлолт

Зэвсгийн шилжүүлэг гэдэг нь зэвсэг худалдах буюу эзэмшихийн тулд улс орон ба тоглогчид оролцсон бүх үйл ажиллагааг ерөнхийд нь хамаардаг.

Зэвсгийн худалдаа болон шилжүүлгийн тухай үндэсний бодлого

- ✓ Засгийн газар парламентаас баталж гаргасан зэвсэг худалдах тухай хууль, бодлоготой байх ёстой. Уг бодлогоор зэвсгийн худалдааны зохицуулах зарчмыг тодорхойлох ёстой ба ялангуяа дараахь зүйлсийг анхаарна;
- ✓ Үндсэн төрлийн зэвсгийн экспорт, импорт нь парламентын холбогдох хорооны хяналтанд байна;
- ✓ Зэвсгийн худалдааны дүрэм нь НҮБ-ын дүрэм, олон улсын хууль, НҮБ-ын зэвсгийн хоригийн тухай зарчмуудтай нийцэж байх шаардлагатай бөгөөд мөн улс орнуудын зэвсгийн худалдаатай холбоотой эдийн засаг, улс төр, ёс зүй, аюулаас хамгаалах асуудлыг авч үзнэ;
- ✓ Мэргэжлийн хариуцлага, шударга занг бэхжүүлэхийн тулд шийдвэр гаргах үйл ажиллагаанд ил тод зарчим баримтлах;

- ✓ Зүй бус зэвсгийн худалдаанаас урьдчилан сэргийлэх механизмыг НҮБ-ын болон бусад холбогдох зөвлөмж, бусад орны туршлага дээр тулгуурлан хуульчлана. Худалдан авагч ба нийлүүлэгч бүхэн хуулийг дагаж мөрдөнө;
- ✓ Зарагдаж буй зэвсгийн мөн чанар, төрөл нь худалдан авч буй орны парламентаар баталсан, батлан хамгаалахын жинхэнэ хэрэгцээтэй холбоотой эсэхийг парламент тодорхойлох шаардлагатай;
- ✓ Зэвсэг нийлүүлж буй орны парламентаас зэвсэг худалдан авч буй орон хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, зэвсэг ханган нийлүүлэх шийдвэрийн төлөө хариуцлагатай хандах үйл ажиллагааг явуулж байгаа эсэхийг тодорхойлвол зохино;
- ✓ Парламентаас зөвшөөрөгдөн явуулж буй зэвсгийн худалдаа нь энх тайвныг аюулд учруулах, бүсийн хурцадмал байдал, зэвсэгт мөргөлдөөнийг хурцатгах, бүс нутагт зэвсгийн худалдааны эргэлтийг үүсгэх буюу жижиг болон галт зэвсгийн тоо, зэвсгийн тогтолцоог тогтвортой болгох үүднээс бүс нутгийн тогтвортой байдлыг бий болгоход чиглэгдсэн байх нь чухал. Парламентын батлан хамгаалах асуудлыг эрхэлсэн хорооноос бүс нутгийн тогтвортой байдлыг заналхийлсэн асуудлаар бүс нутгийн ярилцлага зохион явуулбал зэвсэг илүүгээр ханган нийлүүлэх, гажуудуулах үйл явдалтай холбоотой нууцлаг асуудлууд бүс нутгийн ярилцлагаар ил тод болох юм;
- ✓ Импортын баталгаанд дурдагдсан нөхцөл байдлын эсрэг зориулалтаар ашиглах орнуудад зэвсэг худалдаалах явдлаас сэргийлэх механизм байх нь зохимжтой.

Улс орны зэвсэг худалдаалах үйл ажиллагаатай холбоотой тусгай хяналт шалгалт хийхийн тулд хуулиар заасан эрх бүхий тусгай хяналт шалгалтын журмыг парламентаас бий болгох нь зөв. Энэхүү үйл ажиллагаа нь парламентаас тодорхойлсон зарчим, зааврын дагуу явагдаж байх нь чухал. Тодруулга №76-д зэвсгийн худалдаа, улсын бодлоготой холбоотой олон улсын гэрээ, хуулийн талаар жишээ болгон үзүүлэв.

Тодруулга №76

Зэвсгийн шилжүүлгийн тухай бүс нутгийн хэлэлцээр

▷ Европын хууль

Европын Холбооны Зөвлөлөөс 1998 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Европын хуулийн тухай тогтоол гаргасан. Уг тогтоолыг хүний эрхийг зөрчиж буй Европын холбооны орнуудаас дэлхийн бүс нутгийн орнууд хүртэл зэвсгийн мөргөлдөөнийг хамгаалах зорилготой гаргасан. Уг хуульд өртөмтгий хүлээн авагч улс орнуудын жагсаалтыг багтаасан бөгөөд хэрэглэхийг хязгаарлах зарчмыг шалгах хянах систем, харилцан мэдээллийн систем, экспортын зөвшөөрлийг зөвтгөх тухай зөвлөмж зэргийг агуулсан.

Европын хууль нь улсуудад хууль зүйн үүднээс холбоотой биш бөгөөд үүнийг хүндлээгүй улс орнуудыг хариуцлагад татах тухай механизм байхгүй. Иймд хүний эрхийг зөрчиж буй экспортыг хязгаарлах тухай экспортын хатуу хуультай байх, дараа нь хоёр талын зөвлөмжийн механизмд дарамт үзүүлэх эсэх нь тухайн улсаас хамаарах асуудал юм.

Гишүүн орнууд зэвсэг экспортлох тохиолдолд дагаж мөрдөх найман зүйлийг уг хуульд заасан. Үүнд:

- 1) Европын Холбооны улсуудын олон улсын хоригийн хүндлэх, ялангуяа НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тогтоосон зөвшөөрөл...;
- 2) Хүлээн авах улсын хүний эрхийг асуудлыг хүндлэн сахих. . . ;
- 3) Тухайн улсад хурцадмал байдал буюу зэвсэгт мөргөлдөөн гарч болзошгүй дотоод байдал. . . ;
- 4) Худалдан авагч уг экспортлогдож байгаа зүйлийг өөр улсын эсрэг буюу газар нутгийн төлөө хүч хэрэглэх зорилгоор ашиглах гэж байгаа нь тогтоогдсон жинхэнэ эрсдэлтэй үед гишүүн орнууд экспортын зөвшөөрлийг хүлээн авахгүй байх...;
- 5) Гадаад харилцаа нь гишүүн оронд хариуцлага хүлээх газар нутгийн ба гишүүн орны үндэсний аюулгүй байдал. . . ;
- 6) Худалдан авч буй орны олон улсын нэгдэл, терроризмд хандах хандлага, олон улсын хуулийг хүндлэх хүлээн авах мөн чанар, зан байдал. . . ;
- 7) Худалдан авагч орны дотор уг тоног төхөөрөмж хуваагдаж болох буюу хүсүүштэй бус нөхцөлд дахин зарагдах зэрэг эрсдэл гарч болох. . . ;
- 8) Худалдан авч буй орны техник, эдийн засгийн хүчин чадалтай холбоотой зэвсгийн экспортын нийцтэй байдал. . .

Эх сурвалж: <http://europa.eu.int>

▷ АНУ-ын байгууллага ба зэвсгийн шилжүүлэг

Америкийн бүс нутгийн зэвсгийн худалдааны ил тод байдал АНУ-ын 19 гишүүн байгууллага байнгын зэвсгийн шилжүүлгийн тухай гэрээнд гарын үсэг зурснаар хөгжсөн. Гватемала хотын Ерөнхий

Ассемблейн үеэр батлагдсан ердийн зэвсэг олж эзэмших ил тод байдлын тухай Америкийн бүс нутгуудын конвенцид жил бүрийн зэвсгийн гол гол экспорт, импортын талаарх мэдээллийг нуухгүй гарын үсэг зурахыг шаардсан.

Уг гэрээний 3 дугаар зүйлийн дагуу "Талууд жил бүр экспортолж буй улсын импорттой холбоотой мэдээллээр ханган ердийн зэвсгийн экспорт, импортын тухай, импортолсон ердийн зэвсгийн тоо, төрлийг, импортолж буй улсын тухай экспорттой холбоотой экспортолсон зэвсгийн тоо төрлийг мөн мөнгө хадгалуулагчдаа мэдээлж байх ёстой. Аль нэг тал аливаа холбогдох мэдээллийг ердийн зэвсгийн загвар, дизайнтай холбоотой мэдээллээр хангаж болно. Мөн улс бүр олж эзэмших явдал үүсээгүй тохиолдолд импорт болон үндэсний бүтээгдэхүүнтэй холбоотой ердийн зэвсгийг олж эзэмших тухай мэдээллээр нэг нэгийгээ хангадаг.

Эх сурвалж: <http://www.oas.org>, 2002 он

Олон улсын зэвсгийн хоригийг хүндлэх

Аливаа улс олон улсын хууль, энх тайван байдал, аюулгүй байдалд заналхийлсэн тохиолдолд тухайн улсын байдлыг эс зөвшөөрсөн байдлаа илэрхийлэх нь олон улсын нэгдлийн илэрхийлэл юм. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалахын тулд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс зэвсэггүй үйл ажиллагаа явуулахыг гишүүн орнууддаа уриалсан НҮБ-ын дүрмийн 14 дүгээр зүйлд заасан хууль зүйн үндэс байдаг. 1945-1990 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс зөвхөн хоёр оронд зөвшөөрөл олгосон. 1990 оноос хойш НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс нийт 12 удаа зөвшөөрөл олгосон байна. Үүнтэй холбоотой зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоохтой холбогдсон сертификатыг шаардах нь зэвсгийн шилжүүлгийг зөвшөөрөх журмын нэгээхэн хэсэг болох парламентад ашигтай хэрэгсэл болох юм. Гэвч дуусгавар болгох хуурамч сертификатыг олж авах зэрэг гажуудал байсаар байна.

Ердийн зэвсгийн тухай НҮБ-ын бүртгэл

1991 оны 12 дугаар сарын 6-нд Ерөнхий Ассемблей зэвсэглэлээр хөөцөлдөхөд ил тод байдал сэдэвт 43\36 дугаар тогтоолыг баталжээ. Уг тогтоолд Ерөнхий нарийн бичгийн дарга Нью-Йорк хот дахь НҮБ-ын төв штабт олон улсын зэвсгийн шилжүүлгийн тухай, үндэсний үйлдвэр, холбогдох бодлоготой холбоотой цэргийн ханган нийлүүлэлт

тухайн гишүүн орнуудын мэдээллийг агуулсан дэлхий нийтийн ердийн зэвсгийн бүртгэл явуулах болсон.

Уг бүртгэлд ердийн зэвсгийн зөвшөөрөгдсөн долоон төрлийг багтаасан. Үүнд байлдааны танк, хуягт өөрөө явагч техник, том калибрын их бууны систем, байлдааны нисэх онгоц, байлдааны нисдэг тэрэг, байлдааны усан онгоц, пуужин, пуужингийн хөлөгт онгоц зэрэг. Энэ нь 1992 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Ерөнхий нарийн бичгийн дарга бүртгэлд орсон 110 засгийн газрын ердийн зэвсгийн экспорт, импортын тухай мэдээ, мэдээллийг Ерөнхий Ассемблейд үе үе тайлагнадаг. Уг илтгэлд үндэсний үйлдвэрлэл, цэргийн газраас ханган нийлүүлэлтийн тухай засгийн газруудаас мэдэгдсэн мэдээлэл мөн багтдаг.

Хэрсүү /шийдвэрлэхэд төвөгтэй/ зөвшөөрөл гаргах хэрэгцээ

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга эдийн засгийн ойлгомжтой зөвшөөрлийг “ширүүн хэрэгсэл” гэж нэрлэсэн. Энэ зөвшөөрөл нь тухайн улс орны ард иргэд болон хөрш зэргэлдээ орнуудад төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй байна. Иймд зарим хүмүүс илүү хэрсүү, өргөн чиглэл бүхий зөвшөөрлүүд шаардлагатай гэж үзэж байна. Зэвсгийн хориг нь санхүүгийн ба аялалын хоригийн дараа орох хэрсүү зөвшөөрлийн нэг хэлбэр юм. Хэрсүү зөвшөөрөл улс эх орны систем, удирдлагад чиглэгдэх бөгөөд улс орны энгийн хүн, эсрэг хүчийг зохицуулдаг. Гэвч хэрсүү зөвшөөрөл хэрэгжих ба бүхэлдээ амжилттай явагдах нь нэлээд төвөгтэй байдгийг нотолсон. Тэдгээрийг шинэчлэн, хөгжүүлэх хэрэгцээтэй байдаг /Тодруулга №77-г үзнэ үү/.

Тодруулга №77

Зэвсгийн зөвшөөрлийг боловсронгуй болгох: парламент юу хийж чадах вэ?

Зэвсэг экспортод орнуудын парламент дараахь шаардлагыг биелүүлэх ёстой.

- ▷ Удирдамж, заавар, зөвлөмж зэрэг хууль тогтоомж, НҮБ-ын зэвсгийн хоригийг зөрчих зэрэг эрүүгийн гэмт хэрэг;
- ▷ Зэвсгийн хоригийг биелүүлэх удирдах салбарыг зохион байгуулах засгийн газар хоорондын хамтын зохицуулалт;

- ▷ Сэжигтэй усан онгоц, хүлээн авах улс орон, дамжин өнгөрөх зам, дамжуулагч зэргийг тодорхойлохын тулд засгийн газар хооронд, засгийн газрын салбаруудын дунд тагнуулын мэдээ, мэдээлэл солилцох;
- ▷ Хориг тавьсан барааг тодорхойлох хяналтын жагсаалт;
- ▷ Хориотой бараа ачсан усан онгоцыг анх гаргасан орон руу буцаахгүйгээр баривчлах эрх;
- ▷ Зэвсэг хууль бусаар дамжуулан олсон ашгийг хураах зарчим;
- ▷ Дамжуулалт хийж болох магадлал бүхий зэвсэг тээвэрлэсэн усан онгоцыг мөрдөх, шалгах.

Эх сурвалж: Тодорхой мэдээллийг дараах вэб сайт аас үзнэ үү.
www.bicc.de, 2002 он

Хүйтэн дайны хууль дүрэм: зэвсгийн үлдэгдэл ба шилжүүлэлт

Хүйтэн дайны үеийн дуусгавар нь дэлхий дахины армийн тоог багасгасан. Үүнээс үзэхэд өчнөөн сая зэвсэг илүүдэл болж үлдсэн. Дэлхий даяар үлдэгдэл зэвсгүүдийг тогтвортой удирдаж чадаагүйн улмаас хэдэн сая зэвсэг засгийн газар хооронд шилжигдэн мөн хяналтаас гадуур нэг засгийн газраас бүлэг хүмүүсийн гарт очих болсон. Тодруулж хэлбэл эдгээр зэвсгийн ихэнх нь хулгайн замаар орж алга болох буюу хамгаалалтгүй зэвсгийн агуулахаас шууд хулгайлагдсан байна.

1990-ээд онд худалдаалагдсан үндсэн төрлийн зэвсгийн тавны хоёр нь илүүдэл болж үлдсэн. 1990-ээд оны олон улсын зэвсгийн худалдааны гойд үзэгдэл болсон илүүдэл зэвсэг гарч ирэх гол шалтгаан бол хуучин Зөвлөлт Холбоот Улсын зэвсгийн томоохон агуулахууд гэнэтхэн төв удирдлагаас чөлөөлөгдсөн явдал юм. Эдийн засгийн хүнд хэцүү байдалд оронгуут илүүдэл зэвсгийн томоохон илүүдэл агуулахууд санхүүгийн хэрэгцээг хангах хатуу мөнгөний эх үүсвэр болсон. Нөгөө талаас сүлжээгээр зохион байгуулагдсан зэвсгийн ихэнх худалдаа улс төрийн томоохон лидерүүдтэй холбоотой байсан гэдэг нь үнэн бодит зүйл билээ. Гэвч хуучин Зөвлөлт Холбоот Улс зөвхөн зэвсгийн агуулахаас худалдаа явуулж байсан орон биш юм. Мөн хэд хэдэн хөгжсөн болон хөгжиж буй орнууд ийм үйл ажиллагаа явуулж байжээ.

Тодруулга №78

Илүүдэл зэвсгийн худалдаа: Зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох явдлын эсрэг зэвсгийн худалдаа

“Шинэ зэвсгийн худалдаа буурсан боловч статистикийн үзүүлэлтээр илүүдэл хуучин зэвсгийн худалдааны бүртгэлийн төвшин өссөн. Татах, түлэх үйлдвэрүүдийн нэгдэл энэхүү илүүдэл зэвсгүүдийг дамжуулахад нөлөөлсөн. Зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох хэлэлцээр, зэвсэглэлийг багасгасан явдал нь тоон үзүүлэлтээр дэлхий дахин дахь нийт зэвсгийн 165000-ийг 1990-1995 онд экспортолж, 18.000-аас илүү зэвсгийн үйлдвэрлэлийг бий болгосон. Анх удаа 1994 онд хуучин зэвсгийн худалдаа шинэ зэвсгийн худалдаанаас илүүтэй байсан. Илүүдэл зэвсгийн худалдаа хямд үнэтэй байдгаас гадна тусламжийн хөтөлбөрөөр өгөгдөх нь ихэссэн. Ийм худалдаа нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсооход бэрхшээлтэй байсан төдийгүй зөрчилдөөнтэй асуудлуудыг бий болгож байсан ба бүс нутгийн зэвсгийн худалдааны өрсөлдөөнийг хурцатгаж байсан.

*Эх сурвалж: Бонны олон улсын шинэчлэлийн төв. 1998 он. Herbert Wulf.
www.bicc.de*

Зэвсэг авч буй орнууд бол ерөнхийдөө парламентын хяналтын бүтэц сул дорой орнууд гэдэг нь илт юм. 1990 оны байдлаар доод тал нь 90 орон илүүдэл үндсэн төрлийн зэвсгийг импортолсон. Жижиг зэвсэг хатуу хяналтан дор байж, хуулиар засгийн газар болон батлан хамгаалахын салбараас жижиг зэвсэг, сумны хулгай, алдагдлыг жил бүр парламентад мэдээлж байх нь чухал юм. Жижиг зэвсгийн үйлдвэрлэлд өөрчлөлт оруулж цэргийн бус бүтээгдэхүүн үйлдвэрлэх алхам хийх нь нэн чухал юм.

1997-2001 оны хооронд Дэлхий дахинд зэвсэг дамжуулах ажиллагааны 5 жилийн дундаж үзүүлэлт унасан. Хэдийгээр 1998 оноос хойш зэвсгийн дамжуулалт 65 хувиар буурсан боловч 1997-2001 оны үедэх бууралтыг томоохон нийлүүлэгч АНУ-ын дамжуулалтанд бууралт гарсантай гол төлөв холбож тайлбарладаг. Энэ үед ОХУ бол хоёр дахь томоохон нийлүүлэгч байсан. 2000-2001 онд томоохон нийлүүлэгчдийн нэг болох ОХУ-ын зэвсгийн дамжуулалт 24 хувиар өссөн /Эх сурвалж: 2002 оны СИПРИ жилийн ном/.

2000 онд 44 хувийн өсөлттэй БНХАУ 2001 онд хамгийн том зэвсэг худалдан авагч болсон. Энэтхэг улсын импорт 50 хувиар өсөж 2001 онд гурав дахь томоохон худалдан авагч

болсон. 1997-2001 оны хамгийн томоохон худалдан авагчид бол Саудын Араб, Тайвань, Турк улс байсан /Эх сурвалж: 2002 оны СИПРИ жилийн ном/.

Тодруулга №79

Жижиг буу зэвсгийн худалдааны тухай тооцоо

“Өнөөдөр хүйтэн дайны сүүлийн жилүүдийнхээс жижиг буу зэвсгийн үйлдвэрлэлийн хэмжээ бага байгаа боловч хэдэн сая буу зэвсэг жил бүр үйлдвэрлэгдсээр байна. Тооцооноос харахад 2000 оны дэлхийн зэр зэвсгийн үйлдвэрлэлийн үнэ доод тал нь 4 тэрбум ам.доллараар хэмжигдэх болсон. 2000 оны байдлаар 4.3 сая жижиг зэвсэг шинээр үйлдвэрлэгдсэн нь Хүйтэн дайны үеийн жилийн дундажтай харьцуулахад 30 хувиар буурсан”.

“Шинэ жижиг буу зэвсгийн хэрэгцээ буурч байгаа мэт боловч зах зээлийн нийлүүлт өсөх хандлагатай байна. Сүүлийн хорин жил хүрэхгүй хугацаанд компаниудын тоо гурав дахин өссөн буюу 1980 онд 196 байсан бол одоо 600 гаруй болжээ”.

Жижиг буу зэвсэг үйлдвэрлэгч, хэн нэгэнд дурын үнээр хаана ч гэсэн худалдаа явуулах сонирхолтой компаниуд шинээр бий болж өсөж байгаа нь засгийн газар, хувь хүн, террорист, гэмт хэрэгтнүүдэд шинэ, орчин үеийн, хөнөөх аюултай зэвсэг олж авахад илүү хялбар болж байгаа юм. Жижиг буу зэвсгийн үйлдвэрлэлд засгийн газраас хяналт тавих явдал нь олон улсын аюулгүй байдлын зайлшгүй асуудлын нэг болоод байна.

Эх сурвалж: Оксфордын Их сургуулиас эрхлэн гаргасан Жижиг Зэвсгийн шалгалт . 2001 он.

Тодруулга №80

Жижиг буу зэвсэг, галт зэвсгийн хууль бус худалдааны эсрэг НҮБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр

“Жижиг буу зэвсэг, галт зэвсгийн хориотой худалдааг арилгах, тэмцэх, сэргийлэхийн тулд жижиг буу зэвсэг, галт зэвсгийн хууль бус худалдааны тухай НҮБ-ын хуралд оролцогчид 2001 оны 6 дугаар сард үндэсний, бүсийн, дэлхийн хэмжээнд өргөн цар хүрээтэй улс төрийн үүрэг амлалтыг баталсан. Түүний дотор дараахь зүйлс орсон болно.

Үндэсний хэмжээнд

- ▷ Жижиг буу зэвсэг, галт зэвсгийн үйлдвэрлэл, эдгээр зэвсгийн импорт, экспорт, дамжуулалт буюу дахин дамжуулалт зэрэгт үр ашигтай хяналт тавих удирдлагын зарчим, дүрэм журам, хуулийг хэрэгжүүлэх;
- ▷ Хориотой жижиг буу зэвсэг, галт зэвсгийг олж эзэмшихэд санхүүжүүлэх, хууль бус үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, дамжуулалт, эзэмшиж буй бүлэг хүмүүс болон хувь хүмүүсийг илрүүлэх;
- ▷ Зөвшөөрөлтэй үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн дотоод үйл ажиллагаа болох жижиг буу зэвсэг, галт зэвсэг бүрт тохирох, чанартай үйлдвэрлэл явуулж байгааг хянах;
- ▷ Үйлдвэрлэлийн тухай үнэн зөв, тодорхой бүртгэл хийж байгаа эсэх, жижиг буу зэвсэг, галт зэвсгийг хуулийн дагуу эзэмшиж, дамжуулж байгаа эсэхийг батлах;
- ▷ Улсын бүртгэл бүхий жижиг буу зэвсэг, галт зэвсгийн хариуцлага, эдгээр зэвсгийн мөрдөх үр дүнтэй арга хэмжээг батлах;
- ▷ Зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, цэргээс халах, нэгдмэл байх үр дүнтэй хөтөлбөрийг аль болохоор хөгжүүлэх, хэрэгжүүлэх;
- ▷ Зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүүхдүүдэд тусгай тусламж үзүүлэх.

Эх сурвалж: НҮБ-ын Зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох хэргийн газар.
Вэб сайт : <http://www.un.org/Depts/dda>, 2002 он.

Өмнө дурдсан хүйтэн дайнтай холбоотойгоор хурцадмал болсон зэвсгийн экспортын хяналтын үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай болгох асуудал нь парламент юу хийх ёстой, юуг хийж чадах тухай тодорхой маргаан ихэнх оронд явагдахад хүргэсэн.

Тодруулга №81-д Европын холбооны гишүүн орнуудын авсан арга хэмжээг дурдав. Ил тод байдал, хариуцлагын давуу талыг ухамсарлаж байгаа явдал нь эдгээр улс орнуудад зэвсгийн экспортод парламентаас тавих хяналтанд онцгой дэвшил болсон. Гэвч ихэнх орнуудад одоог хүртэл төгс болж чадаагүй байна.

Тодруулга №81

Зэвсгийн экспортын хяналтанд парламентын үүрэг оролцоо: Европын орнууд дахь ил тод байдал, хариуцлага

Австри: Австрийн хуульд Парламентын гишүүдэд мэдээлэл нээлттэй байх тухай ямар нэгэн заалт байдаггүй.

Бельги: 1991 онд батлагдсан хуулиар засгийн газар жил бүр зэвсгийн дамжуулалтын тухай парламентад мэдээлж байх үүрэгтэй. Уг хуульд зэвсэг хэн нэгэнд экспортлох гэж буй зөвшөөрөл авахад хяналт тавих талаар заагаагүй. Энэ нь экспортчидод европын хуулийг зөрчихгүй байх гол түлхүүр болж байгаа юм.

Дани: Зэвсгийн экспортын тухай парламентын хэлэлцүүлэг явуулах заалт ба уг асуудалд ардчилсан хяналт тавих хүчин төгөлдөр хэрэгсэл байхгүй. Гэвч улсын шахалт хавчлагаар хууль зүйн сайд экспортын хяналт, үнэ, очих газрыг тодорхойлсон зэвсгийн экспортын тухай урьдчилсан мэдээлэл гарахыг оролдсоор байна.

Финлянд: Европын холбооны хуулийн дагуу батлан хамгаалах яамнаас батлан хамгаалахын материалын экспорттой холбоотой мэдээллийг жилд хоёр удаа хэвлэн гаргасан. Уг мэдээлэл нь ил тод байдлыг нэмэгдүүлэх үр дүнтэй ойлголт болсон. Гэвч зэвсэг дамжуулалтын тухай парламентын байнгын хэлэлцүүлэг дутагдалтай байдаг.

Франц: Францын парламент нь засгийн газраасаа жижиг буу зэвсэг, цагдаа, аюулгүйн албаны тоног төхөөрөмж, хосолсон хэрэглээтэй тоног төхөөрөмж, цэргийн бүх хамтын ажиллагааны талаар жил бүрийн тайландаа илүү нарийвчлалтайгаар, тодорхой дурдахыг алхам тутамд шаардаж байна. Мөн парламент дотор уг тайлангийн талаар хэлэлцүүлэг явагддаг.

Герман: Зэвсгийн экспортын тухай анхны тайлан 2000 онд хэвлэгдэн гарсан. Парламентын дараахь нэр бүхий хороод дараагийн тайланг судлахад оролцох хандлагатай байна. Үүнд: Батлан хамгаалах, Гадаад хэрэг, Худалдаа үйлдвэр, Хүний эрхийн хороо. Парламентын эрх үүрэг бол засгийн газар юуг экспортолж байгаа тухай өнгөрснийг хянахаар хязгаарлагдана.

Грек: Зэвсгийн экспортын удирдлагатай холбоотой мэдээллээр парламентыг хангах тайлан тавих механизм байхгүй. Зөвхөн албан

ёсны мэдээллийг НҮБ-ын хэвшсэн зэвсгийн тухай бүртгэлээр хангадаг.

Ирланд: Зэвсгийн холбоотой экспортын тухай мэдээллийг хэвлэн нийтлэх талаар засгийн газарт үүрэг болгосон Ирландын хуулийн заалт байдаггүй. Гэвч Европын холбооны хуультай холбогдуулан Гадаад хэргийн газраас 2002 он хүртэл жилд хоёр тайлан гаргасан. Экспортын зөвшөөрөлтэй холбоотой асуултыг сайдуудад тавих замаар парламентыг хөгжүүлэх заншилтай байдаг.

Итали: Засгийн газар батлан хамгаалахын тоног төхөөрөмжийн экспорт, импорт, дамжуулалттай холбоотой удирдлагын асуудлыг парламентад мэдээлэх ёстой. Энэ тухай 1990 онд батлагдсан хуулиндаа заасан байдаг. Гэвч парламент экспортыг хянах асуудалд албан ёсны үүргийг гүйцэтгэдэггүй.

Люксембург: Тодорхой зэвсгийн үйлдвэрлэл болон хариуцлагын систем байдаггүй.

Голланд: Зэвсгийн экспортын тухай анхны тодорхой тайланг 1998 оны 11 дүгээр сард нийтлэн гаргасан. Голландын зэвсгийн экспортын системд парламент нь хяналт тавих албан бус элемент бий. Засгийн газар илүүдэл зэвсгийн худалдааны тухай парламент дахь батлан хамгаалахын хороонд мэдээлнэ.

Португал: Анхны тайлан 1998 онд хэвлэгдэн гарсан. Зэвсгийн экспортын зөвшөөрлийг парламентын хяналтанд байлгах, парламентын хэлэлцүүлэг явуулах тухай заалт байдаггүй. Парламентын гишүүд зэвсгийн экспортын зөвшөөрлийн тухай асуулт асууж болно.

Испани: 1998 оноос хойш нэг тайлан гарсан. Зэвсгийн экспортын тухай анхны хяналт байдаггүй. Парламентын албаны нууцын хороо зөвхөн энэ асуудалд оролцох ба Парламентад хэлэлцүүлэг явагдах нь идэвхжиж байгаа.

Швед: Европын бусад орнуудад цэргийн тоног төхөөрөмж экспортлох тухай зөвлөх зөвлөлийг парламент байгуулсан жил буюу 1984 онд анхны тайлан хэвлэгдэн гарсан. Парламент уг тайланг жил бүр авч хэлэлцэнэ.

Их Британи: Английн мэдээллийн систем бол хамгийн ил тод байдаг. 1999 онд анхны тайлан хэвлэгдэн гарснаас хойш батлан хамгаалах яам, гадаад хэргийн яам, олон улсын хөгжил, худалдаа, үйлдвэрийн яам хамтран хамтарсан хороог байгуулсан. Энэхүү хамтарсан хороо нь Ерөнхий танхимд мэдээлж экспортыг хянах үүргийг гүйцэтгэнэ.

Эх сурвалж www.safeworld.co.uk, 2002 он.

Парламентын шинжилгээ /expertise/

Өмнө дурдсанаар парламентын шинжилгээ бол зэвсгийн худалдаа, дамжуулах үйл ажиллагааны талаар парламентаас хангалттай хяналт тавих гол хэрэгсэл юм. Мэргэжлийн ур чадварын хомс байдал нь шийдвэр гаргахад нууцыг сахих гол шалтгаан байдаг. Парламентын гишүүдийн сургалт ялангуяа парламентын хороодтой холбоотой гишүүдийг сургаж бэлтгэх нь чухал байдаг. Үүний нэгэн адил парламентын ажлын албыг зэвсгийн худалдаа, нөхөн төлбөрөөр хангах, үйл ажиллагааны судалгаа, материалын удирдлага, тоног төхөөрөмжийн үнэ, эд хогшил данслахад хяналт тавих зэрэгт мэргэшүүлэх сургалтанд сургах нь парламентын батлан хамгаалах хорооноос тавьсан асуултад хариу өгөх чадвартай шинжээчдийг бий болгоход тустай. Мөн аюулаас хамгаалах салбарт шийдвэр гаргах төрөл бүрийн үзэл бодлын тухай мэдээллийн санг бий болгох нь парламентын батлан хамгаалахын хороо дээд албан тушаалтан болон цэргийн салбараас хяналт болон шийдвэрийг дахин хянахтай холбоотой мэдээллийг шаардах боломжтой болно.

Парламентын гишүүний хувьд та юу хийж болох вэ?

Зэвсгийн худалдааг хянах нь

- ▷ Олон улсын зэвсгийн худалдааны хяналтыг парламентын хэлэлцэх асуудалд онцгойлон авч үзэхэд түлхэц болох;
- ▷ Тодруулга №80-д дурдагдсан “Жижиг зэвсэг, галт зэвсгийн хориотой худалдааны эсрэг НҮБ-ын хөтөлбөр: парламентын гишүүдэд чиглэгдсэн асуудал” гарчигтай зөвлөмжийг хэрэгжүүлэхийг дэвшүүлэх;
- ▷ Өөрийн улсаа НҮБ-ын үндсэн төрлийн зэвсгийн бүртгэлийг шаардлагын дагуу мэдээлэх, цэргийн зардлын талаар мэдээлэх, НҮБ-ын стандартчлагдсан хэрэгсэл, үндсэн төрлийн зэвсэгтэй холбоотой бүс нутгийн холбогдох гэрээ хэлэлцээрийг байнга дагаж мөрдөхөд туслах.

Зэвсгийн худалдааны тухай улсын бодлого

- ▷ Зэвсэг худалдах тухай одоогийн улсын бодлогыг баримтлах, парламентаар зүй ёсоор батлуулахаар хүргэгдсэн эсэхийг тодорхойлох;
- ▷ Засгийн газар зэвсгийн худалдаатай холбоотой мэдээллийг парламентад мэдээлж байх үүрэг бүхий механизм хэрэгжиж байгаа эсэхийг шалгах.

Зэвсгийн хориг

- ▷ Хоригтой холбогдох асуудлууд зардал төсөвлөх, тусгай загвар, нөлөөний холбогдолтойгоор парламентад хэлцэгдэж байгааг анхаарах;
- ▷ Ялангуяа тодруулга №77-д жагсаасан үзэл баримтлалыг бодож “шалмаг зөвшөөрөл” парламентаар хэлцэхийг дэмжих;
- ▷ Парламентаас зэвсгийн хоригийг хүндлэхийг, хоригийг зөрчсөн тохиолдолд үүнийг хүлээн зөвшөөрөх, хохиролгүй болгох талаар анхаарах.

Илүүдэл зэвсэг

- ▷ Парламент буюу түүний холбогдох хороо, гаалийн асуудлыг хариуцсан хорооноос зэвсгийн илүүдэлд онцгой анхаарч танай улс болон танай улсаар дамжуулан илүүдэл зэвсгийн дамжуулалт явагдаж байгаа эсэх, илүүдэл зэвсгийн аливаа хангамжийг хориглох, хянахад үйл ажиллагаагаа чиглүүлэхэд хүчлэх;
- ▷ Зэвсгийн илүүдэл ба түүний устгалыг данслах ажилд танай улсаас оруулах хувь нэмэр;
- ▷ Илүүдэл зэвсэг дамжуулахад оролцсон компаниудыг тодорхойлж үйл ажиллагааг нь хянахад танай улсаас үзүүлэх тусламж.

Жижиг зэвсэг

- ▷ Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, жижиг зэвсгийн худалдааны тухай тодорхой мэдээллийг жил бүр парламент буюу холбогдох хороод авч байхад туслах, эдгээр компаниудын оролцсон үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл бүхий жилийн тайланг шаардах;
- ▷ Үндэсний хэмжээнд үйлдвэрлэгдсэн жижиг зэвсгийн худалдаа нь энэхүү бүлэгт тодорхойлсон үзүүлэлтүүдтэй тохирч байгаа эсэхийг анхаарах.

Женев дэх Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих төв

Сүүлийн арван жилийн хөгжил, иргэд цэргийн ардчилсан харилцааны удирдлага, өөрчлөлт ихэнх улс орнуудын гол бэрхшээлтэй асуудал болж байна. Энэ нь ялангуяа ардчилсан систем рүү шилжиж буй, дайн байлдаан, хуучин зөрчил мөргөлдөөнтэй байсан орнуудад бодит үнэн байлаа. Зэвсэг хүчин болон парламент-цэргийн хүчин, мөн цагдаа, хил хамгаалагчид, аюулаас хамгаалахын бусад бүтцүүд ихэнх оронд чухал үүрэгтэй болсон. Тэд ихэвчлэн улсын нөөцийн санд хүнд цохилт өгөх, ардчиллын үйл ажиллагаанд саад тотгор учруулах, дотоодын буюу олон улсын мөргөлдөөн гарах бололцоо олгох замаар “улсын доторх улс” мэт үйлдэл хийх болсон. Иймд эдгээр хүчний байгууллагуудад ардчилсан, иргэний хяналт тавих нь мөргөлдөөнөөс сэргийлэх, энхийг сахиулах, ардчиллыг бэхжүүлэх, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг бэхжүүлэхэд онцгой үүрэгтэйг нийтээр хүлээн зөвшөөрдөг.

Хүчний байгууллагуудад ардчилсан, иргэдийн хяналтыг бэхжүүлэх нь олон улсын нэгдлийн хөтөлбөрийн бодлогын чухал асуудал болоод байна. 2000 оны 11 дүгээр сард энэхүү ерөнхий, эерэг чиглэлийг дэмжиж Швейцарийн засгийн газраас Батлан хамгаалах, Спорт, Иргэдийг хамгаалах нэгдсэн хэлтэс, Гадаад хэргийн нэгдсэн хэлтэстэй хамтран Женев дэх Зэвсэгт Хүчинд Ардчилсан Хяналт тавих төвийг /ЖЗАХТ/ байгуулжээ.

Зорилго

Энэхүү төв нь улс орон, төрийн бус байгууллагуудыг зэвсэгт хүчин, аюулгүй байдалд иргэний ардчилсан хяналтыг бэхжүүлж, ялангуяа Хойд атлантын бүс нутагт төлөвлөн олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тусалж дэмжинэ.

Энэхүү зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд уг төвөөс

- асуудлыг тодорхойлох, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, зэвсэгт хүчин, цэрэг, иргэний харилцааны ардчилсан хяналтын хүрээнд шилдэг туршлагыг санал болгохын

тулд мэдээлэл цуглуулах, судалгаа явуулах, сүлжээний үйл ажиллагаанд оролцох;

- сонирхож буй бүх талуудад ялангуяа засгийн газар, парламент, цэргийн удирдлагууд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, академийн салбарууд **туршлага судлуулах, дэмжих үйл ажиллагаа явуулдаг.**

ЖЗАХТ нь үндэстний удирдлага, олон улсын, төрийн бус байгууллагууд, академи институтууд, хувь шинжээчидтэй нягт хамтран ажилладаг. ЖЗАХТ нь үйл ажиллагаа, судалгааны ажлын хувьд байгуулах зөвлөлд төлөөлсөн 42 засгийн газрын дэмжлэг, 50 гаруй шинжээчид бүхий Олон улсын зөвлөх зөвлөл, өөрийн судалгаа шинжилгээний байгууллага, ажлын хэсэгтээ итгэдэг. Уг төв нь хэд хэдэн судалгааны институт, олон улсын байгууллага, парламент хоорондын чуулгануудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулсан байна.

Ажлын хөтөлбөр

Зэвсэгт хүчний ардчилсан хяналтын тодорхой сэдвээр хандахын тулд дараахь асуудлыг хариуцах 12 ажлын хэсгийг байгуулсан буюу байгуулах шатандаа орсон байна. үүнд: аюулгүйн салбарын шинэчлэл, зэвсэгт хүчинд тавих парламентын хяналт, зэвсэгт хүчний ардчилсан хяналтын хууль зүйн хэмжээ, батлан хамгаалахын төсөв боловсруулах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсооход ил тод байдлыг бий болгох, үндэсний аюулгүй байдлын бодлогод иргэдийн шинжээчид, цагдаагийн байгууллага ба цэргийн бус аюулгүй байдлын ардчилсан хяналт, өөрчлөлт ба хүчнийг өөрчлөх цэрэг иргэний харилцаа, цэрэг ба нийгэм, иргэний нийгмийг байгуулах, хуучин зөрчилтэй газруудад иргэний нийгмийн харилцаа, зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавихад амжилттай ба амжилтгүй байх үзүүлэлтүүд, Африкийн асуудлаарх цэрэг, иргэний харилцаа. Ажлын хэсгүүдийн төлөвлөгөө, удирдлага, зохицуулалт нь судалгаа шинжилгээний төвд чиглэгдсэн байдаг.

ЖЗАХТ нь өөрийн туршлагаа хоёр ба олон талт харилцаанд ашиглах бөгөөд олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлдэг. Зэвсэгт хүчинд парламентын хяналт тавих, аюулгүй байдлын шинэчлэлийн асуудалд хэд хэдэн хоёр талт төслийг Зүүн

өмнөд болон Зүүн Европын орнуудын дунд явуулж байна. Олон талт төвшинд ЖЗАХТ-өөс Зүүн өмнөд европын тогтвортой байдал, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байна. Уг төвөөс хэвлэл гаргаж, семинар, сургалт бусад арга хэмжээг байнга зохион байгуулж байна. Үзэгчид болон олон нийтэд хүргэхийн тулд өөрийн вэб сайтын тусламжтайгаар мэдээллийн технологийг ашиглаж байна.

Байгуулалт ба төсөв

ЖЗАХТ нь Швейцарийн хуулийн дагуу олон улсын сан юм. Уг төвийг байгуулах зөвлөлд 42 засгийн газар оролцсон. Үүнд: Албани, Армени, Австри, Азербайджан, Белоррус, Босни Герцогвен, Болгар, Кот Дилвор, Хорват, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литви, Молдав, Голланд, Нигер, Норвег, Польш, Португал, Румын, ОХУ, Серб ба Монтенегро, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швецарь, Македоны хуучин Югослав улс, Украин, Англи, АНУ, Женевийн Кантон. Олон улсын зөвлөх газар нь батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар дэлхийд тэргүүлэх, уг төвийн захирал, стратегийн асуудлаар зөвлөдөг шинжээчдээс бүрэлддэг. ЖЗАХТ-д 23 орны 40 мэргэжилтэн ажилладаг бөгөөд судалгаа шинжилгээ, алсын зайн хөтөлбөр, мэдээллийн нөөц, удирдлага гэсэн 4 хэлтэстэйгээр төв штаб нь ажилладаг.

Швейцарийн батлан хамгаалах, Иргэний хамгаалалт, Спортын нэгдсэн хэлтэс нь 2002 онд найман сая швецарь франктай байсан ба эндээс ЖЗАХТ-ийн ихэнх төсвийг санхүүжүүлдэг. Бас нэгэн чухал дэмжигч бол Швецарийн Гадаад хэргийн нэгдсэн хэлтэс юм. ЖЗАХТ-ийн хэд хэдэн гишүүн орнууд уг төвийн онцгой үйл ажиллагааг дэмжих, штабын гишүүдэд туслах замаар ЖЗАХТ-ийг дэмждэг.

Харилцах хаяг

Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF)
Rue de Chantepoulet 11, P.O.Box 1360, CH-1211 Geneva 1,
Switzerland
Tel: 41(22) 741-7700; Fax: 41 (22) 741-7705;
E-mail: info@dcaf.ch; Website: www.dcaf.ch

Парламент хоорондын холбоо /ПХХ/ гэж юу вэ?

Парламент Хоорондын Холбоо /ПХХ/ нь 1889 онд байгуулагдсан бөгөөд тусгаар тогтносон улсуудын олон улсын парламентын байгууллага юм. НҮБ дахь шинэ ажиглагчийн статус нь парламентын хэмжигдэхүүнийг олон улсын төвшинд хүргэх сүүлчийн алхмыг хийх, сонгогдсон иргэдийн төлөөлөгчдийн дуу хоолойг олон улсын хэлэлцээрийн үйл ажиллагаанд хүргэхэд онцлох юм.

2003 оны 1 дүгээр сард 144 улсын парламент ПХХ-ны гишүүн болсон байлаа. Парламентын хэлэлцүүлэгт чиглэгдсэн асуудал, уг байгууллагын үйл ажиллагаа нь:

- ▷ олон улсын ашиг сонирхол, бодлогын асуудлыг эргэцүүлэх;
- ▷ парламентын гишүүдийн хүний эрхийн асуудлыг дэмжих, хамгаалахад туслах;
- ▷ дэлхийн төлөөлөх байгууллагуудыг батжуулахад туслах болно.

Энх тайван, аюулаас хамгаалах асуудлыг ПХХ-ны хөтөлбөрт үргэлж хүчтэй дүрсэлдэг. Олон үйл явдалд жинхэнэ гишүүн байгууллагууд зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, зэвсгийн хориг, олон улсын зөвшөөрөл, олон улсын эрүүгийн шүүх, терроризм зэрэг аюулаас хамгаалах асуудалд оролцдог. 1994 онд олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндлэн бэхжүүлэх үүднээс тусгай хороог байгуулсан. Энэхүү хороо олон улсын улаан загалмайн хороотой хамтран олон улсын хүмүүнлэгийн хуулийг хүндлэн сахих тухай парламентын гишүүдэд зориулсан гарын авлагыг 1999 онд нийтлэн гаргажээ.

ПХХ нь улс төрийн хэлэлцээрийн замаар хурцадмал байдлыг намжаахад туслах сонирхолтой байдаг. ПХХ-ны хурлаар хурцадмал байдлыг намжаах, энхийг сахиулах асуудлыг хэлэлцэх боломжтой байдаг. Мөн уг байгууллага нь Ойрхи Дорнодод хангалттай зохицуулалт хийхэд туслах, Киприйн хоёр талд үүссэн улс төрийн намуудын

*Парламент Хоорондын Холбоо, Женев дэх Зэвсэгт хүчинд Ардчилсан Хяналт
тавих төв – Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт*

төлөөлөгчдийн дунд хэлэлцээр байгуулах тусламжийн бүлэгт туслах парламентын хороотой байхын зэрэгцээ Газрын дундад тэнгист аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх тусгай механизмтай байдаг.

ПХХ-ны төв штаб
Inter-Parliamentary Union
Chemin du Pommier 5
Case Postale 330
CH-1218 Grand Saconnex, Geneva
Switzerland
Tel: 41 22 919 41 50
Fax: 41 22 9919 41 60
E-mail: postbox@mail>ipu.org
Website: www.ipu.org

НҮБ дахь ПХХ-ны
Ажиглагчдын Газар
Inter-Parliamentary Union
220 East 42nd Street
Suite 3102
New York, N.Y. 10017
USA
Tel: /212/ 557 58 80
Fax: /212/ 557 39 54
E-mail: nyoffice@mail.ipu.org